

РОМЫН ЧУУЛГАНД БИЧСЭН ЗАХИДАЛ

ОРШИЛ

“Христитгэлийн тулгуур сургаал”

–Фредерик Годет

I. БИЧЭЭСТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Ром ном Паулын захидлуудын тэргүүнд зохих байраа үргэлж эзэлдэг. Үйлс ном Паулын Ромд очсон аяллаар төгсдөг учраас Шинэ гэрээний захидлууд Паул элчийн Ромын итгэгчид дээр очихоосоо өмнө уг чуулганд бичсэн захиагаар эхлэх нь зүйн хэрэг. Ром ном теологийн хувьд Шинэ гэрээний бүх номоос хамгийн чухал нь бөгөөд Бурханы үгэнд байгаа христитгэлийн системчилсэн теологийн үлгэр загвар мөн.

Библийн номуудаас түүхэнд хамгийн их нөлөө үзүүлсэн нь Ром ном. Августин Ром 13:13-14 дүгээр ишлэлийг уншаад Христэд итгэсэн (М.Э. 380 он). Мартин Лутер Бурханы зөвт байдал ба “зөвт хүн итгэлээр амьдарна” гэсэн үгийг ойлгосноор Протестант шинэчлэлийг эхлүүлсэн (1517 он).

Жон Весли Лондон хотын Алдерсгэйтийн гудамжин дахь Моравийн нэгэн гэр чуулганд

байхдаа Лутерын бичсэн Ром номын тайлбарын оршлыг уншиж байхыг сонсоод авралын баталгааг олж авсан (1738 он). “Энэ захидлыг л ойлговол бүх Бичээсийг ойлгох үүд хаалга нээгдэнэ” гэж Жон Калвин тэмдэглэн үлдээсэн.

II. ЗОХИОГЧ

Христийн сургаалыг эсэргүүцэгч нар төдийгүй эрс сөрөг шүүмжлэгч нар хүртэл харь үндэстнүүдэд илгээгдсэн элч Паул Ром номын зохиогч мөн хэмээх бүх нийтээр баримталдаг уламжлалт байр суурийг зөвшөөрдөг. Бидний мэдэж байгаагаар Паулыг тус номын зохиогч мөн хэмээн бичсэн зохиолчдоос хамгийн эхнийх нь буруу сургаал баримталдаг байсан Марсион юм. Христитгэлийн уламжлалт байр суурийг баримтлагч Ромын Клемент, Игнатиус, Жастин Мартир, Поликарп, Хипполитус, Иренаус нар Ром номоос иш татсан байдаг. Мураторын бичээсийн жагсаалтад Ром номыг Паулын захидал дотор оруулжээ.

Түүнчлэн Паулыг бичсэн гэх *дотоод нотолгоо* ч нэлээд жинтэй байна. Захидлын теологи, үгийн сан, хэв маяг нь гарцаагүй Паулын өвөрмөц шинжийг агуулдаг. Захидлыг Паул явуулсан гэдгийг захидалд дурдсан (1:1) хэмээх баримт үл итгэгч нарт хангалттай нотолгоо болж чадахгүй нь мэдээж. Гэхдээ үүнийг 15:15-20 дугаар ишлэл ба захидлын бусад хэсэг улам бататгаж өгдөг. Үйлс номтой

санаанаасаа зохиохын аргагүй маш олон тохиолдолд таарч байгаа явдал нь магад хамгийн итгэл төрүүлэх баримт болов уу. Хэрэв Паул бичээгүй бол ингэж таарах арга байхгүй. Тухайлбал итгэгч нарт зориулж хандив босгосон тухай, Гайос, Ераст гэх мэт итгэгч нарыг дурдсан ба удаан хугацаанд төлөвлөсөн Ром уруу хийсэн аялал зэрэг нь бүгдээрээ тус захидлыг Паул бичсэн гэдгийг баталж байна. Терт бол Паулын дуудсаныг буулгасан хүн ажээ (16:22).

III. БИЧИГДСЭН ОГНОО

Ром номыг 1, 2 Коринт номын дараа бичсэн. Яагаад гэвэл энэ хоёр захидлыг бичиж байхад цуглуулж байсан мөнгийг Иерусалимын ядуу итгэгчид рүү явуулахад бэлэн болсон байгаа нь Ром номоос харагддаг. Коринтын боомт хот болох Кенхрейг дурдсан (16:1) ба бусад мэдээллүүдэд үндэслэн тус захидлыг Коринт хотод бичсэн гэдэг дээр ихэнх эрдэмтэд санал нийлдэг. Паул өөрийнх нь эсрэг явуулсан аливаа хуйвалдаанаас зугтахын өмнө Коринт хотод (илгээлтийн гурав дахь аяллынхаа төгсгөлд) гуравхан сар байсан учраас тэрхүү богинохон хугацаанд энэ захиагаа бичсэн байх учиртай. Тэгэхээр захидлыг бичсэн цаг хугацаа нь М.Э. 56 он болж байна.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ, ХӨНДСӨН СЭДЭВ

Христийн сургаал анх яаж Ромд хүрсэн бэ? Бидэнд баттай мэдээлэл байхгүй. Гэхдээ Пентекостын өдөр Иерусалим хотод очихдоо Христэд итгэсэн Ромын иудейчүүд (Үйлс 2:10-ыг үз) буцаж очоод сайнмэдээг хүргэсэн байх боломжтой. Энэ үйл явдал М.Э. 30 онд болсон.

Тус үйл явдлаас хойш хорин зургаан жилийн дараа Коринт хотоос захиагаа бичиж байхдаа Паул Ромд очиж үзээгүй байсан. Гэвч тэндхийн нэлээд хэдэн итгэгч нарыг таньдаг байсан нь 16 дугаар бүлгээс харагдана. Тухайн үеийн христитгэгчид хавчлага зовлон эсвэл сайнмэдээ тараах ажил эсвэл өөрсдийн ажлын онцлогоос болж байнга шилжиж нүүдэг байсан. Ромд байсан эдгээр итгэгч иудей ба харь үндэстнүүдээс бүрэлдэж байв.

Эцэст нь Паул М.Э 60 онд Ромд очсон. Гэвч хүсэж байсан шигээ биш, харин Христ Есүсийн төлөөх хоригдол болж очсон.

Ром ном бол сонгодог бүтээл. Үүнд хараахан аврагдаагүй хүмүүст гэмтэй, төөрөлдсөн байдлыг нь ойлгуулж, тэдний авралын төлөөх Бурханы зөв шударга төлөвлөгөөг тодорхой харуулж өгдөг. Шинэ итгэгчид эндээс Христийн дотор хэн гэдгээ ойлгож, Ариун Сүнсний хүч чадлаар байгуулдаг ялалтыг сурдаг. Төлөвшсөн итгэгчдийн хувьд христитгэлийн үнэнийг сургаал, эш үзүүлэлэг, практик амьдралын хувьд

өргөн цар хүрээтэй авч үзсэн энэ ном дуусашгүй баяр хөөрийг өгдөг.

Тус захиаг Паул нэр нь дурдагдаагүй сөргөлдөгчтэй явуулсан харилцан яриа гэж үзвэл ромчуудад бичсэн захидлыг ойлгоход маш тустай. Сайнмэдээг тунхаглаж байхад нь сайнмэдээний эсрэг янз бүрийн маргаан гаргаж ирж байгааг сонсоод Паул хариулж байгаа мэт байдаг. Элч Паул эсэргүүцэгчийн асуултад нэг нэгээр нь хариу өгчээ. Тийнхүү тэдгээр асуултад хариулж дуусах үедээ Паул Бурханы нигүүлслийн сайнмэдээний талаар хүмүүсийн зүгээс гарган тавьж болох бүх гол асуултад хариулсан байна.

Зарим хэсэгт сөрөг үгийг тодорхой дурдсан бол зарим хэсэгт нь битүү утгаар гаргажээ. Тодорхой дурдсан, битүү цухуйлгасан аль нь ч бай бүгдээрээ сайнмэдээ буюу хуулийн үйлсээр биш харин Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжин нигүүлслээр ирдэг авралын тухай сайнмэдээний эргэн тойронд эргэлдэж байна.

Бид Ром номыг арван нэгэн үндсэн асуултад хариу өгч байна гэж үзэх болно: (1) Захидал юуны тухай бичсэн бэ? (1:1, 9, 15, 16); (2) Сайнмэдээ гэж юу вэ? (1:1-17); (3) Хүнд яагаад сайнмэдээ хэрэгтэй вэ? (1:18-3:20); (4) Сайнмэдээний дагуу ариун Бурхан бурханлаг бус нүгэлтнийг хэрхэн зөвтгөдөг вэ? (3:21-31); (5) Сайнмэдээ нь Хуучин гэрээнд нийцэх үү? (4:1-25); (6) Зөвтгөгдөх нь итгэгчдийн амьдралд ямар ашигтай вэ? (5:1-21); (7) Итгэлээр дамжин

нигүүлслээр ирдэг авралын тухай сургаал гэмт амьдралыг зөвшөөрдөг, тэр ч байтугай хөхүүлэн дэмждэг үү? (6:1-23); (8) Христэд итгэгчдэд Бурханы хууль ямар хамаатай вэ? (7:1-25); (9) Христэд итгэгч хүн хэрхэн ариун амьдрах боломжтой болдог вэ? (8:1-39); (10) Сайнмэдээ иудейчүүд ба харь үндэстнүүдийн аль алинд авралыг амлаж байгаа нь Бурхан өөрийн ард түмэнд (иудейчүүдэд) өгсөн амлалтаа цуцалсан гэсэн үг үү? (9:1-11:36); (11) Нигүүлслээр зөвтгөгдсөн хүмүүс өдөр тутам тулгардаг амьдралын асуудалд хэрхэн хандах ёстой вэ? (12:1-16:27).

Дээрх арван нэгэн асуулт, тэдгээрт өгсөн хариултыг мэдэж авснаар энэхүү чухал захидлын талаар сайн мэдлэгтэй болж чадна. “Ромчуудад бичсэн захидал юуны тухай вэ?” хэмээх эхний асуултын хариу нь мэдээж “сайнмэдээ”. Паул цаг алдалгүй шууд гол асуудал уруу оржээ. Эхний арван зургаан ишлэлд Паул дөрвөн удаа үүнийг дурдсан (1, 9, 15, 16 дугаар ишлэлүүд).

Эндээс хоёр дахь асуулт урган гарна. “Сайнмэдээ гэж юу вэ?” Элч Паул 1-17 дугаар ишлэлд сайнмэдээний талаар зургаан чухал баримтыг бидэнд хэлж байна: (1) Сайнмэдээ Бурханаас эхтэй (1-р ишлэл); (2) Сайнмэдээг Хуучин гэрээний эш үзүүлэгчүүдэд урьдаас амласан (2-р ишлэл); (3) Сайнмэдээ нь Бурханы Хүү, Эзэн Есүс Христийн тухай байдаг (3-р ишлэл); (4) Сайнмэдээ нь Бурханы аврах хүч

чадал мөн (16-р ишлэл); (5) Сайнмэдээ нь иудейчүүд төдийгүй харь үндэстнүүд, бүх хүн төрөлхтөнд зориулагдсан (16-р ишлэл); (6) Сайнмэдээг зөвхөн итгэлээр хүлээн авах боломжтой (17-р ишлэл). Үүгээр танилцуулгаа өндөрлөөд хамтдаа Ром номыг ишлэл нэг бүрээр нь дэлгэрэнгүй үзье.

ТОЙМ

I. СУРГААЛ: БУРХАНЫ САЙНМЭДЭЭ (1-8-р бүлэг)

- А. Сайнмэдээний танилцуулга (1:1-15)
- Б. Сайнмэдээний тодорхойлолт (1:16, 17)
- В. Бүх нийтэд сайнмэдээ хэрэгтэй (1:18-3:20)
- Г. Сайнмэдээний үндэс суурь, түүний шаардлага (3:21-31)
- Д. Сайнмэдээ ба Хуучин гэрээний нийцэл (4-р бүлэг)
- Е. Амьдралд өгөх сайнмэдээний ашиг тус (5:1-11)
- Ё. Адамын нүглийг ялсан Христийн ялалт (5:12-21)
- Ж. Ариун амьдрах сайнмэдээний арга (6-р бүлэг)
- З. Бурханы хууль итгэгчдийн амьдралд эзлэх байр суурь (7-р бүлэг)
- И. Ариун амьдрах хүч чадал нь Ариун Сүнс (8-р бүлэг)

II. ТӨЛӨВЛӨГӨӨТ ЦАГ ҮЕ: САЙНМЭДЭЭ БА ИЗРАЙЛЬ (9-11-р бүлэг)

- А. Израилийн өнгөрсөн үе (9-р бүлэг)
- Б. Израилийн одоо үе (10-р бүлэг)
- В. Израилийн ирээдүй үе (11-р бүлэг)

III. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА: САЙНМЭДЭЭ БОДИТ АМЬДРАЛ ДЭЭР (12-16-р бүлэг)

- А. Хувь хүний ариусал (12:1, 2)
- Б. Сүнслэг бэлгүүдийн үйлчлэл (12:3-8)
- В. Нийгэмд хандах байдал (12:9-21)
- Г. Төр засагт хандах байдал (13:1-7)
- Д. Ирээдүйд хандах байдал (13:8-14)
- Е. Бусад итгэгчдэд хандах байдал (14:1-15:13)
- Ё. Паулын төлөвлөгөө (15:14-33)
- Ж. Зарим хүнийг талархан танилцуулсан нь (16-р бүлэг)

ТАЙЛБАР

I. СУРГААЛ: БУРХАНЫ САЙНМЭДЭЭ (1-8 дугаар бүлэг)

A. Сайнмэдээний танилцуулга (1:1-15)

1:1 Паул өөрийгөө худалдагдсан (Христ Есүсийн боол гэдэг үгэнд энэ утга битүү харагддаг), дуудагдсан (Дамаск уруу явж байх замд Аврагч Есүсийн онцгой төлөөлөгч, элч болохоор дуудагдсан), тусгаарлагдсан (харь үндэстнүүдэд сайнмэдээг хүргэхийн төлөө тусдаа гарсан [Үйлс 9:15, 13:2-ыг хар]) хүн хэмээн танилцуулж байна. Бид мөн ялгаагүй Христийн үнэт цусаар худалдагдаж, Түүний аврах хүч чадлыг гэрчлэхээр дуудагдан, сайнмэдээг хаа явсан газартаа ярихаар тусдаа гарсан хүмүүс билээ.

1:2 Өөрийнх нь захиаг уншиж байгаа иудей хүн сайнмэдээг цоо шинэ зүйл, сүнслэг өв уламжлалтай нь холбоогүй хэмээн үзэх вий гэсэндээ Хуучин гэрээний эш үзүүлэгчид тодорхой мэдэгдлээр (Дэд хууль 18:15; Исаиа 7:14; Хабаккук 2:4) ба билэгдлээр (жишээ нь Ноагийн хөвөгч авдар, гуулин могой, тахилын тогтолцоо) сайнмэдээг амлаж байсан гэдгийг Паул дурдсан.

1:3 Тэрхүү сайнмэдээ нь махан биеэр (хүний хувьд) Давидын удмаас төрсөн, Бурханы Хүү, бидний Эзэн Есүс Христийн тухай юм. Махан

биеийн хувьд гэдэг нь манай Эзэн зөвхөн хүн байгаагүй гэдгийг илтгэдэг. *Хүний хувьд* хэн байсныг ойлгуулдаг. Хэрэв Христ зөвхөн хүн байсан бол, заавал түүнийг нь онцлоод байх шаардлага байхгүй. Гэвч тэр зөвхөн хүн байгаагүй гэдгийг дараагийн ишлэлд харуулсан.

1:4 Эзэн Есүс **сүр хүчээр Бурханы Хүү** гэж тодорхойлогдсон. Энэ хэсэгт **ариун байдлын Сүнс** гэгдсэн Ариун **Сүнс** Есүсийг баптисм хүртэх үед, бас гайхамшигт үйлсээр дүүрэн үйлчлэлийнх нь туршид түүнийг тодорхойлж байсан. Ариун Сүнсний¹ хүч чадлаар хийж байсан Аврагч Есүсийн хүчирхэг гайхамшгууд түүнийг Бурханы Хүү гэдгийг нь гэрчилж байв. **Үхэгсдээс амилснаар сүр хүчээр Бурханы Хүү гэж тодорхойлогдсон** гэснийг уншихдаа бид шууд Есүсийн өөрийнх нь амилалтыг боддог. Гэхдээ үүнээс гадна “үхэгсдээс амилуулснаар” гэсэн утга бий. Тэгэхээр элч Паул үүнийг бичиж байхдаа Иаирын охин, Найн хотын бэлэвсэн эмэгтэйн хүү, Лазар гэх мэт хүмүүсийг Христ үхлээс амилуулсан талаар бодож байсан байх магадлалтай. Гэхдээ Эзэний өөрийнх нь амилалт гэх утга голлох байрыг эзэлж байгаа нь эргэлзээгүй.

Есүс бол **Бурханы Хүү** гэсэн нь Есүс бол бусдаас тэс ондоо Хүү гэж байгааг ойлгох хэрэгтэй. Бурханд олон хүү байдаг. Бүх итгэгч нар түүний хөвгүүд мөн (Галат 4:5-7). Тэнгэр элч нарыг хүртэл Бурханы хөвгүүд гэж нэрлэдэг (Иов 1:6; 2:1). Харин Есүс онцгой байдлаар

Бурханы Хүү. Эзэн Есүс Бурханыг өөрийнхөө Эцэг гэж нэрлэх үед өөрийгөө Бурхантай эн тэнцүү байр сууринд тавьж байгааг иудейчүүд зөв ойлгож байсан (Иохан 5:18).

1:5 Паул Есүс Христээр **дамжуулан нигүүлсэл** (хүртэх зохисгүй Паулд авралыг өгсөн хайр ивээл) **ба элчийн үүргийг хүлээн авсан билээ. Бид...нигүүлсэл ба элчийн үүргийг хүлээн авсан билээ** гэж хэлэхэд хэрэглэсэн *бид* гэдэг үг угтаа бол зөвхөн Паулыг өөрийг нь зааж байгаа нь тодорхой байна. Тэрээр **харь үндэстнүүдийн** төлөөх **элчийн үүргийг** бусад элч нарт биш зөвхөн өөртөө хамааруулдаг. Паул бүх үндэстний хүмүүсийг итгэлийн дуулгавартай байдалд буюу гэмшил ба Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр (Үйлс 20:21) сайнмэдээний сургаалыг дагах дуулгавартай байдалд дуудах үүрэг авсан. Бүх дэлхий даяар сайнмэдээг тунхаглах энэхүү ажлын зорилго нь Есүсийн нэрийн төлөө бөгөөд түүний таалалд нийцүүлж, түүнд алдар хүндлэлийг авчрах явдал байлаа.

1:6 Хүмүүсийн **дундаас** сайнмэдээнд итгэгсдийг Паул **Есүс Христийнх болохоор дуудагдсан** гэж нэрлэсэн нь тэдний авралыг Бурхан санаачилсан гэдгийг онцолж байгаа юм.

1:7 Захидлыг **Ромд** байгаа **бүх** итгэгч нарт буюу (бусад захидал шиг) ганц чуулганд хаяглаагүй. Энэ захидлын сүүлийн бүлгээс харахад Ром хотод итгэгч нарын цугладаг хэд

хэдэн газар байсан аж. Тиймээс энэ мэндчилгээ тэднийг бүгдийг нь хамарч байна.

Ариун хүмүүс байхаар дуудагдсан Бурханы хайртай хүмүүс. Сэтгэлд дотно энэ хоёр үг Христийн цусаар зольж аврагдсан бүх хүнд хамаатай юм. Тааллыг олсон тэдгээр хүмүүсийг Бурхан онцгойгоор хайрладаг бөгөөд өөртөө зориулан энэ дэлхийгээс тусгаарласан ажээ. Үүнд **ариун** гэсэн утга оршиж байна.

Паулын байнга хэрэглэдэг мэндчилгээнд **нигүүлсэл ба амар тайван** хоёулаа ордог. **Нигүүлсэл** (*харис*) гэдэг нь грек мэндчилгээ бол **амар тайван** (*шалом*) гэдэг нь иудейн уламжлалт мэндчилгээ. Паулын тунхагладаг мэдээнд иудейчүүд ба харь үндэстнийг Христ дотор нэг шинэ хүн болсныг өгүүлдэг учраас энэ хоёрыг хамтад нь хэрэглэж байгаа нь туйлын тохиромжтой юм.

Энд дурдсан **нигүүлсэл** бол аврал өгдөг нигүүлсэл биш (Паулын захидлыг уншиж байсан хүмүүс аврагдсан хүмүүс байсан) харин Христэд итгэдэг хүний амьдрал, үйлчлэлийг зэвсэглэж, хүчирхэгжүүлдэг **нигүүлсэл** юм. Энд дурдсан **амар тайван** нь Бурхантай тогтоосон энх тайван биш (эдгээр ариун хүмүүс итгэлээр зөвтгөгдөн тэрхүү амар тайвныг авчихсан байсан) харин боргилсон нийгмийн дунд амьдарч байгаа итгэгчдийн сэтгэл зүрхэнд ноёлдог Бурханы **амар тайван** юм. **Бидний Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христээс нигүүлсэл ба амар тайван нь байх болтугай** гэж хэлэх

үедээ Паул Хүүг Эцэгтэй эн тэнцүү байр сууринд тавьсан байна. Хэрэв Есүс жирийн нэг хүн байсан бол Есүсийг Эцэгийн нэг адил нигүүлсэл ба амар тайвныг соёрхогч болгож Эцэгтэй эн тэнцүүлэн тавих нь утгагүй зүйл болох байсан. Хэрэв тийм бол энэ нь “Эцэг Бурхан ба Абрахам Линкольноос нигүүлсэл ба амар тайван байх болтугай” гэж хэлсэнтэй адил болно.

1:8 Боломж гарах бүрд Паул өөрийн уншигчдын талаар магтууштай зүйлсийг онцлон тэмдэглэснээр захидлаа эхлүүлдэг байсан. (Бид бүхэнд ямар хэрэгтэй сайн үлгэр дууриал вэ!) Энд Ром дахь Христэд итгэгчдийн **итгэл бүх ертөнц даяар** тунхаглагдаж байгаад Паул Зууч **Есүс Христээр дамжуулан Бурхандаа** талархсан. Тэдний итгэлийн гэрчлэл Ромын эзэнт гүрэн даяар яригдаж байлаа. Газар дундын тэнгис орчмоор амьдарч байсан тухайн үеийн хүмүүс Ромын Эзэнт гүрнийг **бүх ертөнц** гэж үздэг байв.

1:9 Ромын христитгэгчид өөрсдийн гэрлийг хүмүүсийн өмнө тусгасан учраас Паул тэдний төлөө **тасралтгүй** залбирдаг байжээ. Түүний залбирлын гэрч бол **Бурхан** юм гэж Паул хэлсэн. Учир нь тийнхүү залбирдгийг нь өөр хэн ч мэдэхгүй. Гэхдээ **Бурхан** мэдэж байв. **Хүүгийнх нь сайнмэдээнд сүнсээрээ** үйлчилдэг Бурхан л мэднэ. Паул **сүнсээрээ** үйлчилдэг байжээ. Шашны янз бүрийн уйтгартай ёслол, давтаж уншдаг залбирал, элдэв

зан заншлаар биш, харин халуун сэтгэл, итгэл дүүрэн залбирлаар үйлчилдэг ажээ. Түүний үйлчлэл сайн дураар, өөрийгөө бүрэн зориулж, шантралгүйгээр Эзэн Есүсийг дээд зэргээр шүтэн хайрладаг сүнсээр дүрэлзсэн гал агаад Бурханы Хүүгийн сайнмэдээг олон хүнд мэдүүлэх гэсэн шатсан тэмүүлэл байв.

1:10 Паул Ромд байсан ариун хүмүүсийн төлөө Бурханд талархахаас гадна тун удахгүй тэдэн дээр очихын төлөө залбирдаг байв. Бусад зүйл дээр ч тэр, энд ч тэрээр **Бурханы хүслийн** дагуух аялал байгаасай гэж хүссэн.

1:11 Элч Паулын туйлын хүсэл нь ариун хүмүүсийн сүнслэг байдалд тусалж, тэднийг итгэлээр **бат болгох** явдал байлаа. Энд ямар нэгэн “хоёр дахь ерөөл”-ийн талаар, аль эсвэл гар тавьж сүнслэг бэлэг өгөх тухай (тэрээр 2Тм 1:6-д Тимот дээр үүнийг үйлдсэн хэдий ч) ярьж байгаа юм биш. Харин үгийн үйлчлэлээр **сүнслэг** өсөлтөд нь туслах тухай ярьж байна.

1:12 Цааш нь тэр **хэн хэндээ** ивээл болох тухай ярьсан. Паул Ромын итгэгч нарын **итгэлээр**, Ромын итгэгч нар Паулын **итгэлээр зоригжино** гэжээ. Бүгд бие биенээ босгон байгуулдаг хамт олны дотор сүнслэг өсөлт дүүрэн байдаг. “Төмөр төмрийг ирлэдэг. Тийнхүү хүн хүнээ хурцалдаг” (Сургаалт үгс 27:17). Паулын даруу, зөөлөн зан хандлагыг бид эндээс харах хэрэгтэй. Тэр бусад итгэгч нарынхаа тусламжийг авахааргүй тийм дээгүүр зантай хүн биш байжээ.

1:13 Паул Ромд очихыг **олон удаа төлөвлөсөн** боловч **саад тотгортой** байсан. Өөр чухал ажил байсан учраас, эсвэл Ариун Сүнс саатуулсан учраас, эсвэл Сатаны эсэргүүцсэн учраас саад тотгор болсон байж магадгүй. Ямартай ч Паул **бусад үндэстнүүдийн дунд олсны адил зарим үр дүнг** Ромд олохыг хүсэж байжээ. Энд тэрбээр сайнмэдээний **үр дүнг** талаар ярьж байгаа нь дараагийн хоёр ишлэлээс харагддаг. 11, 12 дугаар ишлэлд тэрээр Ромын христитгэгчдийн итгэлээр батжихыг хармаар байгаагаа хэлсэн бол энэ ишлэлд Ромын эзэнт гүрний нийслэлд Христ рүү сүнснүүдийг авчрахыг хүсэж байгаагаа өгүүлж байна.

1:14 Христийг хүлээн авсан хүмүүст энэ дэлхийн хамгийн гүн хэрэгцээг шийдэх хариулт байгаа. Тэдэнд нүгэл хэмээх өвчнийг эдгээх ерөндөг, мөнх тамын аймшгаас зайлах арга зам, Бурхантай хамт үүрд хамт жаргах баталгаа бий. Тийм учраас итгэгч хүн бүх үндэстэн ястан (**грекчүүд болон бусад үндэстэн**), янз бүрийн боловсролын хүмүүст (**мэргэн ба мунхаг хүмүүс**) сайнмэдээ хуваалцах ажил эрхэм үүрэг болдог. Паул энэ үүргийг хурц мэдэрч байв. Тэрээр **“би өртэй”** гэжээ.

1:15 Тэрхүү өрөө төлөхийн тулд Паул Бурханы өгсөн хүч чадлаар **Ромд** байгаа хүмүүст **сайнмэдээг тунхаглахыг хүсэж** байлаа. Хэдийгээр Паул Ромд байгаа итгэгчдэд сайнмэдээ тунхаглана гэж байгаа мэт тус ишлэлээс ойлгогдож байгаа боловч тэд

сайнмэдээг аль хэдийн хүлээгээд авчихсан байсан учраас итгэгчдэд биш гэдэг нь мэдээж ойлгомжтой. Харин Ром хотын үл итгэгч харь үндэстнүүдэд сайнмэдээг тунхаглахыг хүсэж байсан нь дамжиггүй.

Б. Сайнмэдээний тодорхойлолт (1:16, 17)

1:16 Хэдийгээр сайнмэдээ нь иудейчүүдийн хувьд бүдрэх чулуу, грекчүүдийн хувьд мунхаглал байсан боловч Паул Бурханы сайнмэдээг өндөр мэдлэгтэй Ром хотынхонд хүргэхээс **ичээгүй**. Яагаад гэвэл сайнмэдээ **авралд хүргэх Бурханы хүч** чадал гэдгийг Паул мэдэж байлаа. Хүүд нь итгэсэн хүн бүрийг Бурхан хүч чадлаараа хэрхэн авардгийг сайнмэдээ тунхагладаг. Энэ хүч чадал иудейчүүд ба грекчүүдийн хэн хэнд нь адилхан нөлөөлдөг.

Юуны түүрүүнд Иудей, мөн түүнчлэн Грек хүнийг гэсэн дараалал Үйлс номын цаг хугацааны үед түүхэн биеллээ олсон. Өнө эрт цагт Бурханы сонгож авсан ард түмэн болох иудейчүүдэд сайнмэдээг хүргэх үүрэг хариуцлага одоо ч гэсэн бидэнд байгаа боловч харь үндэстнүүдэд хүрэхийнхээ өмнө заавал тэднээс эхлэх ёстой гэсэн үг биш ээ. Өнөөдөр Бурхан иудейчүүд ба харь үндэстнүүдтэй ижил түвшинд харьцдаг бөгөөд хүргэж байгаа мэдээ ба цаг хугацаа нь бүгдэд ижил байна.

1:17 Зөвт байдал гэдэг үг тус захидалд хамгийн анх энд гарч байгаа учраас бид үүний утгыг авч үзэхийн тулд хэсэг зогсох болно. Энэ үг Шинэ гэрээнд хэд хэдэн янзаар хэрэглэгдсэн байдаг. Гэхдээ бид гурван хэлбэрийг нь авч үзнэ.

Нэгд, Бурханы зөвт байдал гэдэг нь зөв, шударга, зохистой зүйлсийг үргэлж үйлддэг, өөрийнхөө бусад мөн чанартай зөрчилддөггүй Бурханы зан чанарыг тодорхойлоход хэрэглэгддэг. Бурхан бол зөвт нэгэн гэж хэлэх үед түүнд ямар ч буруу зүйл, шударга бус явдал, худал хуурмаг байхгүй гэдгийг илтгэж байдаг.

Хоёрт, Бурханы зөвт байдал гэдэг нь бурханлаг бус нүгэлтнүүдийг зөвтгөх Бурханы арга замыг илэрхийлдэг. Тэр зөв шударга мөн чанараа алдахгүйгээр хийж чадна. Яагаад гэвэл ямар ч гэм нүгэлгүй Есүс золиос болсноор тэнгэрлэг шударга ёсны шаардлагыг бүрэн биелүүлсэн билээ.

Эцэст нь, Бурханы зөвт байдал гэдэг нь Хүүд нь итгэсэн хүмүүст Бурханаас өгдөг төгс байр суурийг хэлдэг (2Коринт 5:21). Зөвт бус хүмүүс өөрсдийн хүчээр зөвт байдалд хүрч чадахгүй ч төгс Христийн дотор хорогдвол Бурхан тэднийг зөвт хүн гэж хардаг. Нэг ёсондоо зөвт Христийн зөвт байдал тэдний данс уруу шилжиж, тэд зөвт хэмээн тооцогдоно гэсэн үг юм.

Тэгвэл энэ гурвын аль нь 17-р ишлэлийн утга вэ? Энэ гурвын аль алианаар ойлгож болж байна. Гэхдээ нүгэлтнүүдийг итгэлээр зөвтгөх

Бурханы арга зам гэдгийг илүүтэй хэлж байх шиг.

Бурханы зөвт байдал сайнмэдээн дотор илчлэгдсэн. Нэгдүгээрт сайнмэдээ Бурханы зөвт байдал нүглийг шийтгэхийг шаарддаг бөгөөд шийтгэл нь мөнхийн үхэл гэдгийг хэлдэг. Тэгтэл Бурханы хайр тэрхүү зөвт байдлын шаардсаныг хангаж өгсөн гэдгийг бид сонсож байна. Бурхан өөрийн Хүүгээ илгээн нүгэлтнүүдийн оронд үхүүлж шийтгэлийг бүрэн төлсөн. Харин одоо түүний зөвт байдлын шаардлага бүрэн ханасан учраас Христийн хийсэн ажилд өөрсдийгөө хамаатуулж байгаа бүх хүнийг Бурхан зөв шударгаар аврах боломжтой болсон.

Бурханы зөвт байдал **итгэлээс итгэлд илчлэгдсэн. Итгэлээс итгэлд** гэдэг үг дараах утгуудыг илэрхийлэх боломжтой: (1) Бурханы итгэмжит байдлаас бидний итгэлд; (2) Итгэлийн нэг түвшнөөс нөгөө түвшинд; (3) Эхнээс нь дуустал итгэлээр. Сүүлийн гурав дахь утга энд явж байгаа болов уу. Бурханы зөвт байдал ажил үйлсэд тулгуурлан өгөгдөхгүй. Бас хичээл зүтгэлээрээ зөвт байдалд хүрэхийг оролдож байгаа хүмүүст өгөгдөхгүй. Энэ нь зөвхөн итгэлийн зарчим дээр илчлэгддэг. Энэ нь Хабаккук 2:4 дээрх **“Зөвт хүн итгэлээр амьдарна”** гэсэн тэнгэрлэг зарлигтай төгс уялддаг. Үүнийг өөрөөр бас **“Итгэлээр зөвтгөгдсөн хүмүүс амьдрах болно”** гэж ойлгож болно.

Ром номын эхний арван долоон ишлэлд Паул гол сэдвээ танилцуулж, зарим үндсэн ойлголтуудыг товчхон дурдсан. Харин одоо Паул гурав дахь үндсэн асуулт уруу орж байна: “Хүмүүст яагаад сайнмэдээ хэрэгтэй вэ?”. Энэ асуултад товчхон хариулбал: Сайнмэдээ байхгүй бол хүмүүс үнэнээс төөрч, мөхлийн зам уруу явж байдаг. Эндээс дөрвөн дэд асуулт гарч ирнэ: (1) Сайн мэдээ хэзээ ч сонсож байгаагүй үндэстнүүд мөхөл рүү явж байгаа юу? (1:18-32); (2) Иудейчүүд ба харь үндэстнүүдийн доторх өөрсдийгөө зөвт шударга, ёс суртахуунлаг гэж үздэг хүмүүс мөхөл рүү явж байгаа гэж үү? (2:1-16); (3) Бурханы эртний ард түмэн болох иудейчүүд мөхөл рүү явж байгаа гэж үү? (2:17-3:8); (4) Бүх хүн төрөлхтөн мөхөл рүү явж байгаа гэж үү? (3:9-20).

В. Бүх нийтэд сайнмэдээ хэрэгтэй (1:18-3:20)

1:18 Энд “Хүмүүст яагаад сайнмэдээ хэрэгтэй вэ?” хэмээх асуултын хариу байна: “Сайнмэдээ байхгүй бол хүмүүс төөрөлдсөн, мөхөл рүүгээ явж байгаа бөгөөд **үнэнийг** зөвт бус байдлаар болон зөвт бус амьдралаараа **дарагч хүмүүсийн хорон муу байдлын эсрэг Бурханы уур хилэн тэнгэрээс илчлэгддэг**. Тэгвэл Бурханы уур хилэн хэрхэн **илчлэгддэг вэ?** Бурханы уур хилэн хэрхэн илчлэгддэг талаар ийм хариулт өгчээ: Бурхан хүнийг бузар байдал (1:24), гутамшигт хүсэл тачаал (1:26), завхарсан

сэтгэлд (1:28) нь зөнд нь орхисон. Гэхдээ үүний хажуугаар Бурхан хүн төрөлхтний түүхэнд хааяа орж ирж, хүний гэм нүгэлд маш дургүйцэж байгаагаа харуулдаг. Жишээлбэл усан галав (Эхлэл 7-р бүлэг); Содом, Гоморра хотуудын мөхөл (Эхлэл 19-р бүлэг); Кора, Датан, Абирам нарын шийтгэл (Тооллого 16:32).

1:19 “Сайнмэдээ хэзээ ч сонсож байгаагүй үндэстнүүд төөрөлдсөн гэж үү?” Паулын бичсэнээс харвал үүнд “гийм” гэж хариулна. Гэхдээ өөрсдөд нь байхгүй мэдлэгээс болж биш, харин байгаа атлаа хүлээн авахаас татгалзсан гэгээрлээс болж тэд төөрч одсон юм. Бүтээлийн дотор **Бурханы тухай мэдэж болох зүйлс тэдэнд илчлэгдсэн байдаг.** Бурхан өөрийнхөө тухай илчлэлтийг тэдэнд үлдээсэн.

1:20 **Ертөнц бүтээгдсэнээс хойш Бурханы үл үзэгдэх хоёр чанар** бүгдийн нүдэнд ил харагдаж байсан: **Түүний мөнх хүч ба бурханлаг чанар.** **Бурханлаг чанар** гэдэг нь Бурханы оршин байгааг биш, харин түүний мөн чанар, сүр жавхланг хэлж байна.

Энд нэг зүйл тодорхой байна: Бүтээл байгаа бол Бүтээгч байх ёстой. Зохицол нийцэлтэй аливаа зүйлс Зохион бүтээгчтэй байх ёстой. Нар, сар, оддыг хараад хэн ч байсан Бурхан байгааг мэдэж чадна.

Тэгвэл “сайнмэдээг сонсоогүй үндэстнүүд яах вэ?” гэдэг асуултын хариу нь: **Тэдэнд шалтаг байхгүй.** Бурхан бүтээлийн дотор өөрийгөө илчилсэн боловч хүмүүс тэрхүү илчлэлтийг

хүлээн авахаас татгалзсан. Тийм учраас хэзээ ч сонсож байгаагүй Аврагчийг хүлээн аваагүйнхээ төлөө яллагдах бус, харин Бурханы тухай мэдэж болох байсан зүйлийг үл ойшоосныхоо төлөө яллагдах болно.

1:21 Тэд хийсэн зүйлсээр нь **Бурханыг мэдсэн атлаа** хэн гэдэгт нь **түүнийг алдаршуулаагүй**, хийсэн зүйлийнх нь төлөө түүнд талархал өргөөгүй. Харин өөр бурхдын тухай **хоосон** философи, гүн ухаан өөрсдөдөө бий болгож, үр дүнд нь тодорхой харах, бодох чадвараа гээсэн. “Гэгээрлийг хүлээн авахаас татгалзсан бол тэр нь өгөгдөхгүй”. Харахыг хүсэхгүй байгаа хүмүүс харах чадвараа гээдэг.

1:22 Хүн өөрийн бий болгосон мэдлэгтээ хэт бардах тусам, төдий чинээгээр харанхуй, утгагүй байдалдаа улам гүн шигдэж байлаа. Бурханы мэдлэгийг хүлээн авахаас татгалзаж байгаа хүмүүст хоёр шинж тэмдэг үргэлж дагалддаг: тэд аймшигтай биеэ тоож, үүний зэрэгцээ мунхаг харанхуй болдог.

1:23 Доод түвшний хэлбэрээс ахиж дэвшиж, сайжирдаг гэсэн онолын эсрэгээр эртний хүмүүс өндөр цадиг журамтай байсан. Үнэн, хязгааргүй, **үл муудах Бурханыг** хүлээн авахаас татгалзсаны улмаас хүн төрөлхтөн хуурамч шүтээн шүтэхэд дагалддаг тэнэгрэл, завхрал уруу уруудан доройтсон. Энэ хэсэг бүхэлдээ эволюцын онол худал болохыг харуулж байна.

Хүн төрөлхийн шашинлаг ажээ. Түүнд мөргөж, хүндэтгэх объект зайлшгүй шаардлагатай байдаг. Хүн амьд Бурханыг хүндлэн дээдлэхээс татгалзах үедээ **хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад, мөлхөгчид** буюу хэвлээр явагчдын дүртэй мод чулуун бурхдыг өөрсдөдөө бий болгосон. **Хүн, шувууд, дөрвөн хөлт амьтад, мөлхөгчид** гэсэн нь уруудах дараалалтай байгааг анхаараарай. Хүн юуг шүтэж мөргөнө түүнтэйгээ адилхан болдог. Бурханыг үзэх хүний үзэл ойлголт доройтох тусам ёс суртахууных нь хэм хэмжээ ч мөн доройтдог. Хүн хэвлээр явагч амьтныг бурхнаа болговол өөрийгөө дураараа амьдарч болно гэж үздэг. Ер нь бол хүн хүндлэн мөргөж байгаа зүйлээсээ өөрийгөө доор гэж тооцдогийг санах хэрэгтэй. Бурханы дүр төрхөөр, Бурхантай адил байдлаар бүтээгдсэн хүн өөрийгөө могойноос доор тавьсан байна!

Шүтээн шүтэж байгаа хүн чөтгөрүүдийг шүтэж байгаа хэрэг юм. Харь үндэстнүүдийн шүтээндээ тахил болгон өргөж байгаа зүйлс үнэндээ чөтгөрүүдэд өргөж байгаа хэрэг юм гэдгийг Паул тодорхой мэдэгдсэн (1Коринт 10:20).

1:24 Бурхан хүнийг зөнд нь орхисон гэж гурван удаа хэлжээ. Бурхан **хүнийг бузар байдал** (1:24), гутамшигт хүсэл тачаал (1:26), завхарсан сэтгэлтэй (1:28) нь **зөнд нь орхисон**. Өөрөөр хэлбэл хүний бүх мөн чанарт Бурхан уурлан хилэгнэсэн.

Хүний зүрх сэтгэл дэх бузар муу хүсэл тачаалынх нь хариуд Бурхан тэднийг гетеросексийн (эсрэг хүйстний бэлгийн харилцаа) бузар байдал болох завхайрал, хууль бус эр эмийн харьцаа, садар самуун, биеэ үнэлэлт, янхандалт гэх мэт бузар булай явдалд нь хаясан. Тэд зөвхөн бэлгийн дур ханамж авах гэж л амьдрах агаад энэ нь эргээд **өөрсдийнхөө махан биеийг гутаахад хүргэдэг.**

1:25 Бурхан хүнийг ийнхүү зөнд нь орхисон шалтгаан юу гэвэл хүн эхлээд Бурханы тухай **үнэнийг** хаяж, хуурамч шүтээний **худал хуурмагаар сольсон** явдал юм. Шүтээн бол худал хуурмаг бөгөөд Бурханыг хуурамчаар дүрслэх явдал мөн. Шүтээн шүтэгч нь үнэндээ **бүтээлийн** дүр төрхийг шүтэж мөргөдөг учраас үүгээрээ **Бүтээгчийг** үл хүндэтгэн, доромжилж буй хэрэг билээ. Бурхан доромжлолыг бус, харин үүрд мөнхөд алдар, хүндлэлийг хүртэх зохистой **Бүтээгч** мөн.

1:26 Яг энэ шалтгааны улмаас **Бурхан** хүнийг ижил хүйстэнтэйгээ бэлгийн харилцаанд ордог бузар явдалд нь **зөнд нь орхисон**. **Эмэгтэйчүүд** ичиж зовох зүйлгүйгээр эмэгтэй хүнтэйгээ төрөлх бус бэлгийн харилцаанд ордог болсон.

1:27 **Эрчүүд** төрөлх, зүй ёсны харилцаагаа гэж содомчлох (ижил хүйстэн) болсон. Тэд Бурханы тогтоосон гэрлэлтийн харилцааг эвдэж өөр **эрчүүдийн** хойноос **тэмүүлэх хүсэлдээ шатаж** гомосекс хийдэг болсон. Гэвч тэдний гэм нүгэл өөрсдийнх нь бие махбод, сүнсэнд

зохих үр дагавраа авчрав. Өвчин, буруутгал, зан чанарын доройтол тэднийг хилэнцэт хорхойн хатгуур мэт хатгадаг. Ийм гэм нүгэлд орооцолдлоо гээд ямар ч шийтгэлгүй мултарна гэсэн ойлголтыг Библийн энэ хэсэг няцааж байна.

Өнөөдөр гомосексийг зарим нь өвчин, зарим нь байж болох амьдралын өөр хэв маяг гэж хэлтрүүлдэг. Христитгэгчид энэ дэлхийн ёс суртахууны хэм хэмжээг хүлээн авалгүй Бурханы үгээр удирдуулахад анхаарах ёстой. Хуучин гэрээнд ийм гэмд үхэх ял оноохыг тушаасан (Леви 18:29, 20:13) байдаг бол энд Шинэ гэрээнд ийм гэм үйлддэг хүн үхвэл зохино (Ром 1:32) гэжээ. Библи гомосексийн харилцааг маш ноцтой гэм нүгэл гэж өгүүлдгийг ижил хүйстэнтэйгээ явалдагчид үймээн дэгдээж байсан Содом, Гоморра хотыг Бурхан бүрэн устгасан түүх (Эхлэл 19:4-25) батална.

Эзэн Есүс Христэд итгэж, гэмшсэн ямар ч нүгэлтэнд уучлал, өршөөлийг амласан сайнмэдээ ижил хүйстэнтэйгээ явалдагчдад ч бас уучлал, өршөөлийг амладаг. Энэхүү жигшим муухай нүгэлд унасан христитгэгчдийн хувьд гэмээ хүлээн зөвшөөрч, түүнээсээ эргэх аваас уучлал, сэргэлтийг хүлээн авах боломжтой. Бурханы үгийг дагахыг хүсэж байгаа бүх хүнд гомосексээс бүрэн чөлөөлөгдөх боломж бий. Ихэнх тохиолдолд байнгын зөвлөгөө, тусламж үүнд маш чухал байдаг.

Зарим хүмүүсийн ижил хүйстнээ сонирхох чиг хандлага төрөлхийнх юм шиг байдаг нь үнэн. Гэм нүгэлд унасан хүний мөн чанар ямар ч хэлбэрийн бузар муу, гажуудлыг үйлдэх чадвартай учраас үүнд гайхах зүйл үгүй. Үүнд татагдах чиг хандлага байгаа нь гэм биш ээ. Харин үүнд бууж өгч, үйлдэх нь гэм юм. Аливаа сорилт, уруу татлагыг эсэргүүцэж, түүнийг бүрэн ялах хүч чадлыг Ариун Сүнс өгдөг (1Коринт 10:13). Коринт хотын христитгэгчдийн зарим нь ижил хүйстэнтэйгээ явалдах амьдралын хэв маягаас салж ангижирсан явдал бол үүнээс чөлөөлөгдөж болдгийн амьд жишээ юм (1Коринт 6:9-11).

1:28 Хүн төрөлхтөн Бурханыг өөрсдийн Бүтээгч, Ханган тэтгэгч, Авран чөлөөлөгч гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан учир есөн бусын бузар булай зүйл үйлдэхэд **Бурхан тэднийг завхарсан сэтгэлтэй нь зөнд нь орхижээ.** Төрөлх хүн яагаад эволюцын онол, сургаалыг дагаж хошуурах болсон талаар гүн ойлголтыг энэ ишлэл өгч байна. Хүн ухаан дутсандаа бус харин хүсэхгүй байгаад гол учир нь байдаг аж. Хүмүүс **Бурханыг хүлээн зөвшөөрөхийг** хүсдэггүй. Эволюцын онолыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй тийм их нотолгоо баримт байдаг учраас биш, харин Бурханыг үгүйсгэхэд хүний үүсэл гарлын тухай ондоо тайлбарыг хүсэж байгаа учраас тэд эволюцын онолыг зөвтгөдөг. Хэрэв Бурхан байх

юм бол тэд Бурханы өмнө ёс суртахууны хариуцлага хүлээнэ гэдгээ мэддэг.

1:29 Энэ хэсэгт хүн Бурханаас холдохоороо үйлддэг нэмэлт гэм нүглийн хар дансыг жагсаажээ. Хүн тэдгээр гэм нүглийг хааяа нэг сонирхож хийдэг биш харин түүнд бүрэн автсан буюу тэдгээрээр *дүүрсэн* болохыг энд дурдсан. Өөрт нь үл тохирох гэм нүгэлд хүн туршлагажсан: **зөвт бус байдал** (шударга бус байдал); **садар самуун**² (гэрлэхээсээ өмнө эр эмийн харьцаанд орох, завхайрах ба бэлгийн бусад хууль бус харилцаа); **хорон муу явдал** (гэмт явдлыг идэвхийлэн үйлдэх); **шунал** (ховдог, ханаж цаддаггүй сэтгэл); **хорон санаа** (бусдад гай тарих хүсэл; хорсол); **атаа жөтөөгөөр дүүрэн** (бусдад жөтөөрхөх); **аллагаар дүүрэн** (уур уцаараар эсвэл гэмт сэдлээр бусдыг санаатайгаар, хууль бусаар алах); **хэрүүлээр дүүрэн** (маргаан, зөрчилдөөн, арцалдаан); **заль мэхээр дүүрэн** (башир ов, итгэл эвдсэн явдал, далд явуулга); **хар санаагаар дүүрэн** (өшөө хорсол, дайсагнал, гомдол); **хов жив яригч** (нууцаар гүжирдэх, цуурхал тараах);

1:30 **гүтгэгч** (илээр гүжирдэх, бусдыг муугаар ярих); **Бурханыг үзэн ядагч** (Бурханд хорсох); **дээрэлхүү** (басамжлан доромжлогч); **их зантай** (ихэмсэг, омог бардам); **сагсуу** (онгиороо ойворгон, өөрийгөө өргөмжлөгч); **хорон мууг санаачлагч** (гай балаг таригч, шинээр муу явдал бий болгогч); **эцэг, эхдээ**

дуулгаваргүй (эцэг эхийн эрх мэдлийг эсэргүүцдэг);

1:31 ухваргүй (сүнслэг байдал ба ёс суртахууны хувьд зөв бурууг ялгах чадваргүй, ухамсаргүй); **найдваргүй** (хувийн ашгийн төлөө хэзээ л бол хэзээ гэрээ хэлэлцээрээ зөрчих, хэлсэн үгнээсээ ухрах); **үл хайрлагч** (жам ёсны үүрэг хариуцлагаа уландаа гишгэдэг); **үл уучлагч**³ (эвлэрдэггүй, цагаан цайлган сэтгэлгүй); **өршөөл үзүүлдэггүй** (зэрлэг балмад, өс санадаг, өрөвдөх сэтгэлгүй).

1:32 Ёс бус бэлгийн харилцаанд ордог (1:24), гажууд бэлгийн харилцаанд ордог (1:26, 27), энд жагсаасан гэм нүглүүдийг үйлддэг (1:29-31) хүмүүс хийж байгаа бүхэн нь буруу гэдгийг дотроо мэдээд зогсохгүй **үхвэл зохино** гэдгээ ч мэддэг. Тэд гэм нүглээ ердийн үзэгдэл болгох, хуульчлан батлахыг хичээгээд ч Бурхан ийм ял тогтоосныг мэддэг. Тэглээ гээд тэд бурханлаг бусын эдгээр хэлбэрийг дагаж мөрдөхөө зогсоодоггүй. Харин ч бусдыг өөгшүүлж, үйлдэхэд нь сайшааж, гэм нүгэлдээ хамтрагч нарыг бий болгодог.

САЙНМЭДЭЭ ХҮРЭЭГҮЙ ҮНДЭСТНҮҮД

Тэгвэл “Сайнмэдээ хэзээ ч сонсож байгаагүй үндэстнүүд мөхсөн гэж үү?” гэдэг асуултад Бурхан ямар хариу өгөх бол? Бурхан өөрийн бүтээлээр дамжуулан үнэнийг ойлгох гэгээрлийг тэдэнд өгсөн боловч тэд Бурханы

өгсөн илчлэлтийн дагуу амьдраагүй учраас яллагдах болно. Тэд Бурханы оронд хуурамч шүтээн шүтэж, эцэст нь завхрал, гажуудалд өөрсдийгөө тушаажээ.

Гэтэл тэдгээр үндэстний дотроос хэн нэгэн Бурханы өгсөн гэгээрлийн дагуу амьдарлаа гэж үзье. Тэрээр хуурамч шүтээнээ шатаан, үнэн Бурханыг хайвал юу болох вэ? Бурхан тэр хүнд хэрхэн хандах вэ?

Энэ асуудалд эвангелийн итгэгч нар хоёр янзын байр суурь баримталдаг.

Нэг хэсэг нь, “Хэрэв хуурамч шүтээн шүтдэг хүн бүтээлээр дамжуулан Бурханы өгсөн гэгээрлийн дагуу амьдарвал Бурхан сайнмэдээнийхээ гэрлийг түүн дээр тусгах болно” гэж үздэг. Үүнд Корнелийг жишээ болгодог. Корнел Бурханыг хайсан. Түүний залбирал ба өглөгүүд Бурханы өмнө дурсгал болжээ. Тиймээс Бурхан Петрийг илгээж, хэрхэн аврагдахыг Корнелд хэлж өгсөн (Үйлс 11:14).

Харин нөгөө хэсэг нь, “Хэрэв хүн бүтээлээр илчлэгдсэний дагуу цорын ганц, үнэн, амьд Бурханд итгээд сайнмэдээ сонсохоосоо өмнө нас барвал Голготын толгой дээр хийсэн Христийн ажилд тулгуурлан Бурхан түүнийг аврах болно. Тэр хүн Христийн ажлыг огт сонсоогүй хэдий ч бүтээл дотор илчлэгдсэн гэрлийг хүлээн авч, түүнийхээ дагуу Бурханд итгэсэн тул Бурхан түүнийг Христийн ажилд итгэсэн хэмээн тооцно” гэж үздэг. Энэ үзлийг

баримтлагч нар, Христийг ирэхээс өмнө амьдарч байсан хүмүүс ба оюуны сааталтай, галзуу хүмүүс, бас шийдвэр гаргаж, хариуцлага хүлээх насанд хүрээгүй байхдаа нас барсан хүүхдүүд ийм байдлаар аврагдана гэж үздэг.

Эхний үзлийг Корнелийн жишээ дэмжиж өгдөг. Гэтэл Христийн үхэл, амилалтын дараах эрин үеийн хувьд (бидний одоогийн эрин үе) хоёр дахь үзлийг дэмжсэн Библийн ишлэл байдаггүй. Түүнээс гадна хоёр дахь үзэл нь эрчимтэйгээр илгээлтийн ажил хийх шаардлагыг сулруулдаг.

Хуурамч шүтээн шүтэгч үндэстнүүд төөрөлдсөн бөгөөд тэдэнд сайнмэдээ хэрэгтэй гэдгийг Паул харуулж өгсөн. Одоо тэр хоёр дахь төрлийн хүмүүс рүү хандаж байна. Түүний ярьж байгаа хүмүүсийг тодорхойлоход зарим нэг маргаан гардаг. Харин бидний хувьд элч Паулыг Иудей ба харь үндэстнүүдийн доторх өөрсдийгөө зөвт шударга гэж тооцдог хүмүүсийн тухай ярьж байна гэж үздэг. Энэ хүмүүс бусдын биеэ авч яваа зан хандлагыг шүүж байгаа талаар эхний ишлэлд дурдсанаас харахад тэд өөрсдийгөө зөв шударга гэж үздэг байсан бололтой (гэвч эдгээр нүглийг өөрсдөө үйлддэг). 9, 10, 12, 14, 15 дугаар ишлэлээс харвал Паул иудейчүүд ба харь үндэстнүүдийн аль алиных нь тухай ярьж байна. Асуулт: *Иудей ба харь үндэстнүүдийн доторх өөрсдийгөө зөвт шударга гэж тооцдог, ёс суртахуунлаг хүмүүс төөрөлдөн мөхөл рүүгээ явж байгаа*

гээж үү? Бидний харж байгаагаар энэ асуултад Паул “Тийм ээ, тэд ч бас төөрөлдсөн” гэж хариулжээ.

2:1 Энэ хоёрдугаар бүлэг өөрсдийгөө бусад үндэстнээс илүүд тооцдог, бусдаас илүү соёлтой, илүү боловсролтой, илүү мэдрэмжтэй гэж үздэг ажээ. Тэд үл итгэгч хүмүүсийн бузар бүдүүлэг зан үйлийг буруутгадаг хэдий ч үнэндээ арай өөр байдлаар өөрсдөө яг адил гэм буруутай билээ. Гэм нүгэлд унасан хүн төрөлхтөн бусдын бурууг өөрөөсөө түрүүлж хардаг. Бусдын амьдралд жигшмээр, бузар гэх зүйлс өөрийнх нь амьдралд байвал зүгээр юм шиг санана. Гэхдээ бусдын гэм нүглийг **шүүдэг** хүн зөв, бурууг ялгадаг болохоо харуулж байна. Хэрэв өөрийнх нь эхнэрийг булаавал буруу гэдгийг мэдэж байгаа хүн өөрөө бусдын эхнэрийг булааж болохгүй гэдгээ мэдэж байгаа гэсэн үг. Бусдыг буруутган шүүх атлаа өөрөө түүнийгээ адилхан үйлдвэл түүнд ямар ч шалтаг үлдэхгүй.

Соёлтой боловсон хүмүүсийн гэм нүгэл нь бүдүүлэг бурангуй хүмүүсийн гэм нүгэлтэй үндсэндээ адилхан. Хэдийгээр ёс суртахуунлаг хүмүүс Бурханы хуулийн номд бичсэн бүх гэмийг үйлдээгүй гэж маргаж болох ч тэд дараах зүйлсийг санах хэрэгтэй:

1. Тэд бүгдийг нь үйлдэх боломжтой.

2. Нэгийг нь л зөрчсөн бол бүгдийг нь зөрчсөн хэрэг (Иаков 2:10).

3. Үйлдлээрээ хийгээгүй боловч бодлоороо гэм нүгэл үйлдсэн бол үүнийг Бурханы үгэнд ялгаагүй гэм гэж үздэг. Жишээ нь Есүс тачаадан харах нь завхайрсантай адил гэж сургасан (Матай 5:28).

2:2 Өөртөө дэндүү итгэл төгс байгаа ёс суртахуунлаг хүнд **Бурханы шүүлтийн** тухай сургаал хэрэгтэй. Элч Паул тэдэнд хэрэгтэй хичээлийг 2-16 дугаар ишлэлд өгнө. Нэгдүгээрт **Бурханы шүүлт үнэний дагуу** байх болно гэдгийг ойлгох хэрэгтэй. Бурханы шүүлт бүрэн бус, алдаатай, нөхцөл байдлаас шалтгаалсан тодорхойгүй баримтад тулгуурлахгүй. Харин үнэн дээр, бүх үнэн дээр, өөр юун дээр ч биш, зөвхөн үнэн дээр тулгуурлах болно.

2:3 Хоёрдугаарт бусдыг буруутгах атлаа өөрсдөө бас адилхан гэм үйлддэг хүмүүс **Бурханы шүүлтээс зугтах арга байхгүй**. Бусдыг **шүүх** чадвар нь өөрсдийнх нь бурууг цайруулахгүй. Харин ч ял зэмлэлийг нь нэмэгдүүлэх болно.

Бид гэмээ *гэмшиж, уучлуулаагүй* цагт Бурханы шүүлтээс зугтаж чадахгүй.

2:4 Гуравт *Бурханы шүүлт заримдаа хожуу ирдэг гэдгийг* ойлгох хэрэгтэй. Ингэж удаж хойшилж байгаа нь **түүний энэрэл, хүлцэл, тэвчээрийн** баталгаа юм. **Түүний энэрэл** гэдэг нь Бурхан нүгэлд сайнаар хандахгүй ч нүгэлтнүүдэд сайнаар ханддаг гэсэн үг. **Түүний хүлцэл** гэдэг нь хүний бузар муу, тэрслүү байдалд ногдуулсан шийтгэлээ Бурхан хойш

татаж байдгийг хэлнэ. Түүний **тэвчээр** гэдэг нь хүн тасралтгүй өдөөн хатгаж байхад Бурхан өөрийгөө барьж байгаа гайхалтай чадварыг хэлдэг.

Хүнийг **гэмшил** рүү хөтлөхийн тулд хамгаалж, хадгалж, хайрлаж байгаа нь **Бурханы энэрэл**, сайн сайхны тод илрэл билээ. “Тэр хэнийг ч мөхүүлэхийг хүсдэггүй, харин бүгдийг гэмшилд ирээсэй гэж хүсдэг” (2Петр 3:9).

Гэмшил гэдэг нь гэм нүглээсээ нүүр буруулж, түүн рүү нуруугаа харуулан эсрэг зүгт алхахыг хэлнэ. “Гэмшил бол зан хандлагын өөрчлөлтийг бий болгож үр дүнд нь үйлдлийг маань өөрчилдөг оюун санааны өөрчлөлт юм”⁴. Гэмшил хүнийг өөрийнхөө эсрэг, нүглийнхээ эсрэг Бурханы талд орж байгааг илтгэнэ. Өөрийнхөө гэм нүглийг сэтгэл оюундаа хүлээн зөвшөөрснөөр гэмшил хязгаарлагдахгүй. Үүнд бидний ухамсар, мөс чанар оролцдог. Энэ талаар Жон Ньютон, “Мөс чанар минь гэм буруугаа мэдэрч, хүлээн зөвшөөрсөн” гэж бичжээ.

2:5 Бурханы шүүлтийн талаар сурах дөрөв дэх зүйл бол: *Гэм буруу хуримтлагдсаар эцэст нь тэр бүхэн дээр Бурханы шүүлт буух болно.* Хатуу, гэмшдэггүй зүрх сэтгэлтэй гэмт хүмүүс өөрсөд дээрээ шүүлтийг **хурааж байгаа** тухай зураглалыг Паул өгсөн. Яг л алт, мөнгө бүхий сан хөмрөг босгож байгаа мэт. Гэтэл Бурхан агуу цагаан сэнтийн (Илчлэлт 20:11-15) **шүүлтийн өдөр Бурханы уур хилэн** илчлэгдэх

ямар сан хөмрөг дээрээс нь буух вэ! Тэр өдөр Бурханы шүүлт *туйлын зөв шударга*, ямар ч алдаа мадаггүй, шударга бусаас ангид байх болно.

2:6 Дараагийн таван ишлэлд *Бурханы шүүлт хүний үйлсийнх нь дагуу байх болно* гэдгийг Паул бидэнд сануулсан. Хүн өөрийн сайн зан чанараараа бардан сайрхаж болох юм. Аль эсвэл гарал угсаандаа ач холбогдол өгч болно. Өвөг дээдэс дотор нь Бурханы хүмүүс олон байсан гэж ч болох. Гэхдээ тэр хүн зөвхөн *өөрийнхөө хийсэн үйлсийг* шүүлгэх болно. Өөр ямар нэгэн хүчин зүйл үүнд хамаарахгүй. Тухайн хүний ажил үйлс нь түүнийг шүүх үндсэн хүчин зүйл болно.

Хэрэв бид 6-11 дүгээр ишлэлийг дангаар нь салгаж авбал “аврал үйлсээр ирдэг” гэж зааж байна хэмээн хялбархан дүгнэх боломжтой. Энэ ишлэлүүдэд сайн үйлс хийдэг хүмүүс мөнх амийг авах болно гэж байгаа *мэт харагддаг*.

Гэвч энэ хэсэгт ийм утга байхгүй гэдэг нь тодорхой. Хэрэв ийм утга байсан бол аврал үйлсээс ангид, итгэлээр ирдэг гэсэн бусад Бичээстэй зөрчилдөж байгаа хэрэг болно. Аврал итгэлээр ирдэг гэсэн 150 орчим багц ишлэл Шинэ гэрээнд байдаг гэдгийг Чафер онцолсон⁵. Хэрэв зөвөөр ойлгож чадвал аврал итгэлээр ирдэг хэмээх энэ сургаалыг Библийн ямар ч хэсэг үгүйсгэдэггүй.

Тэгвэл энэ хэсгийг бид хэрхэн ойлгох ёстой вэ? Юуны өмнө хүнийг дахин төрөхөөс нааш

сайн үйлс эхэлдэггүй гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Хүмүүс Есүсээс “Бид Бурханы ажлуудыг хийхийн тулд юу хийх вэ?” гэж асуухад Есүс, “Та нар Бурханы илгээсэн Нэгэнд итгэх нь түүний ажил мөн” гэж хариулсан (Иохан 6:28, 29). Тиймээс хүний хийж чадах хамгийн эхний сайн үйл бол Эзэн Есүс Христэд итгэх нь юм. Гэхдээ *итгэл бол* аврал олж авах *гавьяатай үйл биш* гэдгийг бид үргэлж санах хэрэгтэй. Тэгэхээр аврагдаагүй хүн ажил үйлсээрээ шүүгдвэл тэдэнд баталгаа нотолгоо болгон үзүүлэхүйц үнэ цэнэтэй зүйл байхгүй юм. Тэдний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт тооцогдох болно (Исаиа 64:6). Тэд Есүсийг Эзэн хэмээн итгээгүй нь тэднийг яллах гэм байх болно (Иохан 3:18). Түүнээс гадна тэдний ажил үйлс шийтгэлийнх нь хэмжүүр болно (Лук 12:47, 48).

Хэрэв *итгэгч* нар ажил үйлсийнхээ дагуу шүүгдэнэ гэвэл үр дүн нь юу болох вэ? Тэд авралыг олж авахуйц сайн үйлс гарган тавьж чадахгүй. Аврагдахын өмнөх ажил үйлс бүр нь гэм нүгэлтэй байсан. Харин Христийн цус өнгөрснийг арчсан билээ. Тийм учраас Бурханд тэднийг тамд хаях ямар нэгэн ял олдохгүй. Тэд аврагдсанаах дараа сайн үйлс хийж эхэлдэг. Гэхдээ энэ дэлхийн нүдээр сайн гэж харагдах бус, Бурханы нүдээр сайн гэж харагдах сайн үйлс юм. Тэдний сайн үйлс тэдний гавьяа биш харин авралын үр дүн юм. Христ шүүх суудалдаа залрах цагт тэдний сайн үйлсийг

шалгаж, бүх итгэмжит үйлчлэлийг нь шагнах болно.

Гэхдээ энэ багц ишлэл итгэгч нарын тухай биш, харин бурханлаг бус хүмүүсийн тухай гэдгийг бид байнга санах хэрэгтэй.

2:7 Шүүлт ажил үйлсийн дагуу байх болно гэдгийг тайлбарлахдаа Паул **сайныг үйлдэхдээ тэвчээртэйгээр алдар, хүндэтгэл, мөхөшгүй байдлыг хайдаг хүмүүст** Бурхан **мөнх амь өгнө** гэж хэлсэн. Энэ хэсгийн хэлэх гэсэн санаа нь **сайныг үйлдэхдээ тэвчээртэй** байсан хүмүүс аврагдана гэсэн үг биш юм. Үүнийг өмнө бид тайлбарласан. Хэрэв **сайныг үйлдэхдээ тэвчээртэй** байсан хүмүүс аврагдана гэж хэлбэл ондоо сайнмэдээ болж хувирна. Төрөлх мөн чанараараа тийм амьдралын хэв маягаар амьдрах хүн байхгүй. Хэрэв тэнгэрлэг хүч чадал байхгүй бол хэн ч тийн амьдарч чадахгүй. Энэ тодорхойлолтод хамгийн сайн тохирч байгаа хүмүүс бол итгэлээр дамжин нигүүлслээр аврагдсан хүмүүс билээ. **Алдар, хүндэтгэл болон мөхөшгүй байдлыг хайдаг** гэдэг нь тэр хүн аль хэдийн дахин төрсөн болохыг харуулж байна. Түүний амьдралын бүх чиг хандлага Бурхан уруу эргэснийг харуулж байна.

Тэрээр тэнгэрийн **алдар**, Бурханаас ирэх **хүндлэл** (Иохан 5:44), мөхөшгүй, бузартаагүй, алга болчихгүй тэнгэрлэг өв (1Петр 1:4) буюу дахин амилсан биеийн (1Коринт 15:53, 54)

шинж чанар болох **мөхөшгүй байдлыг** эрэн хайдаг.

Бурхан уруу эргэсэн нь амьдралаар нь нотлогдож байгаа ийм хүмүүст Бурхан **мөнх амийг** шагнал болгон өгнө. Шинэ гэрээнд **мөнх амийг** хэд хэдэн янзаар өгүүлжээ. Мөнх амь бол Бурхан уруу эргэсэн мөчөөс эхлэн бидэнд ирсэн одоогийн өмч юм (Иохан 5:24). Мөнх амь бол алдрын биеийг хүлээн авах үед биднийх болох ирээдүйн өмч юм (энэ ишлэл болон Ром 6:22). Хэдийгээр мөнх амь итгэлээр ирсэн бэлэг боловч заримдаа түүнийг итгэмжтэй амьдралын шагналтай холбох нь бий (Марк 10:30). Бүх итгэгчид **мөнх амьтай** болох боловч зарим нь үүнд бусдаасаа илүү давуу талыг эзэмших болно. Нэг ёсондоо мөнх амь гэдэг нь зүгээр нэг эцэс төгсгөлгүй амьдрал биш, харин **амьдралын** чанарын тухай юм. Иохан 10:10-д Аврагч Эзэний амласан илүү бялхсан **амьдрал** гэсэн үг. Энэ бол Христэд өөрт нь байдаг тэр **амьдрал** юм (Колоссай 1:27).

2:8 Хувиа хичээгч, үнэнийг дагадаггүй, харин зөв бусыг дагадаг хүмүүс уур хилэн ба хилэгнэлээр шагнуулна. Тэд **үнэнийг дагадаггүй**. Тэд сайнмэдээний дуудлагад огт хариулаагүй. Харин тэд зөв бусыг өөрсдийн эзэн мэт дагах сонголт хийдэг. Тэдний амьдралыг хэрүүл маргаан, зөрчил тэмцэл, дуулгаваргүй байдлаар тодорхойлж болно. Тэд огт аврагдаагүй гэдэг нь үүгээр батлагддаг.

2:9 Элч Паул хоёр төрлийн үйлс ба тэдгээрийг үйлдэгч хоёр төрлийн хүнд өгөх Бурханы хариуг давтан өгүүлсэн. Гэхдээ энэ удаа урвуу дарааллаар тоочжээ.

Бузар мууг үйлдэгч хүн бүрд Бурхан **цөхрөл, зовлонг** хариу болгон өгнө. Тэдгээр бузар муу үйл нь итгэлгүй, бузар муу зүрх сэтгэлийг илтгэн харуулж байгаа гэдгийг энд онцлох нь зүйтэй. Тэдгээр үйлс Эзэний талаар тухайн хүн ямар хандлагатай байгааг харуулах гадаад илрэл юм.

Юуны түрүүнд энэ нь Иудей, мөн түүнчлэн Грек хүмүүст байна гэсэн хэллэг *Бурханы шүүлт нь хүлээн авсан давуу эрх ба гэрэл гэгээнийх нь дагуу* байна гэдгийг харуулж байна. Бурхан иудейчүүдийг энэ дэлхий дээрх өөрийн ард түмэн болгон сонгосноор тэдэнд **нэн түрүүний** давуу эрхийг олгосон хэрэг бөгөөд энэ нь эргээд тэдэнд **нэн тэргүүний** хариуцлага ногдуулдаг. Бурханы шүүлтийн талаарх энэхүү үзэл санаа 12-16 дугаар ишлэлд илүү тодорхой гарна.

2:10 Иудей ч бай, грек ч бай **сайныг үйлдэгч хүн бүрийн** авах хариу нь **алдар, хүндэтгэл, амар тайван** байх болно. Итгэл найдвараа эхлээд Эзэн Есүс Христэд тавьж, Бурханыг ойшоон үзэхгүйгээр ямар ч хүн сайныг үйлдэж чадахгүй гэдгийг бүү мартаарай.

Юуны түрүүнд энэ нь Иудей, мөн түүнчлэн Грек хүмүүст байна гэсэн хэллэг нь ялгаварлах үзлийг харуулаагүй. Яагаад гэхээр дараагийн

ишлэлд Бурханы шүүлтэд ялгаварлал гарахгүй гэдгийг онцолсон. Тиймээс энэ хэллэг 1:16 дугаар ишлэлд дурдсантай адил сайнмэдээ хүрсэн түүхэн дарааллыг илэрхийлж байна. Сайнмэдээ эхлээд иудейчүүдэд хүрсэн бөгөөд анхны итгэгчид Иудей хүмүүс байв.

2:11 Бурханы шүүлтийн талаарх өөр нэгэн үнэн бол *шүүлтэд хүнээс нь хамаарсан ялгаварлал байхгүй*. Хүний байгуулсан шүүх сайхан харагдсан, хөрөнгө чинээтэй, нөлөөтэй хүмүүст ялгамжтай хандах тохиолдол байдаг боловч **Бурханд** харин ялгаварлах үзэл огт байхгүй. Тухайн хүний яс үндэс, албан тушаал, царай төрх Бурханд ямар ч нөлөө үзүүлэхгүй.

2:12 Дээр дурдсанчлан Бурханы шүүлт хэр их гэрэл гэгээрийг хүлээн авсан түүний дагуу байх болно гэсэн үзэл санааг 12-16 дугаар ишлэлд илүү тод өгүүлнэ. Үүнд хоёр төрлийн хүмүүс байна: хуульгүй хүмүүс (харь үндэстнүүд) ба хуулийн дор байгч хүмүүс (иудейчүүд). Үүнд Бурханы чуулган дотор байгаа хүмүүсээс бусад бүх хүнийг хамарна (хүн төрөлхтнийг гурван төрөлд ангилсан 1Коринт 10:32-ыг үз).

Хуульгүйгээр нүгэл үйлдсэн бүх хүн мөн хуульгүйгээр мөхөх болно. Энд хуульгүйгээр *шүүгдэнэ* гэж хэлээгүй, харин **хуульгүйгээр мөхөх болно** гэсэн. Тэд Эзэнээс ямар илчлэлтийг хүлээн авсан түүгээрээ шүүгдэж, тэрхүү илчлэлтийн дагуу амьдраагүйнхээ улмаас **мөхөх болно.**

Хуулийн дор нүгэл үйлдсэн бүх хүн хуулиар шүүгдэх болно. Хэрэв хуулийг дагаагүй бол тэд ч мөн адил мөхнө. Хууль нь бүрэн дуулгавартай байдлыг шаарддаг.

2:13 Хуультай байх нь хангалттай биш. Хууль нь төгс төгөлдөр, байнгын дуулгавартай байдлыг шаарддаг. Хууль мэддэг байснаараа зөвт гэж тооцогдох хүн нэг ч үгүй. Хуулийн дор зөвтгөгдөх цорын ганц арга зам бол хуулийг бүхэлд нь сахих явдал. Гэвч хүн бүр гэм нүгэлтэй учраас үүнийг хийх ямар ч боломжгүй. Тиймээс энэ ишлэлд хүний хүрч чадах зүйлийг яриагүй, харин төгс нөхцөлийг зааж өгсөн.

Хуулийг сахиснаар зөвтгөгдөх боломж байхгүй гэдгийг Шинэ гэрээнд тов тодорхой сургасан (Үйлс 13:39; Ром 3:20; Галал 2:16, 21; 3:11-ийг үз). Бурхан хүнийг хэзээ ч хуулиар аврахыг зориогүй. Хэн нэг хүн өнөөдрөөс эхлэн хуулийг ямар ч алдаа мадаггүй сахиж чадлаа ч тэр хүн зөвтгөгдөж чадахгүй. Яагаад гэвэл Бурхан өнгөрсөн амьдралыг нь нэхэх болно. Тиймээс 13-р ишлэлд гарч байгаа **хуулийг биелүүлэгчид нь зөвтгөгдөнө** гэсэн үгийг бид “хуулийг анх төрсөн өдрөөсөө эхлээд ямар ч алдаа мадаггүй сахисан хүмүүс зөвтгөгдөнө” гэж ойлгох хэрэгтэй. Гэвч бодит байдал дээр хэн ч ингэж чадахгүй.

2:14 14,15 дүгээр ишлэл 12а ишлэлийг улам тодруулж байна. Тэнд хуульгүйгээр нүгэл үйлдсэн харь үндэстнүүд хуульгүйгээр мөхөх болно гэдгийг бид мэдэж авсан. Харин энд

хэдийгээр харь үндэстнүүдэд хууль өгөөгүй боловч тэд зөв, бурууг ялгаж салгах төрөлхийн мэдлэгтэй болохыг Паул тайлбарлаж байна. Худлаа хэлэх, хулгай хийх, завхайрах, хүн алах буруу гэдгийг харь үндэстнүүд зөнгөөрөө мэднэ. Тэдний төрөлхөөс мэдээгүй байж болох ганц тушаал бол амралтын өдрийг сахих тухай. Гэвч амралтын өдрийн тухай тушаал нь ёс суртахууны гэхээсээ шашны ёслол, зан үйлийн шинжтэй.

Тийм учраас эцэст нь дүгнээд хэлэхэд **харь үндэстнүүд хуульгүй** боловч энэхүү төрөлх мэдлэг нь **тэдэнд хууль болдог**. Тэдний ёс суртахууны төрөлх совингоороо зөв, буруу зан үйлийн тухай хууль бий болгодог.

2:15 Хуулийн шаарддаг үйлс нь тэдний зүрх сэтгэлд бичигдсэнийг тэд харуулдаг. Тэдний зүрх сэтгэлд бичигдсэн зүйлс өөрөө хууль биш боловч хуулийн **шаарддаг үйлс** мөн. Израильчуудын аж амьдралд хуулийн хийхийг зорьсон үйлс тодорхой хэмжээнд харь үндэстнүүдийн аж амьдралаас харагддаг. Жишээ нь харь үндэстнүүд эцэг, эхээ хүндлэх зөв гэдгийг мэдэж байгаа нь **хуулийн шаарддаг үйлс тэдний зүрх сэтгэлд бичигдсэнийг** харуулж байна. Мөн зарим үйлдлүүдийг ер нь буруу гэдгийг тэд мэддэг. **Тэдний мөс чанар нь** тэдэнд байгаа энэхүү төрөлхийн мэдлэгийг баталдаг. Тэдний бодол **буруутгаж, зөвтгөж**, аливаа зүйлийг хориглож эсвэл зөвшөөрснөөр

өөрсдийн үйлдлийн зөв, бурууг байнга шийдэж байдаг.

2:16 Энэ ишлэл 12-т гарч байгаа үзэл санааны үргэлжлэл юм. Энд хуульгүй хүмүүс ба хуулийн дор байгч хүмүүс хэзээ шүүгдэхийг хэлсэн. Ингэхдээ Бурханы шүүлтийн талаарх эцсийн үнэнийг сургаж байна. Тэр нь *Бурханы шүүлт олны өмнө хийгдсэн зүйлсийг төдийгүй хүмүүсийн нууц зүйлсийг авч үзэх болно.* Өнөөдөр нууц байгаа гэм нүгэл агуу цагаан сэнтийн шүүлтэн дээр илчлэгдэн шуугиан тарина. Эцэг Бурхан Есүст бүх шүүлтийг даатгасан (Иохан 5:22) учраас тэрхүү яруу жавхлант өдрийн шүүгч нь **Есүс Христ** байх болно. **Миний сайнмэдээний дагуу** гэж Паулын хэлж байгаа үг миний сайнмэдээнд ингэж заадаг ч гэсэн утгатай. **Миний сайнмэдээ** гэдэг нь Паулын зааж байсан, бусад элч нарын ч бас заан тунхаглаж байсан тэрхүү сайнмэдээ мөн.

2:17 Ингээд элч Паул гуравдугаар төрлийн хүмүүсийг авч үзэх гэж байна. Одоо тэр “*Хуулийг хүлээн авсан иудейчүүд ч бас төөрөлдсөн, мөхөл рүүгээ явж байгаа гэж үү?*” гэдэг асуултад хариулах болно. Мэдээж хэрэг энэ асуултад “Тийм ээ, тэд ч бас төөрөлдсөн” гэж хариулна.

Олон иудей өөрсдийгөө Бурханы шүүлтийг үзэхгүй гэж итгэдэг байсан нь эргэлзээгүй. Бурхан **Иудей** хүнийг хэзээ ч тамд хаяхгүй, харин харь үндэстнүүд бол тамын галд

зориулсан түлш гэж тэд боддог байв. Тийм учраас Паул энэхүү худал итгэл үнэмшлийг үгүй хийхийн тулд тодорхой нөхцөлийн хүрээнд харь үндэстнүүд иудейчүүдээс ч илүү Бурханд ойр байж болохыг харуулсан.

Юуны өмнө тэр иудей хүн Бурхантай ойр хэмээн өөрийгөө дөвийлгөн сайрхдаг байсан зүйлсийг тоочно. Иудей хүн энэ дэлхийгээс Бурханы сонгосон ард түмний нэгэн гишүүн болж **Иудей** хэмээх нэрийг зүүсэн. Тэрээр **хуульд** түшиглэдэг. Үнэндээ хуулийг найдвар түшиг болгож өгөөгүй, харин хүнийг гэм нүгэлтэй болохыг нь ойлгуулах зорилготой байсан. Иудей хүн Израиль үндэстэнтэй гэрээний онцгой харилцаанд орсон цор ганц үнэн **Бурханаар** сайрхдаг.

2:18 Бичээст Бурханы хүслийг ерөнхийд нь өгүүлдэг тул иудей хүн Бурханы **хүслийг** мэднэ. **Хууль** ёс суртахууны хэм хэмжээг хэрхэн үнэлэхийг сургадаг учраас тэр **онц сайн юмсыг** сайшаадаг.

2:19 Тэрээр өөрийгөө ёс суртахуун, сүнслэг байдалдаа **сохорсон** хүмүүст **газарчин**, мунхаглалын **харанхуйд байгаа** хүмүүст гэрэл гэгээ хэмээн үзэж бардан ихэрхдэг.

2:20 Тэрээр хуулиар **мэдлэг** ба **үнэний** ерөнхий тоймыг заалгасан тул **тэнэг мунхаг** буюу боловсрол мэдлэггүйг залруулах, **балчир хүүхдүүдийг** сургах чадвартай гэж өөрийгөө үздэг.

2:21 Гэвч иудей хүний бардан сайрхдаг эдгээр зүйлс өөрийнх нь амьдралд ямар ч өөрчлөлт авчирсангүй. Үндэс угсаа, шашин шүтлэгийн ба мэдлэгээрээ бардамнахаас өөр юмгүй, ёс суртахууны амьдралыг нь өөрчлөөгүй ажээ. Тэр бусдад заах авч өөрийнхөө зүрх сэтгэлд ямар ч сургамж авсангүй. Тэр хулгай хийж болохгүй хэмээн сургадаг авч сургаалаа өөрөө хэрэгжүүлсэнгүй.

2:22 **Завхайрахыг** буруушаадаг ч үнэн чанартаа “амьдралаас минь биш амнаас минь суралц” гэх үгийн бодит жишээ болж байв. **Шүтээнүүдийг жигшиж**, тэдэнд дургүйцдэг гэх боловч **сүмүүдийг тонож** гэжээ. Шууд утгаараа харь үндэстнүүдийн шүтээний бунхнуудыг тонодог байсан байж болох.

2:23 Өөрт нь **хууль** байгаад бардавч ариун тушаалуудыг **зөрчсөнөөрөө** хуулийг өгсөн **Бурханыг** гутаадаг.

2:24 Ам нь том ч амьдралд харагдах бодит үр дүн нь өчүүхэн учраас **харь үндэстнүүдэд Бурханыг** доромжлох боломж өгчээ. Тэд хүний л ёсоор дагалдагчдыг нь хараад Эзэнийг шүүжээ. Исаиагийн өдрүүдэд ч ийм байсан (Исаиа 52:5). Өнөөдөр ч хэвээрээ байна. Бид өөрсдөөсөө ингэж асууцгаая:

*Есүс Христийг харах ганц боломж
Таны харуулж байгаа тэрхүү Эзэн бол
(Энд нэрээ оруул), танаас тэд юу харж байна вэ?*

2:25 Иудей хүний өөрөөрөө бардамнах шалтгаан нь хууль төдийгүй, бас хозлол хийх зан үйл байв. Хозлол хийх зан үйл нь эр бэлэг эрхтний тээрхийн арьсыг тойруулан зүсэж танах жижиг мэс ажилбар ажээ. Бурхан Абрахамтай байгуулсан гэрээнийхээ бэлэг тэмдэг болгож үүнийг хийж байхыг тушаасан байдаг (Эхлэл 17:9-14). Үүний утга нь Бурханы ард түмэн энэ дэлхийгээс тусгаарлагдсаныг илтгэдэг ажээ. Ийнхүү хэсэг хугацаа өнгөрөхөд иудейчүүд энэхүү мэс ажилбарыг хийлгэдэгтээ өөрсдөөрөө бардах болж харин харь үндэстнүүдийг “хозлуулаагүй хүмүүс” хэмээн басамжлан нэрлэдэг болсон.

Паул энд **хөвч хөндөлтийг** Мосегийн **хуультай** холбон үзэж, дуулгавартай амьдралыг дагалдах бол хүчин төгөлдөр бэлгэдэл болно гэж онцолсон. Бурхан зан үйл баримтлагч биш. Хүний дотор ариун байдал үгүй бол гадна талын ёс заншил, зан үйлд Бурханы сэтгэл ханахгүй. Тийм учраас хуулийг зөрчиж байгаа хозлуулсан иудей хүн хозлуулаагүй хүнээс ялгаагүй юм.

Элч Паул энэ багц ишлэлд хуулийг сахидаг, үйлддэг хүмүүсийн тухай ярьсныг бид үгчлэн хүлээн авах хэрэггүй.

2:26 Тиймээс харь үндэстэн хэдийгээр хуулийн доор байдаггүй боловч **хуульд** заасан ёс суртахууны зарчмуудыг дагах юм бол **түүний хозлуулаагүй** байгаа нь гэмт амьдралтай иудей хүний хозлолоос илүү таалал

авна. Ийм тохиолдолд түүний зүрх сэтгэл хозлуулсан хэрэг бөгөөд энэ нь гол зүйл.

2:27 Хуулийн үсэг болон хөвч хөндөлттэй атлаа хуулийг сахидаггүй, мөн тусгаарлагдаж, ариусах хозлуулсан амьдралаар амьдардаггүй иудей хүнийг түүнээс илүү зөвт амьдралтай харь үндэстэн яллах болно.

2:28 Бурханы хувьд жинхэнэ **Иудей хүн** гэж зөвхөн судсаар нь Абрахамын цус гүйж байгаа, биедээ хозлолын тэмдэгтэй хүнийг хэлэхгүй. Хүнд энэ хоёр зүйл хоёулаа байвч ялзарсан ёс суртахуунтай байж болно. Эзэн угсаа гарал, шашин шүтлэгийн гадаад хүчин зүйлд автдаггүй, харин дотоод сэтгэлийн чин шударга зан, ариун байдлыг хардаг билээ.

2:29 Жинхэнэ иудей хүн зөвхөн Абрахамын үр удам байхаас гадна бурханлаг амьдралтай хүн байх ёстой. Гэхдээ энэ ишлэл бүх итгэгчид иудейчүүд эсвэл чуулган бол Бурханы Израиль гэсэн сургаал заагаагүй. Паул Иудей угсаа гаралтай хүмүүсийн тухай ярьж байгаа ба төрөхөөс заяасан үндэс угсаа, хозлол хийх ёслол хангалттай биш гэж байна. Дотоод сэтгэлийн бодит үнэн байх ёстой.

Жинхэнэ **хозлол** нь бие махбодод хийх бодит зүсэлт биш, харин гэмт хуучин мөн чанартаа хийх сүнслэг мэс ажилбар буюу **зүрх сэтгэлийн** асуудал юм.

Гаднах тэмдэг хийгээд дотоод нигүүлслийг ийнхүү хослуулсан хүн хүнээс бус Бурханаас ирдэг магтаалыг хүлээн авах болно. Сүүлийн

энэ ишлэлд бидний хэлэнд тодорхой харагдахгүй үгээр наадсан байдаг. Иудей гэдэг үг еврей хэлээр Иуда буюу **магтаал** гэсэн үгнээс гаралтай. Тэгэхээр жинхэнэ **Иудей хүн** гэж **Бурханы магтаалыг** авахуйц зан чанартай хүнийг хэлнэ.

3:1 Энэ бүлгийн эхний найман ишлэлд Паул иудейчүүдийн гэм буруугийн талаар үргэлжлүүлэн ярина. Энд иудей сөргөлдөгч гарч ирэн Паулыг байцаана. Асуулт, хариулт нь дараах байдалтай байна:

СӨРГӨЛДӨГЧ: Хэрэв 2:17-29 дүгээр ишлэлд таны хэлсэн бүх зүйл үнэн юм бол **Иудей** байхын **давуу тал, хөвч хөндөлтийн ашиг** нь тэгээд **юу** юм бэ?

3:2 *ПАУЛ:* Иудейчүүдэд маш олон онцгой давуу эрх байдаг. Хамгийн чухал нь тэдэнд **Бурханы үгийг** даатгасан. Хуучин гэрээний бичээсүүдийг бичиж, хадгалж хамгаалах эрхийг иудейчүүдэд өгсөн. Гэтэл Израилийн ард түмэн энэхүү үлэмж давуу эрхэнд хэрхэн хандсан бэ? Ерөнхийдөө туйлын итгэлгүй зан харуулсан.

3:3 *СӨРГӨЛДӨГЧ:* За тийм дээ, иудей хүн бүр итгээгүй нь үнэн. Тэгвэл Бурхан амлалтаасаа буцах уу? Бурхан өөрөө Израилийг ард түмнээ болгон сонгож, тэдэнтэй тодорхой гэрээ байгуулсан шүү дээ. Зарим нэгнийх нь **итгэлгүй** байдлаас болж **Бурхан** амласан үгээ цуцлах уу?

3:4 ПАУЛ: Бүү ийм байх болтугай (Огтхон ч тийм биш). Бурхан, хүн хоёрын хэн нь зөв бэ гэдэг асуулт гарах тоолонд **Бурхан** зөв, **хүн бүр худалч** гэдэг зарчмыг үргэлж санах хэрэгтэй. Үүнийг Давид Дуулал 51:4-т: “Тиймээс та айлдахдаа зөвтгөгдөж, шүүгдэхдээ ялна” гэжээ. Бидний гэм нүглүүд Бурханы үгийн үнэн болохыг л баталж байдаг.

3:5 СӨРГӨЛДӨГЧ: Хэрэв тийм юм бол Бурхан юунд биднийг яллана вэ? **Хэрэв бидний зөв бус нь Бурханы зөвийг** улам тодоор гэрэлтүүлдэг юм бол **Бурхан** юунд бидэнд **уурлан хилэгнэв** ээ? (Паул энд хүмүүсийн маргадаг шиг ярьж байна гэжээ).

3:6 ПАУЛ: Нухацтай авч үзэх шаардлагагүй асуулт байна. Хэрэв Бурхан ямар нэг байдлаар шударга бус байсан бол тэр **ертөнцийг яаж шүүх юм бэ?** Гэвч бид бүгдээрээ түүнийг энэ ертөнцийн *шүүнэ* хэмээн хүлээн зөвшөөрдөг шүү дээ.

3:7 СӨРГӨЛДӨГЧ: Хэрэв миний гэм нүгэл Бурханд алдрыг авчирч, **миний худал үг** түүний үнэнийг батлан, хүний уур хилэнгээр Бурхан өөрийгөө магтуулдаг юм бол яагаад тэр намайг үргэлж **гэм нүгэлтэн** хэмээн буруутгана вэ?

3:8 Тэгж яривал...

ПАУЛ: Яриаг чинь таслаад нэг юм хэлчихье. Христэд итгэгч биднийг ийм зүйл ярьдаг хэмээн зарим хүмүүс буруутгадаг. Энэ бол худал гүтгэлэг.

СӨРГӨЛДӨГЧ: Тэгж яривал **“Сайныг гаргахын тулд мууг үйлдэцгээ”** гэж ярьж болох биш үү?

ПАУЛ: Миний хэлж чадах ганц зүйл юу гэвэл ингэж ярьдаг хүмүүсийн ял шийтгэл нь шударга юм аа.

(Үнэндээ тэнэг харагдах сүүлийн асуултыг Бурханы нигүүлслийн сайнмэдээний эсрэг үргэлж тавьдаг. “Хэрэв хүн Христэд итгээд л аврагддаг юм бол гэмт амьдралаа үргэлжлүүлж болох юм байна. Бурханы нигүүлсэл хүний гэм нүглээс давдаг учраас гэм нүгэл их хийх тусам төдий чинээний их нигүүлслийг хүртэнэ” гэх хүмүүс бий. Элч Паул энэ талаар 6-р бүлэгт хариу өгсөн.)

3:9 СӨРГӨЛДӨГЧ: Тэгвэл иудейчүүд бид гэм нүгэлт тэдгээр харь үндэстнүүдээс давуу гэж та хэлэх гээд байгаа юм уу? Библи зарим орчуулгад энэ асуултыг “Иудейчүүд бид харь үндэстнүүдээс дутуу гэж үү?” гэсэн байдаг. Аль ч талаас нь асуулаа гэсэн хариу нь юу вэ гэхээр иудейчүүд харь үндэстнүүдээс илүү ч биш, дутуу ч биш, бүгд нүгэлтнүүд юм.

Эндээс дараагийн асуулт урган гарч, Паулын ярьж байгаа юмстай тохирч байна. Харь үндэстнүүд төөрөлдсөн. Өөрийгөө шударгад тооцдог ёс суртахуунлаг хүмүүс, Иудей ба харь үндэстний хэн нь ч бай, ялгаагүй төөрөлдсөн. Иудейчүүд төөрөлдсөн. Харин одоо Паул *“Бүх хүн төрөлхтөн төөрсөн гэж үү?”* гэдэг асуултыг хөндөж байна.

Үүнд “Тийм ээ, **бүгд нүглийн хүчин дор байдаг хэмээн бид аль хэдийн ял тулгасан**” гэж хариулна. Юу гэхээр энэ тал дээр иудейчүүд харь үндэстнүүдээс ялгарах зүйл үгүй.

3:10 Нэмж баталгаа хэрэгтэй бол Хуучин гэрээнд бий. Нэгт, хүнээс төрсөн хэн бүхэнд гэм нүгэл нөлөөлснийг (3:10-12) бид харж байна. Хоёрт, гэм нүгэл хүний амьдралын бүх хэсэгт нөлөөлснийг (3:13-18) харж байна. Үүнийг өөрөөр бас ингэж хэлж болох юм: “**Зөвт хүн нэг ч байхгүй**” (Дуулал 14:1).

3:11 “Бурханы тухай зөв ойлголттой нэг ч хүн байхгүй. **Бурханыг хайдаг хүн нэг ч байхгүй**” (Дуулал 14:2). Хэрэв хүнийг зөнд нь орхивол гэм нүгэлд унасан хүн Бурханыг хэзээ ч эрэлхийлэхгүй. Зөвхөн Ариун Сүнс ажиллахад хүн Бурханыг эрэн хайдаг.

3:12 “**Бүгд Бурханаас холдон одсон. Хүн төрөлхтөн бүгдээрээ завхарч гажуудсан. Зөв, сайн амьдралаар амьдарч байгаа хүн гэж үгүй. Бүр ганц ч үгүй**” (Дуулал 14:3).

3:13 “Хүний хоолой **онгорхой булш** мэт. Хэл яриа нь тэр чигээрээ худал хуурмаг” (Дуулал 5:9). “Ярилцаж хэлэлцэх үгс нь хорт уруулаас гардаг” (Дуулал 140:3).

3:14 “Аманд нь **хараал**, үзэн ядалт **дүүрэн байдаг**” (Дуулал 10:7).

3:15 “**Хөл нь** хүний амь бүрэлгэх ажилд **түргэн хөдөлдөг**” (Исаиа 59:7).

3:16 “Тэд **сүйрэл** балгас, **гай гамшгийн** ул мөр үлдээдэг” (Исаиа 59:7).

3:17 “Тэд хэрхэн **амар тайван** тогтоохыг огтхон ч **мэдэхгүй**” (Исаиа 59:8).

3:18 “Тэдэнд **Бурханыг** хүндэтгэх хүндлэл үгүй” (Дуулал 36:1).

Тэгэхээр хүн гэгчийг нэвт хардаг Бурханы рентген энэ ажээ. Бүх нийтээрээ хүмүүс зөвт бус (3:10), харанхуй мунхаг, Бурханаас хараат бус (3:11), дур зоргоороо, гай тарихаас өөр ашиггүй, сайн сайхан юмгүй (3:12) болохыг үүгээр илчилж байна. Хүний хоолой нь өмхий ялзралаар дүүрэн, хэл нь хууран мэхлэгч, уруул нь хор хөнөөлтэй (3:13), ам нь хараал зүхлээр дүүрэн (3:14), хөл нь хүний амь хөнөөх гэж гүйдэг (3:15), тэрээр гай балаг, эвдрэл сүйрэл тарьж үлдээдэг (3:16), тэр хэрхэн амар тайван тогтоохыг мэдэхгүй (3:17), бас Бурханыг хүндэлдэггүй. Хүн гэгч бүрэн гажуудсан болохыг эндээс бид харж байна. Өөрөөр хэлбэл гэм нүгэл бүх хүн төрөлхтөнд нөлөөлөөд зогсохгүй хүний бүх талбарт нэвчсэн. Хүн хэдийгээр бүх гэмийг хийдэггүй боловч түүний мөн чанар нь бүх гэмийг хийхэд бэлэн байдаг.

Хэрэв Паул гэм нүглийг дэлгэрэнгүй өгүүлэхийг хүссэн бол *бэлгийн гэм нүглийг* дурдах байсан биз ээ: завхайрах, ижил хүйстэнтэйгээ явалдах, лесбидэх, гажуудах, амьтантай явалдах, биеэ үнэлэх, хүчиндэх, садарлах, порно, шалиг зохиол. Мөн *дайн дажинтай холбоотой гэм нүглүүдийг* дурдаж

болох байсан: гэмгүй хүмүүсийг хөнөөх, харгислах, хорт хийгээр утах өрөө, хүн шатаадаг зуух, хорих лагерь, тамлан зовоох хэрэгсэл, садизм. Паул *гэр бүлийн хүрээнд болдог гэм нүглүүдийг* дурдаж болох байсан. Үүнд: үнэнч бус байдал, салалт, эхнэрээ зодох, сэтгэлзүйн харгислал, хүүхдийн хүчирхийлэл. Түүнээс гадна аллага, бусдыг гэмтээх, хулгай, тонуул, мөнгө шамшигдуулах, хорлон сүйтгэх ажиллагаа, авилга, хээл хахууль. Мөн *хэл ярианы гэм нүгэл*: хараалын үг, өдсөн шог яриа, шалиг завхай үгс хэрэглэх, зүхэх, Бурханыг доромжлох, худал хэлэх, араар муулах, хов жив ярих, нэр хүнд унагах, үглэж янших, гомдоллох. Хувь хүмүүст байдаг *бусад төрлийн гэм нүгэл*: архидан согтуурах, мансууруулах бодист донтох, бардамнал, атаа жетөө, шунал, ач тус санахгүй байх, бохир завхай бодол, үзэн ядалт, гомдол хорсол. Энэ жагсаалт дуусашгүй мэт. Бохирдуулах, хог хаях, арьс өнгөөр ялгаварлах, мөлжих, хуурах, урвах, амлалтаасаа буцах гээд цааш үргэлжилнэ. Хүн гажуудаж завхарсныг харуулах өөр ямар баталгаа хэрэгтэй юм бэ?

3:19 Бурхан Израильд хууль өгөхдөө Израилийг бүх хүн төрөлхтний сорьц болгон ашигласан. Бурхан Израиль хэмжүүрт хүрсэнгүй гэдгийг мэдээд бүх хүн төрөлхтөн хэмжүүрт хүрэхгүй нь гэсэн зөв дүгнэлт гаргажээ. Зүйрлэвэл эрүүл мэндийн байцаагч худгийн усыг шинжлэхийн тулд худгаас багахан хэмжээний сорьц авна. Хэрэв сорьц

бохир болох нь шинжилгээгээр илэрвэл байцаагч худгийн бүх усыг бохир гэж дүгнэлт гаргана.

Хууль нь Израилийн ард түмэн буюу хуулийн дор байгч хүмүүст хандан ярьдаг бөгөөд үүний зорилго нь *Иудей ба харь үндэстэн ам болгоныг таглаж, ертөнц даяар Бурханы өмнө буруутан* болохыг тунхаглахад оршдог гэдгийг Паул тайлбарлаж байна.

3:20 Ямар ч хүн хуулийг сахиснаар зөвтгөгдөж чадахгүй. Хүмүүсийг зөвтгөх зорилгоор биш харин **нүглийн мэдлэгийг** өгөхийн тулд хуулийг өгсөн. *Авралын* мэдлэгийг биш харин **нүглийн мэдлэгийг** өгөх зорилготой.

Бид шулуун шугамыг мэдэхгүйгээр муруй шугамыг бас мэдэж чадахгүй. Хууль бол шулуун шугамтай адил. Хүмүүс өөрсдийгөө хуулиар шалгах үедээ ямар их мурийсан болохоо харж чадна.

Бид нүүрээ бохир байгааг харахын тулд толь ашиглаж болно. Гэхдээ толь хиртэй нүүрийг цэвэрлэж чадахгүй. Халууны шилээр хүнийг халуунтай эсэхийг хэлж чадах боловч халууны шил залгилаа гээд халууныг эдгээж чадахгүй.

Гэм нүглээ буруу болохыг ойлгон ухаарахад ашиглавал хууль сайн. Гэвч хуулинд гэм нүглээс аврах хүч байхгүй. “Хуулийн зорилго нь зөвтгөх биш, харин эмээлгэх явдал юм” гэж Лутер хэлсэн байдаг.

Г. Сайнмэдээний үндэс суурь, түүний шаардлага (3:21-31)

3:21 Одоо бид Ромчуудад бичсэн захидлын хамгийн чухал хэсэг дээр ирж байна. Паул *“Сайнмэдээний дагуу ариун Бурхан бурханлаг бус нүгэлтнийг хэрхэн зөвтгөдөг вэ?”* гэсэн асуултад хариулж байна.

Паул **Бурханы зөв нь Хуулиас ангид** илэрхийлэгдэв гэж эхэлжээ. Өөрөөр хэлбэл хуулийг сахих шаардлага тавихгүйгээр зөвт бус нүгэлтнийг зөв шударгаар аварч чадах Бурханы хөтөлбөр, төлөвлөгөөг **илэрхийлсэн** гэсэн үг юм. Бурхан ариун нэгэн учраас гэм нүглийг хэзээ ч зүгээр өнгөрөөхгүй. Бурхан гэм нүглийн хажуугаар нүдэн балай, чихэн дүлий өнгөрөхгүй. Тэр нүглийг шийтгэх ёстой. Харин нүглийн шийтгэл бол үхэл юм. Гэвч Бурхан нүгэлтнийг хайрладаг тул түүнийг аврахыг хүсдэг. Ингээд мухардмал байдал бий болно. Бурханы шударга чанар нүгэлт хүний үхлийг нэхэх боловч түүний хайр тэр нүгэлтэнд мөнх жаргал өгөхийг хүсдэг. Тэгвэл өөрийн шударга чанарыг сэвтээхгүйгээр гэмт хүнийг Бурхан хэрхэн аврахыг сайнмэдээ илчилсэн.

Зөв шударга энэ төлөвлөгөөг **Хууль ба Эш үзүүлэгчид гэрчилдэг**. Эвлэрлийн төлөө амьтны цус урсгахыг шаарддаг тахилын тогтолцооны бэлгэдэл ба утга учир нь энэхүү төлөвлөгөөг урьдаас зөгнөсөн. Түүнээс гадна

шууд хэлсэн эш үзүүллэгээр үүнийг урьдаас зөгнөсөн (Исаиа 51:5, 6, 8; 56:1; Даниел 9:24).

3:22 Зөв шударга авралыг бид хууль дагаснаар олж авч чадахгүй гэдгийг 21-р ишлэл бидэнд хэлж байна. Тэгвэл одоо яаж аврагдах вэ гэдгийг элч Паул хэлж өгч байна: **Есүс Христэд итгэх итгэлээр**. Итгэл гэдэг нь амьд Эзэн Есүс Христийг гэм нүглийн цорын ганц Аврагч, тэнгэрт хүрэх цорын ганц найдвар болгож, түүнд бүрэн түшиглэхийг хэлнэ. Итгэл нь Библид илчилсэн Христийн бодгаль хийгээд ажилд тулгуурладаг.

Итгэл гэхээр харанхуй уруу үсрэхийг хэлэхгүй. Үүнд хамгийн найдвартай баталгааг шаардагдах ба үүнийг Бурханы алдаа мадаггүй үгнээс олж авдаг. Итгэл гэхээр утга учиргүй, тайлбарлашгүй зүйл биш ээ. Бүтээл нь Бүтээсэн Эзэндээ итгэж найдахаас илүү утга учиртай ямар зүйл байдаг вэ?

Итгэл гэдэг авралыг хүртэх зохистой болгодог гавьяат үйл биш. Эзэнд итгэснийхээ төлөө хүн бардамнаж чадахгүй. Тэнэг хүн л *итгэхгүй*. Итгэл гэдэг авралыг олж авах ямар нэг оролдлого ч биш. Харин зүгээр л Бурханы үнэгүй өгч бэлэг болох авралыг хүлээн авч буй явдал юм.

Паул цааш нь энэхүү аврал **итгэгч бүх хүнд, итгэгч бүх хүний дээр⁶** байна гэдгийг бидэнд хэлж байна. **Бүх хүнд** гэдэг нь авралыг хүн бүр хүртэх боломжтой, хүн бүрд санал болгодог, хүн бүрд хангалттай болохыг илэрхийлдэг.

Гэхдээ зөвхөн итгэсэн хүмүүс л авралыг авна. Өөрөөр хэлбэл Эзэн Есүсийг итгэлийн бодит үйлдлээр хүлээн авсан хүмүүсийн амьдралд л аврал хэрэгждэг. Хүн бүрд өршөөл үзүүлсэн боловч үүнийг хүлээн авсан хүмүүсийн амьдралд л хүчин төгөлдөр болно.

Авралыг хүн бүр авах боломжтой гэж Паул хэлэхдээ харь үндэстэн болоод иудейчүүдийн аль алиныг үүнд багтааж байсан. Яагаад гэвэл **ялгаварлал байхгүй**. Иудей хүнд тусгай давуу эрх гэж үгүй. Харь үндэстнүүд бас тэднээс дутуу биш.

3:23 Аврагдах хэрэгцээ бүх нийтэд байгаа шиг сайнмэдээ бүх хүнд нээлттэй байгаа. **Бүгд нүгэл үйлдсэнээр⁷ Бурханы алдарт хүрдэггүй** тул хэрэгцээ бүх нийтэд байдаг. Хүн бүр Адамын дотор **нүгэл үйлдсэн**. Адам нүгэл үйлдэхдээ бүх үр удмынхаа өмнөөс төлөөлөл болсон. Гэхдээ хүн төрөлх мөн чанараараа гэм нүгэлтэйгээс гадна *өөрсдөө үйлдсэн* гэм нүгэлтэй. Хүн бүр байгаа байдлаараа **Бурханы алдарт хүрдэггүй**.

ГЭМ НҮГЛИЙН ТУХАЙ ТАЙЛБАР

Нүгэл гэдэг нь Бурханы ариун, төгс байдлын хэм хэмжүүрт үл хүрэх аливаа бодол санаа, үг яриа, үйлдлүүд юм. Нэг ёсондоо хэм хэмжээнд хүрэхгүй байх, байндаа тусахгүй наана унах гэсэн үг. Харвасан сум байндаа хүрэлгүй унах үед “Би нүгэл үйлдлээ” гэж индианчууд ярьдаг.

Нүгэл үйлдэх ба байгаа онохгүй байхыг тэдний хэлэнд⁸ нэг адил үгээр илэрхийлдэг ажээ.

Нүгэл бол ёс бус хэрэг (1 Иохан 3:4) бөгөөд Бурханы хүслийн эсрэг өндөлзсөн бүтээлийн тэрслүү хүсэл мөн. Нүгэл нь зөвхөн бурууг үйлдэх бус, бас мэдэж байгаа зөв зүйлээ үл үйлдэх явдал билээ (Иаков 4:17). Итгэлээр биш алив бүхэн нь нүгэл мөн (Ром 14:23). Өөрөөр хэлбэл хүн хийх гэж буй зүйлдээ нэлээд эргэлзээтэй байгаа бол хийх нь буруу. Хэрэв тухайн асуудлаар мөс чанар нь эвгүйцэж байвал цааш нь үргэлжлүүлэн хийвэл нүгэл үйлдэж байгаа хэрэг юм.

“Зөвт бус байдал нь бүгдээрээ нүгэл мөн” (1 Иохан 5:17). Мунхаглалыг сэдэх нь нүгэл (Сургаалт үгс 24:9). Нүгэл бодол санаанд эхэлдэг. Үүнийг өөгшүүлж, дэмжих үед үйлдэл болж соёолно. Тэрхүү үйлдэл үхэл рүү хөтөлдөг. Гэм нүглийг анх төсөөлж эхлэхэд ихэнхдээ сэтгэл татам ч эцэстээ аймшигтай зүйл.

Паул заримдаа нүглүүдийг нүгэл гэдгээс ялгаж хэлдэг. Нүглүүд гэдэг нь бидний хийсэн буруу зүйлсийг илэрхийлнэ. Харин нүгэл гэдэг нь бидэнд байгаа бузар муу төрөлх мөн чанар буюу бид хэн бэ гэдгийг илэрхийлдэг. Гэтэл бид хэн бэ гэдэг нь бидний үйлдсэн нүглээсээ долоон дор байдаг. Харин Христ бидний төрөлх гэмт чанар төдийгүй нүгэлт үйлсийн төлөө амиа өгсөн. Бурхан бидний нүглүүдийг уучилдаг ч нүглийг уучилдаг гэж Библид огт дурдаагүй.

Харин нүглийг махан бие дотор *яллаж, шийтгэсэн* (Ром 8:3) гэдэг.

Мөн нүгэл ба алдаа зөрчлийн хооронд ялгаа бий. Алдаа зөрчил гэж мэдэж байгаа хуулийг зөрчихийг хэлнэ. Хулгай хийх нь ерөнхийдөө гэмт, буруу зүйл мөн. Харин хулгай хийхийг хориглосон хууль байгаа үед энэ нь алдаа зөрчил юм. “Хаана хууль үгүй байна, тэнд бас [алдаа] зөрчил гэж үгүй” (Ром 4:15).

Бүх хүн нүгэл үйлдсэн бөгөөд Бурханы алдарт хэзээ ч хүрэхгүй гэдгийг Паул харуулсан. Харин одоо Паул үүнээс хэрхэн эдгэрэх тухай ярих болно.

3:24 Түүний нигүүлслээр үнэгүй зөвтгөгдсөн билээ. Сайнмэдээнд Бурхан гэмт хүмүүсийг ямар ч төлбөр авалгүй, хүртэх зохисгүй ивээл хүртээн зөвтгөсөн. Тэгвэл зөвтгөсөн гэж ямар үйлдлийг хэлж байгаа вэ?

Зөвтгөх гэдэг үг зөвд тооцох, зөвт гэж зарлах гэсэн утгатай. Жишээлбэл, Эзэн Есүс Христэд итгэсэн гэмт хүнийг Бурхан зөвт хэмээн тунхагладаг. Энэ үгийг ийм байдлаар Шинэ гэрээнд хамгийн их хэрэглэсэн.

Гэхдээ хүн ч гэсэн Бурханы үгэнд итгэж, түүнийг дагаснаар Бурханыг зөвтгөдөг буюу түүний зөв шударга болохыг зөвшөөрч болно (Лук 7:29-ийг үз). Өөрөөр хэлбэл Бурханыг хэлсэн, хийсэн бүхэндээ зөв хэмээн тунхаглаж буй хэрэг юм.

Мэдээж хэрэг хүн өөрийгөө бас зөвтгөж буюу өөрийгөө зөв гэж эсэргүүцэж болно (Лук 10:29-

ийг үз). Гэвч энэ нь өөрийгөө хуурахаас хэтрэхгүй.

Зөвтгөнө гэдэг үнэндээ хэн нэгнийг зөвт болгоно гэсэн үг биш. Бид Бурханыг зөвт болгож чадахгүй. Бурхан угаас зөвт нэгэн. Харин бид Бурханы зөвт байдлыг *тунхаглаж* чадна. Бурхан итгэгч хүнийг нүгэлгүй эсвэл зөвт *болгодоггүй*. Үүний оронд Бурхан түүнийг зөвт хэмээн тооцдог. А. Т. Пиерсон “Бурхан зөвтгөхдөө зөвт бус гэмтнийг зөвт хэмээн нэрлэж, оршин байгаа нүглийг үл хэрэгсэн, үл оршин байгаа зөвт байдлыг тэдэнд оноодог”⁹ хэмээн бичсэн.

Зөвтгөлийн түгээмэл нэгэн тодорхойлолт: *Хэзээ ч гэм хийж байгаагүй мэт зөвт*. Гэхдээ үүгээр зогсохгүй. Бурхан итгэсэн гэмтнийг зөвтгөхдөө зөвхөн гэм буруугаас цагаатгаад зогсохгүй өөрийнхөө зөвт байдлаар хучин тэнгэрийн жишигт бүрэн дүйцэх хүн болгодог. “Зөвтгөл гэж хийсэн ялаас хэлтрүүлэх, гэм бурууг нь уучлахаас ч илүү зүйл билээ”¹⁰. Хэлтрүүлнэ гэж тухайн хүнийг зөвхөн ялаас чөлөөлдөг бол зөвтгөл нь түүнд эерэг зөв шударга байдлыг хамаатуулна гэсэн үг.

Эзэн Есүс Христ өөрийн үхэл ба амилалтаараа гэм нүглийнх нь төлөөсийг бүрэн төлсөн учраас бурханлаг бус нүгэлтнүүдийг Бурхан зөвт хэмээн тунхаглаж чадна. Гэмт хүмүүс Христийг итгэлээр хүлээн авснаар зөвд тооцогдоно.

Иаков үйлсээр зөвтгөгдөх тухай заахдаа (Иаков 2:24) биднийг сайн үйлсээр юм уу итгэл дээр сайн үйлсийг нэмснээр аврагдана гэж хэлэх гээгүй. Харин сайн үйлс итгэлийн үр дүнд бий болдог гэж хэлэхийг зорьсон.

Зөвтгөл гэдгийг Бурхан оюун санаандаа тооцохыг хэлж байгааг ойлгох нь чухал. Зөвтгөлийг итгэгч хүн мэдэрдэг юм биш, харин Библид хэлсэн учраас зөвтгөгдлөө гэдгээ мэддэг. С. А. Скофилд үүнийг ийнхүү илэрхийлсэн байна: “Зөвтгөл бол Есүс Христэд итгэсэн хүн бүрийг зөвт хэмээн зарлах Бурханы ажил бөгөөд Бурханы оюун бодол дотор явагддаг зүйл болохоос итгэгч хүний мэдрэлийн систем эсвэл сэтгэл хөдлөлд явагддаг зүйл биш.”

Энд Ром 3:24-т элч Паул биднийг **үнэгүй зөвтгөсөн** тухай ярьсан. Энэ нь бидний олж авч болох эсвэл худалдаж авч болох зүйл биш, харин бидэнд бэлэглэсэн зүйл юм.

Цааш нь уншвал бид Бурханы **нигүүлслээр зөвтгөгдсөн** гэдгийг олж мэднэ. Товчхондоо энэ нь биднээс огт шалтгаалахгүй гэсэн үг. Бидний хувьд зөвтгөлийг хүртэх зохисгүй, олж авъя гэж хайгаа ч үгүй, ямар нэгэн төлбөр хийгээгүй.

Будлиулахгүйн тулд Шинэ гэрээнд дурдсан зөвтгөл нь зургаан шинж төрхтэй гэдгийг энд тайлбарлая. Бид нигүүлсэл, итгэл, цус, хүч чадал, Бурхан, үйлсээр зөвтгөгдсөн гэж хэлдэг. Үүнд зөрчил байхгүй.

Нигүүлслээр зөвтгөгдсөн гэдэг нь бид зөвтгөгдөх зохисгүй байсан гэсэн үг.

Итгэлээр зөвтгөгдсөн (Ром 5:1) гэдэг нь бид Эзэн Есүс Христэд итгэснээр зөвтгөлийг хүлээн авсан гэсэн үг.

Цусаар зөвтгөгдсөн (Ром 5:9) гэдэг нь биднийг зөвтгөхийн тулд Аврагч Эзэн Есүсийн төлсөн хөлсийг хэлж байна.

Хүч чадлаар зөвтгөгдсөн (Ром 4:24, 25) гэж бидний Эзэн Есүсийг үхлээс амилуулсан тэр хүч чадлыг хэлж байна.

Бурханаар зөвтгөгдсөн (Ром 8:33) гэдэг нь Бурхан бол биднийг зөвт хэмээн тооцсон Нэгэн.

Үйлсээр зөвтгөгдсөн (Иаков 2:24) гэж сайн үйлс бүтээснээр зөвтгөлийг олж авдаг гэсэн үг биш, харин сайн үйлс нь бид зөвтгөгдсөний нотолгоо болдог.

3:24 уруу эргээд ороход **Христ Есүс доторх золилтоор дамжуулан** бид зөвтгөгдсөн гэжээ. **Золилт** гэдэг нь зохих төлөөсийг нь төлөөд эргүүлэн худалдаж авах гэсэн утгатай. Эзэн Есүс Христ биднийг гэм нүглийн боол болон зах дээр зарагдаж байхад буцааж худалдан авсан билээ. Түүний үнэт цус ариун, зөвт Бурханы шаардлагыг хангахын тулд өгсөн төлөөс байсан юм. Хэрэв хэн нэг хүн “Төлөөсийг хэнд төлсөн юм бэ?” гэж асуувал тэрбээр гол утгыг нь ойлгоогүй хэрэг юм. Төлөөсийг Бурханд эсвэл Сатанд тодорхой төлбөр хийсэн гэх санаа Бичээсийн хаана ч үгүй. Төлөөсийг хэн нэгэнд төлөөгүй, харин нүгэлт

хүмүүсийг аврах зөвт үндэслэлийг Бурханд өгсөн абстракт шийдэл байсан.

3:25 Бурхан Есүс Христийг эвлэрүүлэл гэж нийтэд харуулав. Эвлэрүүлэл гэдэг нь шударга ёс хангагдсан, Бурханы уур хилэн зайлсан, хүлээн зөвшөөрхүйц тахил дээр үндэслэн өршөөлийг үзүүлэх боломжтой болсон гэсэн утгатай болно.

Шинэ гэрээнд Есүс Христийг гурван удаа эвлэрүүлэл гэж хэлсэн. Энэ Ром 3:25-д Христэд итгэлээ өгсөн хүмүүс Есүсийн урсгасан цусны хүчээр өршөөлийг хүртдэг гэж зааж байна. 1Иох 2:2-т Есүс Христийг бидний гэм нүгэл төдийгүй бүх ертөнцийн гэм нүглийн эвлэрүүлэл гэж хэлсэн. Түүний ажил бүх ертөнцийн нүглийг үүрэхэд бүрэн хангалттай боловч түүнд итгэлээ өгсөн хүмүүс л үр дүнг нь амсаж чадна. Эцэст нь 1Иох 4:10-т Бурхан Хүүгээ бидний гэмийн төлөөх эвлэрүүлэл болгон илгээснээр хайраа харуулсан гэв.

Лук 18:13-т гарч байгаа татвар хураагчийн залбирлыг үгчилбэл, “Бурхан та гэмт надад эвлэрэнгүй хандаач” хэмээн ойлгож болно. Тэрбээр гэм буруугийнхаа шийтгэлийг төл гэж шаардалгүй өршөөл үзүүлээч хэмээн Бурханаас гуйсан.

Эвлэрүүлэл гэдэг үг нь мөн Еврейчүүд 2:17-д гардаг: “Тиймээс Бурханд *хамаарах* юмсад өршөөнгүй, итгэмжит Тэргүүн Тахилч болж хүмүүсийн нүглийн төлөөх эвлэрүүллийг хийхийн тулд тэр бүх талаараа өөрийн ах дүү

нартайгаа төстэй болгогдох ёстой байв.” Энд гарч буй “эвлэрүүлэл хийх” гэдэг нь шийтгэлийг төлж зайлуулах гэсэн утгатай.

Эвлэрүүлэлтэй ижил утга санааг илэрхийлдэг Хуучин гэрээний ойлголт бол *өршөөлийн суудал* юм. Өршөөлийн суудал нь гэрээний авдарны таг байв. Эвлэрүүллийн өдөр болоход тэргүүн тахилч тахилд өргөсөн малын цусыг өршөөлийн суудал уруу цацна. Ингэснээр тэргүүн тахилч ба нийт ард түмний алдаа гэм цагаатгагдаж, халхлагддаг байжээ.

Христ бидний гэмийн төлөө эвлэрүүлэл болохдоо үүнээс илүү дээр ажлыг гүйцээсэн. Тэр *гэмийг* зөвхөн *далдалж халхлаагүй* харин *нэг мөсөн зайлуулсан*.

Тэгвэл 3:25-д Паул бидэнд **итгэлээр дамжуулан Бурхан Түүнийг цусаар нь эвлэрүүлэл гэж нийтэд харуулав** хэмээн хэлсэн байна. Энд Түүний цусанд итгэлээ өг гэж бидэнд хэлээгүй. Бид *Христэд* итгэх учиртай. Үхлээс амилсан, одоо ч амьд байгаа Христ Есүс л биднийг аварч чадна. Тэр бол эвлэрүүлэл билээ. **Эвлэрлийг** авах нөхцөл нь түүнд **итгэлээ** өгөх явдал мөн. **Түүний цус** бол төлбөр нь юм.

Христийн гүйцээсэн ажил Бурхан өнгөрсөн гэм **нүглийг** хүлцэн тэвчихдээ **зөв** байсан хэмээн тунхагладаг. Энэ нь Христийн үхлээс өмнө үйлдэгдсэн гэм нүглийн тухай хэлж байна. Адамаас Христийг хүртэл Бурхан өөрийнх нь өгсөн аливаа нэг илчлэлтэд тулгуурлан өөрт нь

итгэсэн хүмүүсийг аварч байв. Жишээлбэл, Абрахам Бурханд итгэсэн нь түүнийг зөвд тооцуулсан (Эхлэл 15:6). Гэвч Бурхан үүнийг яаж шударгаар хийсэн бэ? Гэмгүй Золиос өргөгдөөгүй байсан. Төгс Тахилын цус урсаагүй байсан. Нэг үгээр хэлэхэд Христ үхээгүй байсан. Өр төлөөс төлөгдөөгүй байсан. Бурханы шударга шаардлага хангагдаагүй байсан. Тэгвэл Бурхан итгэсэн нүгэлтнийг Хуучин гэрээний үед хэрхэн аварч байсан бэ?

Үүний хариу нь: Хэдийгээр Христ хараахан үхээгүй байсан боловч Бурхан *үхнэ* гэдгийг нь мэдэж байсан ба Христийн ирээдүйд хийх ажил дээр үндэслэн хүмүүсийг аварч байв. Хэдийгээр Хуучин гэрээний итгэгч нар Есүсийг цовдлогдох тухай мэдэхгүй байсан ч *Бурхан* мэдэж байсан ба өөрт нь итгэсэн хүмүүст Христийн ажлын үнэ цэнийг тохоон тооцдог байжээ. Хуучин гэрээний итгэгчид жинхэнэ утгаараа зээлээр аврагдсан. Тэд төлөгдөх төлбөрийн үндсэн дээр аврагдсан. Тэд Есүсийн цовдлогдох үе болох ирээдүй рүү хардаг байсан бол бид өнгөрсөн рүү хардаг.

Христийн эвлэрүүлэл **урьд үйлдэгдсэн нүглүүдийг тэвчин өнгөрүүлсэн** Бурханы **зөвт байдлыг** тунхагладаг гэх Паулын үг ийм утгатай ажээ. Зарим хүний буруу боддог шиг хэн нэг хувь хүний Христэд итгэхээсээ өмнө үйлдсэн гэм нүглийн талаар Паул яриагүй. Тэгвэл Христийн хийсэн ажил хүний дахин төрөхөөс өмнөх гэм нүгэлд л хамаатай, түүнээс

хойших гэм нүглээ хүн өөрөө хариуцах хэрэгтэй гэсэн санааг төрүүлнэ. Үгүй ээ, харин Христийг загалмай дээр цовдлогдохоос өмнөх үед аврагдсан хүмүүсийн гэм нүгэлд Бурхан хүлцэнгүй хандсаныг тайлбарлаж байна. Бурхан тэдгээр гэм нүглийг зүгээр өнгөрөөсөн юм уу хараагүй мэт дүр эсгэсэн гэж санагдаж болох юм. Тийм биш ээ гэж Паул хэлж байна. Христ бүрэн дүүрэн цагаатгалыг хийнэ гэдгийг Эзэн мэдэж байсан бөгөөд тэрбээр үүнд үндэслэн хүмүүсийг аварсан юм.

Тиймээс Хуучин гэрээний үе нь Бурханы **тэвчин өнгөрүүлсэн** цаг байв. Наанадаж 4000 жилийн хугацаанд Бурхан гэм нүглийг шүүх шүүлтээ хойшлуулсан. Тэгээд цаг нь ирэхэд тэр өөрийн Хүүг гэм нүглийг үүрүүлэхээр энэ дэлхийд илгээв. Эзэн Есүс бидний гэм нүглийг өөр дээрээ авах үед Бурхан зөв шударга хилэнгээ зад асгаж, ариун уураа хайрт Хүү дээрээ буулгав.

3:26 Одоо Христийн үхэл Бурханы **зөвийг** тунхаглаж байна. Бурхан гэмийн шийтгэлийг бүрэн төлөхийг шаардсан учраас тэр бол **шударга**. Төгс Тахил үхэж амилсан учраас Бурхан өөрийн шударга чанарыг сэвтээхгүйгээр бурханлаг бус хүмүүсийн гэм нүглийг өөгшүүлэлгүйгээр тэднийг зөвтгөж чадна. Алберт Мидлэйн өөрийн шүлэгтээ уг үнэнийг ийн буулгасан:

*Бурханы төгс зөвт байдлыг
Аврагчийн цус гэрчилнэ
Христийн загалмай дээрээс бид
Зөвт байдлыг болон гайхамшигт хайрыг олж харна
Бурхан гэмийг зүгээр өнгөрөөхгүй
Нүгэл хилэнц үхлийг шаарддаг
Гэвч Христийн загалмай дээр бид
Бурхан зөв шударгаар аварч чадахыг харна
Гэм нүглийг Аврагч дээр тохоож
Цусаар нь нүглийн төлөөсийг хангав
Шударга ёс золиосонд ханаж
Өршөөл энэрэл гэмтнийг чөлөөлөв
Нүгэлт хүмүүн нь итгэж чөлөөлөгдөнө
Аврагч миний төлөө үхсэн гэх эрхтэй тэр
Нүглийг цагаатгагч цус уруу заагаад
Үүгээр Бурхантай амгалан болсон гэнэ*

3:27 Тэгвэл энэ гайхалтай авралын төлөвлөгөөнд сайрхал хаана байна вэ? Сайрхлыг зайлуулж, таглаж, хориглосон. Ямар зарчмаар сайрхлыг үгүй хийв? Үйлсийнх үү? Үгүй. Хэрэв аврал нь үйлсээр байсан бол өөрөөрөө сайрхах боломжийг олгох байсан. Гэтэл аврал итгэлийн зарчмаар ирдэг тул сайрхах юм алга. “Би хамаг нүглийг үйлдсэн. Есүс хамаг авралыг үйлдсэн” хэмээн зөвтгөгдсөн хүмүүс ярьдаг. Жинхэнэ итгэл нь өөртөө туслах, өөрийгөө сайжруулах, өөрийгөө аврах аливаа замыг үгүйсгэж, зөвхөн Христийг Аврагчаа болгодог. Үүнийг ийн хэлж болох юм:

*Гарт минь ямар ч төлөөс үгүй
Ганцхан загалмайг би зорьсон
Хоосон би, танаас хувь горьдоно
Арчаагүй би, танаас нигүүлсэл хүлээнэ
Бохир би, цэнгэг ус уруу тэмүүлье
Аврагч та, намайг угаагаач, эс бөгөөс би үхнэ
- Августус М. Топлади*

3:28 Сайрхал зайлуулагдсан шалтгааныг Паул хүн хуулийн үйлсээс ангид, итгэлээр зөвтгөгддөг хэмээн давтан хэлж байна.

3:29 Сайнмэдээ Бурханыг яаж харуулдаг вэ? Бурхан зөвхөн **Иудейчүүдийнх юм гэж үү?** Үгүй, Тэр бас **харь үндэстнүүдийн Бурхан** мөн. Эзэн Есүс Христ нэг үндэстний төлөө үхээгүй, харин бүх хүн төрөлхтний төлөө үхсэн. Тийнхүү Иудей ба харь үндэстэн аль нь ч бай, хүссэн бүхэнд бүрэн дүүрэн, үнэгүй авралыг санал болгодог.

3:30 Нэг нь иудейчүүдийн, нөгөө нь харь үндэстнүүдийн гэсэн хоёр Бурхан байхгүй. Бүх хүн төрөлхтөнд **ганц Бурхан**, ганц л авралын зам бий. Тэрээр **хозлуулсныг нь ч итгэлээр, хозлуулаагүйг нь ч итгэлээр** зөвтгөдөг Бурхан мөн. Үгийн араас залгах нөхцөлийг (**-ээр, -ийн дагуу¹¹**) яаж ч өөрчилсөн бай зөвтгөлийг авах нөхцөл буюу болзол хэвээрээ байна. Зөвтгөлийн болзол зөвхөн итгэл юм.

3:31 Эндээс нэгэн чухал асуулт урган гарна. Авралыг хууль дагаснаар биш, итгэлээр олж авдаг гэвэл хууль ач холбогдолгүй, тоохгүй байж болно гэсэн үг үү? Сайнмэдээ хуулийг

хойш тавьдаг уу? Огтхон ч үгүй. **Харин ч**, сайнмэдээ нь **хуулийг** улам бататгадаг. Хэрхэн бататгадгийг доор сийрүүлье:

Хууль нь төгс дуулгавартай байдлыг шаарддаг. Хуулийг зөрчсөний төлөөх шийтгэлийг бид заавал төлөх ёстой. Тэрхүү шийтгэл бол ҮХЭЛ. Хэрэв хууль зөрчигч хүн шийтгэлийн төлөөсийг төлбөл тэрээр мөнхөд амиа алдана. Тэгвэл сайнмэдээ нь хууль зөрчсөний шийтгэлийг Христ үхлээрээ хэрхэн төлсөн тухай ярьдаг. Есүс хуулийг хэрэгсэх хэрэггүй зүйл гэж хандаагүй. Харин ч тэр өрийг бүрэн төлсөн. Христ өмнөөс нь шийтгэлийн төлөөсийг төлснийг хууль зөрчсөн хүн өөртөө хамааруулж болно. Ийнхүү итгэлээр олддог авралын тухай сайнмэдээ нь хуулийн бүх нөхцөлийг бүрэн хангагдсан байхыг шаарддаг учраас хуулийг бататгаж байна.

Д. Сайнмэдээ ба Хуучин гэрээний нийцэл (4-р бүлэг)

Паулын тав дахь үндсэн асуулт: *Сайнмэдээ Хуучин гэрээний бичээстэй таардаг уу?* Хариулт нь Иудей хүмүүст онцгой ач холбогдолтой байсан. Тийм учраас элч Паул Шинэ гэрээний сайнмэдээг Хуучин гэрээний бичээстэй бүрэн нийцдэг болохыг харуулсан. Зөвтгөл нь ямар ч үед итгэлээр ирнэ.

4:1 Паул Израилийн түүхэн дэх хамгийн нөлөө бүхий Абрахам ба Давид гэсэн хоёр

хүний жишээгээр хэлж буй зүйлээ баталсан. Бурхан энэ хоёр хүнтэй хоёулантай нь агуу гэрээ байгуулсан. Нэг нь хууль өгөгдөхөөс хэдэн зууны өмнө амьдарч байсан бол нөгөө нь хууль өгөгдсөнөөс хойш олон жилийн дараа амьдарч байв. Нэг нь хозлуулахаасаа өмнө, нөгөө нь хозлуулсныхаа дараа зөвтгөгдсөн.

Эхлээд **Абрахамын** тухай авч үзье. Бүх иудейчүүд түүнийг өөрсдийн өвөг эцэг гэж үздэг. **Махан биеийн дагуу** тэрээр юу туулсан бэ?¹² Хүн зөвтгөлийг олж авах арга замын талаар тэр юуг олсон бэ?

4:2 Хэрэв Абрахам үйлсээрээ зөвтгөгдсөн бол дараа нь түүнд сайрхах шалтгаантай болох байсан. Тэр өөрийгөө **Бурханы өмнө** зогсож чадах зөвт болгож чадсандаа өөртөө баяр хүргэх байсан. Гэвч ингэх ямар ч боломжгүй. Бурханы өмнө хэн ч сайрхаж чадахгүй (Ефес 2:9). Абрахам үйлсээрээ зөвтгөгдсөн гэж сайрхах юмтай байсан гэх нэг ч зүйл Бичээст байхгүй.

Тэгвэл зарим хүмүүс, “Иаков 2:21-т Абрахамыг үйлсээр зөвтгөгдсөн гэж байдаг шүү дээ” хэмээн маргаж магад. Тийм ээ, байдаг. Гэхдээ утга санаа нь нэлээн өөр. Эхлэл 15:6-д дурдсанчлан үй түмэн үр садтай болгоно гэсэн Бурханы амлалтад итгэсэн учраас Абрахам зөвд тооцогдсон. Энэ явдлаас хойш гуч гаруй жилийн дараа Исаакийг шатаалт тахил болгон өргө хэмээх Бурханы тушаалыг (Эхлэл 22) биелүүлэх гэж явахдаа Абрахам үйлсээр зөвтгөгдсөн (цагаатгагдсан). Дуулгавартай

байдлын энэ үйлдэл нь түүний итгэл бодитой байсныг баталсан. Түүний үйлдэл нь итгэлээр зөвтгөгдсөн гэдгийн гадаад илрэл нь байв.

4:3 Абрахам хэрхэн зөвтгөгдсөн тухай **Бичээст юу гэж байдаг вэ?** “Абрахам Бурханд итгэсэн, энэ нь түүнийг зөвд тооцуулсан” (Эхлэл 15:6) гэдэг. Бурхан өөрийгөө Абрахамд илчилсэн бөгөөд үй түмэн үр удамтай болгоно гэж амласан. Өвөг Абрахам Эзэнд итгэсэн учраас Бурхан түүнийг **зөвд** тооцжээ. Өөрөөр хэлбэл Абрахам итгэлээр зөвтгөгдсөн. Ийм л энгийн. Үйлсээр зөвтгөгдсөн юм юу ч байхгүй. Үйлсийн тухай дурдаа ч үгүй байна.

4:4 Ажил үйлс ба итгэл нь авралын төлөвлөгөөнд ямар эсрэг тэсрэг зүйл болохыг Библид өгүүлсэн хамгийн агуу мэдэгдлийг эндээс бид харж болно.

Ингэж бодоорой: Хүн амьдралаа залгуулахын тулд ажил хийгээд сарын эцсээр төлбөр авахдаа авбал зохих **цалин хөлсөө** авдаг. Тэрээр өөрийн хүч хөдөлмөрөөр олж авсан тул ажил олгогчийнхоо өмнө бөхөлзөж, тонголзохгүй. Аль эсвэл ажил олгогчдоо ийм их сайхан сэтгэл үзүүллээ гэж баярлахгүй, би энэ мөнгийг авах албагүй байсан гэж эсэргүүцэхгүй. Огт тэгэхгүй! Тэр халаасандаа мөнгөө хийгээд гэртээ харихдаа өөрийн зарцуулсан цаг, хөдөлмөрөө л нөхөж авсан гэж бодно.

Харин зөвтгөл тийм биш.

4:5 Хэчнээн цочирдмоор сонсогдсон ч зөвтгөгдсөн **хүн** юуны түрүүнд **ажил**

хийдэггүй. Тэрбээр өөрийн хөлсөөр авралыг олж авах ямар ч боломж байхгүй гэж тунхаглана. Тэрээр хувийн гавьяа зүтгэл, сайн үйлсэд ач холбогдол өгөхгүй. Хамаг сайн ажил үйлс нь ч Бурханы зөвт байдлын шаардлагыг хэзээ ч хангахгүй гэдгийг тэр хүн ойлгодог ажээ.

Үүний оронд тэр хүн *бурханлаг бус хүнийг зөвтгөдөг түүнд итгэдэг билээ.* Тэр өөрийн итгэл, найдвараа Эзэнд өгсөн байна. Тэр Бурханыг Үгийнх нь дагуу хүлээн авдаг. Энэ бол гавьяат үйлс биш гэдгийг бид түрүүн үзсэн. Гавьяа нь түүний итгэлд байгаа юм биш, харин *итгэлийнх нь Объектод* байгаа юм.

Бурханлаг бус хүнийг зөвтгөдөг Түүнд итгэдэг гэснийг анхаараарай. Тэр хүн Бурханы өмнө ирэхдээ би чадлаараа хичээсэн, алтан дүрэм баримталж амьдарсан, бусад шиг муу байгаагүй хэмээн өмгөөлөхгүй. Харин *бурханлаг бус*, гэм буруутай хүн гэдэг үнэн төрхөөрөө ирж, өөрийгөө Бурханы өршөөлд бүрэн даатгадаг.

Тэгвэл үр дүн нь юу вэ? **Итгэл нь түүнийг зөвд тооцуулдаг.** Тэр хүн үйлс буян бүтээсээр ирэхийн оронд итгэлээр ирсэн учраас Бурхан түүний дээр **зөвт байдлыг** тохоожээ. Дахин амилсан Аврагчийн гавьяагаар Бурхан түүнд **зөвт байдлыг** өмсгөсөн тул тэрбээр тэнгэрийн улсад орох бүрэн эрхтэй болдог. Тиймээс Бурхан түүнийг Христ дотор байгаагаар харах бөгөөд тэр үндсэн дээр түүнийг хүлээн авдаг.

Дүгнэн үзвэл зөвтгөл нь бурханлаг бус хүмүүст зориулагдсан болохоос сайн хүмүүст зориулагдаагүй. Зөвтгөл гэдэг өр төлөөсийн бус хайр нигүүлслийн хэрэг мөн. Зөвтгөлийг үйлсээр бус итгэлээр хүлээн авах боломжтой.

4:6 Дараа нь Паул өөрийн сургаалаа батлахын тулд **Давидыг** иш татсан. Паул үгээ **түүнчлэн** гэж эхлүүлсэн нь Давид ч бас Абрахамтай адил замаар зөвтгөгдсөнийг харуулж байна. Бурханд **үйлсгүйгээр** зөвд тооцогдсон хүн ерөөлтэй хэмээн Израилийн хайртай дууч хэлсэн билээ. Давид хэдийгээр энэ тухай олон юм ярьж байгаагүй боловч Дуулал 32:1,2 дээр энэ тухай хэлсэн. Үүнийг нь Паул дараагийн хоёр ишлэлд иш татсан.

4:7 **Хууль бус явдал нь уучлагдаж,
Нүглүүд нь далдлагдсан хүмүүс
ерөөлтэй.**

4:8 **Эзэн нүглийг нь огт үл тооцох
Тэр хүн ерөөлтэй.**

Эдгээр ишлэлээс Паул юуг олж харсан бэ? Юун түрүүнд, Давид үйлсийн тухай огт яриагүй гэдгийг Паул анзаарсан. Мөн уучлал бол Бурханы нигүүлслийн асуудал болохоос хүний хичээл зүтгэл биш гэдгийг олж харсан. Хоёрдугаарт, хүний **нүглийг** Бурхан **үл тооцвол** тэр хүн Бурханы өмнө зөвт хүн байж таарах нь. Эцэст нь, бурханлаг бус хүнийг Бурхан зөвтгөдөг юм байна гэдгийг олж харсан. Давид завхайрал, аллага үйлдсэн гэмт хүн байсан боловч энд хэлсэн байдлаас нь харахад

тэрбээр бүрэн дүүрэн, үнэгүй өршөөл уучлалын амтыг мэдэрч байжээ.

4:9 Гэвч зарим Иудей хүмүүсийн сэтгэлд хаа нэгтээ Бурханы сонгосон ард түмэн л Бурханы зөвтгөлийг хүртэнэ гэх юм уу хозлуулагсдыг л Бурхан зөвтгөнө гэх санаа нуугдаж байж болох юм. Тиймээс элч Паул **Абрахамын** жишээ рүү дахин очиж тийм биш гэдгийг харуулсан. Паул “Итгэсэн иудейчүүд зөвхөн зөвтгөгдөх үү? Харь үндэстнүүдээс итгэвэл тэд зөвтгөгдөх үү?” гэдэг асуултыг тавьжээ. Абрахамын жишээ нь зөвхөн иудейчүүд гэсэн санааг өгч байгаа мэт харагдаж болох юм.

4:10 Гэтэл Паул энд бидний тэр бүр анзаардаггүй түүхэн баримтыг дурдсан. Абрахам **хозлуулахаасаа** (Эхлэл 17:24) өмнө зөвтгөгдсөн (Эхлэл 15:6) гэдгийг Паул дэлгэн тавьсан. Хэрэв Израиль үндэстний өвөг эцэг нь **хозлуулаагүй байхдаа** зөвтгөгдсөн юм бол “Яагаад хозлуулаагүй бусад хүн зөвтгөгдөж болохгүй вэ?” гэсэн асуулт гарч ирнэ. Бүр нарийн яривал Абрахам харь үндэстний байр суурин дээр байхдаа зөвтгөгдсөн байна. Ийнхүү хозлуулахгүйгээр зөвтгөгдөж болох өргөн хаалгыг харь үндэстнүүдэд нээлттэй үлдээсэн ажээ.

4:11 Тэгэхээр Абрахамын зөвтгөгдсөн шалтгаан нь **хозлол** байгаагүй юм. Хозлол нь итгэлээрээ зөвтгөгдсөн гэдгийг илтгэх махан биеийн **тэмдэг** байв. Үндсэндээ хозлол нь Израилийн ард түмэн ба Бурханы хоорондох

гэрээний гадаад бэлэг тэмдэг ажээ. Абрахамын хувьд хозлол хийхийн утга санаа нь илүү өргөн агуулгатай бөгөөд итгэлд нь үндэслэн Бурханаас өгсөн зөвт байдлыг харуулж байсан билээ.

Тэмдэг гэдгээс гадна хозлол нь тамга юм. **Абрахам хозлуулаагүй үедээ итгэлийн зөвийн тамга...** Тэмдэг гэдэг нь илэрхийлж байгаа зүйлийнхээ оршин байгааг илэрхийлдэг. Тамга гэдэг нь илэрхийлж байгаа зүйлийнхээ үнэн мөнийг баталж, зөвшөөрч, гэрчилж, нотолдог. Абрахам итгэлээр дамжин Бурханы хувьд зөв шударга нэгэн болсон гэдгийн баримт нь хозлол байжээ.

Хөвч хөндөлт бол Абрахамын **итгэлийн зөвийн тамга байв**. Энэ нь Абрахамын итгэл зөв байсан гэх юм уу Абрахам итгэлээр дамжуулан зөв болсон гэх утгатай. Хоёр дахь нь хамгийн зөв утга гэж бид үздэг. Өөрөөр хэлбэл **хөвч хөндөлт** бол түүний **итгэлд** хамаардаг буюу **итгэлээрээ** олж авсан зөвт байдлын тамга ажээ.

Абрахам хозлуулахаас өмнө зөвтгөгдсөн учраас тэр итгэгч харь үндэстнүүд болох **хозлуулаагүй хүмүүсийн эцэг** болж чадна. Тэдгээр харь үндэстнүүд ч бас Абрахамын нэгэн адил итгэлээр зөвтгөгдөж чадна.

Абрахам итгэгч харь үндэстнүүдийн эцэг гэдэг нь махан биеийн гарал үүслийн тухай ойлголт мэдээж биш. Энгийнээр утгыг нь тайлбарлавал, итгэгч харь үндэстнүүд

Абрахамын итгэлийг даган дуурайсан учраас түүний хүүхдүүд гэж нэрлэгддэг. Тэд мах, цусан төрлөөрөө Абрахамын хүүхдүүд биш ч, түүний замнал ба үлгэр жишээг дагаж байгаагаараа түүний хүүхдүүд юм. Мөн энэ ишлэлд итгэсэн харь үндэстнүүд нь Бурханы Израиль болно гэж заагаагүй. Бурханы Израиль нь Есүс Христийг өөрсдийн Аврагч Эзэн Мессиа хэмээн хүлээн авсан иудейчүүдээс бүрдэнэ.

4:12 Абрахам **хөвч хөндөлтийн** тэмдгийг хүлээн авсан өөр нэг шалтгаан бий. Юу гэхээр зөвхөн хозлуулсан байхаас гадна Абрахамын **итгэлээр** замнах, өөрөөр хэлбэл **хозлуулаагүй байхад** нь Абрахамд байсан тэрхүү **итгэлийн** замаар алхах иудейчүүдийн эцэг болохын тулд тэр хозлолыг хүлээн авсан билээ.

Абрахамын үр удам байх ба Абрахамын хүүхдүүд байх хоёр хоорондоо ялгаатай. Есүс Фарисайчуудад, “Та нарыг би Абрахамын үр удам гэдгийг мэднэ” (Иохан 8:37) гэж хэлсэн. Гэхдээ цааш нь Есүс “Хэрэв та нар Абрахамын хүүхдүүд байсан бол Абрахамын хийснийг хийх байсан” (Иохан 8:39) гэж хэлсэн. Тиймээс Паул энд бие махбодын хозлол нь гол хүчин зүйл биш гэдгийг дахин онцолж байна. Хамгийн гол нь амьд Бурханд итгэх **итгэл** байх ёстой. Эзэн Есүс Христэд итгэгч **хозлуулсан хүмүүс** нь Бурханы жинхэнэ Израиль мөн.

Дүгнээд хэлэхэд, Абрахамын амьдралд хозлуулаагүй мөртлөө итгэж байсан үе байжээ.

Мөн итгэсэн бөгөөд хозлуулсан үе ч байв. Паул бүргэдийн нүдээр энэ баримтын цаана итгэсэн харь үндэстнүүд ба итгэсэн иудейчүүд хоёулаа Абрахамыг эцэг хэмээн дуудаж болно гэдгийг, тэдний хэн хэн нь Абрахамын хүүхдүүд мөн гэдгийг мэдэгдсэн.

4:13 “Логик ба Бичээст байгаа боломжит гаргалгаа бүрийг Паул авч үзээд мэтгэн сөргөж болох бүх асуултад хариулах тусам маргаан цааш үргэлжилсээр байна.”¹³ Харин одоо элч Паул, хуулиар дамжин ерөөл ирдэг тул хуулийг үл мэдэгч харь үндэстнүүд хараалын дор байдаг хэмээх үзлийг няцаах хэрэгтэй болж байна (Иохан 7:49-ийг үз).

Бурхан **Абрахам** болон **түүний үр удамд ертөнцийн өв залгамжлагч** болно гэж амлахдаа ямар нэгэн хуулийг чандлан мөрдөх тохиолдолд л энэ амлалт биелнэ гэсэн шаардлага тавиагүй. (Хууль үүнээс хойш 430 жилийн дараа өгөгдсөн - Галат 3:17.) Бурхан Абрахамд болзолгүй нигүүлслийн **амлалт** өгсөн. Энэ амлалтыг **итгэлээр** хүлээн авдаг. Өнөөдөр ч гэсэн тэр л **итгэлээр** бид Бурханы зөвт байдлыг олж авдаг.

Энэ ертөнцийн өв залгамжлагч гэдэг нь Абрахам итгэсэн харь үндэстнүүд төдийгүй Иудей хүмүүсийн өвөг эцэг болно (4:11, 12), зөвхөн иудейчүүдийн биш, олон үндэстний эцэг болно (4:17-18) гэсэн үг. Абрахамын үр Эзэн Есүс бүх ертөнцийг хаанчлах эзэнт гүрнийхээ очирт таягийг барин хаадын Хаан ба эздийн

Эзэн болж захирах цагт энэ амлалт бүрэн биелнэ.

4:14 Бурханы ерөөлийг, тэр дундаа зөвтгөлийн ерөөлийг эрэн хайгч нар хуулийг дагаснаар зөвтгөлийг өвлөдөг байсан бол **итгэл нь хоосон болгогдсон ба амлалт нь устгагдсан юм.** Итгэл нь хуулийн эсрэг зарчим учраас түүнээс тусдаа байдаг. **Итгэл** нь *итгэх* тухай байдаг бол **хууль** нь *үйлдэх, хийх* тухай байдаг. Тийм тохиолдолд хэн ч биелүүлж чадахгүй нөхцөлтэй болох учраас амлалт нь дэмий хоосон зүйл болно.

4:15 Хууль Бурханы ерөөлийг биш харин түүний **уур хилэнг авчирдаг.** Хууль захирамжуудыг нь тасралтгүй төгс дагаагүй хүмүүсийг ялладаг. Үүнийг хэн ч хийж чадахгүй учраас хуулийн доор байгаа бүх хүн үхэх ялтай болжээ. Тиймээс хуулийн дор байгаа хүмүүс бүгд хараалын дор байдаг аж.

Гэвч **хаана хууль байхгүй байна тэнд** [алдаа] **зөрчил гэж байхгүй.** Алдаа **зөрчил** гэдэг нь тогтоосон хуулийг зөрчихийг хэлдэг. Хууль байхгүй газар нүгэл гэж байхгүй гэж Паул хэлээгүй. Буруутгасан хууль байхгүй боловч буруу үйлдэл гэж бий. Харин “Хурдны дээд хязгаар 32 км/ц” гэсэн тэмдэг байсаар атал үүнийг биелүүлээгүй нь [алдаа] **зөрчил юм.**

Хуультай байснаар ерөөлийг өвлөсөн хэмээн иудейчүүд бодсон боловч үнэндээ тэдний өвлөсөн зүйл нь **зөрчил** байв. Бурхан хуулийг өгөхдөө нүглийг зөрчил болгон харуулахыг

хүссэн. Өөрөөр хэлбэл нүглийг бүхий л гэмт байдал дотор нь харуулахыг хүссэн. Бурхан хуулийг өгөхдөө нүгэлт мөн чанартай, гэм зөрчил үйлдэгч хүмүүсийг аврах арга зам болгохыг хэзээ ч зориогүй.

4:16 Хууль нь Бурханы зөвтгөлийг биш, харин уур хилэнг төрүүлдэг учраас итгэлээр дамжин өгдөг өөрийн нигүүлслээр хүнийг аврахаар шийдсэн. Бурхан мөнх амьдралыг энгийн **итгэлийн** үйлдлээр хүлээн авах бурханлаг бус нүгэлтнүүдэд үнэгүй, тэдний хүртэх зохисгүй бэлэг болгон өгнө.

Ийнхүү амийн **амлалт** нь **бүх үр удамд баталгаатай** болох юм. Энд хоёр үгийг онцлох ёстой: *баталгаатай, бүх*. Нэгдүгээрт, Бурхан **амлалтаа баталгаатай** байхыг хүссэн. Хүн хуулийг сахиснаар зөвтгөлийг авна гэвэл энэ нь хэзээ ч баталгаатай байж чадахгүй. Яагаад гэвэл тэр хүн хангалттай сайн үйл хийсэн үү, үгүй юу, зөв төрлийн зүйлийг хийсэн үү, үгүй юу гэдгээ мэдэхэд хэцүү. Ийм тохиолдолд авралыг *үйлсээр олж авахыг* оролдож байгаа хүнд бүрэн баталгаа өгч чадахгүй. Харин зөвтгөлийг итгэлээр дамжуулан бэлэг болгон хүлээн авах үед хүн Бурханы үгийн эрх мэдлийн дагуу аврагдсан болохоо баттай мэдэж чадна.

Хоёрдугаарт, Бурхан **амлалтаа бүх үр удамд, зөвхөн хууль** өгөгдсөн иудейчүүд **төдийгүй Абрахамтай** адил замаар Эзэнд найдвараа тавьсан харь үндэстнүүдэд хүртэл **баталгаатай** байхыг хүссэн. **Абрахам бол** Эзэнд итгэлээ

тавьсан **бүх** иудей ба харь үндэстэн буюу **бид бүгдийн эцэг мөн**.

4:17 Абрахам бол үнэн сэтгэлээс итгэгч бүгдийн эцэг гэдгийг батлахын тулд Паул Эхлэл 17:5-ыг хаалтан дотор иш татсан: **“Би чамайг олон үндэстний эцэг болгосон”**. Израилийг энэ дэлхий дээрх ард түмнээ болгосон Бурханы сонголт нь түүний өршөөл, нигүүлслийг зөвхөн Израильчуудаар *хязгаарласан* хэрэг биш юм. Хэн байх нь хамаагүй, итгэл л байвал Бурхан үргэлж хүндэлнэ гэдгийг элч Паул ойлгуулахын тулд Хуучин гэрээнээс удаа дараа иш татаж байна.

Өөрийн итгэсэн Бурханы өмнө гэдэг нь 4:16-д гарсан “Абрахам бол бид бүгдийн эцэг мөн” гэсэн санааг үргэлжлүүлж байна. Хэрхэн холбогдох вэ гэвэл: **Үхэгсдэд амь өгөгч, байхгүй** байгаа зүйлийг хэдийнээ болж, **байгаагаар дуудагч**, Абрахамын итгэсэн тэр **Бурханы өмнө** Абрахам бол бид бүгдийн эцэг мөн. Бурханы талаарх энэ тодорхойлолтыг ойлгохын тулд дараагийн ишлэлүүдийг нь бид харах хэрэгтэй. **Үхэгсдэд амь өгөгч Бурхан** гэдэг үгийг Абрахам, Сара нарт хамааруулж хэлсэн. Хэдий тэд биеэрээ үхээгүй байсан боловч үр хүүхэдгүй өтөлж, хүүхэд төрүүлэх наснаас хэтэрсэн байсан (4:19-ийг үз). Бурхан **байхгүйг байгаагаар дуудагч** гэдэг нь олон үндэстнээс бүрдсэн тоолж барагдашгүй үй түмэн үр удмыг өгнө хэмээн Бурханы амласныг хэлж байна (4:18-ыг үз).

4:18 Паул өмнөх ишлэлүүдэд нигүүлслээр өгөгдөж, бүх үр удамд нь баталгаатай байлгахын тулд Бурхан өөрийн амлалтыг Абрахамд хуулиар бус, итгэлээр өгснийг онцолсон. Эндээс амилалтын Бурханд өгсөн Абрахамын итгэлийн тухай бодож үзэх нь зүйн хэрэг болж байна. Бурхан Абрахамд амлахдаа элсний ширхэг, түг түмэн одод мэт тоолж баршгүй үр удмыг өгнө гэж хэлсэн. Хүмүүний ухаанаар бодвол үүнд ямар ч боломж, ямар ч найдвар байгаагүй. **Гэвч** хүний **найдвар** тасарсан үед ч хүртэл Эхлэл 15:5-т **“Чиний үр удам ийм болох болно”** гэж Бурхан амлахад Абрахам **олон үндэстний өвөг эцэг болно** гэдэгт **найдан итгэсэн.**

4:19 Асар их үр садтай болно гэсэн амлалтыг хүлээн авах үедээ Абрахам 75 настай байлаа (Эхлэл 12:2-24). Тухайн үед бол түүний бие махбод нь эцэг болох боломжтой байсан байна. Яагаад гэвэл дараахан нь тэр Ишмаел хүүтэй болсон (Эхлэл 16:1 - 11). Харин Паул энд Абрахамыг 100 настай байх үеийг ярьж байна. Тэр үед мөн амлалтыг шинэчлэн өгсөн(Эхлэл 17:15-21). Харин одоо бол Бурханы гайхамшигт хүч чадлаас ангид үр тогтох боломж бүрэн үгүй болсон байв. Гэхдээ Бурхан түүнд хүү өгнө гэж амласан. Абрахам ч Бурханы амлалтад итгэсэн.

Тэр биеийнхээ бараг үхсэнийг, Сарагийнх нь умай үхмэл болсныг мэдсэн ч итгэлээр дорой болсонгүй. Хүний ухаанаар бодвол

түүнд ямар ч найдвар байсангүй. Харин Абрахам итгэж байлаа.

4:20 Тэрхүү амлалт хэзээ нэгэн цагт биелэх боломж байхгүй байгаа нь Абрахамын итгэлийг гуйвуулаагүй. Бурхан *айлдсан*, Абрахам *итгэсэн*, тэгээд л боллоо. Өвөг Абрахамын хувьд боломжгүй ганц л зүйл нь Бурхан худал хэлэх. Абрахамын итгэл хүчтэй бас амьд байсан. Тэрбээр боломж, магадлалын бүх хуулийг үл харгалзан амлалтаа биелүүлнэ гэдэгт нь найдаж болох Бурхан хэмээн **Бурханд алдрыг** өргөсөн.

4:21 Бурхан *яаж* амлалтаа биелүүлэхийг Абрахам мэдээгүй ч тэр нь чухал биш байв. Абрахам Бурханыг мэддэг байсан ба **амласнаа** бүрэн **биелүүлэх чадвартай** гэдэгт эргэлзээгүй итгэж байсан. Нэг талаараа үнэхээр гайхалтай итгэл. Нөгөө талаараа хүний хийж болох хамгийн зөв, үндэслэлтэй зүйл. Яагаад гэвэл Бурханы үг энэ хорвоогийн хамгийн найдвартай зүйл билээ. Тиймээс Бурханы үгэнд итгэхэд Абрахамд ямар нэг эрсдэл байгаагүй.

4:22 Үгэнд нь ингэж итгэх хүнийг олсон нь Бурханд тааламжтай байв. Энэ нь ямар ч үед Бурханд тааламжтай. Тийнхүү Бурхан Абрахамд **зөвт байдлыг** хамааруулсан. Нэгэн цагт гэм нүгэл, ял буруутгалын өртэй байсан бол, одоо ямар ч өргүй, Бурханы өмнө зөвт гэсэн байр суурьтай болсон. Абрахам ялаас чөлөөлөгдөж, итгэлээр ариун Бурханаар зөвтгөгдсөн.

4:23 Итгэлээр дамжин зөвтгөгдсөн Абрахамын түүх бичигдсэн нь зөвхөн түүний төлөө байсангүй. Мэдээж түүний төлөө бичигдсэн утга үүнд явж байна. Түүний ялаас чөлөөлөгдөж, Бурханы өмнө төгс байр суурьтай болсон мөнхийн тэмдэглэл үйлдэгдсэн.

4:24 Гэхдээ бас бидний төлөө бичигдсэн. Бидний Эзэн Есүсийг үхэгсдээс амилуулсан Бурханд итгэх үед бидний итгэл түүнийх шиг бидэнд зөвт байдлыг тооцуулдаг. Үүнд ганц л ялгаа бий: Бурхан үхэгсдэд (Абрахамын суларч доройтсон бие ба эхнэрийнх нь хүүсэр хэвлий) амь өгч чадна гэдэгт Абрахам итгэсэн. Харин бид Бурхан үхсэн биед амь өгч Эзэн Есүс Христийг амилуулсан гэдэгт итгэдэг. Ч. Х. Макинтош үүнд дараах тайлбарыг өгсөн:

*Абрахам амлалтад итгэхээр дуудагдсан бол бид болж өнгөрсөн түүхэн баримтанд итгэх давуу эрхийг авсан. Абрахам хэзээ нэг өдөр биелэх ирээдүй рүү харж, түүнд найдахаар дуудагдсан бол бид болж өнгөрсөн зүйлийг буюу амилж, алдрыг хүртэн тэнгэрт сүр жавхлангийн баруун гарт заларч буй Аврагчийн нотлох бүрэн гүйцэд хийгдсэн золилтыг харж, түүнд найддаг.*¹⁵

4:25 Эзэн Есүс бидний нүгэл хилэнцээс болж тушаагдан бидний зөвтгөлийн төлөө амилуулагдсан. -ээс болж, -ийн төлөө [грек хэлээр *δια*] гэдэг дагавар нүгэл хилэнц ба зөвтгөл гэдэг хоёр үгийн аль алинтай нь холбогдож байгаа мэт боловч хам сэдэв нь үг

тус бүр дээр өөр өнгө аяс шаардаж байна. Есүс зүгээр л **бидний нүгэл хилэнцээс болж тушаагдсан** төдийгүй нүгэл хилэнцийг зайлуулахын тулд тэгсэн. Тэр **бидний зөвтгөлийн төлөө амилуулагдсан** нь биднийг зөвтгөсөн Христийн ажилд Бурхан бүрэн ханасан гэдгийг харуулах зорилготой. Эхний хэсэгт **бидний нүгэл хилэнц** шийдэх ёстой асуудал байсан. Хоёр дахь хэсэгт **бидний зөвтгөл** Христийн амилалтаар баталгаажсан үр дүн нь байсан. Хэрэв Христ булшиндаа үлдсэн бол зөвтгөл гэж үгүй байхсан. Гэвч Есүс амилсан хэмээх баримтаас бид Есүс ажлаа гүйцээснийг, төлөөс төлөгдсөнийг, Аврагчийн хийсэн нүглийг цагаатгах ажилд Бурхан үүрд ханасан болохыг ойлгож чадна.

Е. Амьдралд өгөх сайнмэдээний ашиг тус (5:1-11)

Элч Паул зөвтгөлийн тухай ярьж буй зүйлээ дараагийн шатанд гарган ирж, *зөвтгөл нь итгэгч нарын амьдралд ямар ашигтай вэ?* гэсэн асуултыг тавьсан. Өөрөөр хэлбэл, зөвтгөл үнэхээр ашиг авчрах уу? Үүнд үнэхээр тийм гэсэн хариулт өгөөд итгэгч хүн бүрд байдаг долоон ерөөлийг тоочжээ. Эдгээр ерөөл итгэгч хүний амьдралд Христээр дамжин орж ирдэг. Христ бол Бурхан, хүн хоёрын дундах зууч

бөгөөд Бурханы бүх бэлэг түүгээр дамжин орж ирдэг.

5:1 Итгэлээр зөвтгөгдсөн бидний хувьд амьдралд ирдэг хамгийн эхний агуу ашиг нь **Эзэн Есүс Христээр дамжин Бурхантай эвлэрсэн эвлэрэл** юм. Дайн дуусаж, дайсагнал төгсөв. Христийн үйлсээр дамжуулан бидний сүнс ба Бурханы хоорондох дайсагнал зайлав. Нигүүлслийн гайхамшгаар өстөн байсан бид анд нөхөр болов.

5:2 Мөн бид Бурханы тааллыг авах үгээр илэрхийлшиггүй байр суурь уруу орох боломжтой болсон. Бурхан биднийг Хайрлагдсан Нэгэний дотор хүлээн авсан учраас түүний хувьд бид Хайрт Хүүтэй нь адил ойр дотно, үнэ цэнэтэй хүмүүс билээ. Эцэг бидэн рүү очирт алтан таягаа сунгаж, биднийг танихгүй хүмүүс мэт биш, өөрийн хүү мэт угтан авав. **Энэхүү нигүүлсэл** буюу Бурханы таалалд нийцсэн байдалд Бурханы өмнө байгаа бидний байр суурийн бүх шинж чанар орно. Бид Христийн дотор байгаа учраас энэ байр суурь Христийнх шиг төгс бөгөөд өөрчлөгдөшгүй.

Энэ нь багадсан юм шиг, *бид бас Бурханы алдрын найдварт баярладаг*. Бид Бурханы сүр жавхланг хараад зогсохгүй өөрсдөө бас алдар дотор илчлэгдэх ирээдүйг харан баярладаг (Иохан 17:22, Колоссай 3:4). Энэ найдварын бүрэн ач холбогдлыг бид энэ дэлхий дээр байхдаа гүйцэд ойлгож чадахгүй. Бас мөнхийн мөнхөд гайхаж барахгүй.

5:3 Зөвтгөлөөс урган гардаг дөрөв дэх ерөөл нь **бид бас зовлонтойдоо баярладаг**. Тухайн үеийнх нь тааламжгүй байдалд биш ч гэлээ эцсийн үр дүнд нь баярладаг (Еврей 12:11). Баяр хөөр зовлон зүдгүүртэй хамт оршиж болно гэдэг нь христитгэлийн талархмаар сургаал мөн. Баяр хөөрийг үгүй хийгч нь зовлон бэрхшээл бус, гэм нүгэл юм. **Зовлон зүдгүүрийн** үр дүнд **тэвчээр** бий болдог. Амьдрал маань ямар ч асуудалгүй байсан бол бид хэзээ ч **тэвчээрийг** хөгжүүлж чадахгүй байсан.

5:4 Паул **тэвчээр** нь **зан чанарыг** төлөвшүүлдгийг өгүүлсэн. Бид зовлон зүдүүрийг тэвчин тэдгээрээр дамжуулан Бурхан зорилгоо хэрэгжүүлэхийг хүлээж байгааг хараад Тэр биднийг сайшаан Сайн Тэвчээрийн тамгаараа тамгалан шагнадаг. Түүний сайшаал биднийг **найдвараар** дүүргэдэг. Бурхан бидний зан чанарыг хөгжүүлж, амьдралд маань ажиллаж байгааг бид мэднэ. Ийнхүү Бурхан бидний дотор эхлүүлсэн сайн ажлаа заавал гүйцээнэ гэдэг бат итгэл бидэнд төрдөг (Флип 1:6).

5:5 **Найдвар нь урам хугалдаггүй**. Бид ямар нэг зүйлд найдавч хэзээ ч биелэхгүй байсныг нь хожим мэдвэл бидний найдвар ичгүүрт орох буюу бидний урам хугарна. Гэвч бидний авралын найдвар хэзээ ч ичгүүрт орохгүй. Бид хэзээ ч урам хугарахгүй. Бидний итгэл худал байжээ гэсэн нөхцөл хэзээ ч бий болохгүй. Тэгвэл бид үүнд яаж итгэлтэй байх вэ? **Учир нь**

Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг. Бурханы хайр гэдэг нь Бурханы төлөөх бидний хайр эсвэл бидний төлөөх Түүний хайрын аль нь ч байж болно. Гэхдээ энэ хэсэгт бидний төлөөх Түүний хайрыг хэлсэн байна. Яагаад гэвэл 6-20 дугаар ишлэлд бидний төлөөх Бурханы хайрын тухай агуу баталгаануудыг өгүүлжээ. Есүст итгэсэн тэр мөчид **Ариун Сүнс бидэнд өгөгдөж**, Бурханы мөнх хайрын илэрхийллийг бидний зүрхэнд цутгасан. Тэнгэр дэх гэр рүүгээ аюулгүй очих хүртэл хамгаална гэдгийг бид үүгээр баттай мэддэг. Ариун Сүнсийг хүлээн аваад Бурхан танд хайртай болохыг мэдрэх болно. Энэ мэдрэмж бол хүн төрөлхтний төлөө “хаа нэгтээ оршигч Нэгэн” санаа тавьдаг гэсэн тодорхойгүй, нууцлаг мэдрэмж биш, харин хувь хүнтэй харилцаанд ордог Бурхан *таныг* хувь хүний хувьд үнэхээр хайрладаг гэсэн гүн мэдрэмж юм.

5:6 6-20 дугаар ишлэлд Паул багаас их рүү өгсөх байдлаар тоочиж байна. Паулын гол санаа: “Бид Бурханыг эсэргүүцдэг нүгэлт дайснууд нь байхад Бурханы хайр бидний төлөө асгарсан юм бол, тэр тусмаа одоо бид Түүний харьяат болсон байхад тэр хайр нь биднийг хамгаалахгүй гэж үү?” Зөвтгөлийн тав дахь ашгийг эндээс бид харж болно: *Бид Христ дотор мөнхөд аюулгүй болжээ.* Энэ санаагаа улам тодруулахын тулд элч Паул “тэр тусмаа” гэдэг үгийг таван удаа хэрэглэсэн.

“Тэр тусмаа” уур хилэнгээс ч аврагдах болно (5:9).

“Тэр тусмаа” бид Түүний амилсан амиар хамгаалагдах болно (5:10).

“Тэр тусмаа” нигүүлслээр ирэх бэлэг бялхах болно (5:15).

“Тэр тусмаа” итгэгч нар амь дотор ноёрхоно (5:17).

“Тэр тусмаа” нигүүлсэл улам илүү бялхана (5:20).

Паул 6, 7, 8 дугаар ишлэлд **Христ** бидний **төлөө үхэх** үед **бид** ямар байдалтай (**сул дорой, бурханлаг бус**, гэмтэй) байсныг онцолж, 9, 10 дугаар ишлэлд одоо бид ямар болсныг (Христийн цусаар зөвтгөгдөж, түүний үхлээр эвлэрүүлэгдсэн) онцолжээ. Үүнээс үүдэн Аврагч бидний төлөө хийх юмс гарцаагүй (уур хилэнгээс чөлөөлж, амиараа биднийг хадгалан хамгаална).

Эхлээд биднийг **сул дорой**, арчаагүй, хүчгүй, өөрийгөө ч аврах чадалгүй хүмүүс байсан гэдгийг сануулсан. Харин урьдаас тогтоосон цаг болоход Эзэн Есүс Христ манай гариг дээр ирж, хүн төрөлхтний төлөө амиа өгөв. Зарим хүмүүсийн ташааран ойлгодог шиг тэр сайн хүмүүсийн төлөө үхээгүй, харин **бурханлаг бус хүмүүсийн өмнөөс** үхсэн юм. Бидэнд Бурханы таашаалыг хүртэх ямар ч сайн чанар, давуу тал байгаагүй. Бид үнэхээр зохисгүй хүмүүс байсан ч гэсэн **Христ** бидний **өмнөөс үхсэн**.

5:7 Бурханы хайраас гарсан энэ үйлдэл юутай ч зүйрлэшгүй онцгой агаад хүн хэзээ ч ийм зүйлийг амсаагүй билээ. Хүний амь өөртөө үнэ цэнэтэй байдаг. Тэр хүн энэ амь насаа ямар нэгэн олиггүй этгээдийн төлөө золиослохыг хүсэхгүй. Жишээ нь тэр хүн алуурчин, завхай явдалтан, дээрэмчний төлөө амиа өгөхгүй. Нарийн яривал шударга үнэнч, итгэл найдвартай гэхдээ тийм ч сайхан сэтгэлтэй биш “зөвт” хүний төлөө ч гэсэн үхэхэд хайран санагдана. Гэхдээ бүр аргагүй тохиолдол гарвал сайхан сэтгэлтэй, найрсаг, бусдыг хайрладаг, хайр булаасан “сайн” хүний төлөө үхэх хүн гарч магадгүй л юм.

5:8 Тэгвэл Бурханы хайр энэ ертөнцийнх огт биш бөгөөд ер бус. **Биднийг нүгэлтнүүд байхад Бурхан хайрт Хүүгээ бидний төлөө үхүүлэхээр илгээснээр биднийг хайрлах** гайхамшигт **хайраа** харуулсан билээ. Хэрэв бид яагаад Тэр үүнийг хийсэн юм бэ гэвэл хариултыг Бурханы Өөрийнх нь дээд эрх мэдэлт хүслээс хайх хэрэгтэй. Ийм хайрыг хүртэх сайн сайхан зүйл бидний дотор огтхон ч байгаагүй.

5:9 Одоо цоо шинэ нөхцөл үүсжээ. Бид цаашид ял зэм үүрсэн нүгэлтнүүд биш болсон. Аврагчийн хэмжээлшгүй үнэ цэнэтэй **цус** бидний төлөө Голготын толгой дээр урссан тул Бурхан биднийг зөвт хэмээн тооцсон. Гэмтэн байхад маань зөвтгөхийн тулд Бурхан ийм өндөр үнэ төлсөн юм бол **тэр тусмаа** Христээр **дамжуулан** биднийг **уур хилэнгээс** аврах биш

үү? Хэрэв тэр биднийг таалалдаа нийцүүлэхийн тулд ийм агуу үнэ төлсөн юм бол эцэст нь мөхөхийг маань зөвшөөрнө гэж үү?

Уур хилэнгээс аварсан гэдэг нь “уур хилэнгээс аврах” эсвэл “уур хилэнд өртүүлэх бүх зүйлээс чөлөөлсөн” гэх утгатай юм. Бид энд байгаа угтвар үг (грекээр *ано*) хоёр дахь утгыг илэрхийлж байгаа гэж үздэг. Бурханы уур хилэнд өртүүлэх бүх зүйлээс энэ цагт ч, мөн мөнхөд ч аварсан гэсэн утгатай.

5:10 Урьд нь ямар байсан, одоо ямар байгаа тухайгаа эргэн нэг хараад үүнийг ингэж бодоорой. **Бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрүүлэгдсэн.** Бид Эзэний эсрэг дайсагнаж, үүндээ огтхон ч харамсдаггүй байсан. Бид өөрсдөө бол Бурхантай эвлэрэх хэрэгтэй гэж огт бодохгүй. Бодоод үзээрэй - **Бурханы дайсан.**

Гэтэл Бурхан бидэн шиг хандаагүй. Тэр цэвэр нигүүлслээ харуулан ажилласан. Христ биднийг орлон амиа өргөхдөө Бурхантай дайсагнах шалтгааныг маань зайлуулав. Тэр шалтгаан бол бидний гэм нүгэл байжээ. Ийнхүү Христэд итгэснээр бид **Бурхантай эвлэрсэн.**

Бурхан бидний эвлэрлийг ийм их үнээр худалдаж авсан юм бол тэр биднийг явуулна гэж үү? **Хүүгийнх нь үхэл** буюу туйлын сул дорой байдлын бэлгэдэл болсон **үхлээр дамжуулан бид эвлэрсэн** юм бол, хязгааргүй хүч чадалт амь буюу Бурханы баруун талд заларсан Христийн одоогийн амь биднийг эцэс

хүртэл хамгаалахгүй гэж үү? Хэрэв үхэл нь биднийг аврах тийм хүч чадалтай юм бол, тэр тусмаа **амь нь** биднийг хамгаалах хүч чадалтай байх бус уу?

5:11 Одоо бид зөвтгөлийн зургаа дахь ашгийг авч үзэх гэж байна: **Бид бас Бурханы дотор бидний Эзэн Есүс Христээр дамжуулан баярлан хөөрдөг.** Бид өгсөн бэлгэнд нь баярлаад зогсохгүй өгсөн нэгэнд нь бас баярлан хөөрдөг. Аврагдахаасаа өмнө бид өөр юманд баярлан хөөрдөг байсан. Одоо харин Түүнийг *санах* бүрдээ баярлаж, Түүнийг *мартах* үедээ гунигладаг. Бурханд баярлах болсон энэ гайхалтай өөрчлөлт юунаас болж бий болсон бэ? **Эзэн Есүс Христийн** хийсэн ажил. Бусад бүх ерөөлийн адилаар энэ баяр хөөр ч бас Түүгээр **дамжин** бидэнд ирдэг.

Эдүгээ бид эвлэрлийг¹⁶ авав хэмээх үгнээс бид зөвтгөгдсөн хүний эдэлдэг долоо дахь ашгийг олж харах болно. **Эвлэрэл** гэдэг нь золиос тахил болон өргөгдсөн Аврагч Есүсийн ажлаар дамжин хүн ба Бурханы хооронд бий болсон таарамж, нийцлийг хэлнэ. Гэм орж ирснээр Бурхан ба хүний хоорондох харилцаа тасарч, тэдний хооронд хөндийрөл, дайсагнал бий болсон. Эзэн Есүс дайсагнал үүсгэж байсан гэм нүглийг зайлуулаад өөрт нь итгэсэн хүмүүсийг Бурхантай нийцтэй болгон сэргээжээ. Үүний хажуугаар нэг зүйлийг тэмдэглэн хэлэх хэрэгтэй. Бурханд эвлэрүүлэгдэх шаардлага

байгаагүй. Харин Бурхантай дайсагнаж байсан учир хүнд эвлэрүүлэл хэрэгтэй байсан юм.

Ё. Адамын нүглийг ялсан Христийн ялалт (5:12-21)

5:12 5-р бүлгийн үлдсэн хэсэг нь захидлын эхний хэсгийг дараагийн гурван бүлэгтэй холбосон гүүр болж байна. Адамаар ирсэн ял ба Христээр ирсэн зөвтгөлийн тухай сэдвийг эхний хэсгээс аван үргэлжлүүлэхдээ алдагдал, Адамын ажлаас үүдсэн алдагдал, зовлонгоос Христийн ажлаас ирсэн ерөөл хол давууг харуулна. Энд зөвтгөлөөс ариусал руу, гэм нүглийн үйлдлээс мөн чанарт байдаг гэм нүгэл рүү шилжиж байгаагаараа 6-8 дугаар бүлэгтэй холбогдоно.

Эдгээр ишлэлд Адамыг хуучин бүтээл доторх бүх хүний тэргүүн буюу төлөөлөгч гэж дүрсэлсэн бол Христийг шинэ бүтээл доторх бүх хүний Тэргүүн гэж дүрсэлсэн. Тэргүүн өөрийн дор байгаа бүх хүний өмнөөс үйлддэг. Жишээлбэл улсын Ерөнхийлөгч хуулийг баталгаажуулан гарын үсэг зурвал, тэрбээр улсынхаа бүх иргэний өмнөөс үйлдэж байгаа хэрэг билээ.

Адамын хувьд ч мөн үүнтэй адил зүйл болсон. Түүний хийсэн **нүглээс** болж, хүний **үхэл** энэ **ертөнц** уруу орж ирсэн. Адамын үр удам түүний дотор **бүгд нүгэл үйлдсэн** учраас үхэл гэдэг зүйл тэдэнд бүгдэд хамаатай болов. Тэд

хувь хувьдаа гэм нүгэл үйлдсэн нь үнэн боловч энд үүнийг ярих гээгүй. Адам гэм нүгэл үйлдсэн нь *төлөөлөх үйлдэл* байсан ба бүх хойч үе нь түүний дотор **нүгэл үйлдсэнд** тооцогддог гэдгийг Паул энд хэлж байна.

Дэлхий дээрх анхны нүглийг Адам биш, Ева хийсэн шүү дээ гэж зарим хүн хэлж болох юм. Энэ үнэн. Гэхдээ Адам эхэлж бүтээгдсэн ба *тэргүүн байр суурийг* түүнд өгсөн байсан. Тиймээс Адам бүх үр удмынхаа өмнөөс үйлдсэн гэж үздэг.

Хэдийгээр Адамын гэм нүгэл биеийн үхлээс гадна сүнслэг үхлийг дагуулсан боловч элч Паул **үхэл нь бүх хүнд тархсан** гэж *биеийн үхлийг* ярьж байна. (13, 14 дүгээр ишлэлийг харвал биеийн үхлийн тухай ярьж байгаа нь тодорхой байна).

Бид Бичээсийн энэ багц ишлэл дээр ирэх үед өөрийн эрхгүй зарим асуултууд урган гарна. Зөвхөн Адам нүгэл хийсний төлөө түүний үр удмыг гэм нүгэлтэй гэж тооцох нь шударга хэрэг мөн үү? Бурхан төрөлхийн нүгэлтэй төрсний төлөө ялладаг уу, эсвэл өөрөө хийсэн гэм нүглийнх нь төлөө ялладаг уу? Хэрэв хүн төрөлхийн гэмт мөн чанартай төрж, угаас мөн чанар нь гэмтэй учраас гэм нүгэлд унадаг юм бол Бурхан яагаад тэднийг хийдэг зүйлд нь хариуцлагаа хүлээлгэнэ вэ?

Библийн эрдэмтэд энэ болон үүнтэй төстэй асуудлуудыг нухаж, гайхалтай олон янзын

дүгнэлтийг гаргасан. Гэхдээ бидний *баттай* хэлж чадах *баримтууд* бий.

Нэгдүгээрт, бүх хүн төрөлхийн ба үйлдлийн гэм нүгэлтэй гэж Библи заадаг. Хүн бүр Адамын гэм нүглийг өвлөн төрдөг. Бас өөрийн ухамсартай сонголтоор гэм нүгэл үйлддэг.

Хоёрдугаарт, гэмийн төлөөс бол үхэл гэдгийг бид мэднэ. Үүнд бие махбодын үхэл ба үүрд мөнх Бурханаас тусгаарлагдах сүнсний үхэл хоёулаа орно.

Гэвч хүн өөрөө л хүсээгүй цагт тэр шийтгэлийг үүрэх шаардлага байхгүй болсон. Энэ бол маш чухал хэрэг мөн. Бурхан Өөрийн Хүүг илгээн, гэмтнүүдийг орлон үхүүлж асар өндөр үнэ төлжээ. Одоо гэм нүгэл ба гэм нүглийн төлөөсөөс аврагдах боломжийг Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан үнэгүй бэлэглэхээр санал болгожээ.

Хүн гурван үндэслэлээр яллагддаг: Хүн *төрөлхийн гэмтэй*; Адамын *гэм нүгэл* түүнд *тохоогддог*; хүн *өөрөө гэм нүгэл үйлддэг*. Гэвч хүний хамгийн том ял, буруу бол өөрийг нь аврахын тулд Бурханы хангаж өгсөн зүйлээс татгалзсанд оршино (Иохан 3:18, 19, 36).

Тэгвэл сайнмэдээг хэзээ ч сонсоогүй хүмүүс яах болж байна гэж асууж болох юм. Энэ асуултад 1-р бүлэг тодорхой хэмжээнд хариулсан. Түүн дээр нэмж хэлэхэд, энэ дэлхийн Шүүгч бүхнийг зөв хийх болно гэдэгт бид бүрэн итгэлтэй байж болно (Эхлэл 18:25). Тэр хэзээ ч шударга бусаар хандахгүй. Түүний

бүх шийдвэр тэгш эрх, зөвт байдалд тулгуурладаг. Бидний хараа өнөөдөр сайнгүй байгаа тул зарим нэг нөхцөл байдал бидэнд асуудалтай санагдаж байвч Бурханы хувьд асуудалтай биш. Эцсийн хэрэг дуусаж, шүүхийн шийдвэр нэгэнт гарсан бол дахин давж заалдах хуульзүйн үндэслэл хэнд ч үлдэхгүй.

5:13 Харин одоо Паул Адамын нүгэл бүх хүн төрөлхтөнд нөлөөлснийг нотлох гэж байна. Эхлээд тэр Адамын үеэс эхлэн Синай уулан дээр хууль өгөгдөх хүртэл **ертөнцөд нүгэл байсан** гэдгийг дурдсан. Тэр үед тодорхой илчилсэн Бурханы хууль байгаагүй. Адам Бурханы амнаас тодорхой тушаал хүлээж авсан. Харин олон зуун жилийн хойно тэнгэрлэг хуулийг тодорхой бичиж илчилсэн арван хууль өгөгдөв. Энэ хооронд хүнд Бурханаас өгсөн хууль гэж байгаагүй. Тийм учраас тухайн үед **нүгэл** байсан боловч *зөрчил* гэж байсангүй. Яагаад гэвэл зөрчил гэдэг нь тогтоосон хуулийг зөрчихийг хэлдэг. Тэгэхээр хориглосон **хууль байхгүй бол нүглийг зөрчил гэж тооцохгүй.**

5:14 Гэвч хуульгүй байсан тэр эрин цагт **үхэл** амралт эдэлсэнгүй. Енох гэдэг ганц хүнээс бусад бүх хүнд **үхэл** ноёрхсон. Тэдгээр хүмүүс Адам шиг Бурханы тодорхой хэлсэн тушаалыг зөрчөөгүй байж яагаад нас барж байгаа юм бэ гэж асууж болох юм. Хариултыг энэ ишлэлд дам өгчээ: тэд Адамын дотор нүгэл үйлдсэн тул үхсэн. Хэрэв шударга бус санагдаж байвал энэ нь авралтай ямар ч хамаагүй гэдгийг санах

хэрэгтэй. Эзэнд итгэлээ өгсөн бүх хүн үүрд мөнхөд аврагдаж байсан. Тэгсэн ч гэлээ *бие махбодын* хувьд адилхан үхсэн. Ийнхүү үхсэн шалтгаан нь өөрсдийнх нь тэргүүн болох Адамын гэм нүглээс болжээ. Адам нь тэргүүн төлөөлөгчийн хувьд **ирэх нэгэний дүрс** буюу бэлгэдэл байв. Дараагийн ишлэлүүдэд Паул энэ хоёр тэргүүний тухай дэлгэрэнгүй өгүүлнэ. Ингэхдээ адил төстэй талаар нь гэхээсээ илүү, эсрэг ялгаатай байдлаар нь харьцуулсан. Түүний үгийг ийн дүрсэлж болох юм:

*Адамын хөвгүүд Христ дотор
Авынхаа алдсанаас илүү ерөөлийг олов*

5:15 Хамгийн эхний ялгаа нь, Адам **алдаа зөрчил** гаргасан бол Христ үнэгүй **бэлэг** өгсөн. Анхны хүний гэм зөрчлөөс болж **олон хүн үхсэн**. Энд гарч байгаа **олон** гэдэг үг мэдээж хэрэг Адамын үр удмыг хэлж байна. Түүнчлэн үхсэн гэдэг үг бие махбодын ба сүнсний үхлийг аль алиныг хэлж байж болно.

Тэгвэл тэр тусмаа **бэлэг** нь **олон хүнд** бялхжээ. Үнэгүй бэлэг бол гэм нүгэлт хүн төрөлхтөнд бялхаасан **Бурханы нигүүлслийн** гайхамшигт илэрхийлэл юм. Энэ нь **Есүс Христ гэдэг ганц Хүний нигүүлслээр** ирсэн. Тэрслүү бүтээлийнхээ өмнөөс үхнэ гэдэг бол Түүний талаас үзүүлж байгаа гайхамшигт хайр нигүүлсэл мөн. Есүсийн золиост үхэл мөнх амийн бэлгийг **олон хүнд** өгсөн.

Энэ ишлэлд *олон хүн* гэж хоёр удаа дурдахдаа өөр өөр хүмүүсийг хэлж байна. Эхний удаад дурдсан **олон хүн** бол Адамын хийсэн алдаа зөрчлөөс болж үхдэг болсон хүмүүс. Хоёр дахь удаад дурдсан **олон хүн** бол тэргүүн болох Христийн шинэ бүтээлийн гишүүн болсон хүмүүс юм. Үүнд зөвхөн Бурханы нигүүлсэл **бялхсан** хүмүүс буюу жинхэнэ итгэгч нар орно. Бурханы өршөөл бүгдийн дээр асгарсан боловч зөвхөн Аврагч Есүст найдвараа өгсөн хүмүүс л Бурханы нигүүлслийг хүртэнэ.

5:16 Адамын гэм нүгэл ба Христийн **бэлэг** хоорондоо бас нэг чухал ялгаатай. Адамын хийсэн **ганц алдаа зөрчил** гарцаагүй **шүүлт** авчирч, “гэм буруутай” гэх ял гарсан. Тэгвэл Христийн **үнэгүй бэлэг** нь эсрэгээрээ ганц бус олон алдаа зөрчлийг уучилж, “цагаатгасан” гэдэг тогтоол гаргасан. Паул Адамын гэм ба Христийн бэлгийг хооронд нь эсрэгцүүлэн тавьж ялгааг онцолсон. Ганц гэмийн уршиг болсон аймшигт сүйрэл ба олон гэмээс гаргах гайхалтай аврал; тэгээд эцэст нь **ялын** тогтоол ба **зөвтгөлийн** тогтоол.

5:17 Ганц хүний алдаа зөрчлөөс болж үхэл нь догшин дарангуйлагч мэт **ноёрхов**. Гэвч **зөвт байдлын** нигүүлсэнгүй **бэлэг** буюу бялхсан нигүүлслийн бэлгийг хүлээн авсан бүх итгэгч нар **Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжуулан амь дотор ноёрхоно**.

Ямар гайхалтай нигүүлсэл вэ! Бид догшин дарангуйлагч үхлийн ноёрхлоос чөлөөлөгдөөд

зогсохгүй хаад мэт захирч, одоо хийгээд мөнхөд амьдран жаргах хувьтай болжээ. Үүнийг бид үнэхээр ойлгож, талархаж байна уу? Бид тэнгэрийн улсын хаант угсаа мэт амьдардаг уу эсвэл энэ дэлхийн хог новшин дотор зүдэн ядан амьдардаг уу?

5:18 Адамын алдаа зөрчлөөс болж бүх хүн ялд унасан бол Христийн зөвт үйлээс болж бүх хүнд амийн зөвтгөл ирэв. **Зөвт үйл** гэдэг нь Аврагч Есүсийн амьдрал юм уу, Тэрээр хуулийг сахин биелүүлснийг хэлж байгаа бус, харин Голготын толгой дээр бусдын өмнөөс амиа өргөснийг хэлж байна. Энэ үхэл **амийн зөвтгөлийг** буюу **амь** дагуулдаг **зөвтгөлийг** авчирсан. Тэгэхдээ **бүх хүнд** авчирсан.

Энэ ишлэлд хоёр удаа дурдагдсан *бүх хүн* гэдэг үг өөр өөр хүмүүсийг хэлж байна. Эхэнд дурдагдсан **бүх хүн** бол Адамын дотор байгаа **бүх хүнийг** хэлж байна. Хоёрдугаарт дурдагдсан **бүх хүн** гэдэг нь Христийн дотор байгаа **бүх хүнийг** хэлж байна. Өмнөх ишлэлд гарсан “...нигүүлслийн баялаг ба зөвт байдлын бэлгийн бялхалыг хүлээн авагсад...” гэдэг үгнээс үүнийг тодорхой харж болно. *Энэ бэлгийг итгэлээр хүлээж авах ёстой.* Зөвхөн Эзэнд итгэсэн хүмүүс **амийн зөвтгөлийг** хүлээж авна.

5:19 Адам Бурханы тушаалд дуулгаваргүй хандсанаас болж **олон хүн нүгэлтэн болсны адил түүнчлэн** Христ Бурхан Эцэгт **дуулгавартай** хандсанаас болж Түүнд итгэсэн

олон хүн **зөвт болгогджээ**. Христ дуулгавартай байснаасаа болоод бидний нүглийг үүрэхээр загалмайн үхэл туулах болсон.

Бүх хүн аврагдана гэж үздэг юниверсалистууд эдгээр ишлэлийг ашиглаад бүх хүн эцэстээ аврагдана гэж нотлохыг оролдох нь явуургүй хэрэг юм. Энэ багц ишлэлд хоёр тэргүүний тухай өгүүлж байгаа ба Адамын гэм нүгэл “түүний дотор” байгаа бүх хүнд нөлөөлсний адил Христийн зөвт үйл зөвхөн “Түүний дотор” байгаа хүмүүст л үр шимээ өгдөг нь энд тодорхой байна.

5:20 Бүх зүйл хуулийн эргэн тойронд эргэлддэг гэж бодож байсан Иудей сөргөгчийн хувьд Паулын ярьж байгаа зүйл тэсрэлт болсон биз ээ. Харин одоо энэ хүн гэм ба аврал нь хуульд бус хоёр тэргүүн дээр төвлөрдгийг ойлгож авсан. Үүнийг ойлгож авсан бол тэр хүнд ийм нэг асуулт төрж болох юм: “Тэгвэл яагаад хууль өгөгдсөн юм бэ?” Паул үүнд **алдаа зөрчил ихэссэн байхын тулд хууль орж ирсэн** гэж хариулсан. Хууль гэм нүглийг бий болгоогүй, харин гэм нүгэл бол Бурханы эсрэг хийж байгаа **алдаа зөрчил** юм гэдгийг илчилсэн. Хууль гэм нүглээс аварч чадаагүй, харин гэм нүглийн үзээрийн муухай дүр төрхийг илчлэн харуулдаг.

Гэвч Бурханы нигүүлсэл хүн төрөлхтний бүх гэм нүглээс илүү агуу гэдгээ баталсан. **Хаана нүгэл ихэссэн байна**, тэнд Голготын толгой

дээр үзүүлсэн Бурханы нигүүлсэл улам илүү бялхдаг.

5:21 Тэгэхээр бүх хүнийг үхэлд хүргэж байсан гэм нүглийн ноёрхол дууссан учраас **нигүүлсэл нь бидний Эзэн Есүс Христээр дамжуулан мөнх амь өгөн зөвт байдлаар ноёрхох юм.** Нигүүлсэл нь зөвт байдлаар ноёрхох гэдгийг анхаараарай. Бурханы ариун байдлын бүх шаардлага ханаж, хуулийн шийтгэл төлөгдсөн тул өмнөөс нь өргөгдсөн Христийн ач буяныг хүсэн ирж байгаа хүн бүрд Бурхан мөнх амийг өгч чадна.

Хүмүүсийн түгээмэл асуудаг “Бурхан яагаад энэ дэлхийд гэм орж ирэхийг зөвшөөрсөн юм бэ?” хэмээх асуултын хариу энэ ишлэлд зарим нэг талаараа өгөгдсөн байна. Юу гэхээр энэ дэлхийд гэм нүгэл орж ирсэн тул Христийн золиосоор дамжуулан гэм нүгэл орж ирээгүй байснаас илүү их алдрыг Бурхан авч, илүү их ерөөлийг хүн хүртсэн юм. Гэм нүгэлд унаагүй Адамын дотор байснаас ч илүү сайныг Христийн дотор бид хүлээн авах боломжтой. Хэрэв Адам хэзээ ч гэм хийгээгүй байсан бол тэр энэ дэлхий дээр, Еден цэцэрлэгт мөнхийн жаргалтай амьдралаар амьдрах байсан. Гэвч тэр Бурханы зольсон хүүхэд, Бурханы өв залгамжлагч, Есүс Христийн хамтран өв залгамжлагч болохгүй байсан. Мөн тэнгэрт амлагдсан гэр орон ба тэнгэрт Есүстэй хамт байх, мөнхөд Түүн шиг болох гэдэг амлалт байгаагүй. Энэ ерөөлүүд зөвхөн **бидний Эзэн**

Есүс Христийн золилтын ажлаар дамжин ирдэг билээ.

Ж. Ариун амьдрах сайнмэдээний арга (6-р бүлэг)

Паул 5 дугаар бүлгийн төгсгөлд нигүүлсэл нь бүх хүн төрөлхтний гэм нүглийг даван бялхдаг гэж хэлснээс бас нэг асуулт гарч ирдэг. Энэ бол маш чухал асуулт мөн. *Итгэлээр дамжин нигүүлслээр ирдэг авралын тухай сургаал нь гэмт амьдралыг зөвшөөрч, тэр ч байтугай хөхүүлэн дэмждэг үү?*

Энэ асуултад тов тодорхойгоор үгүй гэж хариулах ба хариултыг 6-8 дугаар бүлэг хүртэл дамнуулан өгчээ. Энэхүү 6 дугаар бүлэгт уг асуултад өгөх хариулт *мэдэх* (3, 6-р ишлэл), *тооцох* (11-р ишлэл), *өргөх* (13-р ишлэл) гэсэн түлхүүр үгнүүд дээр төвлөрнө.

Хэрэв бид итгэгч хүний байр суурь ба түүний амьдралын хэв маягийн хоорондох ялгааг ойлговол энэ бүлэгт Паулын ярьж байгаа санааг ойлгоход тусална. Итгэгч хүний байр суурь Христийн дотор оршдог. Харин амьдралын хэв маяг гэдэг бол өдөр тутмын амьдралдаа ямар байгаа, ямар байх ёстой гэдгийг хэлнэ.

Нигүүлсэл биднийг тэрхүү байр суурин дээр тавьж, байр сууриндаа тохирсон зохистой амьдралаар амьдрахыг заадаг. Бид *Христийн дотор* байдаг учраас байр суурь маань төгс билээ. Тиймээс амьдралын хэв маяг маань улам

бүр байр суурийг маань илэрхийлдэг байх ёстой. Гэвч тэнгэрийн улсад Аврагчтайгаа уулзах хүртэл бидний амьдрах хэв маяг хэзээ ч бүрэн төгс байр суурьтай маань яв цав адилхан болох аргагүй боловч, бид өдрөөс өдөрт улам бүр Есүстэй адил болох ёстой.

Юуны түрүүнд элч Паул, үхэл ба амилалтаараа Христ биднийг хэн болгосон бэ гэдэг үнэнийг тайлбарлаад, энэхүү агуу үнэний гэрэл дотор амьдрахыг бидэнд уриалсан.

6:1 Паулыг эсэргүүцэж байгаа Иудей сөргөгч Паулын амыг таглана гэж бодсон нэгэн асуултыг гарган ирж байна. Нигүүлслийн сайнмэдээ хүний гэм нүгэл Бурханы нигүүлслийг улам агуу болгодог гэж заавал **нигүүлсэл нь ихсэхийн тулд нүгэл дотор байсаар бай** гэж хэлж байгаа хэрэг биш үү?

Энэ асуултын орчин үеийн хувилбар нь: “Хүн хуулиас ангид, итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагддаг гэж та хэллээ. Хэрэв аврагдахын тулд зөвхөн итгэх л хэрэгтэй юм бол нүгэл үйлдсээр байж болох юм биш үү?” Энэ асуултыг тавьж байгаа хүн нигүүлслийг ариун амьдрахад хангалттай хөшүүрэг болж чадахгүй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хүмүүсийг хуулийн хориг тушаал, заавар дор тавих хэрэгтэй гэсэн санаа байна.

Бид нүгэл дотор байсаар байх уу? гэдэг асуултад энэ бүлэг дөрвөн хариу өгсөн.

1. Та нүгэл *үйлдэж чадахгүй*. Яагаад гэвэл та Христтэй нэгдсэн. Учрал (1-11 дүгээр ишлэл).

2. Та нүгэл *үйлдэх хэрэг байхгүй*. Яагаад гэвэл нигүүлсэл нүглийн ноёрхлыг нураасан. Уриалга (12-14 дүгээр ишлэл).

3. Та нүгэл *үйлдэж болохгүй*. Яагаад гэвэл гэм нүгэл эргээд таныг ноёрхож эхэлнэ. Тушаал (15-19 дүгээр ишлэл).

4. Нүгэл *үйлдэхгүй байсан нь дээр*. Яагаад гэвэл нүгэл гамшигт хүргэнэ. Анхааруулга (20-23 дугаар ишлэл).¹⁷

6:2 Тэгэхээр Паул хамгийн түрүүнд, бид **нүгэлд үхсэн** тул нүгэл үйлдэж чадахгүй гэсэн хариу өгч байна. Энэ бол бидний байр суурийн тухай үнэн юм. Есүс нүглийн золиос болж үхэхдээ биднийг төлөөлж үхсэн. Тэрээр бидний *оронд* буюу биднийг *өмнөөс* үхсэн төдийгүй биднийг *төлөөлж* буюу бид үхэж байгаа *мэтээр* үхсэн билээ. Тэгэхээр Тэр үхэхэд бид ч бас үхсэн. Тэр үхэхдээ гэм нүглийн бүх асуудлыг нэгмөсөн бүрэн шийдсэн. Тиймээс Христийн дотор байгаа бүх хүнийг Бурхан нүгэлд үхсэн гэж хардаг.

Тэглээ гээд итгэгч хүн нүгэлгүй гэсэн үг биш. Харин Христийг үхэхэд болон тэрхүү үхлийн бүх утга учирт итгэгч хүнийг Христтэй адил болсон гэдгийг хэлж байна.

6:3 Паулын тайлбарын хамгийн эхний түлхүүр үг нь **МЭДЭХ**. Итгэгч хүн нүгэл үйлдэх нь зохисгүй гэдгийг харуулахын тулд Паул энд баптисмын тухай сэдвийг хөндсөн. Гэтэл “Паул ямар баптисмыг ярьж байгаа вэ”

гэдэг асуулт даруй урган гардаг. Тэгэхээр үүнд тайлбар өгөх хэрэгтэй болов уу.

Хүн аврагдахдаа **Христ Есүс рүү баптисм хүртдэг** буюу тэрээр хэн гэдэг нь Христийн үхэл ба амилалтаар тодорхойлогддог болно. Хэдийгээр Сүнсний (доторх) баптисм нь үүнтэй нэг зэрэг явагддаг боловч энэ тухай яриагүй. Ариун Сүнсний баптисм нь итгэгч хүнийг Христийн бие дотор тавьдаг (1Коринт 12:13). Тэр нь үхэл **рүү** хүртээж байгаа баптисм биш. **Христ рүү** баптисм хүртсэн гэдэг нь итгэгч хүн Бурханы нүдэнд Христтэй хамт үхээд түүнтэй хамт амилсан хэмээн тооцогдож байгааг хэлдэг.

Паул энд баптисмын тухай ярихдаа сүнсний хувьд бид Христтэй нэг болж байгаа тухай, энэ нь усан баптисмаар дүрслэгддэг тухай аль алиныг бодож байсан нь дамжиггүй. Гэвч маргаан цаашлах тусам, Паул усан баптисмыг түлхүү онцолж уншигчдаа Христийн үхэлтэй “адил байдлаар” “оршуулагдсан”, “хамтдаа холбогдсон” гэдгийг сануулдаг.

Шинэ гэрээнд хэзээ ч баптисм хүртээгүй итгэгч хэмээх хэвийн биш зүйлийн тухай ярьдаггүй. Христийг хүлээн авмагц хүн тэр даруй баптисм хийлгэдэг гэж үздэг. Тийм болохоор Эзэн Есүс итгэл ба баптисмыг нэг дор ярьжээ: “Хэн итгэж баптисм хүртэнэ тэр аврагдах болно” (Марк 16:16). Хэдийгээр баптисм нь авралыг авахад заавал байх ёстой шаардлага биш боловч олон нийтийн өмнө гэрчлэх тэмдэг байх ёстой.

6:4 Усан баптисм бол Христ рүү баптисм хүртсэний нүдэнд харагдах гадаад дүрслэл юм. Тухайн итгэгч хүн үхлийн хар усан дотор (Эзэн Есүс гэдэг бодгаль дотор) булхан ороод шинэ амьдралаар алхахаар шинэ хүн Христ дотор амилж байгааг усан баптисм дүрсэлдэг. Нэг ёсондоо баптисм хүртэхдээ итгэгч хүн хуучин хүнээ оршуулж байна гэсэн үг. Тэр хүн ус уруу орох үедээ “Адамын нүгэлт хүүгийн хувьд би хэн байсан тэр хүн загалмай дээр үхлээ” гэж хэлж байгаатай адил. Харин уснаас гарч ирэх үедээ “Амьд байгаа нь би биш, харин Христ миний дотор амьд байна” (Галат 2:20) гэж хэлж байгаа хэрэг.

Конибийр, Хоусон нар энэ тухай “Усан баптисмыг ус уруу булхан орж хийдэггүй бол энд гарч байгаа үгийг ойлгох арга байхгүй” гэж цохон тэмдэглэсэн.

Элч Паул цааш нь хэлэхдээ Христийн амилалт биднийг **шинэ амийн дотор явах** боломжтой болгосон гэж байна. Тэрээр **Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсан** гэжээ. Энэ юу гэсэн үг вэ гэвэл Бурханы зөвт байдал, хайр, шударга ёс зэрэг бүх төгс төгөлдөр бурханлаг чанарууд Эзэн Есүсийг үхлээс амилуулахыг шаардаж байсан гэсэн үг. Аврагчийн Бодгалийн онц гойд чанарыг харгалзвал Түүнийг булшинд үлдээх нь Бурханы зан чанарт нийцэхгүй байсан. Бурхан Түүнийг *үнэхээр* амилуулсан. Бид Христийн амилалт дотор Түүнтэй нэг болсон тул бид

шинэ амийн дотор явж чадах бөгөөд явах ёстой юм.

6:5 Бид Христийн үхэлтэй адил байдалд түүнтэй хамт холбогдсон шигээ Түүний амилалттай нь ч бас холбогдох болно. Түүний үхэлтэй адил байдал гэдэг үг нь итгэгч хүн баптисм хүртэх үедээ усан доогуур орохыг хэлж байна. Христийн үхэл дотор Түүнтэй холбогдсон жинхэнэ холбоо 2000 орчим жилийн өмнө бий болсон бол, тэр үед болсон үйл явдлын “адил байдал” нь баптисм билээ.

Бид зөвхөн ус уруу ороод зогсохгүй, мөн уснаас гарч ирдэг. Энэ бол Түүний амилалттай адил байдал. Эх бичвэр дээрээ энэ ишлэлийн хоёрдугаар хэсэгт адил байдал гэдэг үг байхгүй боловч утга нь байна.

Бид үхэлтэй нь адил байдалд (ус уруу булхан орох) Христтэй холбогдсон шиг мэдээж бас амилалттай нь адил (уснаас гарч ирэх) байдалд Түүнтэй холбогдсон.

Холбогдох болно гэдэг үг ирээдүйд болох зүйлийг заагаагүй. Ходж энэ тухай хэлэхдээ:

*Энд хожим болох зүйлийн тухай яриагүй, харин зайлиггүй гарах үр дагаврыг хэлж байна. Энэ зүйл болж байгаа бол нөгөө зүйл зайлиггүй болно гэсэн үг.*¹⁸

6:6 Баптисм хийлгэснээр хуучин хүн маань Түүнтэй хамт цовдлогдсон гэдгийг бид хүлээн зөвшөөрч байгаа юм. Бидний хуучин хүн гэдэг

нь Адамын хүүхэд байхдаа хэн байсан тэр хүнийг хэлнэ. Тухайлбал хуучин, бузар муу, бүх хуучин дадал зуршил, дур хүсэл бүхий аврагдаагүй хүнийг хэлнэ. Христэд итгэх үедээ бид хиртэй бохир хувцсаа толбогүй цэвэр хувцсаар солих адил **хуучин хүнээ** тайлж, шинэ хүнийг өмсдөг (Колоссай 3:9,10).

Хуучин хүнийг Голготын толгой дээр цовдолсон гэдэг нь гэм **нүглийн бие** эрх мэдлээ алдсан гэсэн утгатай. Гэм **нүглийн бие** гэдэг нь махбодыг маань хэлээгүй. Харин тухайн хүнийг удирддаг, хүний дотор оршин дарангуйлагч гэм **нүглийг** хэлж байна. Нүглийн биеийг маань **хүчингүй болгох** гэдэг нь *захиран жолоодох хүчийг нь үгүй болгох, ажиллагаагүй болгох* гэсэн үг. Ийм утгатай болохыг нь **хойшид биднийг нүгэлд боолчлуулалгүй** гэдэг үгнээс харж болно. Биднийг ноёлж байсан гэмийн боолчлол нуран унажээ.

6:7 Учир нь үхсэн нэгэн нь нүглээс чөлөөлөгдсөн. Жишээ нь цагдаагийн ажилтны амь бүрэлгэсэн хэргээр цахилгаан сандал дээр цаазаар авахуулах ял авсан хоригдолд ялыг нь гүйцэтгэсэн гэж бодъё. Тэр ялаа үүрээд нэгэнт үхчихвэл хийсэн гэмээсээ **чөлөөлөгдөж** буй хэрэг болно. Өөрөөр хэлбэл зөвтгөгдсөн гэсэн үг. Ял шийтгэлийг нэгэнт үүрсэн буюу төлсөн тул хэрэг хаагдана.

Үүний адилаар бид Христ Есүстэй хамт Голготын толгой дээр загалмай дээр үхсэн билээ. Гэмийн төлөөс төлөгдөөд зогсохгүй

амьдралд маань байсан гэм нүглийн хүчит цайз хэрэм нуран унасан. Одоо бид гэм нүглийн арчаагүй боол байхаа больсон.

6:8 Бид **Христтэй хамт** үхсэн нь үнэний зөвхөн нэг тал. **Бид мөн Түүнтэй хамт амьдрах болно** гэдэг нь үнэний нөгөө тал. Бид нүгэлд **үхсэн** боловч зөвт байдалд амьдарч байна. Биднийг дээр байсан нүглийн ноёрхол бутран унав. Бид эдүгээ энд байж байхдаа Христийн амилалтыг эдэлж байна. Үүнийг бид мөнхөд эдлэх болно. Христийн нэрийг магтъя!

6:9 Амилсан Христ хэзээ ч дахин үхэхгүй гэдэг баримтан дээр бидний итгэл тулгуурладаг. **Үхэл цаашид Түүнийг захирахгүй.** Үхэл гурван өдрийн турш түүнийг захирсан боловч тэр ноёрхол үүрд мөнхөд өнгөрөн одов. Христ дахиж хэзээ ч үхэхгүй.

6:10 Эзэн Есүсийн **үхлийн хувьд, Тэр нэг удаа нүглийн** бүх асуудлыг нэгмөсөн шийдэн **үхсэн. Тэр үхэхдээ** нүглийн нэхэмжлэл, төлөөс, шаардлага, шийтгэлийг бүрэн төлжээ. Есүс энэ ажлыг төгс гүйцээсэн тул дахин давтаж хийх шаардлагагүйгээр данс тооцоог бүрэн хаасан. Харин одоо **Түүний амьдралын хувьд, Тэр Бурханд амьдардаг.** Мэдээж тэр үргэлж Бурханд амьдарч байсан. Гэхдээ одоо шинэ харилцаан дотор, амилсан Нэгэний хувьд, гэм нүгэл дахин хэзээ ч орж ирэх боломжгүй шинэ нөхцөлд **Бурханд амьдарч байна.**

Цааш явахын өмнө, эхний арван ишлэлийг тоймлон харцгаая. Ерөнхийдөө яригдсан сэдэв

ариусал буюу ариун амьдралыг бий болгох Бурханы арга замын тухай байсан. Бурханы өмнө зогсож байгаа бидний байр суурийг Христтэй хамт үхээд, хамт амилсан гэж Бурхан хардаг. Баптисм үүнийг дүрсэлдэг. Христтэй хамт үхэх үед Адамын доторх байсан түүх маань дуусгавар болжээ. Хуучин хүний маань асуудлыг Бурхан шийдэхдээ шинэчлэл хийсэнгүй харин үхүүлэв. Тэрхүү цаазын ял биднийг Христтэй хамт үхэхэд хэрэгжжээ. Одоо бид шинэ амийн дотор явахаар Христтэй хамт амилсан. Гэм нүгэл үхсэн хүнд юу ч хийж чадахгүй учраас биднийг захирч байсан гэм нүглийн дарангуйлал ч мөн төгсөв. Одоо бид Бурханы төлөө амьдрах эрх чөлөөтэй боллоо.

6:11 Паул бидний *байр суурийн* талаарх үнэнийг өгүүлсэн. Тэгвэл одоо энэ үнэнийг амьдралдаа хэрхэн *хэрэгжүүлэхийг* зааж байна. **Бид өөрсдийгөө нүгэлд үхсэн боловч Бурханд Христ Есүсээр амьд байгаа гэж ТООЦОХ ёстой.**

Тооцох гэдэг нь бидний талаар хэлсэн Бурханы үнэнийг хүлээн авч, түүний гэрэл дотор амьдрахыг хэлнэ. Рут Пакссон энэ тухай ийн бичжээ:

[Тооцох гэдэг нь] Ром 6:6 дугаар ишлэлд хэлсэн Бурханы үгэнд итгэж, өөрийгөө аврагдах үед энэ зүйл тохиолдсон үнэн баримт гэж мэдэхийг хэлнэ. Үүний тулд итгэлийн тодорхой үйлдэл хийж, улмаар “хуучин хүнийхээ” талаар хөдөлшгүй бат байр суурьтай болох

шаардлагатай. Бурхан хуучин хүнийг маань Христтэй хамт загалмайд цовдлогдсон гэж хардаг шиг, бид ч бас тийн харах ёстой. Хуучин хүнийг маань Бурханы нигүүлсэл хаана тавьсан тэр л газар нь үргэлж байлгахын тулд итгэл маань тасралтгүй ажиллах ёстой. Үүнд бид маш гүн гүнзгий оролцоно. Яагаад гэвэл бид хуучин хүнээ цаашид амьдрах учиргүй, биднээс аливаа юм шаардах эрхгүй гэж хуучин “миний” талаар Бурханы гаргасан ял, шүүлттэй бүрэн санаа нийлэх учиртай болно. Ариун амьдралаар амьдрах хамгийн эхний алхам бол “хуучин хүнээ” ийнхүү загалмайд цовдлогдсон гэж тооцох явдал билээ.”¹⁹

Бид сорилт, уруу татлагатай учрахдаа өөрсдийгөө гэм нүгэлд үхсэн гэж тооцоод үхсэн хүн ямар хариу үзүүлэх байсан шиг тийн хандах хэрэгтэй. Нэг өдөр Августин гудамжаар явж байтал Христэд итгэхийн өмнө нууц амраг нь байсан бүсгүйтэй таарчихжээ. Тэгэхэд Августин шууд нүүр буруулан хамаг хурдаараа алхаж эхлэв. Нөгөө эмэгтэй түүнийг хойноос нь дуудаад “Августин, би байна, би байна” гэж хашхирав. Августин улам хурдлах зуураа эргэж хараад “Тийм ээ, би таньж байна. Гэхдээ би нэгэнт би биш болсон”²⁰ гэсэн гэдэг. Августин нүгэлд үхэж, Бурханд амьдарч байгаагаа ийн хэлжээ. Үхсэн хүн ёс суртахуунгүй байдал, худал хэлэх, бусдыг мэхлэх, хов жив ярих, юм уу өөр ямар ч гэм нүгэлд орооцолдож чадахгүй.

Харин одоо бид **Христ Есүсээр Бурханд амьд байна.** Өөрөөр хэлбэл бид ариун байдал,

мөргөл хүндлэл, залбирал, үйлчлэл, үр жимстэй амьдралд дуудагдсан гэсэн үг.

6:12 6:6 дугаар ишлэлд дурдсанчлан бидний хуучин хүн загалмай дээр цовдлогдсон тул гэм нүгэл хэмээх дарангуйлагчийг нокаут-нд оруулж, гэм нүглийн арчаагүй боол байхаа больсон гэдгээ одоо бид мэднэ. Тэгэхээр амьдралд өгөх сургамж нь байр суурийн хувьд үнэн байгаа зүйл дээр тулгуурлаж байна. Бузар хүслүүдээ дагаж, **үхлийн** биедээ **гэм нүгэл ноёрхохыг** бид **зөвшөөрч болохгүй**. Голготын толгой дээр гэмийн ноёрхлыг үхлээр дуусгасан. Харин одоо бид үүнийг амьдралдаа хэрэгжүүлэх ёстой юм. Үүнд бидний хамтын ажиллагаа хэрэгтэй. Зөвхөн Бурхан л биднийг ариун болгож чадна. Гэвч бидний хүсэл үгүй бол Тэр үүнийг хийхгүй.

6:13 Энэ нь биднийг гурав дахь түлхүүр үгэн дээр авчирч байна: **ӨРГӨХ**. Бид бие махбодын **эрхтнүүдээ нүгэлд өргөж**, хорон муугийн багаж, зэвсэг болгон ашиглаж болохгүй. Бидний үүрэг бол өөрсдийн эрхтнүүдийг **Бурханд** захируулж, **зөвт байдлын** хэрэгт ашиглах явдал юм. Яагаад гэвэл бид үхлээс амь уруу амилсан билээ. Өмнө 6:4 дүгээр ишлэлд дурдсанчлан бид шинэ амьдрал дотор алхах ёстой.

6:14 Гэм нүгэл яагаад итгэгч биднийг **захирахгүй** өөр нэгэн шалтгааныг энд өгч байна. Бидний хуучин хүн Христтэй хамт цовдлогдсон (6:6) гэдэг нь эхний шалтгаан байсан. **Бид хуулийн доор бус, харин**

нигүүлслийн доор байгаа гэдэг нь хоёр дахь шалтгаан.

Хуулийн доор байгаа хүний дээр гэм нүгэл ноёрхлоо тогтоодог. Яагаад? Яагаад гэвэл хууль хүнд юу хийхийг зааж өгөхөөс биш, түүнийгээ хийх хүч чадлыг өгдөггүй. Бас хүний нүгэлт мөн чанарт оршдог, хориотой зүйлийг хиймээр санагддаг төрөлхийн хүслийг хууль өдөөдөг. “Хориотой жимс амттай” гэх хуучны үгийн утга энэ билээ.

Нигүүлслийн доор байгаа **хүнийг гэм нүгэл захирахгүй**. Итгэгч хүн гэм нүгэлд үхсэн. Тэр хүн ариун амьдрах хүч болох Ариун Сүнсийг дотроо нутаглуулан хүлээн авдаг. Шийтгүүлнэ гэсэн айдас бус, Аврагч Эзэнээ гэх хайр хөдөлгөгч хүч нь болдог. Ариун байдлыг бий болгодог цорын ганц зүйл бол **нигүүлсэл** билээ. Денни энэ тухай, “Хориг цааз биш, ухаарал ойлголт гэмээс чөлөөлдөг. Синай уул биш, Голготын толгой ариун хүмүүсийг төрүүлдэг”²¹ гэж хэлсэн.

6:15 Нигүүлслээс айдаг хүмүүс нигүүлслийг гэм хийх зөвшөөрөл олгож байгаа хэрэг юм гэж маргадаг. Паул энэ ташаа ойлголтыг тас цохихдоо асуулт тавьснаа эрс шийдэмгий няцаасан. Бид хуулиас чөлөөлөгдсөн боловч хуульгүй хүмүүс биш. Нигүүлсэл гэдэг нь Эзэнд үйлчилж, Түүний эсрэг гэм хийхгүй байх эрх чөлөө юм.

6:1 дүгээр ишлэлд “Бид нүгэл дотор байсаар байх уу?” гэсэн асуулт тавьсан бол энэ ишлэлд

“Бид багахан нүгэл үйлдэж болох уу?” гэсэн асуулт тавьж байна. Энэ хоёр асуултад хоёуланд нь “**Бүү ийм байх болтугай**” буюу огтхон ч үгүй гэж хариу барьсан. Бурхан ямар ч гэм нүглийг хүлээн зөвшөөрөхгүй.

6:16 Хэрэв бид өөрсдийгөө хэн нэгэнд захируулбал бид түүний зарц, боол болдог нь амьдралын жирийн нэгэн үнэн билээ. Үүний адилаар бид гэм нүгэлд өөрсдийгөө худалдвал гэм нүглийн **боол** болох ба замынх нь төгсгөлд мөнхийн **үхэл** хүлээж байдаг. Харин эсрэгээрээ, бид Бурханыг дагах сонголт хийвэл үр дүнд нь ариун амьдралтай болно. Гэм нүглийн боолууд ял буруутгал, айдас, уй гашууд хүлэгддэг. Харин Бурханы зарц нар шинэ хүний хайртай зүйлсийг үйлдэх эрх чөлөөтэй. Тэгвэл эрх чөлөөтэй байх боломж байсаар атал заавал яагаад боол болох ёстой гэж?

6:17 “Нэгэн цагт гэм нүглийн боол байсан та нар Христийн сургаалын нөлөөг авахдаа тэр сургаалын дуудлагад шударга үнэнээр дагахаар шийдсэний төлөө Бурханд талархъя” (Библийн JBP орчуулга). Ромын итгэгч нар нигүүлслийн сайнмэдээнд өөрсдийгөө зориулахдаа тэрхүү сайнмэдээ болон энэ захидалд Паулын заасан бүх **сургаалд** бүрэн зүрхээр дуулгавартай байв.

6:18 Зөв сургаал зөв үйлдэл рүү хөтөлдөг. **Нүгэл** гэдэг эзнээс **чөлөөлөгдсөн** хэмээх үнэнийг хүлээн аваад тэд **зөвт байдлын боол болсон**. **Нүглээс чөлөөлөгдсөн** гэдэг нь гэмт мөн чанар нь байхгүй болсон гэсэн үг биш.

Эсвэл гэм нүгэл дахин үйлдэхээ больсон гэсэн үг ч биш. Хам сэдвээс нь харвал гэм нүгэл амьдралын ноёрхогч хүч байхаа больж, эрх чөлөөтэй болсон гэх утгыг илтгэж байна.

6:19 Элч Паул 18 дугаар ишлэлд зөвт байдлын боол гэж хэлэхдээ зөв шударга хүн үнэндээ боолчлолд байдаггүй гэдгийг мэдэж байсан. “Зөвт байдал нь үнэндээ боолчлол биш. Хүний нийгэмд байдаг ухагдахууныг ашиглан дүрсэлж байгаа юм”²². Нүгэл үйлдэгч нь нүглийн боол мөн. Харин Бурханы Хүүгийн чөлөөлсөн хүмүүс нь жинхэнэ эрх чөлөөг авдаг (Иохан 8:34, 36).

Паул хүмүүсийн өдөр тутмын амьдралд байдаг энгийн ухагдахуун буюу **боол**, эзний харилцааг ашиглан **хүний ёсоор** ярьж байна гэжээ. Паулын захидлыг уншиж байсан хүмүүсийн **махан биеийн сул дорой байдлаас** болж тэр ийн тайлбарласан. Махан биеийн сул дорой байдал гэдэг нь сайнмэдээний үнэнийг ерөнхий байдлаар тайлбарлах үед үнэнийг ойлгоход тэдний оюун ба сүнсний хувьд бэрхшээлтэй байсныг хэлж байна. Үнэнийг хүнд ойлгуулахын тулд жишээ, зураглалыг түгээмэл ашигладаг.

Итгэгч нар Христ рүү эргэхээсээ өмнө есөн жорын **цэвэр бус байдал**, түмэн янзын бузар явдалд өөрсдийн биеийг **боолчлуулсан** байдаг. Харин одоо тэд нөгөө биеэ **зөвт байдлын боол болгон** өргөх ёстой. Ингэснээр тэдний амьдрал үнэхээр ариун болох юм.

6:20 Гэм нүглийн боол байхдаа тэдний мэддэг цорын ганц эрх чөлөө нь **зөвт байдлаас** чөлөөтэй байх явдал байсан. Хамаг мууд хүлэгдэж, сайн сайхан болгоноос **чөлөөтэй** байсан нь туйлын цөхөрмөөр нөхцөл байв.

6:21 Паул тэдний (төдийгүй бидний) анхаарлыг үл итгэгч амьдралын үр жимс буюу итгэгч нарын **одоо ичиж байгаа** үйл ажиллагаануудын үр жимс рүү хандуулж байна. Маркус Рейнсфорд тэдгээр зүйлийг дараах байдлаар тодорхойлсон:

*1. Мэдлэг чадвараа дөвийлгөдөг. 2. Сэтгэлээ жолоогүй тавьдаг. 3. Цагийг дэмий үрдэг. 4. Нөлөөгөө буруу ашигладаг. 5. Дотнын нөхдөдөө гай тарьдаг. 6. Бидний амин сонирхол зөрчигдсөн. 7. Хайрыг доромжилдог, ялангуяа Бурханы хайрыг. Энэ бүхнийг нэгтгээд ганцхан үгээр хэлбэл “ИЧГҮҮР”.*²³

Тэдгээр зүйлийн төгсгөл бол үхэл болой. А. Т. Пиерсон “Нүгэл бүр үхэл рүү тэмүүлж байдаг. Хэрэв үүнийг зогсоохгүй л бол үхэлд хүргэх ба тэр нь түүний зорилго ба үр жимс юм”²⁴ гэж бичсэн.

6:22 Христэд итгэн өөрчлөгдөх нь хүний байр суурийг бүрэн өөрчилдөг. Тэр хүн өөрийг нь эзэрхэж байсан гэм **нүглээс чөлөөтэй** болж, сайн дураараа **Бурханы** боол болж хувирдаг. Үр жимс нь өнөөгийн ариун амьдрал бөгөөд аяллынхаа төгсгөлд мөнх аминд хүрнэ. Мэдээж хэрэг итгэгч хүн одоо ч гэсэн мөнх **амьтай**.

Гэхдээ энэ ишлэлийн хэлж байгаа мөнх амь бол алдаршуулагдсан биеэр амилах үе буюу мөнх амийн бүрэн дүүрэн байдал юм.

6:23 Элч Паул ярьсан зүйлсээ тоймлон гурван эсрэгцлийг танилцуулж байна:

Хоёр эзэн - гэм нүгэл ба **Бурхан**

Хоёр арга зам - **хөлс** ба **бэлэг**

Хоёр үр дүн - **үхэл** ба **мөнх амь**

Мөнх амь бидний **Эзэн Есүс Христэд** байгаа бөгөөд **Христийн дотор** байгаа хүн бүр **мөнх амьтай** гэдгийг анзаараарай. Ийм л энгийн!

3. Бурханы хууль итгэгчдийн амьдралд эзлэх байр суурь (7-р бүлэг)

Эндээс эхлээд элч Паул хожим зайлшгүй гарч ирэх нэгэн асуултын хариуг урьдчилан өгч байна: *Христитгэгчдэд Бурханы хууль ямар хамаатай вэ?* Хуулийг Израильд өгсөн учраас энэ асуултад хариулахдаа Паул Иудей итгэгч нарыг бодож байсан биз ээ. Харин эдгээр зарчим зөвтгөгдсөнийхөө дараа амьдралаа хуулиар удирдуулахыг мунхаглан оролдох харь үндэстний итгэгч нарт ч хамаатай.

Бурханы хүүхэд болсон хүний амьдрал дахь гэмт мөн чанарын дарангуйлал үхлээр дуусгавар болсон гэдгийг бид 6 дугаар бүлэгт үзсэн. Тэгвэл одоо үхэл нь хуулийн доор байгаа хүмүүсийн дээрх хуулийн ноёрхлыг ч бас дуусгавар болгодгийг энэ бүлгээс харах болно.

7:1 Энэ ишлэл 6:14-д хэлсэн “Чи хуулийн дор биш, нигүүлслийн дор байдаг” гэдэгтэй уялдаж байна. Юугаар уялдаж байгааг харвал “чи хуулийн дор байдаггүй гэдгээ мэдэх учиртай буюу хууль нь хүнийг амьд байхад л хүнийг захирдаг гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? гэжээ. Паул энд хуулийн үндсэн зарчмуудтай танил тул хууль үхсэн хүмүүст ямар ч хамаагүй гэдгийг мэдэх учиртай хүмүүст ярьж байна.

7:2 Үүнийг дүрслэхийн тулд Паул үхэл гэрлэлтийн гэрээг яаж цуцалдгийг авч үзсэн. **Гэрлэсэн эмэгтэй нөхрийгөө амьд байх үед нь нөхөртэйгөө гэрлэлтийн хуулиар холбогддог. Харин нөхөр нь нас барвал тэр эмэгтэй тэрхүү хуулиас чөлөөлөгдөх аж.**

7:3 Гэрлэсэн эмэгтэй хүн **нөхрийгөө** амьд байхад **өөр эртэй холбогдвол** түүнийг завхайрсанд тооцно. Хэрэв **нөхөр нь нас барвал** тэр эмэгтэй өөр эртэй суулаа гээд ямар нэгэн буруу зүйл биш тул дахин гэрлэхэд **чөлөөтэй.**

7:4 Энэ жишээг бид хэтэрхий үгчлэн тайлбарлах ёсгүй. Жишээлбэл эхнэр *ч тэр*, нөхөр *ч тэр*, аль нь ч хуулийг төлөөлөөгүй. Гол санаа нь үхэл гэрлэлтийн харилцааг тасалдаг шиг Христтэй хамт үхсэн итгэгч хүн хуулийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээх шаардлагагүй болсон гэдгийг энд хэлж байгаа юм.

Паул хуулийг үхсэн гэж хэлээгүй болохыг анхаараарай. Хууль одоо ч гэсэн гэм нүглийг

мэдрүүлэх үйлчлэлээ үргэлжлүүлэн хийж байгаа. Түүнээс гадна энэ бүлэгт Паулын хэлсэн “бид” гэдэг үг нь Христэд итгэсэн иудейчүүдийг хэлж байгааг ойлгох нь чухал.

Бид **Христийн биеэр дамжуулан хуульд үхсэн. Христийн бие** гэдэг нь үхэлд өргөгдсөн Есүсийн бие махбодыг хэлж байна. Тиймээс бид хуульд хамааралгүй болж, харин үхлээс амилсан Есүс Христтэй холбогдсон. Үхлээр нэг гэрлэлт хүчингүй болж, өөр нэг гэрлэлт бий болов. Одоо бид **хуулиас чөлөөлөгдсөн тул Бурханы төлөө үр жимс гаргаж чадна.**

7:5 Энд үр жимсийн тухай дурдсан нь **махан биеийн дотроо байхад маань** биднээс гардаг байсан **үр жимсний** тухай сануулж байна. **Махан биеийн дотор** гэдэг хэллэг “бие махбодын дотор” гэсэн утгыг хэлээгүй. Харин бид аврагдахынхаа өмнө ямар байр суурьтай байсныг дүрсэлж байна. Тэр үед бидний Бурханы өмнөх байр суурь махан биед түшиглэж байжээ. Бурханы тааллыг олохын тулд хэн байсан, юу хийж чадсан гэдэгтээ бид тулгуурладаг байв. **Махан биеийн дотор** байх нь “Христийн дотор” байхын яг эсрэг зүйл мөн.

Бид Христ рүү эргэхийнхээ өмнө **хуулиар сэргээгдсэн нүгэлт хүсэл тачаалуудаар** удирдуулж байсан. Тэр нүгэлт хүсэл тачаалуудыг хууль *бий болгоогүй* боловч тэдгээрийг нэр цохон хориглох үед тэрхүү хорьж цагдсан зүйлсийг нь үйлдэх хүчтэй хүсэл бидний дотор бий болсон!

Нүгэлт энэ хүсэл тачаалууд бидний биеийн эрхтнүүдээр илэрсэн. Тэгээд уруу татлагад бууж өгөх үед маань **үхэлд** хүргэх хорт үр жимсийг бий болгодог. Элч Паул өөр нэг газар энэ үр жимсийг махан биеийн үйлс гэж нэрлэсэн. Тухайлбал: “завхайрал, бузар байдал, тачаангуй байдал, шүтээн шүтэх, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа, атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх” (Галат 5:19-21).

7:6 Бид Христ рүү эргэх үед болсон олон гайхамшгийн нэг нь **хуулиас чөлөөлөгдсөн** явдал юм. Бид Христтэй хамт үхсэн учраас ийм үр дүн гарчээ. Есүс биднийг төлөөлөн үхсэн учраас бид түүнтэй хамт **үхсэн**. Есүс үхэхдээ хуулийн шаардаж байсан аймшигт төлөөсийг төлж шаардлага бүрийг нь биелүүлсэн. Тийм учраас бид хуулиас чөлөөлөгдөж, зайлшгүй ирэх хараалаас нь ангижирчээ. Ингэснээр давхар аюулаас мултарч.

Батлан даагч маань нэгэнт төлөөд

Үнэт цусаа урсгасан болохоор

Бурхан төлөөсийг ахиад нэхэхгүй

Үнэндээ надаас одоо юу ч шаардахгүй

-Августус М. Топлади

Одоо бид чөлөөтэй болсон тул **үсгийн хуучрал дотор биш, харин Сүнсний шинэлэг байдал дотор үйлчилдэг**. Бидний үйлчлэлийн хөдлөгч хүч нь айдас бус хайр. Энэ бол

боолчлолын бус, эрх чөлөөний үйлчлэл юм. Бурханд үйлчлэхийн тулд хэлбэр хөөсөн, зан заншлын нарийн дэг журмыг боол мэт мөрдөх шаардлагагүй болж, харин сайн дураараа, баяр хөөртэйгөөр Бурханы яруу алдар, бусад хүний ивээл ерөөлийн төлөө өөрийгөө асган зориулах болов.

7:7 Энэ бүгдээс харахад Паул хуулийг *шүүмжилж, дургүйцэж* байгаа мэт сэтгэгдэл төрж магад. Итгэгч хүн гэм нүгэлд үхсэн, хуульд үхсэн гэж Паул хэлсэн. Тийм болохоор хууль муу зүйл шиг санагдаж болно. Гэвч огт тийм биш.

7:7-13 дугаар ишлэлд аврагдахынх нь өмнө хууль өөрийнх нь амьдралд ямар чухал үүрэг гүйцэтгэж байсныг Паул дүрслэн өгүүлдэг. Тэрбээр хууль нь өөрөө гэм нүгэлтэй зүйл биш, харин *хүний доторх нүглийг илчлэгч* гэдгийг цохон тэмдэглэсэн. Паулын зүрх сэтгэлд байсан аймшигт гэм нүглийг шүүн яллаж байсан зүйл бол хууль мөн. Өөрийгөө бусад хүнтэй харьцуулан үзэхэд шударга журамтай хүн мэт санагдавч Бурханы хуулийн шаардлага ял зэмийг нь ойлгуулахад Паул хэлэх үггүй болж, буруутайгаа мэдэрчээ.

Гэм нүглийг түүнд онцгойлон илчилсэн тушаал бол арав дахь тушаал байв: **Чи бүү шунахайр.** Шунахайрал хүний бодол санаанд явагддаг. Паул хэдийгээр илүү жигшмээр муу муухай нүгэл үйлдээгүй байж болох ч, түүний бодол санаа ялзарсныг тэр олж харжээ. Гэмт

муу бодол санаа хүний гэмт муу үйлдлийн нэгэн адил бузар муу болохыг Паул ойлгосон байна. Түүний бодол санаа, дотоод ертөнц бохирдсон байв. Гаднаа тэр харьцангуй гэм зэмгүй байсан боловч дотоод сэтгэл нь аймшгийн хонгил болсон байлаа.

7:8 Харин нүгэл тушаалаар шалтаглаж миний дотор зүсэн бүрийн шунахайрлыг төрүүлсэн. Хууль шунахайрлын бүх хэлбэрийг хориглох тусам хүний завхарч ялзарсан мөн чанар улам бүр үүнийг хийх хүсэлд автдаг. Жишээлбэл, хууль нэг ёсондоо “чи бодол санаандаа хүнтэй янз бүрийн бэлгийн харилцаанд орж байна гэж төсөөлж болохгүй. Хүсэл тачаалын хийсвэр ертөнцөд амьдарч болохгүй” гэж заасан. Хэдийгээр хууль бохир заваан, завхай зайдан, ялзарсан бодлуудыг хориглох боловч тэр бодлуудыг ялан дийлэх хүч чадлыг өгдөггүй. Тиймээс хуулийн дор байгч хүмүүс садар самуун бодол мөрөөдлийн ертөнц рүүгээ улам живдэг. Тийнхүү гэм нүгэлд унасан хүмүүний мөн чанар хориглосон зүйлийг улам илүү хүсдэг. “Хулгайлсан ус чихэрлэг. Нууцлан идсэн талх амттай” (Сургаалт үгс 9:17).

Харьцангуйгаар хуулиас ангид бол нүгэл нь үхмэл юм. Хүний гэмт мөн чанар унтаж буй нохойтой ижил. Хууль тэр нохой дээр ирээд “Бүү хий” гэж хэлсэнд нохой босож ирээд хориглосон зүйлийг улангасан хийдэг.

7:9 Хуулийн буруутгал, ял зэм нь ирээгүй байхад Паул **амьд** байв. Түүний гэм нүгэлт мөн чанар *харьцангуй* амар жимэр байсан тул зүрх сэтгэлдээ байсан хорон муугийн уурхайг огтхон ч анзаарсангүй.

Харин тушаал ирэв. Өөрөөр хэлбэл гэм буруугаа хурцаар ухаартал түүний нүгэлт мөн чанар сэрэн ноцжээ. Харамсалтай нь тэр хуулийг дагах гэж хичээх тусам улам бүтэлгүйтсэн. Тиймээс тэр өөрийн зан чанар, хичээл зүтгэлээр авралыг олж авах найдваргүй болж **үхжээ**. Өөрийгөө сайн хүн гэж үзэж байсан хамаг бодол нь бас **үхэв**. Түүгээр ч зогсохгүй хуулийг сахиснаар зөвтгөгдөх бүх мөрөөдөл нь **үхэв**.

7:10 Ийнхүү аминд хүргэх байсан тушаал нь үхэлд хүргэдгийг мэдэв. Тэгвэл аминд хүргэх байсан тушаал гэдэг нь юу гэсэн үг вэ? Үүнийг хэлэх үедээ Паул, “Тиймээс та нар миний тогтоол, миний шүүлтийг сахигтун. Тэдгээрийг үйлддэг хүн түүгээрээ амьдарна. Би бол ЭЗЭН” хэмээн Леви 18:5-д хэлсэн Бурханы үгийг бодож байсан болов уу. Хуулийг сахисан хүнд амь өгөх болно гэсэн амлалт байгаа нь үнэн. Гэвч энэ нь зүйрлэвэл үүнтэй ижил: Амьтны хүрээлэнд арслангийн торны өмнө “торноос хол зогс” гэсэн хориглох бичиг байжээ. Хэрэв тэр үгийг биелүүлбэл хүн амиа аварч үлдэнэ. Харин тэр үгийг дагалгүй арслангийн нүхэнд ойртвол амиа алдах болно.

7:11 Хууль огтхон ч буруугүйг Паул энд ахин онцлон тэмдэглэж байна. Хуулийн хориглосон зүйлийг үйлдэхийг өдөөж байсан нь Паулын дотор орших гэм **нүгэл** байв. Гэм **нүгэл** түүнийг хуурч, хориглосон жимс тийм ч муу зүйл биш, харин ч баяр хөөр өгдөг юм байна, ямар нэгэн ял шийтгэлгүй мултарч болно гэсэн худал бодлыг төрүүлжээ. Түүгээр ч зогсохгүй, Бурханы хориг тушаал өөрийнх нь сайн сайхныг хулгайлж байдаг гэсэн сэтгэгдэл төрүүлэв. Ийнхүү авралыг олж авч чадна гэж хүлээсэн хамаг найдварт нь үхлээр хариу барьж, гэм **нүгэл** түүнийг **алав**.

7:12 Хууль нь өөрөө **ариун бөгөөд тушаал бүр ариун, зөвт, сайн юм**. Хуульд буруу юу ч байхгүй гэдгийг бид байнга санаж байх хэрэгтэй. Хуулийг Бурхан өгсөн. Тиймээс Бурханы хүслийг ард түмэнд нь төгс илэрхийлдэг. Хүмүүсийн гэм **нүгэл**т мөн чанар хуулийн сул тал болдог. Хууль нь нэгэнт гэмд унаж, **нүгэл**т мөн чанартай болсон хүмүүст өгөгдсөн билээ. Тэдэнд **нүглийг** нь мэдүүлэхийн тулд хуулийг өгсөн. Гэвч **нүглийн хүч** чадал, түүний шийтгэлээс чөлөөлөгдөхийн тулд тэдэнд Аврагч хэрэгтэй.

7:13 **Юу нь сайн** гэдэг үг энд хуулийг хэлж байна. Үүнийг бид өмнөх ишлэлээс ойлгож болно. Паул “хууль **надад үхлийн шалтгаан болсон уу?**” гэдэг асуултыг тавьж байна. Өөрөөр хэлбэл “Паул гэдэг хүнийг (бас бид бүгдийг) үхэл рүү түлхсэн нь хууль гэж үү?”

хэмээн асууж байна. Мэдээж **огтхон ч үгүй**. Үхэлд хүргэсэн нь *гэм нүгэл* юм. Хууль гэм нүглийг бий болгоогүй. Харин гэм нүглийг илчлэн харуулсан. “Хуулиар нүглийн мэдлэг ирдэг” (3:20б). Тэгээд дуусчихгүй. Бурханы ариун хууль ямар нэг зүйлийг бүү хий гэж хориглох үед хүний гэмт мөн чанар ямар хариу үзүүлдэг вэ? Хариуг нь бүгд сайн мэднэ. Нойрсож байсан хүсэл шатаж буй шунал болж хувирдаг. Ийнхүү **тушаалаар дамжуулан нүгэл нь туйлын нүгэлт** болдог ажээ.

Паулын энд ярьж байгаа зүйл, 7:10-д хэлсэнтэй нь зөрчилдөж байгаа мэт харагдаж магад. 7:10-д Паул хуулийг үхэл авчирдаг гэж хэлсэн атлаа энд болохоор хууль түүнд үхлийн шалтгаан болоогүй гэж хэлж байна. Үүнийг тайлбарлавал: Хууль нь өөрөө хүний хуучин мөн чанарыг сайжруулдаггүй, бас хуучин мөн чанараар нүгэл хийлгэдэггүй. Термометр дулааны хэмийг харуулдаг шиг хууль гэм нүглийг илчилдэг. Гэхдээ термометр нь термостат шиг дулааны хэмийг тохируулж чаддаггүй. Үүний нэгэн адил хууль гэм нүглийг хянаж чадахгүй.

Тэгээд ийм зүйл болдог: Хүний гэмд унасан нүгэлт мөн чанар хуулийн хориглосон зүйлийг хийхийг хүсдэг. Тиймээс хуулийг ашиглаж, гэмт хүний амьдралд байгаа унтаа хүсэл тачаалыг сэрээдэг. Хүн хичээх тусам, улам бүр дордож эцэстээ хамаг найдвараа алддаг. Ингээд гэм нүгэл хуулийг ашиглаж, хүний дотор

байсан сайжрах найдварыг нь бүрэн мөхөөдөг. Тэгээд тэр хүн өмнө нь анзаардаггүй байсан гэмт хуучин мөн чанарынхаа туйлын нүгэлт байдлыг олж харна.

7:14 Энэ хүртэл элч Паул өнгөрсөн амьдралаа буюу хуулийн үйлчлэлээр гэм нүглээ гүнээ ухамсарлахад өөрт нь тохиолдсон хямралын тухай өгүүлсэн.

Харин одоо дахин төрсөн цагаасаа хойш ямар байгаа тухайгаа өгүүлэхийн тулд одоо цаг дээр ярьж эхэллээ. Тодруулбал, хоёр мөн чанарын хоорондох зөрчил ба өөрийн хүчээр гэмт мөн чанарын хүчийг ялах боломжгүй тухай. **Хууль нь сүнслэг бөгөөд ариун, хүний сүнсэнд сайныг өгөхийн тулд өгөгдсөн гэдгийг Паул хүлээн зөвшөөрсөн.** Гэвч тэр амьдралд нь байгаа гэм нүглийн хүчийг ялж чадахгүй байгаа учраас **махан биетэй** гэжээ. Нэг ёсондоо **нүглийн боолчлолд худалдагдсан** байна. Гэм нүгэл түүний эзэн, тэр өөрөө боол нь мэт Паулд санагдаж байв.

7:15 Тэгвэл одоо элч Паул Христийн үхэл, амилалттай хэрхэн холбогдсон тухай үнэнийг мэдэхгүй итгэгч нарын дотоод сэтгэлд болдог зөрчил, тэмцлийн талаар ярьж байна. Тийм хүн ариун байдалд хүрэхээр Синай уул өөд авирах ба хоёр мөн чанар нь хоорондоо тэмцэж байдаг. Харри Фостер үүнийг ийн тайлбарласан:

*Бурханы “ариун, зөвт, сайн” тушаалуудыг (12-р ишлэл) биелүүлэх гэж хамаг хүчээ зориулан, өөрийн чармайлтаараа ариун байдалд хүрэх гэж оролддог нэг хүн байжээ. Гэтэл хичээх тусам байдал нь дордож байгааг тэр хүн ойлгов. Тэрээр хэзээ ч ялахааргүй байна. Үүнд гайхах юм алга. Гэм нүгэлд унасан хүний мөн чанарт гэм нүглийг ялж, ариун амьдрах хүч байдаггүй билээ.*²⁵

Энэ бүлэгт би, намайг, миний, надад гэх мэт нэгдүгээр биеийн төлөөний үг ямар их байгааг анхаарна уу. 9-25 дугаар ишлэлд нэгдүгээр биеийн төлөөний үг дөч гаруй удаа гарна. Ром 7-р бүлэгт ярьж байгаа амьдралыг амсаж туулсан хүмүүс “Би витамин”-ыг хэтрүүлэн хэрэглэсэн хүмүүс байдаг. Тэд ялалтыг өөрийнхөө дотроос хайдаг боловч тэнд нь байдаггүй.

Орчин үед сэтгэлзүйн зөвлөгөө өгөгч христитгэлт хүмүүс ихэнхдээ зөвлөгөө авч байгаа хүмүүсийн анхаарлыг өөрсөд дээр нь төвлөрүүлдэг нь харамсалтай. Ингэх нь асуудлыг шийдэх биш, бүр дордуулдаг. Есүсийг хүлээн авсан хүн Христтэй хамт үхээд шинэ амьдралаар алхахаар Түүнтэй хамт амилсан гэдгээ мэдэх хэрэгтэй. Тэгвэл тэд махан биеэ сайжруулахыг оролдохгүй, харин Есүсийн булш уруу хаях болно.

Хоёр мөн чанарын хоорондох тэмцэл зөрчилдөөний талаар дүрслэхдээ Паул **би юу үйлдэж байгаагаа өөрөө ч ойлгодоггүй** гэж хэлсэн. Паулын дотоод сэтгэл нь хоёр

хуваагдсан байв. Өөрөөр хэлбэл тэр хийхийг хүсдэггүй зүйлээсээ таашаал авч, үзэн яддаг зүйлээ үйлддэг байв.

7:16 Өөрийнхөө хийж байгаа зүйлийг буруутгаснаараа тэр өөрөө өөрийнхөө эсрэг болж, **хуулийн** талд орж байгаа хэрэг юм. Яагаад гэвэл хууль ч бас тэдгээр зүйлийг буруутгадаг. Тиймээс тэр хуулийг **сайн** гэдгийг дотроо хүлээн зөвшөөрсөн байна.

7:17 Эндээс бид нэгэн дүгнэлтэнд хүрч болно. Гэмийг үйлдэгч нь Христийн доторх шинэ хүн биш харин Паулын дотор оршиж байсан гэм нүгэлт, ялзарсан хуучин мөн чанар нь байжээ. Гэвч бид энд болгоомжтой байх хэрэгтэй. Дотор минь гэм **нүгэл** оршдог гэдгээр гэм хийх явдалд шалтаг өгч болохгүй. Бид хийж байгаа зүйлдээ өөрсдөө хариуцлагатай, бурууг бусдад өгч, алдаагаа өөр зүйл рүү чихэхээр энэ ишлэлийг ашиглаж болохгүй. Паул энд гэмт зан үйлийнхээ цаад үндэс эх үүсвэрийг илрүүлж байгаа болохоос биш түүнийгээ хаацайлж байгаа хэрэг биш.

7:18 Паулын энд ойлгосон зүйлийг ойлгохоос нааш ариун байдалд ахиц гаргах ямар ч боломжгүй. Тэр нь юу гэвэл: **Миний дотор буюу миний махан биед ямар ч сайн зүйл байдаггүй.** Энд гарч байгаа **махан бие** гэдэг үг нь Адамаас өвлөн авсан бузар муу, ялзарсан мөн чанарыг хэлж байна. Энэ мөн чанар итгэгч нарын дотор ч гэсэн бий. Энэ мөн чанар хүний

хийдэг хамаг бузар үйлийн эх үүсвэр мөн. Үүний дотор сайн зүйл юу ч үгүй.

Хэрэв бид үүнийг ойлговол хуучин мөн чанараасаа сайн сайхныг хайх оролдлогоо хаях болно. Тийнхүү тэндээс сайн сайхныг олж чадахгүйгээ ойлгох учраас тэнд сайн сайхан зүйл байхгүйн төлөө урам хугарахгүй. Түүнээс гадна бид өөрсдийн хүч тэнхээнд түшиглэхээ болино. Энэ нь биднийг өөрсөд дээрээ улайран төвлөрөхөөс хамгаална. Бид дотроосоо ялалт олохгүй. Энэ тухай Шотландын итгэгч Роберт Мюррей Маккейн, “Бид өөрсөд рүүгээ нэг удаа харах бүрийдээ Христ уруу арван удаа харах ёстой” гэж хэлсэн.

Элч Паул махан биеийн найдваргүй байдлыг батлахын тулд халаглан гашуудсан. Паулд зөвийг хийх хүсэл байвч хүслээ үйлдэл болгох чадвар дотор нь байхгүй байгаад тэр гашуудсан. Тэр зангуугаа завиныхаа дотор талд хаяад байсан нь гол асуудал байжээ.

7:19 Тиймээс хоёр мөн чанарын хоорондох зөрчилдөөн туйлдаа хүрч байв. Эндээс Паул өөрийнхөө ямар хүн болохыг таньж мэдсэн. Тэр хийхийг хүсдэг **сайныгаа** хийж чадахгүй, үзэн яддаг **бузар муугаа** л хийж байв. Түүний дотор зөрчил, мөргөлдөөн асар их байв.

7:20 Энэ ишлэлд дараах тайлбарыг оруулж өгвөл утга нь илүү тодорно: **Хэрэв би** (хуучин мөн чанар) **өөрийн** (шинэ мөн чанар) **хүсдэггүй зүйлээ хийж байгаа бол цаашид би** (тухайн хүн) **биш, харин миний дотор оршин байгч**

нүгэл нь үүнийг үйлддэг. Дахин хэлэхэд Паул энд өөрийгөө хаацайлаагүй, үүрэг хариуцлагаасаа зайлах гэж оролдоогүй гэдгийг санах хэрэгтэй. Харин дотор нь орших гэм нүглийн хүч чадлаас чөлөөлөгдөж чадахгүй гэдгээ ойлгосон болохоо ярьж байна. Гэм нүгэл үйлдэх үедээ шинэ хүний хүслээр биш гэдгийг энд хэлж байна.

7:21 Ингээд тэр сайныг үйлдэхийг хүсдэг өөрийнх нь дотор бузар муу нь байдаг гэсэн зарчмыг буюу **хуулийг** олж мэдсэн. Хэдий тэр сайныг хийхийг хүсэвч гэм нүгэл хийж дуусдаг байна.

7:22 Шинэ мөн чанарынхаа улмаас тэр **Бурханы хуулинд** баясдаг. Бурханы хууль нь ариун бөгөөд Бурханы хүслийг илэрхийлдэг гэдгийг ч мэднэ. Тэрээр Бурханы хүслийг биелүүлэхийг хүсдэг.

7:23 Гэвч тэр амьдралынхаа ажил үйлсээс эсрэг зарчмыг олж хардаг. Шинэ мөн чанарынхаа эсрэг амьдарч, дотор нь орших гэм **нүглийн** хоригдол болсоор байв. Жорж Каттин энэ талаар ингэж бичсэн:

Дотоод хүнийхээ хувьд хуульд баярлах боловч хууль нь хүч чадлыг өгдөггүй. Өөрөөр хэлбэл Бурханы тушаалыг биелүүлэх гэж хичээх оролдлого хэзээ ч үр дүндээ хүрэхгүй. Махан бие Бурханы ариун хуулийг гүйцэлдүүлж чадахгүй. Махан бие махан биеийн зүйлсийг л боддог. Гэтэл тэр нь Бурханы хуультай төдийгүй Бурхантай өөртэй нь дайсагнадаг.²⁶

7:24 Паул энд өөрийн алдартай халаглалыг хэлсэн. Тэр ямар ч гарах гарцгүй, мухардалд орсноо мэдэрсэн. Энд гарч байгаа **бие** бол мэдээж хэрэг ялзарч доройтсон хуучин мөн чанар билээ. Паул өөрийн арчаагүй дорой байдлыг ойлгож, аймшигт энэ боолчлолоос өөрийгөө аварч чадахгүй гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Түүнд ямар нэгэн гаднын эх үүсвэрээс тусламж хэрэгтэй байлаа.

7:25 Энэ ишлэлийг эхлүүлж байгаа гэнэтийн талархал хоёр утгаар ойлгогдож болж байна. Нэгт, **“Бидний Эзэн Есүс Христээр дамжуулан** аврал, чөлөөлөлт ирсэн тул **Бурханд талархал нь байх болтугай”** гэж ойлгож болж байна. Хоёрт, өмнөх ишлэлүүдэд ярьсан хөөрхийлөлтэй хүн байхаа нэгэнт больсон тул Паул **Эзэн Есүсээр дамжуулан** Бурханд талархал өргөхийг хүссэн байж болох.

Энэ ишлэлийн үлдсэн хэсэг нь чөлөөлөлтийг таньж мэдэхийн өмнөх хоёр мөн чанарын хоорондох зөрчилдөөний талаар нэгтгэн тоймлож бичсэн. Шинэчлэгдсэн **оюун ухаанаар** буюу шинэ мөн чанараар итгэгч хүн **Бурханы хуульд** үйлчилдэг боловч **махан биеэрээ** (хуучин мөн чанар) **нүглийн хуульд** үйлчилдэг. Гэвч дараагийн бүлэгт чөлөөлөгдөх арга замын тухай тайлбарласан.

И. Ариун амьдрах хүч чадал нь Ариун Сүнс (8-р бүлэг)

Ариун амьдралын тухай сэдэв үргэлжилж байна. 6 дугаар бүлэгт Паул “итгэлээр дамжин нигүүлслээр ирдэг авралын тухай сургаал нь гэмт амьдралыг зөвшөөрч, хөхүүлэн дэмждэг үү?” гэсэн асуултад хариу өгсөн бол 7 дугаар бүлэгт “ариун амьдрахын тулд христитгэгчид хуулийг сахих ёстой гэж сайнмэдээнд заадаг уу?” гэсэн асуултад хариу өгсөн. Тэгвэл энэ бүлэгт “Христэд итгэгч хүн яаж ариун амьдарч чадах вэ?” гэдэг асуултад хариу өгөх гэж байна.

7-р бүлэгт олонтаа гарч байсан нэгдүгээр биеийн төлөөний үгс энэ бүлгээс эхлэн арилж харин Ариун Сүнс гэдэг үг түгээмэл гарах болно. Үүнийг анзаарах нь 8 дугаар бүлгийг ойлгоход чухал ач холбогдолтой юм. Бид өөрсдийн хүчээр ялалт байгуулж чадахгүй, харин бидний дотор оршигч Ариун Сүнсний хүчээр боломжтой. А. Ж. Гордон Ариун Сүнсний өгдөг долоон тусламжийг жагсаасан: үйлчлэлийн эрх чөлөө (2-р ишлэл); үйлчлэх хүч чадал (11-р ишлэл); гэм нүглийг ялсан ялалт (13-р ишлэл); үйлчлэлийн чиглэл (14-р ишлэл); Бурханы хүүхэд болсны гэрчлэл (16-р ишлэл); үйлчлэлийн тусламж (26-р ишлэл); залбирлын тусламж (26-р ишлэл).

8:1 Элч Паул цөхрөл, ялагдлын хөндийгөөс ялалтын уухай хадаан уул өөд авирч байна.

Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. Үүнийг хоёр талаар ойлгож болно.

Нэгдүгээрт, бид Христийн дотор байгаа учраас Бурхан бидний гэм нүглийг яллахаа больсон. Махан биеийн эцэг, хүн төрөлхтний анхны тэргүүн Адамын дотор байхад бидэнд ял байсан боловч одоо бид Христийн дотор байгаа учраас Христ ял зэмээс чөлөөтэй тул бид ч чөлөөлөгдсөн. Тиймээс бид доорх үгийг зоригтой хэлж чадна:

*Юуны түрүүнд
Ерөөлт Аврагчийг харчих
Бурханы цэнзүүрээс
Буулгаж чадахаа үзчих
Толбо мэт өчүүхэн гэм
Цэг мэт яльгүй нүгэл
Түүний дотроос олбол
Намайг бузар гэхийг
Харин би зөвшөөрнө*
-У. Н. Томкинс

Хоёрдугаарт, Паулын 7-р бүлэгт дүрсэлсэн шиг өөрийгөө яллах хэрэг байхгүй гэсэн утгатай болов уу. Магад бид 7-р бүлэгт дурдсан амьдралыг туулж, хуулийн шаардлагуудыг өөрийн хүчин чармайлтаар биелүүлэх гэж оролдож байсан байж болох. Гэвч одоо тэгэх шаардлагагүй. Яагаад **ял байхгүй** болсныг 2 дугаар ишлэлд тайлбарлаж байна²⁷.

8:2 Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн

хуулиас чөлөөлсөн ажээ. Эд бол эсрэг тэсрэг хоёр хууль буюу зарчим юм. Ариун Сүнсний гол зарчим нь итгэгч нарт ариун амьдрах хүчийг өгөх, тэднийг хүчирхэгжүүлэх. Хүний дотор орших нүглийн гол зарчим нь хүнийг үхэл рүү доош татах. Яг л татах хүчний хууль адил. Хэрэв та дээш бөмбөг шидвэл тэр бөмбөг агаараас хүнд учир заавал доош унана. Гэтэл амьд шувуу бас агаараас хүнд боловч, агаарт хөөргөвөл дээш нисдэг. Шувууны дотор байгаа *амийн* хууль татах хүчний хуулийг ялна. Үүний адилаар Эзэн Есүсийн дахин амилсан амьдралыг тэтгэгч Ариун Сүнс Есүст итгэгч хүнийг **нүглийн ба үхлийн хуулиас чөлөөлдөг.**

8:3 Хүмүүс хуулийн ариун шаардлагуудыг хуулийн хүчээр биелүүлж чадаагүй боловч нигүүлслийн хүчээр биелүүлж чаджээ. Яаж гэдгийг одоо харцгаая.

Хууль нь махан биеийн мөхөс байдлын улмаас ариун амьдралыг бий болгож **чадсангүй.** Асуудал хуулинд байгаагүй. Харин гэмд унасан хүний мөн чанарт байв. Хуулийг хүлээн авагсад нь нэгэнт гэмд унасан, дуулгавартай дагахаас хүч мөхөс хүмүүс байсан билээ. Гэвч Бурхан энэ асуудлыг шийдэхийн тулд **өөрийн Хүүг нүгэлт махан биетэй адил байдалд илгээв.** Энд Эзэн Есүсийг нүгэлт махан биетэй байсан гэж хэлээгүйг анхаараарай. Харин **нүгэлт махан биетэй “адил байдалд”** гэж хэлжээ. Есүс ямар ч нүгэл үйлдээгүй (1Петр 2:22). Есүс нүглийг үл мэдэгч билээ (2Коринт 5:21).

Түүний дотор ямар ч нүгэл байхгүй (1Иохан 3:5). Гэвч Тэр хүний биеэр энэ дэлхийд ирэхдээ гэм нүгэлт хүнтэй адил төстэй харагдаж байсан. Ийнхүү нүглийн өмнөөс золиос болохдоо Христ **махан биеийн дотор нүглийг шийтгэв**. Тэр бидний хийсэн гэм нүглийн төлөө (1Петр 3:18) төдийгүй бидний нүгэлт мөн чанарын төлөө үхсэн. Өөрөөр хэлбэл юу *хийснээс* минь болж үхээд зогсохгүй хэн *байснаас* минь болж үхсэн юм. Ингэж үхэхдээ **махан биеийн дотор нүглийг шийтгэв**. Нүгэлт мөн чанарыг маань уучилсан гэж Библийн хаана ч байхгүй. Харин **шийтгэсэн** гэж бичсэн байна. Харин бидний *үйлдсэн* гэм нүглийг уучилсан.

8:4 Ингэснээр Хуулийн шаардлага нь махан биеийн дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх болно. Хэрэв бид амьдралын жолоогоо Ариун Сүнсэнд даатгавал Бурханыг болоод эргэн тойрны хүмүүсээ хайрлахад Тэр биднийг хүчирхэгжүүлэх болно. Гэтэл энэ нь хуулийн шаардлага юм.

Эхний дөрвөн ишлэлд элч Паул 5:12-оос 7:25 хүртэл ярьсан зүйлийг нэгтгэн базаж байна. 5:12-21 дүгээр ишлэлд Адам ба Христ гэдэг хоёр тэргүүний тухай ярьсан. Тэгвэл 8:1 дээр Адамаар тодорхойлогдож байхдаа өвлөн авсан бидний ял зэм Христээр тодорхойлогдох үед маань зайлуулагдсан гэдгийг дурдсан. 6, 7 дугаар бүлэгт бидний мөн чанарт байгаа гэм хэмээх ноцтой асуудлын тухай авч үзсэн. Тэгвэл одоо Христ Есүс доторх амийн Сүнсний хууль

нь нүглийн ба үхлийн хуулиас чөлөөлдөг гэдгийг Паул ялгуулснаар тунхаглаж байна. 7 дугаар бүлэгт хуультай холбоотой бүх сэдвийг хөндсөн. Тэгвэл одоо бид Сүнсээр удирдуулсан амьдрал нь хуулийн шаардлагад бүрэн нийцдэгийг ойлгож авлаа.

8:5 Махан биеийн дагуу байгчид гэдэг нь Христэд итгээгүй, гэмт амьдралаасаа эргээгүй хүмүүс бөгөөд тэд **махан биеийн юмсыг боддог**. Тэд махан биеийн дур хүслийг дагаж, завхарсан мөн чанарынхаа хүслүүдийг өдөөн, улам бүр ихэсгэдэг. Хэдхэн жилийн дараа тоос шороо болох бие махбодод хамаг ач холбогдлоо өгдөг.

Харин Сүнсний дагуу байгчид гэдэг нь жинхэнэ итгэгчид бөгөөд мах, цусны асуудлаас давж, мөнх юмсын төлөө амьдардаг. Бурханы үг, залбирал, мөргөл хүндлэл, христитгэлийн үйлчлэлд тэд бүх анхаарлаа тавьдаг.

8:6 Махан биеийн бодол санаа гэдэг нь гэмд унасан мөн чанарын хандлага бөгөөд энэ нь **үхэл мөн**. Ийм бодол санаа амьд ахуй үеийн жаргал ба эцсийн хувь тавилангийн хувьд үхэл юм. Тунг нь хэтрүүлсэн хор мэт үхлийн уршиг дагуулдаг.

Харин Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой. Бурханы Сүнс бол жинхэнэ амьдралын баталгаа, Бурхантай хамт байх амар тайвны баталгаа, амгалан тайван амьдралын баталгаа мөн.

8:7 Махан биеийн бодол санаа Бурханы эсрэг дайсагнал учир үхэл юм. Гэмт хүн Бурханы эсрэг тэрсэлж, түүнтэй дайсагнадаг. Үүний баталгаа гэвэл Эзэн Есүс Христийг загалмайд цовдолсноос тодорхой харж болно. Махан биеийн бодол санаа Бурханы хуульд захирагддаггүй. Бурханы хүслийг биш, өөрийн хүслийг илүүд үздэг. Бурханы дэг журамд бөхийхөөс татгалзаж, өөрөө өөрийнхөө эзэн байхыг хүсдэг. Угаас мөн чанар нь ийм тул Бурханы хуульд захирагдаж чадахгүй. Махан биеийн бодол санаа *бөхийж тонгойхыг* мэдэхгүйгээс гадна захирагдах *хүч чадал* үгүй. Махан биеийг Бурхан үхмэл гэж хардаг.

8:8 Тиймээс **махан бие дотор байгсад Бурханд таашаагдаж чадахгүйн** шалтгааныг гайхах зүйлгүй. Аврагдаагүй хүн **Бурханд таашаагдахын** тулд юу ч хийж чадахгүй. Сайн үйлс, шашны дэг журам, өргөл тахил гээд юу ч хийлээ гэсэн Бурханы тааллыг олж чадахгүй. Үүнийг бодоод үзээрэй. Бурханд таалагдахын тулд эхлээд гэм буруутай нүгэлтэн гэдгээ хүлээн зөвшөөрч, үнэн сэтгэлээс Христэд итгэх хэрэгтэй. Ингэж гэмээнэ Бурханы тааллыг олж, Түүнд хүлээн зөвшөөрөгдөнө.

8:9 Хүн дахин төрсөн цагаасаа эхлэн махан бие дотор байхаа больж, Сүнс дотор байдаг. Дахин төрсөн хүн өөр орчинд амьдарч эхэлдэг. Загас усанд, хүн агаарт амьдардагтай адил, итгэгч хүн Сүнс дотор амьдардаг. Зөвхөн Сүнс дотор амьдардаг биш, Сүнс түүний дотор

амьдардаг. Хэрэв түүний дотор Христийн Сүнс байхгүй бол, тэр Христийнх биш. Энд гарч байгаа **Христийн Сүнсийг** Ариун Сүнс мөн үү гэж зарим хүмүүс асуудаг. Хам сэдвийнх нь уялдааг харахад Христийн Сүнс гэдэг нь Ариун Сүнс мөн юм.

8:10 Ариун Сүнсний үйлчлэлээр дамжуулан Есүс Христ итгэгч хүний дотор оршдог. Нүглээс болж үхмэл болсон биед маань амь ба алдрын Эзэн оршин байгааг бодоход ямар гайхалтай вэ. Зарим нэг хүн, энэ ишлэлээс харвал бидний бие бүрмөсөн үхээгүй юм биш үү гэж магад. Гэхдээ тийм биш. Үхлийн хүч бие дотор маань нэгэнт ажиллаж байгаа тул Эзэн ирчихгүй л бол зайлшгүй үхэх болно.

Бие үхмэл бол, үүний эсрэгээр, **зөвт байдлын улмаас сүнс²⁸ маань амьд байна.** Нэгэн цагт Бурханы хувьд үхдэл байсан бол одоо Эзэн Есүс Христийн үхэл, амиллын зөвт ажлаар дамжуулан амьд болжээ. Учир нь Бурханы зөвт байдал бидэнд тооцогдов.

8:11 Гэвч бие махбод маань одоо ч гэсэн үхлийн хүчний дор байна. Гэхдээ үүнээс болж урам хугарах хэрэггүй. Учир нь бидний бие дотор оршдог Ариун Сүнс **Христийг үхэгсдээс амилуулсан шигээ үхлийн биест амь өгөх** баталгаа маань билээ. Энэ бол авралын ажлын эцсийн шат бөгөөд тэр цагт бидний бие Аврагч Есүсийн яруу жавхлант бие адил алдаршуулагдана.

8:12 Махан бие ба Сүнс хоорондоо эрс тэс ялгаатай болохыг ойлгосон бид үүнээс ямар дүгнэлт хийж болох вэ? Бид махан биеийн албадлагын **дагуу амьдрах ёстой махан биеийн** өртөнгүүд биш. Бидний хуучин, бузар, ялзарсан мөн чанар хөлөөс маань зүүсэн хүнд чулуу байхаас өөр ямар ч тус болсонгүй. Хэрэв Христ биднийг авраагүй бол махан бие маань биднийг тамын хамгийн гүн, хамгийн харанхуй, хамгийн шатам газар уруу доош татах байжээ. Ийм аймшигтай заналт дайсны өмнө яагаад бид үүрэг хүлээх ёстой гэж?

8:13 Махан биеийн дагуу амьдрагч хүмүүс үхэх ёстой. Зөвхөн бие махбодын хувьд төдийгүй мөнхөд үхэх ёстой. **Махан биеийн дагуу амьдрах** гэдэг нь аврагдаагүй байгааг харуулдаг. Үүнийг 8:4, 5 дугаар ишлэлд тодорхой өгүүлсэн. Паул нэгэнт Христэд итгэчихсэн хүмүүст яагаад үүнийг хэлсэн вэ? Паул аврагдсан хүмүүсийг авралаа алдах боломжтой гэж байгаа юм уу? Үгүй. Тэр тэгж хэлэх гээгүй. Гэхдээ элч Паулын захиануудад анхааруулга, сэрэмжлүүлгийн үгс олон удаа гардаг. Христийн чуулган бүрд жинхэнээсээ дахин төрөөгүй хүмүүс байх боломжтойг Паул мэддэг байсан учраас ийм зүйл бичдэг байжээ.

Энэ ишлэлийн үлдсэн хэсэгт жинхэнэ итгэгч нарт ямар шинж чанар байдгийг дүрсэлсэн. Жинхэнэ итгэгч нар Ариун **Сүнсний** хүч чадлаар **биеийн үйлсийг** үхэлд хүргэдэг. Одоо

тэд мөнх амьтай бөгөөд энэ дэлхийгээс явах үедээ бүрэн дүүрэн амьдрал уруу орох болно.

8:14 Жинхэнэ итгэгч гэдгийн өөр нэг шинж бол тэд **Бурханы Сүнсээр удирдуулдаг**. Паул энд, олонд танигдсан итгэгч нарын амьдралд л зөвхөн тэнгэрлэг удирдамж өгөгддөг гэж хэлсэнгүй. Харин бүх **Бурханы хөвгүүдийн** тухай ярьж байна. Бурханы хүүхэд мөн л бол тэр хүн **Сүнсээр удирдуулдаг**. Ариун Сүнсээр хэр зэрэг хэмжээнд удирдуулдаг түвшний тухай энд яриагүй. Харин Христэд итгэсэн тэр мөчөөс эхлэн итгэгч хүний амьдралд ирдэг харилцааг хэлж байна.

Хүү байх гэдэг нь Бурханы гэр бүлд хүлээн авагдсаныг илтгэдэг. Ингэхдээ насанд хүрсэн хүүгийн эрх дарх, үүрэг хариуцлага бүхэн хамт өгөгдөнө. Шинэхэн итгэгч хүн сүнслэг өв хөрөнгөө авахын тулд тодорхой хугацаа хүлээх шаардлагагүй. Тэрхүү өв хөрөнгө нь итгэгч нэг бүрд эр, эм, хөгшин, залуу гэж ялгалгүй аврагдсан цагаас нь эхлээд өгөгдсөн байдаг.

8:15 Хуулийн доор амьдарч байгаа хүмүүсийг зүйрлэвэл насанд хүрээгүй хүүхэдтэй адил. Зарц юм шиг томчууд удирдана, шийтгүүлэх вий гэсэн айдсын сүүдэрт амьдардаг. Гэтэл хүн дахин төрөхдөө зарц боол болдоггүй. Тэр хүн Бурханы гэр бүлд боол болж ирдэггүй. Харин **үрчлэлийн сүнсийг** хүлээн авдаг. Өөрөөр хэлбэл Бурханы гэр бүлд нас биед хүрсэн хүү нь болдог. Тэрбээр Бурхан уруу хараад **“Аав, Эцэг”** гэж дууддаг. Сүнсэнд нь энэ ойлголт бий болдог.

Аав (Абба) гэж арамей үг бөгөөд англи орчуулгад утга нь бүрэн гардаггүй. Энэ нь *эцэг* гэдгийн дотночилсон хэлбэр юм. Бид Бурханыг дотночлон дуудахаасаа эмээдэг байж болох ч Тэрээр хязгааргүй өндөрт оршдог хэр нь яг дэргэд ойр дотно байдаг гэх үнэн өөрчлөгдөхгүй.

Үрчлэлийн Сүнс²⁹ гэдэг нь Бурханы хөвгүүн болсон онцгой нэр төрийг итгэгч хүнд ойлгуулагч Ариун Сүнсийг хэлж байна. Нөгөө талаар, боолчлолын сүнс гэдгийн эсрэгээр, үрчлэлийг авсан болохоо ойлгож мэдсэн хандлагыг хэлж байж болно.

Үрчлэл гэдэг үгийг Ром ном гурван янзаар хэрэглэсэн. Яг энэ ишлэлийн хувьд итгэгч хүн Бурханы хүүхэд болсноо Ариун Сүнсээр мэдэж авах явдлыг хэлж байна. Тэгвэл 8:23 дугаар ишлэлд итгэгч хүний бие алдаршуулагдаж, бүрэн аврагдах үеийг дүрсэлсэн. Нэг ёсондоо *ирээдүй рүү харж байна*. Харин 9:4 дүгээр ишлэлд Израиль Бурханы хүү гэж тооцогдсон үеийг (Египетээс гарсан 4:22) дүрсэлсэн. Өөрөөр хэлбэл *өнгөрсөн рүү харж байна*.

Энэ үг Галат 4:5 ба Ефес 1:5 дээр бас гарна. Энэ хоёр ишлэлд “хүүгийн байр сууринд тавих” гэсэн утгыг илтгэдэг. Бүх итгэгч нарыг насанд хүрсэн хүүгийн байр суурин дээр тавиад хөвгүүн нь байх эрх дарх, үүрэг хариуцлагыг бүгдийг нь өгөхийг “хүүгийн байр суурд тавих” гэж хэлдэг. Итгэгч бүр Бурханы хүүхэд бөгөөд түүний гэр бүлд дахин төрдөг. Тэр айлын Эцэг

нь Бурхан өөрөө юм. Мөн итгэгч бүр Бурханы хөвгүүн мөн. Хөвгүүн гэдэг нь эрийн цээнд хүрч, нас бие гүйцэн, төлөвшсөн хүн болсныхоо хувьд эрх дарх эдэлдэг, Бурхантай харилцах онцгой харилцааг хэлнэ.

Шинэ гэрээнд гардаг **үрчлэл** гэдэг үгийн утгыг буруугаар ойлгож болохгүй. Бидний нийгэмд байдаг шиг, өөр хүний хүүхдийг өөрийн болгодог үрчлэлийн тухай энд яриагүй гэдгийг санах нь зүйтэй.

8:16 Шинээр төрсөн итгэгч сүнсэн дотроо Бурханы хүү гэдгээ мэдэрдэг. Ариун **Сүнс** түүнд үүнийг хэлдэг. Бурханы гэр бүлийн гишүүн мөн гэдгийг нь Ариун **Сүнс өөрөө** тухайн итгэгчийн **сүнстэй хамт гэрчилдэг**. Ариун Сүнс хамгийн нэгт Бурханы үгээр дамжуулж энэ ажлаа хийдэг. Христэд итгэгч хүн Библи уншиж байхад Ариун Сүнс энэ үнэнийг баталж, Есүст итгэсэн тул одоо Бурханы хүүхэд болсныг нь хэлдэг.

8:17 Бурханы гэр бүлийн гишүүн болсноор итгэхийн аргагүй эрх дарх бидэнд ирдэг. Бурханы хүүхэд бүр **Бурханы өв залгамжлагч** мөн. Өв залгамжлагч хүн эцгийнхээ өмч хөрөнгийг өвлөж авдаг. Ийм л утгыг энд хэлж байгаа юм. Эцэгийн юм бүхэн биднийх билээ. Бид одоогоор хараахан өмч хөрөнгөө авч, бүгдийг нь эзэмшээгүй байгаа боловч ирээдүйд гарцаагүй авах болно. Үүнд юу ч саад болж чадахгүй. Түүгээр ч зогсохгүй бид **Христийн хамтран залгамжлагчид** юм. Христ бүх

дэлхийг ноёрхож, бүх засаг захиргааг өөрийн болгохоор энэ дэлхийд эргэн ирэх үед Эцэгийн бүх баялгийг бид Христтэй хамт хуваалцах болно.

Христтэй хамт алдаршуулагдахын тулд хэрэв бид үнэхээр Түүнтэй хамт зовдог юм бол... Паулын хэлсэн энэ үг аврагдахын тулд зовлон эдлэх ёстой гэж хэлэх гээгүй. Аль эсвэл маш их зовлон эдэлсэн ялагч нарын элит бүлэглэл байдаг гэсэн санааг ч илэрхийлээгүй. Харин бүх итгэгч нарыг хамааруулан ярьж байна. Бүх итгэгч нар Христтэй хамт зовлон эдэлдэг. Бүх итгэгч нар Христтэй хамт **алдаршуулагдах** болно. Паул үүнийг хэлэхийг зорьсон. Мэдээж хэрэг зарим итгэгч нар Христийн нэрээс болж бусдаасаа илүү зовдог нь үнэн. Тэдний хүртэх шагнал, авах алдар нь бусдаасаа илүү байх болно. Гэвч энэ ишлэлээс харвал Есүсийг Эзэн ба Аврагч хэмээн хүлээн зөвшөөрсөн хүн бүр энэ ертөнцийн үзэн ядалтын бай болж, ичгүүр, буруутгалыг хүлээн авах болно.

8:18 Хожмын тэр өдөр, тэнгэрийн улсад, Христ биднийг олны өмнө дуудан гаргаад сайшаан магтах цагт, энэ дэлхий дээр байхдаа Христийн төлөө хүлцэж тэвчсэн хамгийн том ичгүүр маань хүртэл өчүүхэн зүйл шиг бодогдох болно. Итгэлийнхээ төлөө амиа өгсөн хүмүүс бас, Аврагч Эзэнээсээ амийн титмийг хүлээн авах үедээ урьд амссан үхлийн зовлонгоо үзүүргүй зүүгээр хатгуулж байсан

мэт санана. Паул өнөөгийн зүдүүрийг маань түр зуур үргэлжлэх ялихгүй (хөнгөн) зовлон гэж нэрлэсэн бол ирээдүйн алдрыг маань мөнхөд хүнд (жинтэй) байх, үлэмж арвин (2 Коринт 4:17) зүйл хэмээн дүрсэлсэн байдаг. Паул ирээдүйн алдрыг өнөөгийн зовлонтой жингээр нь харьцуулж дүрсэлсэн³⁰. Хожим гарцаагүй биднийх болох тэр яруу **алдар** уруу бүх хараагаа чиглүүлж чадвал, бид одоогийн **зовлон** зүдүүрийг ялихгүй зүйл хэмээн үзэж чадна.

8:19 Харин одоо Паул бүх **бүтээлийг** хүншүүлэн дүрсэлж, Бурханы хөвгүүд болохыг маань бүх ертөнцөд мэдүүлэх цагийг **тэсэж ядан** хүлээдэг болохыг нь зураглан өгүүлж байна. Эзэн Есүс бүх дэлхийг хаанчлахаар эргэн ирэхэд энэ зүйл болно.

Бид аль хэдийн **Бурханы хөвгүүд** болсон хэдий ч энэ ертөнц түүнийг маань мэдэхгүй. Мэдлээ ч бидэнд баярлахгүй. Хэдийгээр энэ ертөнц сайн цагийг хүсэн хүлээдэг ч гэлээ Есүс ариун хүмүүсийнхээ хамт бүх дэлхийг хаанчлахаар ирэх хүртэл тийм өдөр ирэхгүй. “Бурханы хөвгүүд жинхэнэ байр суурин дээрээ ирэх гайхамшигт тэр мөчийг харахаар бүх бүтээл амьсгаа даран хүлээж байна” (Библийн JBP орчуулга).

8:20 Адам нүгэл үйлдэхэд, түүний гэм зөрчил хүн төрөлхтнөөр зогсохгүй амьтай, амьгүй бүх бүтээлд нөлөөлсөн. Газар хараагдаж, ан амьтад үхэцгээсэн. Араатан жигүүртэн, загас жараахай,

хэвлээр явагч бүгдэд өвчин ирсэн. Хүний гэм нүгэл усны долгион адил бүх бүтээлд тархав.

Паул үүнийг, **бүтээл нь өөрийн хүслээр бус, харин хүн төрөлхтний анхны тэргүүн болох Адамын дуулгаваргүй байдлаас үүдсэн Бурханы тушаалын улмаас хоосрол, унал, замбараагүй байдалд захирагдсан** хэмээн тайлбарлав.

20 дугаар ишлэлд гарч байгаа **найдварын дор** гэдэг үг дараах ишлэлтэйгээ холбогдоно: “...бүтээл нь өөрөө бас чөлөөлөгдөнө гэсэн найдварын дор”.

8:21 Еден цэцэрлэгт байсан төгс байдлыг Бурханы бүтээл санагалзан байна. Мөн гэм нүглээс үүдсэн эвдрэл, үгүйрлийн дор зүдэрч байна. Гэвч тэрхүү төгс байдал эргэн ирэх найдвар үргэлж байсан ажээ. Төгс байдал ирэх тэр цагт **бүтээл нь өөрөө ч мөн ялзралын боолчлолоос чөлөөлөгдөж**, Бурханы хүүхдүүд алдрын дотор илчлэгдэх алтан эрин үеийн эрх чөлөөг амсах болно.

8:22 Өнөөдөр бидний амьдарч байгаа ертөнц гашуудан мэгшиж, ёолон зовж байна. **Бүх бүтээл ёолж**, хүүхдээ төрүүлэх гэж буй эмэгтэй мэт өвдөж байна. Байгалийн эгшиг гунигтай, газар дэлхий орвонгоороо эргэж, амьтай бүхний дээр үхлийн сүүдэр ноёрхож байна.

8:23 Итгэгчид үүнийг тойрч өнгөрөхгүй. Хэдийгээр тэд **Сүнсний анхны үр жимсийг авсан** ба эцсийн дүндээ аврагдах нь баттай үнэн боловч, тэд ч ялгаагүй алдрын тэр өдрийн төлөө **ёолон** байна. Ариун **Сүнс** өөрөө анхны үр жимс

юм. Боловсорсон үр тарианаас хамгийн эхэнд авсан үр тариагаар бүх ургацыг дүгнэж, баттай мэдэж болдог. Үүний адилаар бүх өв залгамжлал биднийх болох нь үнэн гэдгийг Ариун Сүнс баталдаг.

Ялангуяа, ирж буй **үрчлэл, биеийн золилтын** баталгаа болдог (Ефес 1:14). Нэг талаараа бид үрчлэгдчихсэн. Тиймээс одоо бид Бурханы гэр бүл дотор хүүгийн байр суурин дээр зогсож байна. Гэвч алдаршуулагдсан биеийг хүлээн авах үед маань бидний **үрчлэл** бүрэн дүүрэн болох юм. Тэгэхээр энэ ишлэлд гарч байгаа үрчлэл нь **бидний биеийн золилтын** тухай ажээ. Бидний сүнс, сэтгэл хэдийнээ аврагдчихсан бол, бие маань дээш авагдах үед аврагдана (1Тесалоник 4:13-18).

8:24 Найдварын энэ хандлага биднийг аварсан. Бид Христэд итгэсэн даруйдаа авралынхаа үр ашгийг бүрэн амсаагүй. Гэвч гэм нүгэл, зовлон зүдгүүр, өвчин шаналал, үхлээс бүрэн ангижирч, нэгмөсөн аврагдах ирээдүй рүү бид хараагаа чиглүүлж байна. Хэрэв энэ бүх ерөөлийг авчихсан бол, бид найдан хүлээх шаардлагагүй болохсон. Бид зөвхөн ирээдүйд байгаа зүйлсэд найддаг билээ.

8:25 Оршин буй гэм нүгэл зайлж, түүний бүх хор уршиг устана гэдэг найдвар маань Бурханы амлалт дээр тулгуурладаг. Энэ найдвар заавал биелэх учраас түүний биеллийг бид авсан гэж үзэж болно. Тиймээс бид **түүнийгээ тэвчээртэйгээр хүлээдэг.**

8:26 Яруу алдарт энэ найдвар биднийг тэнхээжүүлдэгийн адил, Ариун Сүнс бидний сул дорой байдалд тусладаг. Заримдаа залбирлын амьдралд маань саад учрах нь бий. Бид яаж залбирах ёстойгоо мэддэггүй. Бидний залбирал хувиа хичээсэн, бүрэн мэдээлэлгүй, явцуу болдог. Гэвч Ариун Сүнс бидний сул дорой байдалд туслахын тулд үгээр илэрхийлшгүйгээр **ёолон байж бидний төлөө зуучлан гуйдаг**. Хэдий бид ч бас ёолдог нь үнэн боловч энэ ишлэлээс харвал ёолдог нь бид биш, Ариун Сүнс гэжээ.

Энэ бол нууц. Ариун Сүнс гэгч агуу Бодгаль, бас агуу хүчнүүд бидний өмнөөс ажиллаж байдаг үл үзэгдэх сүнслэг ертөнцийн хаалгаар хальт шагайхтай адил. Одоогоор бид үүнийг бүрэн ойлгож чадахгүй. Гэхдээ, бүгдийг ойлгохгүй ч гэлээ, заримдаа ёолох нь хамгийн сүнслэг залбирал болдгийг ойлгосноор бид зоригжино.

8:27 Хэрэв Бурхан хүний зүрхийг нягтладаг юм бол, Сүнсний бодол санаа юу болохыг тайлбарлаж бас чадна. Хэдий тэр бодол санаа нь ёололтоор илэрхийлэгдсэн ч гэсэн Тэрээр ойлгодог. Эндээс бидний харах ёстой нэг чухал зүйл байгаа нь юу гэхээр бидний төлөөх Ариун Сүнсний залбирал нь үргэлж **Бурханы хүслийн дагуу**, бидний сайн сайхны төлөө байдаг ажээ. Дараагийн ишлэлд харуулсанчлан энэ нь маш олон зүйлийг тайлбарлаж байна.

8:28 Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүсийн сайн сайхны төлөө Бурхан бүх зүйлийг хамтад нь ажиллуулдаг. Гэвч үргэлж ийм санагддаггүй. Уй гашуу, эмгэнэлт явдал, урамгүй байдал, сэтгэл гутрал, гарз хохирол тохиолдоод шаналж зовох үедээ бид, үүнээс яаж сайн сайхан зүйл гарах юм бэ гэж гайхдаг. Харин дараагийн ишлэлээс үүний хариуг харж болно: Бурхан бидний амьдралд юуг ч зөвшөөрлөө гэсэн, эцсийн зорилго нь биднийг Хүүтэйгээ адил болгоход оршино. Үүнийг ойлгох үед, бидний залбиралд асуултын тэмдэг гарахаа больдог. Амьдралыг маань аз, боломж, хувь тавилан гэх мэтийн сохор хүчнүүд удирддаггүй. Харин гайхамшигтай, дотно Эзэн маань удирддаг. Тэрбээр хахир хатуу байж үл чадах хайр, алдаж эндэх ямар ч боломжгүй мэргэн ухаан билээ.

8:29 Харин одоо Паул, олон хөвгүүдийг алдар уруу авчрах гэж гаргасан тэнгэрлэг хөтөлбөр, төлөвлөгөөний тухай өгүүлэх гэж байна.

Юуны өмнө, Бурхан биднийг мөнх хугацааны өнгөрсөн үед **урьдаас мэдсэн**. Энэ нь зүгээр нэг тархины мэдлэг байгаагүй. Мэдлэгийн хувьд, Тэрбээр энэ дэлхийд мэндлэх байсан **бүх хүнийг** мэдэж байсан. Гэвч Түүний урьдаас мэдэх мэдлэг нь **Өөрийнх нь Хүүгийн дүртэй адил болгохоор урьдаас тогтоосон** хүмүүст л хамаатай. Тийм учраас энэ мэдлэг хэзээ ч нурахгүй зорилгыг агуулж байв. Нэгэн өдөр гэмшиж, итгэх байсан хүмүүсийг Бурхан

урьдаас мэдсэн гэх нь хангалтгүй. Харин Түүний урьдаас мэдэх мэдлэгийн улмаас тэдгээр хүмүүс эцсийн дүндээ гэмшиж, итгэж байгаа юм.

Бурханлаг бус нүгэлтнүүд нэг л өдөр нигүүлслийн гайхамшгаар Христийн дүр төрх рүү өөрчлөгдөх болно гэдэг нь тэнгэрлэг илчлэлтийн хамгийн гайхалтай үнэний нэг билээ. Энд хэлж байгаа үгийн утга нь, бидэнд Бурханы мөн чанарууд өгөгдөнө гэх юм уу, гадаад байдлаараа Христтэй адил болно гэдгийг хэлээгүй. Харин ёс суртахууны хувьд, ямар ч гэм нүгэлгүй Есүстэй адил болж, Түүний биетэй адил алдаршуулагдсан биеийг авна гэсэн үг юм.

Тэрхүү алдрын өдөр Есүс **олон ах дүүсийн дунд ууган** нь байх болно. Энд гарч байгаа **ууган** гэдэг үг хамгийн дээд хүндлэлийг хүртэх болно гэсэн утгатай. Есүс адил зиндаатай хүмүүсийн Нэг нь байх бус, харин ах, эгч, дүүсийнхээ дунд хүндлэлийн хамгийн дээд байр сууринд зогсох Нэг нь байх болно.

8:30 Мөнх цаг хугацаан дотор **урьдаас тогтоогдсон** хүн бүрийг энэ цаг хугацаанд **бас дуудсан**. Тэр хүн сайнмэдээг сонсоод зогсохгүй, түүнд хариу өгсөн. Тийм учраас үүнийг хэрэгжсэн дуудлага гэнэ. Бурхан бүх хүнийг дууддаг. Энэ бол Бурханы ерөнхий дуудлага (бас л хүчин төгөлдөр). Гэвч цөөн хүн үүнд хариу өгдөг. Энэ бол Бурханы хэрэгжсэн дуудлага (хүн Христ рүү эргэнэ) юм.

Хариу өгсөн хүн бүрийг Бурхан **мөн зөвтгөсөн**. Бурханы өмнө зогсох туйлын зөвт байр суурь өгсөн. Тэр хүмүүс Христийн гавьяагаар Бурханы зөвт байдлаар хувцасладаг. Ингэснээр Эзэний оршихуйд зогсох зохистой хүмүүс болсон.

Зөвтгөгдсөн хүмүүс нь **мөн алдаршуулагдсан**. Үнэндээ бид *хараахан алдаршуулагдаагүй* боловч болох нь тодорхой зүйл учраас Бурхан үүнийг дүрслэхдээ өнгөрсөн цагийг ашигласан. Бид алдаршууллыг ирээдүйд авчихсан бөгөөд энэ тодорхой зүйл юм.

Христэд итгэгч хүний мөнхийн аюулгүй байдал, баталгааны талаарх Шинэ гэрээнд байгаа хамгийн хүчтэй ишлэлийн нэг нь энэ мөн. Бурханы урьдаас мэдсэн, **урьдаас тогтоосон** сая сая хүмүүсийн *нэг бүр* нь **дуудагдсан, зөвтгөгдсөн, алдаршуулагдсан** болой. Нэг ч хүн үүнээс дутахгүй. (Иохан 6:37 дээр байгаа “бүгд, бүхэн” гэдэгтэй харьцуул.)

8:31 Аврал золилтын алтан гинжний хэзээ ч үл тасрах эдгээр холбоосыг цэгнэн үзэх үедээ бид огт ганхахгүй дүгнэлтэнд хүрдэг. **Хэрэв Бурхан бидний талд юм бол**, Бурхан биднийг өөрийнхөө төлөө сонгосон юм бол, **биднийг эсэргүүцээд амжилт олох хэн ч үгүй**³¹. Хэрэв бүхнийг чадагч Бурхан бидний өмнөөс ажилладаг юм бол, Түүнтэй эн зэрэгцэж үл чадах хүчнүүд, хэн ч байсан, төлөвлөгөөг нь нурааж чадахгүй.

8:32 Тэр Өөрийн Хүүгээ үл өршөөж, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Ямар гайхалтай үг вэ. Бид энэ үгийг байнга сонссоор танил болсон байлаа ч, мөргөл хүндлэлийг маань хөглөдөг энэ үгийн хүч чадлыг нь багасгаж, цог сүрийг нь буруулах боломжийг өөрсдөдөө өгч болохгүй. Төөрч, алдагдсан хүн төрөлхтний авралд гэмгүй ариун золиос шаардлагатай байхад орчлон ертөнцийн агуу Бурхан Өөрийн зүрхний хамгийн үнэтэй Эрдэнийг харамлаж хойш суусангүй. Харин бидний ичгүүр, ялагдлын өмнөөс үхүүлэхээр илгээжээ.

Эндээс урган гарах санаа нь үнэхээр бишрэм. Бурхан хамгийн үнэтэй бэлгээ нэгэнт барьчихсан юм бол, одоо Түүнд харамлах юм үлдсэн гэж үү? Бурхан хамгийн өндөр үнийг нэгэнт төлчихсөн юм бол, арай бага төлөөсийг төлөхөөс татгалзана гэж үү? Бурхан биднийг аврахын төлөө ийм урт зам туулсан юм бол, одоо биднийг яваад өгөхийг зөвшөөрнө гэж үү? **Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ?**

“Үл итгэгч нар ‘Бурхан яаж хийх вэ?’ гэж асуудаг бол, итгэгч нар ‘Бурхан яаж хийхгүй байх вэ?’ гэж асуудаг” хэмээн Макинтош хэлсэн.

8:33 Бид шүүх танхимаас хараахан гараагүй байна. Одоо харин нэг чухал өөрчлөлт болно. Зөвтгөгдсөн нүгэлтнийг буруутгах хүн байвал урагш гарч ирэхийг дуудлаа. Гэвч хэн ч гарч ирсэнгүй. Хэн гарч ирж чадах юм бэ? Бурхан

сонгосон хүнээ нэгэнт зөвтгөвөл хэн түүнийг **буруутгаж** чадах вэ?

Энэ ишлэл ба дараагийн ишлэлд байгаа хариултын урд “*Тэгж чадах хүн үгүй. Яагаад гэвэл...*” гэдэг үг нэмчихвэл улам тодорхой ойлгомжтой болно: **Хэн Бурханы сонгосон хүмүүсийг буруутгах вэ? Тэгж чадах хүн үгүй. Яагаад гэвэл Бурхан бол зөвтгөгч нэгэн мөн.** Хэрэв бид ийм нэмэлт үг оруулж өгөхгүй бол, Бурхан сонгосон хүмүүсээ буруутгадаг мэт ойлгогдож болохоор байдаг. Гэвч Паул яг үүнийг л няцааж байгаа юм.

8:34 Дахиад нэг асуулт. Ял тулгах хүн байна уу? Тэгж чадах хүн үгүй. Яагаад гэвэл Христ яллагдагчийн төлөө үхээд, үхлээс амилж, одоо **Бурханы баруун талд байдаг** бөгөөд түүний төлөө зуучлан гуйдаг Нэгэн юм. Бүх шүүлтийг хэрэгжүүлэх эрхтэй Есүс Христ энэ яллагдагчийн хэргийг хүчингүй болгоод, түүний төлөө зуучлан гуйдаг юм бол, түүнийг яллах хүчин төгөлдөр шалтгаан гаргаж ирэх хэн ч байхгүй.

8:35 Итгэл сүүлийн цохилтоо хийх гэж байна: Зөвтгөгдсөн хүнийг **Христийн хайраас** салгаж чадах хэн нэгэн байна уу? Хүнийг Христийн хайраас салгаж болзошгүй хамаг сөрөг нөхцөлийг авч үзэн, тэдний дунд хайсан боловч тэгж чадах зүйл нэг ч байсангүй. **Зүдрэл** зовлонгийн хүнд лантуугаар үйрмэг болтол нүдэж, **гамшиг** болтол балбасан ч нэмэргүй. Бие махбод ба оюун санаанд өвдөлт мэдрүүлж,

шаналган зовоогоод, **хавчлага** дарамтаар айлган сүрдүүлж, үхлийн ял тулгалаа ч нэмэргүй. Идэх хоол олдохгүй юу ч үгүй цөлмөгдөж, яс арьс болтлоо турж эцэн ядарч, **өлсгөлөн** зудад нэрвүүлэвч бас л нэмэргүй. Бүрэн хувцсыг нь тайлаад, нүцгэн байдалтай үлдээгээд, хамаг юмыг нь дэлгэж, өмгөөлж хамгаалах хүнгүй болгосон ч байдал яг хэвээр. Энэ хорвоо ертөнцийн хамаг **аюул** бүхэн, болзошгүй эрсдэл бүр бас яаж ч чадахгүй. Илд мэс, хүйтэн, хатуу, заналт үхэл ч ялгаа байхгүй. Энэ бүхний аль нь ч байлаа Христийн хайрыг салгаж чадахгүй.

8:36 Хэрэв энэ бүхэн итгэгч хүнийг Христийн хайраас салгаж чаддаг байсан бол, ийм явдал аль эрт болчих байсан. Учир нь христитгэгчийн амьдрал амьдын там болох үе бишгүй тохиолдож байв. Дуулал зохиогч яг энэ тухай тэмдэглэн үлдээснийг Паул энд иш татжээ: Бид Эзэний харьяатууд болсныхоо төлөө **бүхэл өдөржингөө үхэж, нядлагдах хонь мэт тооцогдож байна** (Дуулал 44:22).

8:37 Энэ зүйлс биднийг Христийн хайраас салгаж чадсангүй. Харин эсрэгээрээ, биднийг Христтэй ойр дотно болгов. Бид зүгээр нэг **дийлдэг биш, харин давуулан дийлдэг хүмүүс**³³. Өөрөөр хэлбэл энэ бүх аймшигт хүчийг ялаад зогсохгүй, бид Бурханд алдрыг, бусдад ерөөлийг, өөрсдөдөө сайныг авчирдаг. Дайсан минь өөрчлөгдөж зарц минь болдог.

Замыг маань хаасан чулуугаар бид дээшээ өгсөх шатны гишгүүр хийдэг.

Гэхдээ өөрсдийнхөө хүчээр бид юу ч хийж чадахгүй. Зөвхөн биднийг хайрладаг Түүгээр дамжуулан хийж чадна. Гашуунаас чихэрлэгийг, доройгоос хүчтэнийг, уналтаас ялалтыг, зовлонгоос ерөөлийг бий болгож чадах цорын ганц зүйл бол Христийн хүч чадал юм.

8:38 Элч Паулын эрэл нэгжлэг хараахан дуусаагүй байна. Тэрбээр бүх ертөнцийг самнаад, Христийн хайраас биднийг салгаж чадах ямар нэг зүйл байгаа эсэхийг нягталж, боломж бүрийг нэг нэгээр авч үзэж байна:

Үхэл ба түүний аюул занал;

Амь амьдрал ба түүний уруу татлага, гоё сайхан зүйлс;

Тэнгэр элч нар ба **эрх баригчид**, тэдний ер бусын хүч чадал, мэдлэг;

Хүч -хүч чадалтай, дарангуйлагч хүн ба сүнслэг дайсан, диаволын аль аль нь;

Өнөөгийн юмс - биднийг зовоож байгаа нөхцөл байдал;

Ирэх юмс - бүрхэг харанхуй ирээдүй, муу ёрлосон зөн;

8:39 **Өндөр ч, гүн ч** - эдгээр нь орон зай, хэмжигдэхүүний ухагдахуун бөгөөд үүнд ер бусын, далдын хүчнүүдийг ч бас хамаарч байна³⁴. Ингээд Паул юу ч үлдээлгүй бүгдийг авч үзсэн болохоо баталж, **өөр ямар ч бүтээл** гэдэг үгийг нэмсэн.

Эцэст нь Паул, **бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас юу ч биднийг салгаж чадахгүй** гэсэн дүгнэлтийг хийлээ.

Ялалт тунхаглах энэ үгс итгэлийнхээ төлөө амиа алдсан хүмүүсийн дуу болж, итгэлийнхээ төлөө амь хайргүй зүтгэсэн хүмүүсийн уриа болж байсанд гайхах юм үгүй. Тэгэхээс ч өөр аргагүй ажээ.

II. ТӨЛӨВЛӨГӨӨТ ЦАГ ҮЕ: САЙНМЭДЭЭ БА ИЗРАИЛЬ (9-11 дүгээр бүлэг)

A. Израилийн өнгөрсөн үе (9-р бүлэг)

Сайнмэдээ иудейчүүд ба харь үндэстнүүдийн аль алинд авралыг амлаж байгаа нь Бурхан өөрийн ард түмэндээ (иудейчүүдэд) өгсөн амлалтаа цуцалсан гэсэн үг үү? хэмээн асуусан сөргөлдөгч иудей хүний асуултад элч Паул 9-11 дүгээр бүлэгт хариулсан. Паулын хариулт Израилийн өнгөрсөн үе (9-р бүлэг), одоо үе (10-р бүлэг), ирээдүй үеийг (11-р бүлэг) авч үзэх болно.

Энэ хэсэгт тэнгэрлэг дээд бүрэн эрх ба хүний үүрэг хариуцлагын талаар ярих болно. Ром 9-р бүлэг бол Бурханы бүрэн эрхт сонголтын талаарх Библийн хамгийн жинтэй хэсэгт зүй ёсоор багтдаг. Энэ бүлэгт Бурханы бүрэн эрхийн тухай ярьсан шиг тэнцвэртэйгээр дараагийн бүлэгт үүний нөгөө тал болох хүний үүрэг хариуцлагын талаар авч үзсэн.

ТЭНГЭРЛЭГ ДЭЭД БҮРЭН ЭРХ БА ХҮНИЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Бурхан бол тэнгэрлэг дээд бүрэн эрх мэдэл гэдэг нь Бурхан бүх ертөнцийг захирдаг ба Өөрийн тааллын дагуу үйлддэг гэсэн утгатай. Гэхдээ тэр Бурхан учраас буруу зөрүү, шударга бус, гэмт муу юм хэзээ ч үйлдэхгүй гэдгийг ойлгох нь чухал. Тиймээс Бурхан бол тэнгэрлэг

дээд бүрэн эрх мэдэл нь Бурханыг Бурхан байлгадаг зүйл юм. Бид энэ үнэнээс айж мэгдэх хэрэггүй. Бас үүний төлөө өршөөл гуйх шаардлагагүй. Сүр жавхланта энэ үнэн биднийг өөрийн эрхгүй Бурханыг хүндэтгэн мөргөхөд хүргэдэг.

Бурхан бүрэн эрхийнхээ дагуу зарим хүмүүсийг Өөрийн болгон сонгожээ. Гэтэл Бурханы бүрэн эрхт сонголтын тухай заадаг Библи хүний үүрэг хариуцлагын тухай ч бас заадаг. Бурхан хүмүүсийг аврал уруу сонгодог нь үнэн хэдий ч хүн өөрийн сайн дурын шийдвэрээр аврагдах сонголт хийх ёстой. Хүний аврал дахь тэнгэрлэг оролцоог Бурханы үгэнд дурдсан байдаг: “Эцэгийн Надад өгдөг бүхэн Над уруу ирнэ.” Тэгтэл энэ үгийн яг ард хүний талаас шалтгаалах хэсгийг нь бас дурдсан байдаг: “Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй” (Иохан 6:37). Итгэгч бидний хувьд ертөнцийн сууриас урьд Бурхан биднийг Христийн дотор сонгосонд (Ефес 1:4) баярладаг. Гэхдээ бас хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй авдаг (Илчлэл 22:17) гэдэгт итгэдэг. Д. Л. Мүүдий үүнийг ийн дүрсэлсэн: Бид авралын хаалганы өмнө ирэх үед хаалган дээр “Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг” гэсэн урилга бичвэртэй байдаг. Харин тэр хаалгаар ороод хаалганы нөгөө талыг харвал “Бурханы урьдаас мэдэх мэдлэгээр сонгогдсон” гэдэг үг бичээстэй байдаг. Тэгэхээр хүн авралын хаалган дээр ирэхдээ өөрийн үүрэг хариуцлагын тухай

үнэнтэй нүүр тулдаг. Харин хаалгаар орсны дараа Бурханы бүрэн эрхт сонголтын тухай үнэнийг хардаг байна.

Бурхан хүмүүсийг Өөртөө сонгон авдаг атлаа энэ дэлхийн бүх хүмүүст авралыг санал болгодог. Яаж ийм зүйл байж болох вэ? Энэ хоёр үнэн хэрхэн уялдаж байгаа вэ? Чин үнэнийг хэлэхэд бид уялдуулж чадахгүй. Хүний ухаанаар харахад энэ хоёр зүйл бие биенээ үгүйсгэж байна. Гэвч Библид энэ хоёр сургаалыг хоёуланг нь заадаг. Бид үүнд итгэх хэрэгтэй. Үүнийг ойлгож чадахгүй байгаа нь хүн бид болохоос, Бурхан биш гэдгийг бас мартаж болохгүй. Энэ хоёр үнэн хэзээ ч үл огтлолцох хоёр параллель шугамтай адил.

Зарим хүмүүс Бурханы бүрэн дээд эрх мэдэл ба хүний үүрэг хариуцлагыг хооронд нь уялдуулах гэж оролдохдоо, Аврагчид итгэх хүмүүсийг Бурхан урьдаас мэдэж байсан ба тэр хүмүүс бол Бурханы аврахаар сонгосон хүмүүс нь гэж хэлдэг. Үүнийг дэвшүүлдэг хүмүүс Ром 8:29 (Тэр урьдаас мэдсэн хүмүүсээ урьдаас тогтоосон) ба 1Петр 1:2 (Та Бурханы урьдаас мэдэх мэдлэгийн дагуу сонгогдсон билээ) дээр тулгуурладаг. Гэвч тэдний гарган ирж байгаа үндэслэл нь зарим баримтыг орхигдуулдаг. Жишээ нь Бурханы урьдаас мэдэх мэдлэг нь *тодорхойлогч* гэдгийг тэд ярьдаггүй. Бурхан хэн Аврагчид итгэх байсныг урьдаас мэдээд зогсохгүй зарим хүмүүсийг өөр уруугаа

татсанаар энэ үр дүнг урьдаас тогтоодог гэж хэлсэн байна.

Бурхан зарим хүнийг аврахаар сонгодог боловч, хэн нэгнийг хөсөр хаях сонголт хэзээ ч хийдэггүй. Хэдийгээр Библид тэнгэрлэг сонголтын тухай заадаг ч гэлээ, хүнийг авралаас холдуулах сонголт хийдэг тухай огтхон ч заадаггүй. “Хэрэв Бурхан зарим хүмүүсийг ерөөхийн тулд сонгодог юм бол, зарим хүмүүсийг сүйрэл уруу илгээхээр сонгодог болж таарч байна” гэж зарим хүн хэлж болох. Гэвч энэ үнэн биш. Бүх хүн төрөлхтөн өөрсдийн гэм нүглээс болж сүйрлийн хувь тавилантай болсон болохоос Бурханаас гаргасан дээд тушаалаас болоогүй. Бурхан бүх хүнийг тамд хаялаа ч, Тэр үүнийг шударгаар хийх буюу хүмүүс хүртэх ёстойгоо л хүртэнэ гэсэн үг. “Бүрэн дээд эрхт Эзэн гараа сунгаад үхэх тавилантай байсан хэдэн хүнийг Өөрийн Хүүгийн бэр болгохоор сонгох эрхтэй юу?” Тийм ээ, мэдээж тийм эрхтэй. Үүнийг дүгнэн хэлбэл ийм: Хүн төөрч одсон бол өөрийн гэм нүгэл, тэрслүү байдлаас болсон хэрэг. Хүн аврагдсан бол Бурханы бүрэн эрхт сонголтын нигүүлслээс болж байна.

Аврагдсан хүний хувьд Бурханы бүрэн эрхт сонголт нь Бурханыг үүрд шагшин бахдах шалтгаан болдог. Тийнхүү тэр хүн эргэн тойрныхоо хүмүүсийг хараад, тэдний дунд өөрөөс нь илүү хүмүүс олон байдгийг

анзаарахдаа “Эзэн намайг яагаад сонгосон юм бэ?” гэж асуудаг.

Дууг тань сонссон минь юунаас вэ

Ийшээ орсон минь яагаад вэ

Түм буман олон сонголтоос

Таныг олсон минь яаж вэ

-Исаак Ваттс

Сонголтын тухай үнэнийг аврагдаагүй хүмүүс авч, өөрсдийн итгэлгүй байдлыг хаацайлах ёсгүй. “Хэрэв би сонгогдоогүй юм бол, би яаж ч чадахгүй биз дээ?” гэж хэлэх эрх тэдэнд байхгүй. Өөрсдийн сонгогдсон болохыг мэдэх цорын ганц зам бол гэмт амьдралаа гэмшиж, Эзэн Есүс Христийг Аврагчаа болгон хүлээн авах явдал юм (1Тесалоник 1:4-7).

Сонголтын тухай үнэнийг ашиглан христитгэгчид сайнмэдээний төлөө хичээл зүтгэлгүй байгаагаа хаацайлах ёсгүй. “Хэрэв тэд сонгогдчихсон юм бол тэд гарцаагүй аврагдах юм байна” гэж ярьж болохгүй. Хэн сонгогдсон гэдгийг зөвхөн Бурхан л мэднэ. Бурхан биднийг бүх дэлхийд сайнмэдээг тунхагла гэж тушаасан. Учир нь авралд урьж байгаа Бурхан хүчинтэй урилгыг бүх хүнд хүргүүлж байгаа. Хүмүүс өөрсдийн хатуу сэтгэлээс болж сайнмэдээг хүлээн авахаас татгалздаг болохоос, бүх дэлхийг урьсан Бурханы урилга зарим нь л хүчинтэй гэж ойлгож болохгүй.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд, анхааралдаа авах ёстой хоёр аюул бий. Нэгдүгээрт, үнэний

нэг талыг л баримтлах. Жишээлбэл, Бурханы бүрэн дээд эрх мэдэлд итгэх атлаа, хүний авралтай холбогдох үүрэг хариуцлагыг нь няцаах. Хоёрдугаарт, нэг үнэнийг нөгөөгөөс нь илүү их дөвийлгөх. Бурханы бүрэн дээд эрх мэдэл ба хүний үүрэг хариуцлагад адил тэнцүү итгэхийг Библи бидэнд заадаг. Ингэж гэмээнэ энэ хоёр сургаалыг Библийн дагуу тэнцвэртэй авч явж чадна.

Харин одоо Ром 9-р бүлэг уруу орж, элч Паул энэ сэдвээр юу өгүүлснийг харцгаая.

9:1 Иудейчүүд төдийгүй харь үндэстнүүд бас авралд хүрэх боломжтой гэдгийг нотолж байсан учраас Паул Израилийн урвагч, тэрслэгч гэж харагдаж байв. Тиймд Паул иудей хүмүүсийн төлөө сэтгэлээ ямар их чилээдэг болохоо тангараглан илэрхийлж байна. Паул **үнэнийг** ярьж байсан. **Худал яриагүй**. Паулын **мөс чанар, Ариун Сүнстэй** нөхөрлөх нөхөрлөл нь түүний үнэн ярьж байгаагийн гэрч юм.

9:2 Эхлээд Израилийн яруу алдарт дуудлагыг, дараа нь Мессиаг үгүйсгэснээс болж Бурханд гологдсоныг бодох үед Паулын зүрх сэтгэл **маш их уйтгар гуниг, байнгын зовуураар** дүүрч байв.

9:3 Паул иудей ахан дүүсээ авралд ирүүлэхийн тулд өөрөө Христээс салгагдаж, авралаа алдан, **хараал болоосой гэж хүсэж байв**. Өөрийгөө үгүйсгэж байгаа энэ хүчтэй мэдэгдлээс бид хүний хайрын хамгийн дээд хэлбэрийг харж байна. Нөхдийнхөө төлөө амиа

зориулахаас өөр агуу хайр байхгүй (Иохан 15:13). Христ уруу эргэсэн нэгэн иудей хүн **махан биеэрээ хамаатан** болсон нутаг нэгтнүүдийнхээ авралын төлөө ингэж их хүслэн болж, сэтгэлдээ хөндүүрлэн байгааг бид харж байна. Энэ нь бидэнд ард түмнийхээ төлөө залбирсан Мосегийн залбирлыг сануулдаг: “Хүсвэл та тэдний нүглийг уучлаач. Үгүй бол та өөрийнхөө бичсэн номоос намайг арилгаач” (Гэтлэл 32:32).

9:4 Паул өөрийн ард түмний төлөө харуусахдаа тэдний яруу алдарт ерөөлүүдийн тухай сөхөв. Тэд бол Бурханы эрт цагт сонгож авсан ард түмний нэгэн хэсэг, **израильчууд** билээ.

Бурхан энэ үндэстнийг өөрийн хүү байлгахаар *үрчлэн авч* (Гэтлэл 4:22), өөрийн ард түмнээ Египетээс чөлөөлсөн (Хосеа 11:1). Бурхан бол Израилийн Эцэг (Дэд хууль 14:1), Ефраим бол түүний ууган хүү (Иеремиа 31:9) мөн. (*Ефраим* гэдгийг энд Израиль үндэстний өөр нэгэн нэр болгож ашигласан.)

Шекина буюу **алдрын** үүл нь Бурханы оршихуй өөрсдийнх нь дунд байж, тэднийг замчилж, хамгаалж байсныг бэлгэддэг.

Бурхан харь үндэстнүүдтэй биш, израильчуудтай **гэрээнүүдээ** байгуулсан. Жишээлбэл, Египетийн мөрнөөс Евфрат хүртэлх бүх нутгийг өгнө (Эхлэл 15:18) гэж амласан Палестины гэрээг Бурхан Израилтай байгуулсан. “Үүрдийн эзэмшил, ирээдүйн

эргэлт, гэмшсэн Израилийн ерөөлийг” амласан Шинэ гэрээг (Иеремиа 31:31-40)³⁵ Бурхан Израильд батламжилсан.

Хуулийг Израильд өгсөн. Тэд л дангаараа хуулийг хүлээн авсан.

Сүм ба тахилчлалд хамаарах нарийн чанд мөргөлийн ёслол, **үйлчлэлийг** Бурхан Израильд өгсөн.

Дээр дурдсан гэрээнүүдээс гадна, Бурхан Израильд хамгаалалт, амар тайван, амжилтын талаар тоо томшгүй **амлалт** өгсөн.

9:5 Иудейчүүд бол Абрахам, Исаак, Иаков ба Иаковын арван хоёр хүү зэрэг эцгүүдийг өөрсдийнх гэж хэлэх бүрэн эрхтэй хүмүүс. Энэ хүмүүс үнэхээр Израиль үндэстний өвөг дээдэс юм. Хэдийгээр Есүс орчлон ертөнцийн Эзэн, **мөнхөд магтагдах Бурхан** мөн боловч хүний гарал угсааг нь авч үзвэл Мессиа израиль хүн байсан. Тэгэхээр израильчуудад хамгийн том давуу тал байна. Аврагчийн хүн мөн чанар ба бурхан мөн чанарын талаарх маш зөв тодорхойлолт энд гарч байна. (Библийн зарим орчуулгад энэ ишлэлийн хүчийг сулруулсан байдаг. Жишээ нь RSV орчуулгад “...махан биеийн дагуу Христ тэднээс гарсан. Бурхан бүгдийн дээр мөнхөд магтагдана. Амен.” гэжээ. Грек хэлний хэлзүйн талаас авч үзвэл RSV орчуулгад буруу юм харагдахгүй. Гэвч бичвэрийг өөртэй нь харьцуулсан сүнслэг ялгамжийн талаас авч үзвэл KJV, NKJV ба

бусад консерватив орчуулгын хувилбар илүү зөв гарч ирсэн харагддаг.)³⁶

9:6 Элч Паул нухацтай авч үзэх ёстой нэгэн теологийн асуудалд хариу өгөх гэж байна. Бурхан Израилийг энэ дэлхий дээрх өөрийн ард түмэн болгон сонгосон юм бол, одоо харин Израилийг хүлээн авахгүйгээр үл барам харь үндэстнүүдийг ерөөлийн байран дээр тавьсан байгааг яаж ойлгох ёстой вэ? Бурхан Өөрийн талаас амлалтаа хэзээ ч зөрчөөгүй гэдгийг Паул тайлбарласан. Цааш нь тэр, Бурханы бүрэн эрхт сонголтын үйл явц удам угсаан дээр бус, хэзээд амлалтад тулгуурлаж байсныг харуулахыг зорьсон. Хүн **Израиль** үндэстэн болж төрлөө гээд Бурханы амлалтын өв залгамжлагч болно гэсэн үг биш юм. **Израиль** үндэстний дотор Бурханд итгэдэг, жинхэнэ үлдэгсэд Бурханд үргэлж байсан.

9:7 Абрахамын мах цусны тасархай **бүхэн** түүний **хүүхэд** гэж тооцогдохгүй. Жишээлбэл Ишмаел Абрахамын үр удам мөн боловч амлалт Ишмаелаар биш, Исаакаар дамжиж ирсэн. Бурхан Абрахамд **“Чиний үр удам Исаакаар нэрлэгдэх болно”** гэж амласан. Эзэн Есүс үл итгэгч иудейчүүдтэй ярьж байхдаа үүнтэй яг адил ялгааг гарган ирсэн тухай бид 4:12 дугаар ишлэлд дурдаад өнгөрсөн. Үл итгэгч иудейчүүдтэй ярьсан Есүсийн яриа Иохан 8:33-39 дээр гарна. Тэд Есүст “Бид бол Абрахамын удам...” (33-р ишлэл) гэхэд Есүс “Абрахамын үр удам мөн гэдгийг чинь Би мэднэ” (37-р ишлэл)

гэж хариулсан. Дараа тэд дахиад “Абрахам бол бидний эцэг” гэж хэлэхэд Эзэн тэдэнд “Хэрэв та нар Абрахамын хүүхдүүд байсан бол та нар Абрахамын хийснийг хийх байсан” (39-р ишлэл) гэж хэлдэг. Өөрөөр хэлбэл тэд Абрахамын мах цусны тасархай мөн боловч, тэдэнд Абрахамд байсан шиг итгэл байгаагүй учраас тэд Абрахамын сүнсний хүүхдүүд биш юм.

9:8 Тийм учраас биеийн үрс байх нь гол үзүүлэлт биш ажээ. Жинхэнэ Израиль нь Бурханаар сонгогдсон, онцгой **амлалтыг** нь авсан, түүний **хүүхэд** гэж тусгаарлагдсан иудейчүүдээс бүрдэнэ. Бүрэн эрхт сонголтын энэ зарчмыг бид Исаак, Иаков нарын жишээнээс харж болно.

9:9 Бурхан Абрахамд амлахдаа, товлосон **цагт** эргэн ирж, **Сара хүүтэй болно** гэж хэлсэн. Тэр **хүү** бол мэдээж Исаак. Исаак гарцаагүй амлалтын хүүхэд байв. Тэр гайхамшгаар төрсөн билээ.

9:10 Бүрэн эрхт сонголтын өөр нэг жишээ бол Иаковын жишээ. Ээж, аав нь мэдээж **Исаак, Ребека** хоёр. Ребека нэг биш, *хоёр* ихэр хүүхэд тээж байв.

9:11 Гэтэл **хүүхдүүдийг хараахан төрөөгүй байхад** Бурхан тэдний талаар мэдэгдэл хийв. Хүүхдүүдийн хэн нь ч гавьяатай үйлс хийгээгүй байхад Бурхан мэдэгдлээ хийсэн учир Бурхан тэр хүүхдүүдийн зан чанар, амжилт бүтээлийг нь харж биш, Өөрийн хүсэлдээ тулгуурлан сонголтоо хийсэн. Энэ нь бүхэлдээ Бурханы

сонголтын асуудал байв. **Бурханы зорилго нь сонголтын дагуу** гэдэг нь Өөрийн бүрэн эрхт хүсэл ба сайн тааллын дагуу хайр ивээлээ түгээх Бурханы товлал, тодорхойлолт юм.

Иаковыг сонгосон Бурханы сонголт нь Иаков юу хийх байсныг мэдсэн Түүний урьдаас мэдэх мэдлэгт тулгуурласан гэх үзэл санааг энэ ишлэл няцааж байна. Яагаад гэвэл Бурханы сонголт **үйлсийг** харгалзаагүй гэдгийг энд онцолсон.

9:12 Ах нь дүүдээ үйлчилнэ - Бурханы шийдвэр ийм байв. Есав Иаковоос буурай болох байв. Дүү нь энэ *дэлхийн алдар ба давуу эрхийг* авахаар сонгогдов. Хоёр ихрээс түрүүнд мэндэлсэн нь Есав учраас хүндлэл, давуу эрхийг эхэнд хүртэх ёстой байсан боловч Бурхан түүнийг алгасаж, Иаковыг сонгожээ.

9:13 Цааш нь, Паул Бурханы сонголтын бүрэн эрхийг батлахын тулд Малахи 1:2,3 дугаар ишлэлийг иш татсан: **“Би Иаковыг хайрлаж, Есавыг үзэн ядсан”**. Энд Бурхан **Иаков** ба **Есаваар** тэргүүлүүлсэн хоёр үндэстэн болох Израиль, Едомын тухай ярьж байна. Бурхан Израиль үндэстнийг сонгон авч, түүнд Мессиаг, бас Мессиагийн хаанчлалыг өгөхөөр амласан бол Едомд тийм амлалт өгөөгүй. Есавын уулс ба газар нутаг нь хоосорч эзгүйрэн, цөлийн цөөвөр орогнох газар болсон (Малахи 1:3; Иеремиа 49:17, 18; Езекиел 35:7-9).

Малахи 1:2, 3 дугаар ишлэлд хувь хүмүүсийн тухай бус, үндэстнүүдийн тухай

ярьж байгаа хэдий ч энэ нь хувь хүнийг сонгох Бурханы бүрэн эрхийн тухай санааг мөн дэмжиж өгдөг.

Би Иаковыг хайрлаж, Есавыг үзэн ядсан гэдэг үгийг **ах нь дүүдээ үйлчилнэ** гэсэн Бурханы бүрэн эрхт мэдэгдлийн хүрээнд ойлгох ёстой. Иаковыг сонгосноо хайр гэдэг үгээр, Есавыг алгассанаа үзэн ядах гэдэг үгээр зэрэгцүүлэл болгон хэлжээ. Энэ нь Бурхан хатуу цэвдэг, өст зэвүүрхлээр Есавыг үзэн ядаж байсан гэсэн үг биш. Бурхан Есавыг хайрладаг байсан. Гэхдээ Иаковт хайраа илүү харуулсан. Өөрийн бүрэн эрхт сонголтоор Иаковыг сонгосон нь үүний илрэл юм.

Энэ үг *энэ дэлхийн ивээл ерөөлийн* тухай болохоос мөнх амийн тухай биш гэдгийг анхаараарай. Бурхан Есавыг үзэн ядсан гэдэг нь едом үндэстний хүн аврагдах *боломжгүй* гэсэн үг биш. Бурхан Израилийг хайрласан гэдэг нь израиль хүн аврагдах *хэрэгцээ шаардлагагүй* болсон гэсэн үг биш. (Эхлэл 33:9 дээр, энэ дэлхийн зарим ивээл ерөөлийг *хүртсэн* болохоо Есав өөрөө хэлсэн).

9:14 Бурханы бүрэн эрхт сонголтын тухай сургаал нь зүсэн бүрийн эсэргүүцэлтэй тулгарна гэдгийг элч Паул мэдэж байж. Хүмүүс өнөөдөр ч гэсэн Бурханыг шударга бус хэмээн буруутгадаг. Тэр бүх зүйлийг урьдчилаад тогтоочихсон юм бол хүн юу хийж чадах юм бэ, Бурхан хүмүүсийг буруутгадаг нь шударга бус хэрэг гэж хэлдэг.

Бурханы талаас **шударга бус** юм байх аливаа боломжийг Паул эрс няцаасан. Паул сөргөлдөгч хүмүүстээ илүү сайн ойлгуулах гэж байна гээд Бурханы бүрэн эрхийг бүрхэгдүүлж сулруулаагүй, харин ч илүү эрс шийдэмгий тунхагласан ба үүнийхээ төлөө уучлал ч гуйгаагүй.

9:15 Паул, Мосед хэлсэн Бурханы үгийг эхлээд иш татсан: **“Би өөрийн өршөөх хүнээ өршөөнө. Би өөрийн өрөвдөх хүнээ өрөвдөнө”** (Гэтлэл 33:19). Хамгийн дээд нэгэн, тэнгэр, газрын Эзэнийг **өршөөл, энэрэл** үзүүлэх эрхгүй гэж хэн хэлж чадах вэ?

Хүн бүр өөрийн гэм нүгэл, итгэлгүй байдлаас болж яллагддаг. Тэднийг зөнд нь орхивол, тэд *бүгдээрээ* мөхөх байсан. Бурхан бүх хүнийг сайнмэдээний үнэнд дуудаж, аврал уруу урьдаг боловч, ялд унасан тэдгээр хүмүүсээс заримыг нь Өөрийн нигүүлслийн онцгой объект болгон сонгож авдаг. Тэглээ гээд өөр хэн нэгнийг зориудаар сонгон авч шийтгэл уруу түлхдэг гэсэн үг биш. Бүх амьдралынхаа турш гэм нүгэл дотор амьдарч, сайнмэдээг хүлээн аваагүйнхээ төлөө л хүн шийтгүүлдэг. Сонгогдсон хүмүүс Бурханд нигүүлслийнх нь төлөө талархана. Харин төөрч мөхсөн хүмүүс өөрсдөөсөө өөр хэнийг ч буруутгах эрхгүй.

9:16 Эндээс дүгнэн үзвэл, хүмүүсийн болоод үндэстнүүдийн эцсийн хувь тавилан тэдний хүслийн хүч ба хичээл зүтгэлийнх нь хүчин

чармайлтаас шалтгаалдаггүй, харин **Бурханы өршөөлөөс** болдог ажээ.

Энэ нь хүсдэг хүнээс биш гэсэн үг нь авралын ажилд хүний өөрийн хүсэл хамааралгүй гэх утгатай биш. Илчлэл 22:17 дээр “Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг” гэж хэлснээс харвал сайнмэдээний урилга хүний хүсэл уруу чиглэдэг нь эргэлзээгүй. Есүс нэг удаа үл итгэгч иудейчүүдэд, өөр уруу нь ирэх *хүсэлгүй* болохыг нь хэлж байсан (Иохан 5:40). **Энэ нь хичээдэг хүнээс биш** гэсэн нь бас нарийн хаалгаар орохын тулд хичээл зүтгэл гаргах хэрэггүй (Лук 13:24) гэсэн үг биш. Сүнслэг хичээл зүтгэл, хүсэл хүнд тодорхой хэмжээнд байх ёстой. Гэхдээ хүний хүсэл, хичээл зүтгэл бол үндсэн шаардлага, амин чухал хүчин зүйл биш юм: Аврал бол Эзэнийх билээ. Морган энэ тухай ингэж хэлжээ:

Бидний хүсэл, бидний хичээл зүтгэл бидэнд хэрэгтэй авралыг олж өгч чадахгүй. Авралын өгдөг ивээл ерөөл уруу орох үүд хаалгыг нээж чадахгүй. Бид өөрсдөөрөө байсан бол авралыг хүсэж, Түүнийг авахын төлөө хичээл зүтгэл гаргахгүй байх байсан. Хүний авралын бүх зүйл Бурханы дотор эхэлдэг юм.³⁷

9:17 Бурханы бүрэн эрх нь зарим нэгэнд хайр өршөөл үзүүлэхэд харагддаг бол, бас

зарим нэгний зүрх хатуурахад ч гэсэн харагддаг байна. Үүнд **фараоныг** жишээ болгосон.

Египетийн хаан төрөхөөсөө л мөхөх хувь тавилантай байсан гэх санаа энд нэгээхэн ч үгүй. Харин ийм зүйл болжээ: Египетийн хаан нас биед хүрээд өөрийнхөө мөн чанарыг таниулж, хорон муу, хэрцгий догшин, мунхаг гэжүүд болохоо харуулсан. Бурханы ариун сануулгыг ч хүртэл үл тоон зүрхээ хатууруулсаар байв. Бурхан тэр даруй түүнийг устгаж чадах байсан боловч тэгсэнгүй. Харин түүний дотор өөрийнхөө хүчийг харуулж, түүгээр дамжуулан бүх дэлхий даяар өөрийн нэрийг түгээхийн тулд Бурхан фараоныг амьд үлдээв.

9:18 Фараон зүрхээ байнга хатууруулж байлаа. Ийнхүү хатуурсны *дараа* тухай бүр Бурхан фараоны зүрхийг *улам* хатууруулж байв. Энэ бол түүнд өгсөн шийтгэл байв. Нар мөсийг хайлуулдаг атлаа шаврыг хатаадаг. Нар даавууг гандаан цайруулдаг атлаа, арьсыг борлуулдаг. Яг үүн шиг Бурхан эмтэрсэн зүрхтэй хүнд өршөөлөө үзүүлдэг атлаа гэмшдэггүй зүрхтэй хүнийг хатууруулдаг. Нигүүлслээс татгалзсан бол нигүүлсэл хүртэхгүй.

Бурхан хүссэн хүндээ **өршөөл** үзүүлж, хүссэн хүнээ хатууруулах эрхтэй. Гэвч тэр бол Бурхан, тиймээс хэзээ ч шударга бусаар хандахгүй.

9:19 Бурхан хүссэн бүхнээ хийх эрхтэй гэсэн Паулын үг сөргөлдөх бас нэг шалтгаан гаргаж ирэв. Юу гэвэл, хэрэв Бурхан хүссэн бүхнээ

хийх эрхтэй юм бол, хүнээс **тэр өө хайх** ёсгүй, яагаад гэвэл **Түүний хүслийг** амжилттай **эсэргүүцсэн** хүн нэг ч байдаггүй гэдэг эсэргүүцлийг гарган ирж байна. Паултай сөргөлдөж байгаа хүний хувьд, хүн гэгч Бурханы шатрын хөлөг дээр байгаа хүү ажээ. Шатрын хүү өөрөө юу ч хийдэггүй, юу ч ярьдаггүй. Зөвхөн тоглож байгаа хүнийхээ тавьсан газар л очдог.

9:20 Эхлээд элч Паул, өөрийн Бүтээгчээ аймшиггүйгээр буруутгагч бүтээлүүдийг зэмлэсэн. Хязгаарлагдмал хүрээнд байдаг **хүн** гэгч, гэм нүгэлтэй, мунхаг харанхуй, сул дорой атлаа **Бурханыг** буруутгаж, түүний мэргэн ухаан, шударга ёс, арга замуудыг шүүх нь зүйд үл нийцнэ.

9:21 Дараа нь Паул **ваарчин, шавар** хоёроор жишээ авч, Бурханы бүрэн эрхийн тухай батлан ярьсан. Нэг өдөр **ваарчин** ажил дээрээ ирэхэд ямар ч хэлбэр дүрсгүй хэсэг шавар шалан дээр байхыг харав. Ваарчин тэр шаврыг аваад хүрдэн дээр тавьж, уран чамин **сав** урлаж эхлэв. Ваарчинд үүнийг хийх эрх байгаа юу?

Ваарчин бол мэдээж Бурхан. **Шавар** бол гэм нүгэлтэй, төөрсөн хүн төрөлхтөн. Ваарчин шаврыг тэр чигт нь шалан дээр орхисон бол, энэ нь зүйрлэвээс хүн төрөлхтөн мөнхийн тамд авралгүй хаягдаж байгаатай адил. Ваарчин ийм хандлага үзүүллээ ч түүнд ямар ч буруу байхгүй. Тэр ингэх бүрэн эрхтэй. Гэтэл тэр гэм нүгэлт

хүнийг өөрийн бүрэн эрхээрээ сонгож аваад, нигүүлслээрээ аварч, өөрийн Хүүгийн дүр төрхтэй адил болгож урлав. Түүнд үүнийг хийх эрх байгаа юу? Бурхан хэзээ ч хүнийг там уруу хаяхаар тусгайлан сонгодоггүй гэдгийг санаарай. Хүн өөрийн сайн дураар, итгэлгүй байдлаасаа болоод аль хэдийн мөхөх хувь тавиланг сонгосон билээ.

Бурхан зарим шавраар **хүндэтгэлийн сав**, зарим шавраар **ердийн сав** хийх бүрэн эрх мэдэлтэй. Хог новш мэт бүгд зохисгүй болсон байхад нь Бурхан заримыг нь сонгон аваад ивээл ерөөлөө өгвөл Түүний буруу биш ээ. Тэр хүссэн хүндээ өгч болно. Бас өгөхгүй ч байж болно. Барнес энэ тухай, “Бүх хүн сайныг хүртэх зохисгүй болсон нөхцөлд, Бурханаас шаардаж болох ганцхан зүйл байдаг. ‘Бурхан та хэнд маань ч шударга бус хандах ёсгүй’ гэдгийг л шаардаж болно”³⁸ гэж бичжээ.

9:22 Паул **Бурханыг** ашиг сонирхлын зөрчилтэй тулгараад байгаа агуу Ваарчин мэтээр дүрсэлсэн. Нэг талаас тэр уур хилэнгээ үзүүлж, гэм нүглийг шийтгэн хүч чадлаа мэдүүлэхийг хүсдэг. Харин нөгөө талаас **сүйрэлд зориулагдсан уур хилэнгийн савнуудыг** тэвчээртэйгээр хүлцэхийг хүсдэг. Тэгээд Бурханы шударга уур хилэн ба өршөөнгүй **тэвчээр** нь хоорондоо зөрчилддөг. “Хэрэв Бурхан нүгэлтнийг хүлцэн тэвчихийн оронд тэр даруй шийтгэж өөрийнхөө шударгыг

харуулбал Түүнийг буруутай гэж хэн хэлэх юм бэ?”

Сүйрэлд зориулагдсан уур хилэнгийн сав гэдэг үгэнд анхаарлаа хандуулаарай! **Уур хилэнгийн сав** гэж нүгэл үйлдэн Бурханы **уур хилэнг** хүртэх ёстой болчихсон хүмүүсийг хэлж байна. Тэд Бурханы ямар нэг зарлиг тогтоолоос болж биш, харин өөрсдийн нүгэл, дуулгаваргүй байдал, тэрслэлээс болж **сүйрэлд зориулагдсан** хүмүүс болжээ.

9:23 Мөнх алдрын төлөө урьдаас сонгож, **өршөөл** үзүүлэхийг хүссэн хүмүүстээ **өөрийн алдрын баялагийг мэдүүлэхийг** Бурхан хүссэн бол хэн түүнийг нь эсэргүүцэж чадах юм бэ? Энэ тал дээр Ч.Р.Эрдманы тайлбар нэлээд тустай харагддаг:

Бурхан бүрэн дээд эрх мэдлээ ашиглаж аврагдах ёстой хүмүүсийг ялладаггүй, харин шийтгүүлэх ёстой хүмүүсийг авардаг.³⁹

Бурхан уур хилэнгийн савнуудыг сүйрлийн төлөө бэлтгэдэггүй, харин **өршөөлийн савнуудыг алдрын төлөө бэлтгэдэг**.

9:24 Өршөөлийн савнууд бол иудейчүүд болон харь үндэстнүүдийн дотроос Бурханаар дуудагдсан Христэд итгэгч биднийг хэлж буйг Паул энд тодорхойлж өгчээ. Тэгэхээр үүнээс цааш өгүүлэх зүйлсэд энэ ишлэл суурь болж өгч байна. Юу гэвэл, Израилийн үлдэгсдийг тусгаарлаж, **харь үндэстнүүдийг** давуу эрхийн

байр сууринд дуудаж буй тухайд эндээс цааш өгүүлэх юм.

9:24 Харь үндэстнүүдийг дуудсан дуудлагыг иудейчүүд гайхах зүйл биш гэдгийг харуулахын тулд элч Паул Хосеа номоос хоёр ишлэл иш татсан. Эхнийх нь Хосеа 2:23: **“Минийх байгаагүй ард түмнийг Би “миний ард түмэн”, хайрлагдаж байгаагүйг нь “хайрт” гэж дуудна.** Үнэндээ Хосеагийн энэ үг харь үндэстнүүдийн тухай биш, харин Израилийн тухай байсан. Хожим Бурхан Израилийг өөрийн хайртай ард түмэн болгож дахин сэргээх үеийн тухай энд дурдсан. Харин Паул ромчуудад бичсэн захидалдаа энэ үгийг харь үндэстнүүдийн дуудлагатай холбон иш татжээ. Ийм ноцтой өөрчлөлтийг хийх ямар эрх Паулд байгаа вэ? Хариулт юу гэвэл: Энэ үгсийг бичсэн Ариун Сүнс эднийг өөрөөр тайлбарлах, өөр нөхцөлд ашиглах бүрэн эрхтэй билээ.

9:26 Хоёр дахь нь Хосеа 1:10: **“Та нар миний ард түмэн биш гэж тэдэнд айлдсан газарт тэд амьд Бурханы хөвгүүд гэж дуудагдах болно.”** Энэ удаа ч бас, энэ ишлэлийг Хуучин гэрээнийх нь хам сэдэвтэй хамт харвал харь үндэстнүүдийн тухай биш, харин Израиль ирээдүйд дахин сэргэж, Бурханы тааллыг олох тухай байна. Харин Паул үүнийг харь үндэстнүүдтэй холбож, харь үндэстнүүд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэхийг илэрхийлсэн. Хэрэв Ариун Сүнс Хуучин гэрээнээс Шинэ гэрээнд иш татвал өөрийн

хүссэнээр ашиглах эрхтэй гэдгийг харуулсан бас нэгэн жишээ энэ мөн.

9:27 Бурхан Израилиас нүүр буруулсан ч үлдэгсдийг нь аврах тухайд 9:27-29 дээр өгүүлжээ. **Израиль** үндэстэн тоо томшгүй олуулаа байвч цөөхөн нь л **аврагдана** гэдгийг Исаиа зөгнөжээ (Исаиа 10:22).

9:28 Исаиа “**Эзэн Өөрийн үгээ дэлхий дээр гүйцэд, түргэн биелүүлэх болно**” (Исаиа 10:23) гэж хэлэхдээ вавилончууд Палестиныг эзлэн түрэмгийлэх, израильчууд цөллөгт одох үйл явдлын тухай ярьж байсан. Тэр нь Бурханы шийтгэл байв. Паул энэ үгсийг иш татаад, Израилийн өнгөрсөнд тохиолдсон зүйл өөрийнх нь үед бас тохиолдох боломжтой, тохиолдох ч болно гэдгийг хэлжээ.

9:29 “Тэнгэр дэх түг түмэн цэргийн Эзэн амь хэлтрэгчдийг үлдээгээгүй бол Израиль үндэстэн яг л **Содом ба Гоморра шиг** арчигдах байсан” (1:9) хэмээн Исаиа хэлсэн ажээ.

9:30 Тэгвэл өнөөгийн энэ чуулганы үеийн талаар ямар дүгнэлт хийх вэ гэж Паул асууж байна. Эхний дүгнэлт бол, **зөвт байдлыг мөшгөөгүй**, өөрсдийгөө зөвт болгох гэж хичээгээгүй, харин бузар муугийн хойноос явж байсан **харь үндэстнүүд** Эзэн Есүс Христэд итгэх **итгэлээр** дамжуулан **зөвт байдлыг** олжээ. Гэхдээ мэдээж харь үндэстнүүд бүгд биш. Зөвхөн Христэд итгэсэн хүмүүс л зөвтгөгдсөн.

9:31 Гэтэл нөгөө талд, хуулийг сахиж зөвтгөгдөхийг эрмэлзэж байсан **израиль** хүмүүс **зөвт байдалд хүргэх хуулийг** огт олсонгүй.

9:32 Үүний шалтгаан тодорхой. Тэд Христэд итгэснээр зөвтгөгдөнө гэдэгт итгэхээс татгалзаж, зөвтгөлийг өөрсдийн гавьяагаар олж авах гэж муйхарлан зүтгэж байв. Тэд **бүдрүүлэх чулуу** Эзэн Есүс Христэд **бүдэрцгээжээ**.

9:33 Эзэн Исаиагаар дамжуулж энэ тухай зөгнөн хэлсэн байна. Мессиа Иерусалимд ирэхэд хоёр төрлийн нөлөө үзүүлэх байсан. Зарим хүмүүсийн хувьд тэр бол **бүдрүүлэх чулуу, зөрчилд хүргэх хад** байх болно (Исаиа 8:14). Харин зарим нь **Түүнд** итгэснээрээ ичих, зөрчилдөх, урам хугарах шалтгаангүй болно (Исаиа 28:16).

Б. Израилийн одоо үе (10-р бүлэг)

10:1 Христэд итгээгүй иудей хүнд Паулын номлож байсан сургаал их эвгүй сонсогдож байлаа. Тэд түүнийг урвагч, Израилийн дайсан гэж үзэж байв. Харин Паул захиагаа бичиж байгаа христитгэгч **ах дүү нартаа** түүнийг хамгийн их баярлуулах зүйл бол Израилийн **аврал** бөгөөд үүний төлөө **Бурханд** үнэн сэтгэлээсээ залбирч байдгаа цохон хэлсэн байна.

10:2 Элч Паул тэднийг бурхангүй, сүсэггүй гэж буруутгалгүй, харин ч **Бурханы төлөө хичээл зүтгэлтэй** хэмээн гэрчилсэн. Тэд

иудеизмын ёс заншил, зан үйлийг сахихдаа маш нягт нямбай ханддаг, эсрэг номлол сургаалыг огт хүлээн авдаггүйгээс нь үүнийг тодорхой харж болно. Гэхдээ **хичээл зүтгэл** дангаараа хангалтгүй. Үнэн заавал хамт байх ёстой. Эс бөгөөс сайнаасаа саар нь давна.

10:3 Тэд үүн дээр алдаж байлаа. Тэд **Бурханы зөвт байдлыг мэдсэнгүй**. Бурхан үйлсээр биш, итгэлээр хүнийг зөвд тооцдогийг тэд **мэдсэнгүй**. Тэд хуулийг сахиж **өөрсдийнхөө зөвт байдлыг** бий болгохыг эрмэлзэж байв. Тэд өөрсдийнхөө хичээл зүтгэл, өөрсдийнхөө зан чанар, өөрсдийнхөө сайн үйлсээр Бурханы тааллыг олох гэж хичээцгээжээ. Хүүд нь итгэсэн нүгэлтнүүдэд зөвт гэж тооцох Бурханы төлөвлөгөөнд захирагдахаас тэд мугуйдлан татгалзаж байв.

10:4 Хэрэв тэд Христэд итгэсэн бол, **зөвт байдлын төлөөх хуулийн төгсгөл нь Христ** болохыг харах байсан. Хууль нь нүглийг илчилж, гэмт хүнийг буруутгаж, гэмшүүлэх зорилготой. Харин нүгэлтнийг зөвт болгож чадахгүй. Хууль зөрчсөний шийтгэл нь үхэл. Харин Христ өөрийн үхлээрээ хүний зөрчсөн хуулийн шийтгэлийг эдэлжээ. Нүгэлтэн Эзэн Есүс Христийг өөрийн Аврагч болгож хүлээн авбал, тэр хүний эсрэг мэдүүлэх ямар ч зарга хуульд үлдэхгүй. Учир нь, тэр хүнийг орлож Христ үхсэн болохоор, хуулийн дагуу түүнийг үхсэнд тооцно. Тэр хүн үхчихсэн учраас хууль түүнээс юу ч шаардаж, нэхэх боломжгүй болжээ.

Тиймээс хуулиар зөвт байдалд хүрэх гэж оролдох шаардлагагүй болсон юм.

10:5 Хуучин гэрээний үг хэллэгээс хуулийн үгс ба итгэлийн үгсийн ялгааг бид сонсох болно. Жишээ нь гэхэд, Леви 18:5-д, **хуулийн** шаардаж байгаа **зөвт байдалд** хүрэх хүн хуулийг биелүүлж байж **амьдарна гэж Мосе бичжээ**. Энд хийх, үйлдэхийг онцолсон байна.

Гэхдээ энэ нь нүгэлт хүмүүсийн хэний ч хүрч чадахгүй төгс зүйлийг илэрхийлж байгаа нь тодорхой. Энд хуулийг байнга төгс биелүүлбэл үхлийн ялаас мултрах боломжтой л гэж хэлж байна. Гэвч, хуулийг хүлээн авагсад нь *нэгэнтээ* нүгэлтэн болчихсон, *нэгэнтээ* үхэх ялд уначихсан хүмүүс юм. Яг одооноос эхлэн ямар ч алдаа мадаггүй төгс сахих хүн байлаа ч гэсэн тэр хүн аврагдахгүй. Учир нь, Бурхан түүнээс урдах нүглүүдийн ялыг нэхэмжлэх болно. Хуулиар зөвт байдлыг олж авах гэсэн бүх найдвар эхнээсээ л бүтэхгүй зүйл гэдэг нь тодорхой байна.

10:6 Итгэлийн үгс нь хуулийнхаас огт өөр гэдгийг харуулахын тулд Паул эхлээд Дэд хууль 30:12,13-аас иш татсан. Үүнд:

“Энэ нь тэнгэрт байгаа зүйл ч биш учир чи “Биднээр тэр тушаалыг сахиулахын тулд түүнийг бидэнд авчирч, бидэнд сонсгохоор хэн бидний төлөө тэнгэрт гарах юм бэ?” гэж хэлэхээр юм биш. Энэ бол далайн цаана байгаа зүйл ч биш учир чи “Биднээр тэр

тушаалыг сахиулахын тулд түүнийг бидэнд авчирч, бидэнд сонсгохоор хэн бидний төлөө далайг гатлах юм бэ?” гэж хэлэхээр юм биш.”

Сонирхолтой нь, энэ үгсийг Дэд хууль номын хам сэдвээс нь харвал итгэл ба сайнмэдээтэй огт хамаагүй байдаг. Энэ үгс уг нь хуулийн тухай, тэр дундаа, “Бүх зүрх, бүх сэтгэлээрээ өөрсдийн Бурхан Эзэндээ эргэ” (Дэд хууль 30:106) гэдэг тушаалын тухай ярьж байсан. Хууль нь далд нууц, алс хол, хүршгүй газарт байдаггүй юм шүү, хуулийг олохын тулд тэнгэр өөд авирч, тэнгис далай гатлах хэрэггүй, харин дагаж мөрдөхийг чинь хүлээгээд дэргэд чинь байна гэж Бурхан хэлжээ.

Харин элч Паул энэ үгсийг аваад, сайнмэдээн дээр ашигласан байна. **Итгэлийн үгс нь Христийг доош авчрахын тулд тэнгэр өөд авирахыг хүнээс шаарддаггүй гэж Паул хэлж байна.** Нэг талдаа энэ бол боломжгүй зүйл. Нөгөө талдаа тэгэх *шаардлагагүй*. Яагаад гэвэл, Христ хүн болоод газар дэлхий уруу буун ирсэн билээ.

10:7 Элч Паул Дэд хууль 30:13-ыг иш татахдаа “Хэн далайг гатлах вэ?” гэснийг “**Хэн ёроолгүй гүнд буух вэ?**” болгож өөрчилсөн. Үүгээрээ тэр, сайнмэдээ нь **Христийг үхэгсдээс босгохын тулд үхэгсдийн орон уруу буухыг** хүнээс шаарддаггүй гэж хэлж байна. Ингэх нь боломжгүйгээс гадна шаардлагагүй. Яагаад

гэвэл, Христ аль хэдийнээ үхлээс амилсан билээ. 10:6,7-г харвал, Христийн тухай сургаалуудаас иудей хүний хүлээн авахад хамгийн хэцүү хоёр нь дурдагджээ. Тэдгээр нь, нэгт, Христ хүн болсон гэх сургаал, хоёрт, Христ үхлээс амилсан гэх сургаал. Гэсэн ч, иудей хүн аврагдахын тулд энэ хоёр сургаалыг хүлээн авах ёстой. Энэ хоёр сургаалыг бид 10:9,10 дээр дахин харах болно.

10:8 Сайнмэдээ нь хүний хувьд боломжгүй зүйлийг хий, эсвэл Эзэний нэгэнтээ хийчихсэн зүйлийг хий гэж хэлээгүй юм бол, **юу гэж хэлдэг вэ?**

Паул дахиад Дэд хууль 30 дугаар бүлгээс иш татаад, сайнмэдээ нь бидэнд **ойрхон**, бидний хүрч чадах газар, ойлгоход хялбар, олж авахад амар байдаг гэж хэлж байна. Сайнмэдээ нь энгийн үг яриагаар (**чиний аманд**) илэрхийлэгдэж, бодолд (**чиний зүрхэнд**) хялбархан ойлгогдоно (Дэд хууль 30:14). Паул болон бусад элч нарын номлож байсан, итгэлээр хүрдэг авралын сайнмэдээ энэ билээ.

10:9 Энэ ишлэл дээрх санааг товчхон дүгнэжээ. Юуны түрүүнд та Христийг хүн болсон, Бетлехемийн малын тэвшинд төрсөн нялх Хүү бол амь ба алдрын Эзэн мөн, Шинэ гэрээний **Есүс** бол Хуучин гэрээний **Эзэн** (Ёхова) мөн гэж хүлээн зөвшөөрөх ёстой.

Хоёрт та Христ үхлээс амилсан гэдгийг, амилалтай холбоотой бүхнийг хүлээн зөвшөөрөх ёстой. **Бурхан Түүнийг үхэгсдээс**

амилуулсан нь биднийг аврахын тулд шаардлагатай бүх ажлыг Христ дуусгасан, Бурхан тэрхүү ажлаар ханасны баталгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ бүгдэд **зүрхэндээ** итгэх гэдэг нь оюун бодол, сэтгэл санаа, зорог ухамсараараа итгэнэ гэсэн үг юм.

Ингэж гэмээнэ, **та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэг зүрхэндээ итгэсэн** хэрэг мөн. Эзэн Есүс Христийн хэн болохыг, гүйцэтгэсэн ажил нь ямар утга учиртайг чин үнэнээр ухааран ойлгоно гэсэн үг юм. Энэ бол авралд хүргэх итгэл билээ.

“Хүн Есүсийг Эзэн гэдгийг хүлээн зөвшөөрөхгүйгээр Аврагч хэмээн хүлээн аваад аврагдаж болох уу?” Ийм асуулт олонтаа гарч ирдэг. “Би Есүсийг Аврагчаа болгоно. Гэхдээ бүгдийн Эзэн гэж өргөмжилмөөргүй байна” гэсэн хагас дутуу хүлээн зөвшөөрсөн итгэгч хүнийг Библи огтхон ч дэмждэггүй. Тэгэхдээ нөгөө талд, Есүсийг Эзэн гэж хүлээн зөвшөөрч байж л *аврагдана*, нэг ёсондоо ийнхүү хүлээн зөвшөөрөх нь *авралын болзол* гэж үздэг хүмүүст “Ямар хэмжээнд Түүнийг Эзэн гэж хүлээн зөвшөөрч байж энэ болзол хангагдах вэ?” гэсэн асуулт урган гардаг. Есүст бүрэн гүйцэд туйлын дуулгавартай итгэгч гэж өөрийгөө тунхаглах хүн цөөхөн л олдох болов уу. Бид сайнмэдээг тунхаглахдаа, *итгэл бол зөвтгөгдөх цорын ганц болзол* гэж ярих ёстой. Гэхдээ бид нүгэлтнүүдэд ч, ариун хүмүүст ч ялгаагүй, Есүс Христ бол

Эзэн (Ёхова-Бурхан) ба Эзэн гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстойг байнга сануулах нь зүйтэй.

10:10 Цааш нь Паул, **хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрнэ** гэж бичжээ. Гэхдээ энэ нь оюун бодолдоо зөвшөөрөхийн нэр биш, харин дотор байгаа бүхнээрээ чин үнэнээр хүлээн авахыг хэлж байна. Тэгсэн цагт тэр хүн даруй зөвтгөгдөнө.

Тэгээд **амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ**. Өөрөөр хэлбэл, итгэгч хүн нэгэнт хүлээгээд авчихсан авралаа олны өмнө хүлээн зөвшөөрөхийг хэлж байна. Хүлээн зөвшөөрөх нь аврагдах *болзол* биш харин хүний сэтгэлд болсон зүйлийн яах аргагүй гаднаа илэрч байгаа үр дагавар мөн. “Хэрэв чи Есүс Христэд итгэдэг л юм бол ам чинь үүнийг тунхаглах нь гарцаагүй.” Хүн ямар нэг зүйлд итгэж байвал түүнийгээ бусдад хуваалцахыг хүснэ. Хүн үнэхээр дахин төрсөн бол, үүнийг нуухын аргагүй сайхан зүйл юм. Тийм хүн Христийг хүлээн зөвшөөрнө.

Аврагдсан хүн тэрхүү авралаа олны өмнө харуулдгийг бичвэрт хэлдэг. Энэ хоёр зүйл хамт явдаг. Келли энэ тухайд: “‘Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно’ гэж Эзэний хэлсэн учраас Христ Эзэнийг амаараа хүлээн зөвшөөрөхгүй байгаа хүнийг аврагдсан гэж хэлэхэд хэцүү”⁴⁰ гэжээ. Дэнни үүн дээр дараах тайлбарыг хийсэн:

“Итгэж зөвт байдалд хүрсэн зүрх ба хүлээн зөвшөөрч авралд хүрсэн ам бол үнэндээ хоёр өөр зүйл биш, харин нэг зүйлийн хоёр тал юм.”⁴¹

10:9-д амаараа хүлээн зөвшөөрөх нь нэгт, итгэх нь хоёрт байснаа 10:10-д итгэх нь нэгт, амаараа хүлээн зөвшөөрөх нь хоёрт байгаа нь ямар учиртай юм бол? Үүнд хариулах хэцүү биш ээ. Есдүгээр ишлэл нь Христийн хүмүүн биежилтт ба амиллыг онцолсон ба тухайн хоёр зүйл тохиолдсон цаг хугацааны дарааллаар энэ хоёр сургаалыг дурдсан байна. Эхлээд Христ хүн болсон – биежилт: Есүс бол Эзэн. Харин үхлээс амилсан явдал дараа нь болсон. Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан. Харин аравдугаар ишлэл нь нүгэлт хүний аврагдахад болдог үйл явдлын дарааллыг гаргажээ. Хүн аврагдахын тулд эхлээд **итгэх** ёстой. Дараа нь олны өмнө өөрийнхөө **авралыг хүлээн зөвшөөрдөг**.

10:11 Түүнд итгэгч нь ичгэвтэр байдалд орохгүй гэдгийг хэлэхийн тулд Паул Исаиа 28:16-аас иш татсан. Христийг олны өмнө хүлээн зөвшөөрөх нь ичгэвтэр байдалд хүргэнэ гэж бодогдож болох юм. Гэвч үнэндээ тийм биш. Бид түүнийг *газар дээр* хүлээн зөвшөөрвөл, тэр биднийг *тэнгэрт* хүлээн зөвшөөрнө. Хэзээ ч урам хугалахгүй найдвар бидэнд бий.

Итгэгч нь гэдэг үг дараагийн ишлэлтэйгээ холбогдож байна. Бүр тодруулбал, Бурханы цог

жавхланта аврал нь итгэсэн бүгдэд зориулагдсан, иудейчүүд төдийгүй харь үндэстнүүдэд өгөгдсөн гэдгийг хэлж байна.

10:12 Бүх хүн нүгэлтэй учраас, иудей, иудей бус ялгаагүй бүгдэд аврал хэрэгтэй байдгийг бид Ром 3:23-аас мэдсэн. Тэгвэл одоо аврагдах боломж ч хэнийг ч **ялгахгүй** гэдгийг эндээс мэдэж авч байна. Эзэн ялгаварлан гадуурхагч Бурхан биш, харин бүх хүн төрөлхтний **Эзэн юм**. Өөрийг нь **дуудагч бүгдэд** хүртээх өршөөл нигүүлсэл **баялаг бялхана**.

10:13 Сайнмэдээг ертөнцийн бүх хүнд өгсөн гэдгийг батлахын тулд Иоел 2:32-ыг иш татаж байна. **“Эзэний нэрийг дуудах хэн ч бай аврагдах болно.”** Аврагдах гаргалгааг үүнээс хялбархан илэрхийлэх үг нэхэхийн арга алга. **Эзэний нэр нь Эзэнийг** өөрийг нь илэрхийлдэг.

10:14 Гэхдээ тэр сайнмэдээг ертөнц даяар тунхаглах шаардлагатай. Иудейчүүд ба харь үндэстнүүдэд аврал өгөгдсөн ч, тэд энэ тухай сонсохгүй бол түүнийг яаж авч чадах юм бэ? Христитгэлт илгээлтийн ажлын зүрх хэрхэн цохилж байгааг энд өгүүлжээ.

Элч Паул, гурван удаа яаж гэж асуухдаа **(яаж дуудах вэ... яаж итгэх вэ... тунхаглагчгүйгээр яаж сонсох вэ)** иудейчүүд ба харь үндэстнүүдийг авралд хөтлөх шат дамжлагыг харуулжээ. Гэхдээ түүний хэлсэн дарааллыг эсрэгээр нь харвал илүү ойлгомжтой болно. Үүнд:

Бурхан зарц нараа илгээнэ.

Тэд авралын сайнмэдээг тунхаглана.

Бурхан Христийн дотор амь өгч буйг нүгэлтнүүд сонсоно.

Тэдний зарим нь тэр мэдээнд итгэнэ.

Итгэсэн хүмүүс Эзэнийг дуудна.

Түүнийг дуудсан хүмүүс аврагдана.

“Паулын үгс Бурхан энэ зүйлийг хүсэж байгаа юм бол үүнд хүрэх юмсыг ч хангана гэсэн зарчимд тулгуурлажээ”⁴² хэмээн Ходж тайлбарласан байдаг. Энэ бол христигэлт илгээлтийн ажлын хөдөлгөөн өрнөх үндэс суурь мөн. Паул харь үндэстнүүдэд сайнмэдээ тунхаглаж байгаагаа үүнийг огт хүлээн зөвшөөрөхгүй байгаа итгэдэггүй иудейчүүдэд өмгөөлж байна.

10:15 Бурхан бол илгээгч, бид бол илгээгдсэн хүмүүс юм. Энэ тал дээр бид юу хийж байна вэ? **Сайнмэдээг тунхаглагчийн** талаар Исаиагийн дүрсэлсэн тэрхүү үзэсгэлэнтэй **сайхан хөл** бидэнд байна уу (Исаиа 52:7)? Исаиагийн эш үзүүлэлт “сайнмэдээ тунхаглагчийн” гэж ганц хүний тухай ярьж байсан. Тэр нь Мессиа юм. Харин Ромын 10:15 дээр “тунхаглагчдын” гэж олон тоогоор хэлжээ. Есүс 2000 жилийн тэртээ үзэсгэлэнт **сайхан хөлөөр** ирсэн. Харин одоо, мөхөл уруугаа явж буй ертөнц уруу үзэсгэлэнт **сайхан хөлөөр** явах аз завшаан, үүрэг хариуцлага бидэнд иржээ.

10:16 Харин бүх израильчууд сайнмэдээг хүлээн аваагүй Паул байнга гуниглаж байв.

Исаиа ч бас үүнийг эш үзүүлж “**Эзэн, бидний мэдээнд хэн итгэсэн бэ?**” гэж асуусан (Исаиа 53:1). Энэ асуултын хариуд “цөөхөн” гэж хэлэхээр байна. Мессиагийн анхны ирэлтийн тухай зарлахад ойшоож үзсэн хүн тийм ч олон байсангүй.

10:17 Паул Исаиагийн номоос энэ үгийг иш татахдаа эш үзүүлэгч Исаиагийн ярьж байгаа итгэл нь хүмүүсийн сонссон тэр мэдээнээс урган гарсан бөгөөд тэр мэдээ нь Мессиагийн тухай Бурханы үгнээс ирсэн гэдгийг онцолж байна. Тиймээс **итгэл нь сонсохоос ирдэг, сонсох нь Христийн үгээр ирдэг** гэж Паул дүгнэн бичжээ. **Бурханы** бичигдсэн үгэнд тулгуурлаж Эзэн Есүс Христийн тухай номлохыг сонсох үед хүнд **итгэл** ирдэг байна.

Гэхдээ чихээрээ сонсох нь хангалттай биш. Тухайн хүн зүрх сэтгэл, оюун бодлоо нээлттэй байлгаж Бурханы үнэнийг харах чин хүсэлтэй байх ёстой. Хэрэв тэгж чадвал тэр хүн Бурханы үг үнэн болохыг ойлгох ба тэрхүү үнэн нь өөрөө өөрийгөө батална. Тэгээд тэр хүн итгэнэ. Сонсох тухай ярихдаа чихийг л зөвхөн авч үзээгүй гэсэн битүүхэн санаа энэ ишлэлийн ард байна. Жишээлбэл хүн сайнмэдээг *унишиж* болох юм. Тиймээс “сонсох” гэдэг үг нь Бурханы үгийг ямар нэгэн хэлбэрээр хүлээж авна гэсэн утгыг илэрхийлдэг.

10:18 Тэгвэл ямар асуудал байсан бэ? Харь үндэстнүүд ба иудейчүүд бүгд сайнмэдээг **сонсоогүй** гэж үү? Тэд сонссон. Паул үүнийг

батлахын тулд Дуулал 19:4 дүгээр ишлэлийг ашигласан. Паул “**үнэндээ тэд сонссон**” гээд цааш нь

“Тэдний дуу хоолой бүх газарт,

Тэдний үгс дэлхийн зах хязгаарт ч хүрсэн”
гэсэн байна.

Гэхдээ хачирхалтай нь Дуулал 19 сайнмэдээний талаар ярьдаггүй. Үүний оронд Бурханы сүр жавхланг нар, сар, одод гэрчилдэг тухай дүрсэлдэг. Гэвч өмнө дурдсанчлан Паул тэдгээр ишлэлийг ашиглан тэр өдрүүдэд сайнмэдээ дэлхий даяар хэрхэн тунхаглагдаж байгааг зүйрлэн хэлсэн байна. Элч Паул Бурханы Сүнс хөдөлгөснөөр Хуучин гэрээний хэсгүүдээс иш татахдаа, тэдгээрийг нэлээд өөр байдлаар хэрэглэж байсан. Хуучин гэрээний үгсийг өгсөн тэр Сүнс түүнийгээ дахин ашиглах бүрэн эрхтэй билээ.

10:19 Сайнмэдээг харь үндэстнүүд хүлээн авч иудейчүүдийн *ихэнх* нь эсэргүүцсэн явдал **Израиль** үндэстний хувьд гайхах зүйл биш юм. Тэдний өөрсдийнх нь бичвэрт ийм юм болохыг урьдаас хэлсэн байсан. Тухайлбал үндэстэн биш хүмүүсээр (харь үндэстэн) Израилийг **атаархуулж, ухаангүй, шүтээн шүтэгч үндэстнээр уурлуулна** гэж Бурхан анхааруулсан байдаг (Дэд хууль 32:21).

10:20 Эзэнийг хайгаагүй харь үндэстнүүд Түүнийг **олж**, өөрийг нь сураглаагүй **хүмүүст** Тэр **илэрхий болсон** гэдгийг Исаиа хатуухан хэлсэн (Исаиа 65:1). Ерөнхийдөө харь

үндэстнүүд Бурханыг эрэн хайгаагүй. Тэд өөрсдийн шүтээн, хуурамч шашиндаа сэтгэл хангалуун байв. Гэвч харь үндэстний олон хүн сайнмэдээг сонсоод *хүлээж авсан*. Харьцуулбал иудейчүүдээс илүү олон харь үндэстэн сайнмэдээг хүлээж авсан байна.

10:21 Харь үндэстнүүд Ёхова уруу цувж байхад эсрэгээрээ дуулгаваргүй, зөрүүдлэн татгалзах **Израиль** уруу Эзэн бүхэл өдөржингөө **гараа** сунгаж, тэднийг харуулдан зогсож байгаа зураглалыг Исаиа өгчээ.

В. Израилийн ирээдүй үе (11-р бүлэг)

11:1 Израилийн ирээдүй ямар байх вэ? Зарим хүмүүсийн заадагчлан Бурхан Израилиар дамжин ажиллахаа больсон, өнөөдөр чуулган Бурханы Израиль болж, Израильд амласан бүх амлалтууд чуулганд хамаарах болсон гэдэг үнэн үү?⁴³ Ром 11 дүгээр бүлэг энэ үзлийн эсрэг Библид байгаа хамгийн том няцаалт юм.

Паулын энэ яриаг эхлүүлж **“Бурхан өөрийн ард түмнийг бүрмөсөн голсон уу?”** гэж асууж байна. Өөрөөр хэлбэл израиль хүн нэг бүрийг голсон гэж үү хэмээн асууж байгаа юм. **Огт үгүй!** 11:15-д хэлсэнчлэн Бурхан **өөрийн ард түмнээ огоорсон** боловч энэ нь *бүгдийг* нь хаясан хэрэг биш юм. Бүгдийг голоогүй гэдгийн нэгээхэн баталгаа нь Паул өөрөө байв. Паул өөрөө **Абрахамын үр удам, Бениамин овгийн**

израиль хүн байсан. Паул бол иудей хүн гэдэг нь ямар ч маргаангүй үнэн билээ.

11:2 Тиймээс бид ишлэлийн эхний хэсгийг **“Бурхан урьдаас мэдсэн өөрийн ард түмнээ бүгдийг голоогүй”** гэсэн утгатай болохыг ойлгох хэрэгтэй. Энэ нөхцөл байдал Елиагийн үеийнхтэй адил байна. Тэр үед үндэстний дийлэнх хэсэг нь Бурханыг хаяад шүтээнүүд уруу эргэсэн байсан. Нөхцөл байдал маш муу байсан учраас Елиа Израилийн төлөө бус **Израилийн эсрэг** залбирч байв.

11:3 Хүмүүс эш үзүүлэгч нарыг алж хэлэх үгийг нь нугачин дарж байгаа тухай Елиа Бурханд мэдүүлсэн. Тэд Бурханы **тахилын ширээнүүдийг нураан хаясан**. Елиа өөрийгөө Бурханы өмнөөс дуугарч байгаа цорын ганц итгэмжит хүн тул **амь нас нь** ноцтой аюулд орсон гэж бодож байв.

11:4 Гэвч нөхцөл байдал Елиагийн айж байсан шиг харанхуй, найдваргүй байсангүй. Бурхан эш үзүүлэгч Елиад **“Баалд өвдөг сөгдөөгүй долоон мянган хүнийг Би Өөртөө үлдээсэн”** гэж хэлсэн.

11:5 Тэр үеийн нөхцөл байдал өнөөдөр ч гэсэн адил байна. Бурхан Өөрийгөө гэрчлэх хүнийг заавал байлгадаг. Өөрийн **нигүүлслийг** онцгойлон харуулж, өөртөө сонгон авсан итгэмжит үнэнч **үлдэгсдийг** Тэр үргэлж байлгадаг.

11:6 Бурхан энэ үлдэгсдийг **үйлсээс** нь болж биш харин Өөрийн эрх мэдлийн дагуу

нигүүлслээрээ сонгодог. **Нигүүлсэл, үйлс** гэдэг энэ хоёр зарчим бие биетэйгээ зөрчилддөг. Бэлгийг ажил хийж авдаггүй. Үнэгүй юмыг худалдаж авч болдоггүй. Гавьяа байгуулаагүй бол шагнал авдаггүй. Гэвч Бурханы сонголт **үйлсээр** бус **нигүүлслээр** байв. Эс бөгөөс сонгогдох боломж хэнд ч олдохгүй байсан.

11:7 Эндээс дүгнэн үзэхэд **Израиль** Христийн гүйцээсэн ажлаар бус өөрсдийн хичээл зүтгэлээр зөвт байдлыг олох гэж оролдсон тул зөвт байдалд хүрч чадсангүй. Харин Бурханы сонгосон үлдэгсэд Эзэн Есүст итгэх итгэлээр дамжуулан зөвт байдлыг олж авсан. Эцэст нь Израиль үндэстэн шийтгэл гэж хэлж болохуйц харалган байдалд оржээ. Мессиаг хүлээж авахаас татгалзсаны улмаас Түүнийг хүлээн авах боломж, тэмүүлэл нь бүр бага болов.

11:8 Яг үүнийг л Хуучин гэрээнд урьдаас зөгнөн хэлжээ (Исаиа 29:10; Дэд хууль 29:4). **Бурхан** израильчуудыг **гүн нойрны** байдалд нь орхисон тул тэд сүнсний үнэн бодит байдлыг ойлгох чадваргүй болов. Израильчууд Эзэн Есүсийг Аврагч, Мессиа гэж хүлээн авахаас татгалзсан учраас Түүнийг харах чадвараа гээжээ. Израильчууд Бурханы учирлан ярих дуу хоолойг сонсоогүй тул сүнсний хувьд дүлийрцгээжээ. Энэ аймшигт шийтгэл **энэ өдрийг хүртэл** үргэлжилж байна.

11:9 Давид ч бас Израилийн дээр буух Бурханы шийтгэлийг урьдчилан зөгнөсөн.

Давид Дуулал 69:22, 23 дугаар ишлэлд израильчуудын хүлээж аваагүй Аврагчийг Бурхан уруу хашхиран тэдний **ширээг урхи, тор** болгож өгөөч хэмээн гуйж байгаагаар дүрсэлсэн байдаг. Энд гарч байгаа **ширээ** гэдэг үг Христээр дамжин ирэх ерөөл, сайн сайхныг хэлж байна. Ерөөл байх ёстой зүйл нь хараал болон хувирчээ.

11:10 Энд иш татсан Дуулал номын хэсэгт зовлон эдэлж байгаа Аврагч Бурханыг дуудан тэдний **нүдийг харанхуйлуулж**, хүнд хүчир хөдөлмөр ба өндөр насны доройтлоор нурууг нь бөгтөр болгооч (эсвэл ууц нурууг нь салга болгооч) хэмээн гуйж байна.

11:11 Паул энд өөр нэг асуултыг гаргаж ирсэн. **Тэд бүр унахаар бүдэрсэн гэж үү?** Энд бүр гэдгийг *үүрд* гэж ойлговол утга нь илүү тод ойлгогдоно. Өөрөөр хэлбэл тэд нэгмөсөн, хэзээ ч сэргээгдэхгүй унахаар бүдэрсэн гэж үү? Элч Паул ийм санааг бүрэн үгүйсгэсэн. Бурхан тэднийг сэргээхийг зорилгоо болгож байв. Израилийн алдаа зөрчлөөс болж харь үндэстнүүдэд аврал өгөгдөж ингэснээр Израилийн атаархлыг төрүүлэх нь Бурханы зорилго байж. Тэдний **атаархлыг** төрүүлж байгаагийн цаад шалтгаан Израилийг Бурхан уруу авчрахад оршино.

Паул Израилийн унаж, алдсаныг үгүйсгээгүй. Харин ч хүлээн зөвшөөрч байгаагаа энэ ишлэлд хэлсэн: **Тэдний алдаа зөрчлөөс болж харь үндэстнүүдэд аврал**

өгөгдөв. Дараагийнх нь ишлэлд бас ийн илэрхийлсэн: Хэрэв тэдний *хилэнц* нь дэлхийн баялаг болсон бол... гэжээ. Бурхан Израилийг бүрмөсөн хаясан гэсэн санааг Паул хүчтэй эсэргүүцсэн.

11:12 Израиль сайнмэдээнээс татгалзсан учир Бурхан Израиль үндэстнийг хойш тавьж, сайнмэдээ **харь үндэстнүүд** уруу очсон. Тийм учраас тэдний **алдаа зөрчил нь дэлхийн баялаг болж**, алдагдсан зүйл нь харь үндэстнүүдийн олз болжээ.

Хэрэв тийм бол Израилийн сэргэлт нь бүх дэлхийн хувьд **ямар их** баялаг ерөөлийг авчрах бол. Их зовлонгийн ирмэг дээр Израиль Эзэн уруу эргэх үедээ үндэстнүүдэд ерөөлийн суваг болно.

11:13 Энд элч Паул **харь үндэстнүүдэд** хандан хэлж байна (11:13-24). Зарим хүмүүс түүнийг Ромд байсан итгэгч харь үндэстнүүдэд хандан ярьсан гэж боддог боловч энэ хэсгийн утга санаанаас нийт харь үндэстнүүдийг хэлж байгаа нь харагддаг. 11:13-23 дугаар ишлэлд Паул Израилийн талаар үндэстнийх нь хувьд ярьсан төдийгүй бусад **харь үндэстнийг** ч хэсэг хүмүүс гэхээс илүү үндэстнүүдийн тухай өгүүлсэн гэж үзвэл илүү ойлгомжтой болно. Паул Бурханы чуулганы талаар яриагүй. Хэрэв Паул Бурханы чуулганы талаар ярьсан гэж үзвэл чуулган тастагдах боломжтой гэсэн дүгнэлтийг эндээс хийж болохоор байна (11:22).

Гэтэл ийм ойлголт Библийн сургаалтай зөрчилдөж байгаа юм.

Паул харь үндэстнүүдийн элч байсан учраас харь үндэстнүүдэд ийм илэн далангүй, нээлттэй ярих нь түүний хувьд энгийн зүйл байсан. Ингэх нь **үйлчлэлээ** л биелүүлж байгаа хэрэг байв.

11:14 Паул нутгийнхаа **хүмүүсийн атаархлыг төрүүлэхийг** бүхий л талаар хичээж байсан нь **заримыг нь аврахын тулд** байв. Паул өөрөө хэнийг ч аварч чадахгүй гэдгээ мэддэг байсан. Бид ч бас мэднэ. Гэвч авралын Бурхан зарц нартаа маш ойр дотно учир зөвхөн Өөрийнхөө хийж чадах зүйлсийг зарц нар нь хийх юм шиг ярихыг зөвшөөрдөг.

11:15 Энэ ишлэл 11:12-т яригдсаныг өөр байдлаар дахин хөндсөн. Бурханы сонгосон, дэлхий дээрх ард түмэн болох Израиль хойш тавигдсан үед харь үндэстнүүд Бурханы өмнө давуу байр суурин дээр ирсэн буюу нэг ёсондоо Бурхантай эвлэрсэн. Харин Христийн мянган жилийн хаанчлалын үед Израиль сэргээгдэхэд дэлхийн сэргэн мандал, амилал мэт байх болно.

Иона Израиль үндэстнийг бэлгэддэг учраас үүнийг Ионад тохиолдсон явдлаар дүрсэлж болно. Шуурга болж Иона хөлөг онгоцноос хаягдахад үр дүнд нь хөлөг онгоцон дээр байсан харь үндэстнүүд аврагдсан. Дараа нь Иона эвлэрч, Ниневе хотынхонд номлоход харь үндэстний хот бүхлээрээ аврагддаг. Үүний адил Бурхан Израилийг хэсэгхэн хугацаанд

орхисноос болж хэсэг бүлэг харь үндэстэн сайнмэдээг хүлээн авчээ. Харин Израиль сэргээгдэх үед харь үндэстнүүд үй түмээрээ Бурханы хаанчлалд орох болно.

11:16 Паул энд хоёр зүйрлэлийг хэрэглэдэг. Нэг дэх зүйрлэл нь **дээж** ба **үлдсэн бүхэл**. Хоёр дахь зүйрлэл нь **үндэс** ба **мөчир**. Гэвч **дээж** ба **үлдсэн бүхэл** гэдэг нь үр жимсний тухай бус, зуурсан гурилын тухай ярьсан. Багахан хэмжээний зуурсан гурилыг идээн өргөл болгож Эзэнд ариусгадаг байсныг бид Тооллого 15:19-21 дүгээр ишлэлээс харж болно. Хэсэгхэн гурилыг авч зуураад Эзэнд зориулан өргөвөл үлдсэн гурил нь бүхлээрээ Эзэнд зориулагдсанд тооцдог байжээ.

Энэ жишээнээс бодоход Абрахам бол **дээж** юм. Абрахамыг Бурхан тусгаарлан сонгож авсан учраас **ариун** хүн байсан. Хэрэв **дээж** болох Абрахам ариун юм бол түүний адил сонгогдсон үр удам нь ч бас ариун билээ. Абрахамын үр удам нь Бурханы өмнө давуу эрх эдлэхээр тусгаарлагджээ.

Хоёр дахь зүйрлэл нь **үндэс** ба **мөчир**. Хэрэв **үндсийг** нь сонгогдсон бол мөчрүүд нь ч бас сонгогдсон. Бусад үндэстнээс ялгарах шинэ нийгэм бий болгохын тулд Бурхан Абрахамыг анхлан сонгосон тул тэрбээр **үндэс** юм. Хэрэв Абрахам тусгаарлагдсан юм бол, түүний араас замнагч бүх удам угсаа нь тусгаарлагдсан болно.

11:17 Элч Паул **үндэс** ба **мөчрийн** тухай зүйрлэлээ үргэлжлүүлж байна.

Тастагдсан мөчир гэдэг нь Израилийн арван хоёр овгийн үл итгэгч хэсгийг илэрхийлдэг. Тэд Мессиаг хүлээн авахаас татгалзсан тул Бурханы сонгогдсон ард түмэн байх онцгой эрхээ алджээ. Гэвч **хэсэг мөчир** л тастагдсан ажээ. Паул хийгээд Израилийн үлдэгсэд Эзэнийг хүлээн авсан юм.

Зэрлэг чидуны мод гэдгээр харь үндэстнүүдийг хэлж байна. Энд олон үндэстнийг нэг юм шиг төлөөлүүлэн авч үзсэн. Зэрлэг чидуны мөчир болох харь үндэстний хүн чидун модонд **залгагджээ**.

Ийнхүү харь үндэстнүүд **чидун модны үндэсний шимээс хүртэгч** болжээ. Хамгийн анх Израильд өгөгдөж, одоо Израилийн итгэгч үлдэгсдийн хүртэж байгаа тааллыг харь үндэстнүүд хуваалцаж байна.

Энэ дүрслэлээс **чидун модны** их бие нь *Израиль биш* байгааг харах нь чухал. Чидун модны их бие нь Бурханы олгодог *онцгой эрхийн* зуун зууныг дамнасан гинжин холбоо юм. Хэрэв их бие нь Израиль байсан бол Израиль нь Израилиас тастагдаад, дараа нь эргээд Израильд залгагдаж байгаа утгагүй зураглалыг та харах байсан биз ээ.

Түүнээс гадна **зэрлэг чидун** гэдэг нь *чуулганыг* бус харь үндэстнүүдийг нийтэд нь хэлж байгааг мартаж болохгүй. Эс бөгөөс жинхэнэ итгэгч Бурханы тааллаас тастагдах боломжтой гэсэн утга санаа эндээс урган гардаг.

Гэвч ийм боломж байхгүй гэдгийг Паул аль хэдийнээ дурдсан билээ (Ром 8:38,39).

Тэгвэл их бие нь зуун зууныг дамнасан “онцгой эрхийн гинжин холбоо” гэж юу гэсэн үг вэ? Бурхан Өөртэйгөө ойр дотно байх онцгой газарт байлгахаар тодорхой хүмүүсийг тусгайлан сонгохоор шийджээ. Тэр хүмүүс дэлхийн бусад хүнээс тусгаарлагдан онцгой давуу эрхтэй болдог байна. “Тааллыг олсон үндэстэн” гэж нэрлэж болох тусгай байр суурь тэдэнд өгөгддөг. Түүхийн янз бүрийн цаг үед Бурхан зарим хүмүүсийг ийнхүү тусгаарлаж, тусгай тойрогт оруулдаг байв.

Давуу эрхийн энэ гинжин холбоонд хамгийн анх Израиль хэмээх үндэстнийг оруулжээ. Израиль бол энэ дэлхийгээс өнө эрт сонгогдсон Бурханы ард түмэн билээ. Гэвч тэд Мессиаг хүлээн авахаас татгалзсан тул түүнээс **хэсэг мөчир тасгагдаж** “тааллыг олсон” хүү байх байр сууриа алдав. Харин харь үндэстнүүд чидун модонд **залгагдаж**, итгэгч иудейчүүдийн хамтаар **үндэсний шимээс хүртэгч** болжээ.

Үндэс гэдэг нь давуу эрхийн гинжин холбоог эхлүүлсэн Абрахамыг зааж байна. Чидун модны **шим** гэдэг нь чидун модны өгөөж буюу чидун жимс ба тосыг хэлж байна. **Шим** гэдэг нь чидун модтой холбогдох үед урсан ирдэг ивээл ерөөлийг илтгэж байна.

11:18 Гэхдээ харь үндэстнүүд иудейчүүдийг дорд үзэж болохгүй. Бас өөрсдийгөө тэднээс илүү хэмээн **сайрхаж** болохгүй. Онцгой эрхийн

гинжин холбоог харь үндэстнүүд үүсгээгүй гэдгийг санах хэрэгтэй. Бурханы тааллыг хүртээдэг онцгой эрхийн гинжин холбоонд тэд анхнаасаа байсан юм биш, харин залгагдсан билээ.

11:19 Захиаг нь унших харь үндэстэн хүн, **“Намайг болон бусад харь үндэстэн мөчрүүдийг залгуулахын тулд иудей мөчрүүд тастагдсан шүү дээ” гэж хэлнэ** дээ хэмээн Паул бичжээ.

11:20 Энэ үг нэг талаараа үнэн гэдгийг элч Паул хүлээн зөвшөөрсөн. Иудей мөчрүүд **тастагдаж**, харь үндэстнүүд залгагдсан нь үнэн. Гэхдээ энэ нь Израилийн **итгэлгүйгээс** болсон болохоос, харь үндэстнүүд иудейчүүдээс илүү тааллыг олсон учраас биш юм. Харь үндэстнүүд **итгэлээр** зогссон. **Та итгэлээр зогсож байна** гэснийг үзвэл, элч Паул энд жинхэнэ итгэгч нарын тухай ярьж байгаа мэт. Гэхдээ тийм утгатай байх албагүй. Паул харь үндэстнүүдийг иудейчүүдтэй харьцуулаад, иудейчүүдээс илүү итгэлтэй байгааг ингэж хэлсэн. Ромын зуутын даргад Есүс “Би Израильд хүртэл ийм агуу итгэлийг олоогүй” (Лук 7:9) гэсэн. Хожим нь бас Паул, Ромын иудейчүүдэд “Бурханы аврал харь үндэстнүүд уруу очиж байна. Тэд ч үүнийг сонсоно гэдгийг та нар мэдтүгэй!” (Үйлс 28:28) гэсэн байдаг. “Тэд үүнийг сонсоно” гэснийг та анзаарах хэрэгтэй. Өнөөдөр харь үндэстнүүд ер нь сайнмэдээг хүлээн авах тал дээр Израилиас илүү байгаа. Энд хэлсэн **зогсох** гэдэг үг *унах*

гэдгийн эсрэг нь. Израиль онцгой эрхээсээ салж унасан. Харин харь үндэстнүүд түүнд нь залгагдсан.

Гэвч зогсож байгаа нь унахаас болгоомжлох хэрэгтэй. Харь үндэстнүүд бардамнахын оронд **эмээсэн** нь дээр.

11:21 Хэрэв Бурхан төрөлх мөчрүүдийг тастаж чадсан юм бол тэднийг тастсан үндэслэлээр зэрлэг чидуны залгамал мөчрүүдийг **хэлтрүүлэхгүй** байх нь ойлгомжтой.

11:22 Тэгэхээр чидун модны тухай энэхүү сургаалт зүйрлэлээс бид Бурханд буй эсрэг тэсрэг хоёр зан чанарыг харж байна. Тэр нь Түүний **энэрэл хийгээд хатуурхал**. Тааллыг хүртсэн үндэстэн хэмээх байр сууриас Израилийг холдуулсан нь Түүний **хатуурхлыг** харуулдаг. Харин сайнмэдээгээр харь үндэстнүүд уруу эргэсэн нь Түүний **энэрэл** юм (Үйлс 13:46; 18:6-г үз). Гэхдээ Түүний энэрлийг байдаг л зүйл гэж үзэж болохгүй. Эзэн Есүсийг дэлхий дээр үйлчилж байхад зарим харь үндэстэн шиг нээлттэй байхгүй л бол харь үндэстнүүд ч гэсэн **тастагдах** болно (Матай 8:10; Лук 7:9).

Паул энд чуулган болон итгэгч хүний тухай яриагүй гэдгийг бүү мартаарай. Тэр энд нийт харь үндэстний тухай ярьсан. Христийн биеийг Тэргүүнээс нь юу ч салгаж чадахгүй. Итгэгч хүнийг Бурханы хайраас юу ч салгаж чадахгүй. Харин харь үндэстнүүд одоо хүртсэн байгаа

онцгой эрхийн байр сууринаасаа унах боломжтой.

11:23 Гэхдээ Израильд хандсан хатуу байдал үүрдийн юм биш ээ. **Хэрэв тэд итгэлгүй байдлаа** орхивол Бурхан тэднийг онцгой эрхийн байр сууринд нь тавихгүй байх ямар ч шалтгаан үлдэхгүй. Бурхан тэгэх бүрэн чадалтай.

11:24 Онцгой эрхийн тэр байр сууринд Израилийг дахин суулгах нь Бурханы хувьд харь үндэстнүүдийг тавихаас илүү хялбар ажил юм. Израилийн ард түмэн Бурханы тааллын модонд анхны мөчрүүд байсан учраас тэднийг **төрөлх мөчрүүд** гэж нэрлэдэг. Харь үндэстэн болох мөчрүүд **зэрлэг** чидун модноос ирсэн. **Зэрлэг** чидуны мөчрийг **таримал чидуны модонд** залгах нь **чанарынх нь эсрэг** зүйл гэж Паул хэлсэн. Харин байгалийн мөчрүүдийг анхны **таримал чидуны модонд** залгах нь байгалийн жамаар ургах мөчрүүдийг залгасан үйл явц мөн.

11:25 Эдүгээ элч Паул Израилийн ирээдүйн сэргэлтийг болж магадгүй зүйл биш, гарцаагүй болох үйл явдал хэмээн илчилж байна. Паулын илчилж байгаа зүйл бол **нууц** ажээ. Нууц гэдэг нь тухайн цаг үеийг хүртэл далд байсан, хүний ухаанаар мэдэх боломжгүй, тухайн цагт ил болж байгаа үнэн юм. Харь үндэстний итгэгч нарыг **өөрөө өөртөө ухаалаг болж**, иудейчүүдийн өөдөөс хамраа сөхөх вий

гэсэндээ Паул энэ нууцыг дэлгэн тавьжээ. Энэ нууц нь юу гэвэл:

Израилийн хэсэг нь хатуурчээ. Гэхдээ бүх Израиль биш, харин үл итгэгч хэсэг нь.

Тэрхүү хатуурал түр зуурынх бөгөөд **харийнхан дүүрэн орох хүртэл** үргэлжилнэ. **Харийнхний дүүрэл** гэж чуулганы хамгийн сүүлчийн итгэгч аврагдаж, Христийн бие бүрдэж, тэнгэр дэх гэр өөдөө шүүрэн авагдах үеийг хэлж байна. **Харийнхний дүүрэл** нь “харь үндэстнүүдийн цаг” (Лук 21:24) гэдгээс ялгаатай. **Харийнхний дүүрэл** ба шүүрэлт нэг зэрэг болно. Харин “харь үндэстнүүдийн цаг” бол Вавилоны цөллөгөөс эхлээд (2Шастир 36:1-21) Христийг газар дэлхий дээр ноёрхлоо тогтоохоор ирэх хүртэлх хугацаанд харь үндэстнүүд иудейчүүдийг эзэгнэх бүх үеийг хамарна.

11:26 Израилийн хатуу харалган сэтгэл өргөгдлийн үед авагдана. Гэхдээ хамаг Израиль тэр даруй аврагдана гэсэн үг биш. Иудейчүүд их зовлонгийн үед хэсэг бүлгээрээ аврагдах боловч Христ газар дэлхийд хаадын Хаан, эздийн Эзэн болж эргэн ирэх хүртэл сонгогдсон үлдэгсэд бүгд нэгэн зэрэг аврагдахгүй.

Бүх Израиль аврагдана гэж Паулын хэлсэн үг **бүх итгэгч Израиль** гэсэн утгатай. Израиль үндэстний үл итгэгч хэсэг нь Христийн хоёр дахь ирэлтээр сүйрнэ (Зехариа 13:8,9). “Эзэний нэрээр ирэгч ерөөлтэй еэ!” гэж хэлэгч нар л аврагдаж, хаанчлалд орно.

Золигч **Сионд** ирж, **Иаковоос** нүгэл хилэнцийг зайлуулна (Исаиа 59:20) гэсэн Исаиагийн үг энэ тухай байжээ. Христ Бетлехемд бус, Сионд ирнэ гэснийг анхаарах хэрэгтэй. Тэгэхээр энэ нь Христийн хоёр дахь ирэлт мөн.

11:27 Түүнээс гадна, Исаиа 27:9 ба Иеремиа 31:33, 34-т хэлэхдээ, Бурхан израильчуудтай **Шинэ гэрээ** байгуулж, нүглүүдийг нь зайлуулна гэжээ.

11:28 Тэгэхээр Израилийн өнөөгийн байдлыг хоёр талтай дүгнэж болно. Нэгт гэвэл, **сайнмэдээний талаас, тэд бидний улмаас дайснууд.** Тэд тастагдаж, холдуулагдаж, Бурханы хувьд харийнх болж, оронд нь сайнмэдээ харь үндэстнүүд уруу хүрсэн гэдэг утгаараа бол **тэд дайснууд** юм.

Гэхдээ энэ ердөө зургийн хагас нь. **Сонголтын талаас, тэд эцгүүдийн улмаас хайрлагдагсад** юм. Эцгүүд нь Абрахам, Исаак, Иаков билээ.

11:29 Бурханы бэлгүүд ба дуудлага нь хэзээ ч эргэж буцдаггүй учраас тэд одоо ч гэсэн хайрлагдсаар байна. Бурхан бэлгүүдээ буцааж авдаггүй. Тэрээр болзолгүй амлалт өгсөн л бол хэлсэн амнаасаа буцахгүй. Тэрээр Израильд онцгой эрхүүдийг өгсөн. Тэдгээрийг 9:4,5 дээр жагсаасан. Бурхан Израилийг газар дэлхийн ард түмнээ байлгахаар дуудаж (Исаиа 48:12), бусад үндэстнүүдээс тусгаарласан. Түүний зорилгуудыг юу ч өөрчилж чадахгүй.

11:30 Харь үндэстнүүд урьд өмнө дур зоргоороо, дуулгаваргүй хүмүүс байсан боловч Израиль Мессиа болон авралын сайнмэдээнээс татгалзах үед Бурхан өршөөлөө харь үндэстнүүдэд хандуулжээ.

11:31 Ирээдүй зарим талаараа үүнтэй ижил өрнөнө. Израиль дуулгаваргүй байснаа харь үндэстнүүдэд үзүүлсэн өршөөлийн улмаас атаархалд өдөөгдөх үед Бурхан тэдэнд өршөөл үзүүлэх болно. Зарим хүмүүс үүнийг, харь үндэстнүүд иудейчүүдэд өршөөл үзүүлснээр тэд сэргээгдэнэ гэсэн утгатай гэж заадаг. Гэхдээ тийм биш гэдгийг бид мэднэ. Израиль Эзэн Есүсийн хоёр дахь ирэлтээр сэргээгдэнэ (11:26,27-г үз).

11:32 Энэ ишлэлийг эхлээд уншихад, иудейчүүд ба харь үндэстнүүдийг Бурхан хүчээр итгэлгүй болгосон болохоор тэд юу ч хийж чадахгүй мэт санагддаг. Гэхдээ ийм утга биш. Итгэхгүй байх нь тэдний өөрсдийнх нь ажил юм. Энэ ишлэл юу хэлж байна вэ гэвэл: иудейчүүд болон харь үндэстнүүд аль аль нь угаасаа дуулгаваргүй байгааг Бурхан хараад тэр нөхцөлд нь хорьж зөвхөн Бурханы арга замаар л тэр нөхцөлөөс мултрах боломжтой болгосон гэж байна.

Энэ дуулгаваргүйдэл иудейчүүд ба харь үндэстнүүдийн аль алинд, бүгдэд өршөөл үзүүлэх боломжийг Бурханд олгожээ. Бүх хүн аврагддаг гэсэн ямар ч санаа энд байхгүй. Бурхан харь үндэстнүүдэд төдийгүй

иудейчүүдэд **өршөөл үзүүлж** байгаа боловч бүх хүн аврагдана гэсэн үг биш ээ. Энд яригдаж байгаа **өршөөл** нь хувь хүмүүсийн тухайд бус, үндэстний тухайд юм. Жорж Уилльяамс энэ тухай ийн хэлжээ:

Бурхан иудей болоод харь үндэстнүүдийн аль алийг нь шалган туршжээ. Даанч аль аль нь шалгалтад бүдэрсэн байна. Тийм болохоор тэднийг үл итгэл дотор түгжээд тэдний хийж чадах ямар ч гавьяа байхгүй, Бурханы тааллыг авах аливаа нэхэмжлэл, бүх эрхээ алдсаныг тодорхой харуулсны дараа Бурхан нигүүлслийнхээ яндашгүй баялгаасаа бүгдийн дээр өршөөл үзүүлсэн юм.⁴⁴

11:33 Эцэст нь хэлсэн энэхүү ерөөлийн үг захидлыг бүхэлд нь эргэн харж, тэнд өгүүлсэн Бурханы гайхамшгуудыг магтжээ. Шударга Бурхан шударга байдлаа сэвтээхгүйгээр нүгэлтнийг авардаг авралын гайхамшигт төлөвлөгөөг Паул тайлбарласан. Мөн, Христийн ажил Бурханд илүү их алдрыг авчирч, нүглээсээ болж Адамын алдсан ерөөлөөс бүр ч илүү их ерөөлийг хүмүүст хүртээдгийг учирласан. Түүнээс гадна, нигүүлсэл нь ариун амьдралыг бий болгодог бөгөөд хууль ийм үр дүн авчирч чадахгүй гэдгийг хэлсэн. Цааш нь тэрээр, Бурханы урьдаас мэдэх мэдлэгээс улбаатай зорилгын тасаршгүй гинжин холбоог даган

явсаар эцэст нь Бурхан алдаршихыг харуулсан. Бас, Бурханы эрх мэдэлт сонголт хийгээд хүний хариуцлагын тухай сургаалыг заасан. Эцэст нь, Израиль болон бусад үндэстнүүдэд үе үеэр (диспенсациар) хэрэгжүүлж буй Бурханы хөтөлбөр хэчнээн шударга бөгөөд уялдаатай болохыг баталсан. Одоо харин магтаал, хүндлэлийг өргөхөөс өөр зохистой зүйл үлдсэнгүй.

Аяа, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн баялаг нь ямар гүн гүнзгий вэ!

Бурханы баялаг-Тэрээр өршөөл, хайр, нигүүлсэл, итгэмж, хүч, сайн сайхнаар баян.

Бурханы мэргэн ухаан-Хэмжээ хязгааргүй, ухаарч баршгүй, юутай ч харьцуулшгүй, мөхөж усташгүй мэргэн ухаан Түүнд бий.

Бурханы мэдлэг-Артур В. Пинк энэ тухайд: “Бурхан бол бүхнийг мэдэгч. Үйл явдлын боломжит бүх хувилбар ба болчихсон бодит байдлыг бүгдийг мэднэ. Өнгөрсөн, одоо, ирээдүйн бүх үйл явдал, бүх бүтээлийг тэр мэднэ”⁴⁵ гэсэн байдаг.

Түүний шийдвэрүүд олж илрүүлшгүй. Тэднийг махбодын ухаанаар бүрэн ойлгохын аргагүй дэндүү гүн гүнзгий. Орчлон ертөнцийг бүтээж, түүхийг туурвиж, авралыг гүйцэлдүүлж, бүтээлээ удирдан ажиллуулж байгаа замуудыг ойлгож ухаарахад бидний оюуны цар хүрээ хүрэхгүй.

11:34 Бүтээгдсэн аливаа зүйл Бурханы илчилж ойлгуулснаас цааш **Эзэний оюун**

ухааныг мэдэж чадахгүй. Бид толинд бүдэг бадаг л хардаг (1Коринт 13:12). Бурханд зөвлөгөө өгч чадах хэн ч байхгүй. Түүнд бидний зөвлөгөө ямар ч хэрэггүй (Исаиа 40:13).

11:35 Бурхан хэнд ч өргүй (Иов 41:11). Бидний өргөлүүдийн аль нь ч Мөнх Бурханыг өрөнд оруулахгүй.

11:36 Төгс хүчит Бурхан бүхнээс ангид Өөрөө Өөрөөрөө оршдог. Тэрээр сайн бүхний эх сурвалж мөн. Тэрээр орчлон ертөнцийг идэвхтэйгээр тэтгэж, удирддаг бөгөөд бүтээгдсэн бүгд Түүнд зориулагдах ёстой. Бүх зүйл Түүнд **алдрыг** авчрах зорилгоор бүтээгджээ.

Тэр зорилго биелэх болно. **Түүнд алдар нь үүрд байх болтугай! Амен.**

III. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА: САЙНМЭДЭЭ БОДИТ АМЬДРАЛ ДЭЭР (12-16 дугаар бүлэг)

Ром номын үлдсэн хэсэг нь “Нигүүлслээр зөвтгөгдсөн хүмүүс өдөр тутмын амьдралд хэрхэн хандах ёстой вэ?” гэдэг асуултад хариулна. Паул биднийг бусад итгэгч нарт, нийгэмд, дайснууддаа, төр засагт, сул дорой ах дүү нартаа хэрхэн хандах ёстойг энд дурджээ.

А. Хувь хүний ариусал (12:1, 2)

12:1 1-11 дүгээр бүлэгт өгүүлсэн **Бурханы өршөөлийн** тухай нухацтай авч үзэж, сайтар бодсон хүн ганц л дүгнэлтэд хүрнэ. Тэр бол, **өөрсдийн биеийг Бурханд тааламжит, амьд, ариун тахил болгон өргөх. Бие** бол бүх эрхтнийг илэрхийлдэг. Цаашлаад бүх амьдралыг төлөөлдөг.

Бүхнээ зориулах нь бидний **сүнслэг мөргөл** юм. **“Сүнслэг мөргөл”** гэдгийг зохистой үйлчлэл гэж бас орчуулж болно. Бурханы Хүү миний төлөө үхсэн. Тэгэхээр би ядаж Түүний төлөө амьдрах нь зүйтэй. Энэ бол зохистой үйлчлэл юм. Британийн агуу тамирчин Ч.Т.Стад: “Хэрэв Есүс Христ Бурхан юм бол, тэгээд болоогүй миний төлөө үхсэн юм бол, Түүний төлөө ямар ч золиос дэндүү их гэсэн ойлголт байхгүй”⁴⁶ гэж хэлжээ. Исаак Уаттсын зохиосон магтан дуунд бас үүнтэй ижил зүйл хэлсэн байдаг. Үүнд: “Түүний хайр дэндүү гайхалтай, үнэхээр тэнгэрлэг учраас бүх зүрх, бүх амьдрал, бүхнийг минь шаардана.”

Сүнслэг мөргөл гэдэг утгаар нь авч үзвэл итгэгч бид тахилч нар билээ. Гэхдээ бид нядлуулсан амьтан биш, харин амьдралаа зориулсан сүнслэг тахил болж Бурхан дээр ирдэг. Мөн бид Түүнд өөрсдийн үйлчлэл (Ром 15:16), өөрсдийн магтаал (Еврей 13:15), өөрсдийн эд хөрөнгийг өргөдөг (Еврей 13:16).

12:2 Хоёрдугаарт, Паул биднийг **энэ** ертөнцийн **явдалд бүү нийцэгтүн** гэж ятгаж байна. Филипп үүнийг арай өөрөөр илэрхийлж, дараах үгээр хэлсэн: “Энэ ертөнц та нарыг өөрийнхөө хэвэнд оруулан шахахыг бүү зөвшөөр.” Бид Бурханы хаанчлалд орохдоо, энэ ертөнцийн үзэл санаа, амьдрах хэв маягаас татгалзах хэрэгтэй болдог.

Энэ ертөнц (үгчилбэл: **энэ үе**) гэдэг нь Бурхангүйгээр өөрийгөө аз жаргалтай амьдруулахаар хүмүүсийн бүтээсэн нийгэм, тогтолцоо гэсэн утгаар энд хэрэглэгдэж байна. Энэ ертөнц бол Бурханыг эсэргүүцэгч хаанчлал юм. Энэ ертөнцийн бурхан ба захирагч нь Сатан (2Коринт 4:4; Иохан 12:31; 14:30; 16:11). Аврагдаагүй хүмүүс бүгдээрээ түүний албатууд. Тэрээр хүмүүсийг өөртөө тогтоон барьж байхын тулд нүдний хүсэл тачаал, махбодын хүсэл тачаал, амьдралын бардамналыг ашигладаг (1Иохан 2:16). Энэ ертөнц өөрийн гэсэн улс төр, урлаг соёл, дуу хөгжим, шашин, зугаа цэнгэл, үзэл суртал, амьдралын хэв маягтай бөгөөд өөрийнх нь соёл заншилд таарч нийцэхийг хүн бүрээс нэхдэг. Тэгээд нийцэхгүй байгаа хүмүүсийг үзэн яддаг. Христ болон дагалдагчдыг үзэн ядах шалтгаан энэ юм.

Бидний **энэ** ертөнцөөс чөлөөлөхийн тулд Христ үхсэн. Ертөнц бидний хувьд цовдлогдож, бид ертөнцийн хувьд цовдлогджээ. Итгэгч хүн энэ ертөнцийг хайрлах нь Эзэнээс урваж

байгаагаас ялгаагүй. Энэ ертөнцийг хайрладаг бүхэн Бурханы дайсан мөн.

Христ энэ ертөнцийнх биш, үүн шиг итгэгч нар ч бас энэ ертөнцийнх биш билээ. Гэхдээ тэд энэ ертөнцийн ажил үйлсийн бузар мууг гэрчилж, Эзэн Есүс Христэд итгэлээ өгсөн бүхэн аврагдах боломжтойг тунхаглахаар энэ ертөнц уруу илгээгдсэн юм. Бид энэ ертөнцөөс тусгаарлагдаад зогсохгүй, **оюун санааныхаа шинэтгэлээр өөрчлөгдөх** ёстой. Нэг ёсондоо, Библид илчилсний дагуу, Бурханы бодлын дагуу боддог болох хэрэгтэй гэсэн үг. Тэгвээс, амьдралдаа Бурханы шууд чиглүүлгийг амсах болно. Тэгээд Түүний хүсэл нь тааламжгүй, хатуу хахир биш, харин **сайн, тааламжит, төгс төгөлдөр** гэдгийг мэдэх болно.

Тэгэхээр, Бурханы хүслийг мэдэхэд зориулж гурван түлхүүрийг энд өгчээ. Нэгт, биеэ өргөх. Хоёрт, амьдралаа энэ ертөнцөөс тусгаарлах. Гуравт, оюун санаагаа шинэчлэх.

Б. Сүнслэг бэлгүүдийн үйлчлэл (12:3-8)

12:3 Паул Эзэн Есүсийн элчийн хувьд өөрт нь **соёрхогдсон нигүүлслээр** энд ярьж байна. Тэрээр зарим буруу зөрүү бодлуудыг залруулахын тулд, бичиж байна.

Юуны түрүүнд, сайнмэдээнд хэн нэгнийг нөгөөгөөс нь илүүд тавьсан зүйл байхгүй гэдгийг хэлж байна. Тэгээд, авсан бэлгүүдээ ашиглахдаа даруу байхыг биднийг ятгажээ. Бид

өөрсдийгөө дөвийлгөн бодож огт болохгүй. Бас бусдад атаархах ч хэрэггүй. Харин, хүн бүр нэгнээсээ ялгаатай бөгөөд Эзэнийхээ төлөө хийх үүрэг хүн бүрд бий гэж бодох ёстой. Христийн бие дотор **Бурхан** бидэнд ямар байр суурь **ногдуулсан** байна, түүнд баярлаж, Бурханы өгч буй бүх хүчээр авсан бэлгээ ашиглахыг хичээх хэрэгтэй.

12:4 Хүний **бие** олон **эрхтэнтэй** бөгөөд эрхтэн тус бүр өөрийн өөрийн үүрэгтэй байдаг. Эрхтэн бүр үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байвал хүний бие эрүүл саруул байна.

12:5 **Христийн бие** ч бас үүнтэй адил. Христийн биед нэгдмэл байдал (**нэг бие**), ялгаа (**олуулаа**), харилцан хамаарал (**нэг нэгэндээ эрхтэн**) байдаг. Бидэнд өгөгдсөн бэлгүүд нь хувийн ашиг сонирхлыг хангахын тулд бус, харин Христийн **биеийн** тусын тулд байдаг. Дангаараа хангалттай бэлэг гэж үгүй. Мөн ямар ч хэрэггүй бэлэг гэж байхгүй. Үүнийг ойлговол, бид эрүүл ухаанаар бодох болно (12:3).

12:6 Паул одоо энд зарим **бэлгүүдийг** ашиглах заавар өгч байна. Энэ жагсаалтад бүх бэлэг багтаагүй. Энд бүгдийг жагсаан бичээгүй, харин жишээ байдлаар дурдсан болно.

Бидний **бэлгүүд бидэнд өгөгдсөн нигүүлслийн дагуу** бие биенээсээ ялгаатай. Өөрөөр хэлбэл, янз бүрийн хүмүүст янз бүрийн **бэлгүүдийг** өгөх нь Бурханы **нигүүлслээс** улбаатай ажээ. Бурханд ямар бэлэг байлаа ч, түүнийг ашиглахад шаардлагатай хүч ба

чадварыг Бурхан өгдөг. Тиймээс бид Бурханы өгсөн чадваруудыг сайн нярвын ёсоор ашиглах үүрэгтэй.

Эш үзүүлэгийн бэлэгтэй хүн нь **итгэлийнхээ дагуу эш үзүүлэх** хэрэгтэй. Эш үзүүлэгч бол Бурханы төлөөнөө яригч, Эзэний үгийг тунхаглагч юм. Түүнд нь зөгнөх чадвар багтсан байж болох юм. Гэхдээ эш үзүүлэгийн энэ чанар шаардлагагүй болсон. Ходж энэ тухайд: “Чуулганы эхэн үед эш үзүүлэгч нар Бурханы Сүнсний шууд нөлөөн дор сургаал, одоогийн үүрэг, ирээдүйн үйл явдалд холбоотой Бурханы хүслийг мэдүүлдэг хүмүүс байсан”⁴⁷ гэж бичжээ. Тэдний үйлчлэл бидний төлөө Шинэ гэрээнд хадгалагдан үлджээ. Өнөөдөр, христитгэлийн сургаал бүхлээрээ ариун хүмүүсийн гар дээр бүрэн бүтэн ирчихсэн, ариун хүмүүст итгэл нэгэнт бүрмөсөн тушаагдчихсан (Иуда 3) болохоор түүн дээр шинэ зүйл нэмэх ямар нэгэн эш үзүүлэгч байх боломжгүй юм. Тэгэхээр энэ үеийн эш үзүүлэгч нар бол Библид илчилсэн Бурханы бодол санааг тунхаглагч хүмүүс юм. Түүнээс илүү зүйл биш. Стронг энэ талаар дараах тайлбарыг хийжээ:

“Орчин үеийн үнэн зөв эш үзүүлэгч бүгдээрээ Христийн мэдээг дахин нийтэлж байгаатай адил бөгөөд бичвэрт нэгэнтээ илчилчихсэн сургаалыг тунхаглах, тайлбарлахыг хэлнэ.”⁴⁸

Эш үзүүлэгийн бэлэгтэй хүн нь бидний **итгэлийн дагуу эш үзүүлэх** хэрэгтэй. Энэ нь “итгэлийн хэм хэмжээний дагуу” гэсэн утгатай байж болно. Нэг ёсондоо, Библид зааж буй христитгэлийн сургаалын дагуу гэсэн үг. Эсвэл энэ нь “бидний итгэлийн хэр хэмжээний дагуу” гэсэн утгатай байж болно. Өөрөөр хэлбэл, Бурханы бидэнд өгсөн итгэлийн хэмжээгээр гэсэн үг. Ихэнх орчуулгад “бидний” буюу “итгэлийнхээ” гэх утга энд байдаг ч эх дээрээ байдаггүй.⁴⁹

12:7 Үйлчлэл гэж Эзэнд үйлчлэх гэсэн утгатай бөгөөд маш өргөн хүрээг хамарна. Энэ нь (өнөөгийн нийтлэг ойлголт шиг), санваартан хүний алба, үүрэг, ажил биш. **Үйлчлэлийн** бэлэгтэй хүнд зарцын зүрх сэтгэл байдаг. Тэрээр үйлчлэх боломж бүрийг алдалгүй ашигладаг.

Багш сургагч бол Бурханы үгийг тайлбарлах, сонсогч нарынхаа зүрхэнд хүргэх чадвартай хүн юм. Бид ямар ч бэлэгтэй байсан, хамгийн гол нь түүнийгээ хамаг сэтгэлээсээ хийх хэрэгтэй.

12:8 Ятгах гэдэг нь ариун хүмүүсийг бузар муугийн алив хэлбэрээс холдуулж, ариун байдал ба үйлчлэлдээ Христийн төлөө шинэ түвшинд хүргэх бэлэг юм.

Өгөх гэдэг нь хүний хэрэгцээг мэдэрч, туслах сэтгэл ба хүчийг өгдөг Бурханы соёрхол юм. Тийм бэлэгтэй хүн түүнийгээ **өгөөмрөөр** хийх хэрэгтэй.

Удирдах бэлэг нь нутгийн чуулганы ахлагч, үйлчлэгч нарын ажилтай холбоотой болов уу. Ахлагч гэдэг нь сүргийнхээ урд зогсоод, тэднийгээ халамж анхаарал, **хичээнгүй зүтгэлээр** удирддаг туслах хоньчин юм.

Өршөөл үзүүлэх бэлэг нь зовлонд байгаа хүмүүст туслах ер бусын чадвар чадамж. Ийм бэлэгтэй хүмүүс үүнийгээ **баяртайгаар** хийх ёстой. Мэдээж хэрэг бид бүгдээрээ баяртайгаар өршөөл үзүүлэх хэрэгтэй.

Христитгэгч нэгэн эмэгтэйн ярьсныг энд сийрүүлье: “Ээж минь өндөр настай болж, асарч халамжлах хүн хэрэгтэй болоход нөхөр бид хоёр түүнийг гэртээ байлгах болсон юм. Ээжийгээ тав тухтай байлгах бүх л зүйлийг хийж байв. Хоол хийх, хувцас угаах, гадуур салхилуулах гээд л ээжийнхээ бүх хэрэгцээг хангаж байлаа. Гэхдээ би гаднаа үйлчилж байсан ч, дотроо баяр хөөргүй байсан юм. Гэр бүлийн маань хэвийн хэмнэл алдагдсанаас болж надад бухимдал төрж байв. Тэгэхэд, ээж минь заримдаа, “Чи инээмсэглэхээ больчихоо юу даа? Яагаад инээмсэглэхгүй байгаа юм бэ?” гэж асуудаг байсан. Тэгэхэд би өршөөл үзүүлж байсан ч, баяр хөөртэй хийгээгүй юм.”

В. Нийгэмд хандах байдал (12:9-21)

12:9 Дараа нь Паул, итгэгч бүрийн бусад итгэгч нартай болон итгэдэггүй хүмүүстэй

харилцахдаа хөгжүүлэх шаардлагатай шинж чанаруудыг жагсаажээ.

Хайр нь хоёр нүүртэй байж болохгүй. Хайрлахдаа бид баг зүүх хэрэггүй. Харин чин сэтгэлээсээ, үнэн зүрхнээсээ хайрлах хэрэгтэй.

Мөн бид **муу муухайн** бүх хэлбэрийг **жигшин, сайн** бүхнээс **зуурах** хэрэгтэй. Энд **муу муухай** гэдэг нь үзэн ядалт, хорсол, зэвүүцэл бүхий хандлага, үйлдлийг хэлсэн бололтой. Харин **сайн** гэдэг нь эсрэгээрээ, хайр харуулах бүх хэлбэрийг хэлж байна.

12:10 Итгэлийн гэр бүлийнхэнтэйгээ бид хүйтэн хөндий хандалгүй, үл тоомсорлолгүй, хатуу ширүүн харьцалгүй, эелдэг зөөлнөөр, халуун дулаанаар хайраа харуулах хэрэгтэй.

Бид өөрсдөөсөө түрүүнд бусдыг тавих хэрэгтэй. Олны хайрыг булаасан Христийн нэгэн үйлчлэгч хурлын өмнө хэсэг хүндтэй хүмүүстэй хамт хажуугийн өрөөнд байж байв. Түүний ээлж ирэхээс өмнө зарим нь түрүүлээд индэр дээр гарсан байлаа. Харин түүнийг хаалгаар орж ирэхэд хүмүүс түүнийг нижгэнэсэн алга ташилтаар угтжээ. Тэгэхэд нь тэрээр өөр хүнд зориулсан хүндлэл гэж бодохдоо тэр даруй хажуу тийш болж, хүмүүстэй хамт алга ташсан гэдэг.

12:11 Моффат энэ ишлэлийг үнэхээр сайхан орчуулсан нь, “Зүтгэлээ эс мохоож, сүнснийхээ галыг өрдөн, Эзэнд үйлчил” гэжээ. Иеремиа 48:10 дээр “Эзэний ажлыг хайнга хийдэг хүн

хараагдах болтугай!” гэсэн үгийг энэ ишлэл бидэнд сануулж байна.

*Шалдар булдрыг хөөшгүй
Ахархан богино амьдрал
Ахуй нь бодит нүгэл
Мөнхийн мэт санашгүй
Тасраад унах навчис, энэ амь
Дусаад уусах нулимс, энэ нас
Дэмий алддаг цаг хугацаа
Яахин бидэнд байх вэ
Бидний оридог ийм хорвоод
Яагаад зүгээр суух гэж
-Хоратиус Бонар*

12:12 Өнөөгийн нөхцөл байдал маань ямар байсан ч, бид **найдвар дотроо** баярлах хэрэгтэй. Аврагч маань ирж, биеийг маань бүрэн аварч, бид мөнхийн цог жавхланд орно. Энэ бол бидний найдвар. Мөн **зовлон дотор тэвчээртэй** байхыг Паул бидэнд ятгаж байна. Зовлонг зоригтой үүрнэ гэсэн үг. Ийм ялгуусан тэвчээр бол зовлонг яруу жавхлан болгодог зүйл юм. Мөн бид **залбиралд өөрсдийгөө зориулах** хэрэгтэй. Залбирлаар ажил хийгдэж, залбирлаар ялалтад хүрдэг. Залбирал нь амьдралд хүч, зүрхэнд амгаланг авчирдаг. Бид Эзэн Есүсийн Нэрээр залбирах үед, зуурдын хүн Бүхнийг чадагч Бурханд хамгийн ойр очих боломжтой болдог. Тийм болохоор, залбирлыг үл тоомсорловол бидэнд өөрсдөд маань муу.

12:13 Юмаар дутагдсан **ариун хүмүүс** хаа сайгүй байна. Заримд нь ажил олддоггүй. Зарим

нь эмчилгээний төлбөрөө төлж чаддаггүй. Зарим номлогч, илгээлтийн эзэд хүмүүст үл анзаарагдам газруудад мартагдсан байдаг. Тамир тэнхээ муудсан ахмад настнууд ч бас бий. Итгэгч нар бид хэрэгцээтэй нэгэнтэйгээ хуваалцаж байвал Христийн бие эрүүл чийрэг байна.

“Хэрэгтэй хүнээс нь унд хоол, унтах ор бүү харамла” (ЖВР). Өнөөдөр **зочломтгой байдал** хүмүүсийн ахуй амьдралаас алдагджээ. Гэр нь жижиг гэж шалтаглаад, дайраад гарсан итгэгч ахан дүүгээ хүлээн авахаа больсон. Үнэндээ, гэр орныхоо тав тухыг алдахыг хүсээгүйд л гол учир байдаг. Гэвч, Бурханы хүүхдүүдийг хүлээн авбал, Эзэнийг Өөрийг нь хүлээн авсантай адил гэдгийг бид мартсан бололтой. Бидний гэр орон Есүсийн очих дуртай байсан Бетаны гэр шиг байвал зохино.

12:14 Биднийг хавчсан хүмүүст муугаар биш, харин сайхан сэтгэлээр хариу барихаар бид дуудагджээ. Шударга бусаар хандсан хүмүүст сайнаар хандахын тулд тэнгэрлэг амьдрал хэрэгтэй. Учир нь бидний төрөлх араншин тийм хүмүүсийг хараан зүхэж, хор хохирол учруулахыг хүсдэг.

12:15 Бусдыг ойлгох бэлэг бол бусад хүний мэдрэмж, сэтгэл хөдлөлийг хуваалцах чадвар юм. Бидний төрөлх араншин бол, бусдыг баярлахад хардан сэрдэж, бусдыг гашуудахад үл тоодог. Харин бидний эргэн тойронд байгаа

хүмүүсийн баяр хөөр, уй гашууг хуваалцах нь Бурханы зам мөн.

12:16 Өөр хоорондоо нэг санаатай байх гэдэг нь ач холбогдолгүй зүйлс дээр ч гэсэн адилхан бодолтой байна гэсэн үг биш. Бие биетэйгээ эвтэй зохицож амьдрахын тулд заавал бүх зүйл дээр ижил үзэл санаатай байх албагүй.

Гэхдээ бид өөрсдийгөө бусдаас дээгүүр тавилгүй, даруу байхыг эрхэмлэх хэрэгтэй. Хүнтэй харьцахдаа, түүнийг хөрөнгө чинээ, байр суурьтай хүн мэт үзэж, өөрийгөө доогуур зиндаанд тавих хэрэгтэй. Нэг алдартай номлогчийг онгоцны буудал дээр ирэхэд, номлох гэж байсан чуулганых нь удирдагч нар тосож аваад лимузинд суулгаж дээд зэрэглэлийн зочид буудалд буулгав. Харин тэр, “Уригдсан номлогчийг гол төлөв хэнийх зочилдог вэ?” гэж асуув. Чуулганы ахлагч нар түүнд, муухан байранд холгүйхэн амьдардаг настай эхнэр нөхрийг зааж өгчээ. Тэгэхэд өнөөх номлогч, “Би тэднийд байрлаж болох болов уу?” гэсэн гэдэг.

Ухаан бодолдоо ч бүү ихэрх гэж элч Паул итгэгч нарт сэрэмжлүүлж байна. Бидэнд байгаа бүхэн анхнаасаа биднийх байгаагүй, харин бидэнд өгөгдсөн гэдгийг ойлгох хэрэгтэй. Тэгвээс бие тоох явдлаас өөрсдийгөө хамгаалж чадна.

Мууг муугаар хариулах нь энэ ертөнцийн нийтлэг хандлага. Хүн яаж харьцана, өөдөөс нь адилхан ханд, хүртэх ёстой шанг нь өг гэж

хүмүүс ярьдаг. Гэвч аврагдсан хүмүүсийн амьдралд өс хонзонд баярлах баяр хөөрт зай байхгүй. Түүний оронд тэд, өөрсдөд нь шударга бусаар хандахад нэр төртэй, шударга журамтай амьдрах хэрэгтэй. **Харгалзан үзэх** гэдэг нь *хийх үйлдлээ тунгаан бодож, түүндээ хянамгай бай* гэсэн үг.

12:18 Христигэгчид хэрүүл маргаан хийж, бусадтай сөргөөцөлдөх хэрэггүй. Зөвт Бурхан уур уцаар, зөрчил бухимдлаар дамжуулж ажилладаггүй. Бид амар амгалан, энх тайвныг эрхэмлэж, зөрчилдөөнийг намжааж, тайван тогтуун байх хэрэгтэй. Хэрэв бид бусдыг гомдоосон бол, эсвэл бусад хүн биднийг гомдоосон бол, бид тайван замаар асуудлыг шийдвэрлэхийн тулд цуцалгүй ажиллах хэрэгтэй.

12:19 Бидэнд муу юм хийсэн хүмүүст өс санаж огт болохгүй. **Уур хилэнд зай гарга** гэдэг нь өөрийнхөө асуудлыг Бурханд даатга гэсэн утгатай байж болно. Аль эсвэл, бусдын уур хилэнг эсэргүүцэхгүй, зүгээр өнгөрүүл гэсэн утгатай байж болно. Гэхдээ энэ ишлэлийн үлдсэн хэсгийг харвал нэг дэх утга илүү таарч байна. Өөрөөр хэлбэл, чи бүү оролц, Бурханы **уур хилэн** үүнд чинь санаа тавиг гэж ойлгогдож байна. Бурхан л гагцхүү **өшөө авах** эрхтэй. Түүнд хамаарах эрхийг бид хэрэгжүүлэх хэрэггүй. Тэр зөв цагт, зүй ёсоор хариуг нь барих болно. Ленски энэ талаар дараах тайлбарыг хийжээ:

“Бурхан бурууг үйлдэгчидтэй шударга ёсны тооцоог заавал хийнэ. Түүнээс нь хэн ч зугтаж чадахгүй. Бүх хэрэгт шударга тооцоо хийнэ. Түүнд нь ямар ч алдаа мадаг гарахгүй. Хэрэв бид энэ тооцооны дундуур хөндөлдвөл ихэрхэж байна гэсэн үг.”⁵⁰

12:20 Христигэл бол юуг ч эсэргүүцэхгүй зүгээр хараад суухын нэр биш, харин идэвхтэйгээр сайхан сэтгэлийн үйлдэл хийх юм. Христэд итгэгч хүн дайснаа хүчирхийллээр устгадаггүй, харин хайраар Христийнх болгодог. Христэд итгэгч хүн **дайснаа өлсөж байхад хооллож**, ундаасч байхад уух юм өгдөг. Энэ нь **түүний толгой дээр галтай нүүрс овоолж байгаа хэрэг**. Хэрэв галтай нүүрс овоолох гэдэг хэрцгий санагдаж байвал, зүйр хэлц энэ үгийг ойлгоогүйнх болов уу. Хүний толгой дээр галтай нүүрс овоолно гэдэг нь зүй бусын үйлдлийн хариуд сайхан сэтгэлээр хандаж нүүр хийх газаргүй болтол ичээх гэсэн утгатай.

12:21 Энэ ишлэлийн эхний хэсгийг Дарби ингэж тайлбарлажээ: “Миний муухай ааш таныг муухай ааштай болгож байгаа бол бузар мууд ялагдсан нь тэр.”⁵¹

Их эрдэмтэн Жорж Вашингтон Карвер нэгэнтээ, “Хэн нэгнийг үзэн ядаж амьдралаа сүйрүүлэхийг би хэзээ ч зөвшөөрөхгүй”⁵² гэжээ. Тэрээр Христигэгч байсан бөгөөд бузар мууд ялагдахгүй байх замыг сонгожээ.

Харин бузар мууг сайнаар дийлэгтүн. Христийн сургаалын гол мөн чанар бол ингэж болохгүй, тэгж болохгүй гэх хориг цээрээр баригдан зогсох бус, сайныг хийхээр цааш алхдаг. **Мууг сайнаар** ялан дийлэх боломжтой. Энэ бол бидний байнга ашиглах ёстой зэвсэг мөн.

Стантон Линкольнд хорсон үзэн яддаг байв. Жинхэнэ горилла Иллинойсын Спрингфилдэд байхад заавал Африк явж горилла хайхын хэрэг юун хэмээн Линкольныг доромжилж байв. Гэхдээ Линкольн үүнийг чихнийхээ хажуугаар өнгөрөөжээ. Хожим нь Линкольн Стантоныг дайны сайдын албан тушаалд хамгийн сайн тохирох хүн гээд, томилжээ. Линкольныг буудуулсны дараа, Стантон түүнийг хамгийн шилдэг удирдагч гэсэн юм. Хайр ялалт байгуулжээ.⁵³

Г. Төр засагт хандах байдал (13:1-7)

13:1 Итгэлээр зөвтгөгдсөн хүмүүс хүний байгуулсан засаг төрд **захирагдах** үүрэгтэй. Үнэндээ энэ бол хүн бүрийн үүрэг. Гэхдээ энд элч Паул тусгайлан итгэгч нарт хандан хэлж байна. Усан галавын дараа Бурхан “Хэн хүний цусыг урсгана, түүний цусыг хүн урсгах ёстой” (Эхлэл 9:6) гэж тушаахдаа хүний засаг төрийг байгуулжээ. Гэмт хэргийг шүүж, буруутныг

шийтгэх эрхийг Бурхан энэ тушаалаараа хүнд өгсөн байна.

Дэг журамтай нийгэмд зайлшгүй эрх мэдэл ба тэрхүү эрх мэдэлд захирагдах явдал байх ёстой. Эс бөгөөс эмх замбараагүй байдал бий болно. Тэгээд тэр эмх замбараагүй байдал таныг хэзээ л бол хэзээ хөнөөж мэднэ. Ямар нэг төр засаг байх нь ямар ч төр засаггүй байснаас дээр. Тиймээс Бурхан хүний төр засгийг байгуулжээ. Бурхан хүсээгүй байхад байгуулагдсан төр засаг гэж нэг ч үгүй. Гэхдээ энэ нь удирдагч нарын хийж байгаа бүхнийг Бурхан зөвшөөрдөг гэсэн үг биш. Тэрээр авилга хээл хахууль, дарлал мөлжлөг, харгислалыг огтхон ч зөвшөөрдөггүй. Гэсэн ч, **Бурханаар тогтоогдсоноос өөр эрх мэдэл гэж байхгүй** гэдэг нь үнэн билээ.

Ардчилсан нийгэм, үндсэн хуульт хаант засаг, тэр ч байтугай дарангуйллын дэглэмийн алинд ч, итгэгч нар ялгуусан амьдарч чадна. Аливаа төр засаг нь байгуулсан хүмүүсийнхээ тусгал мөн. Тиймээс төгс төр засаг гэж үгүй. Зөвхөн Эзэн Есүс Христ хаанчлах үед л төгс төр засаг бий болох болно. Паул хүний байгуулсан төр засагт захирагдах тухай энэ хэсгийг бичиж байхад Ромын эзэн хаан нь зартай Неро байжээ. Түүний хаанчлал христитгэгчдийн хувьд харанхуй үе байв. Ром хотод аймшигтай түймэр дэгдэж, тал нь утсан явдалд Неро христитгэгчдийг буруутгажээ (Энэ түймрийг түүний тушаалаар гаргасан байх магадлалтай). Тэрээр зарим итгэгч нарыг тосонд дүрж

шатаагаад, амьд бамбар болгож, найр наадмаа гэрэлтүүлдэг байв. Мөн заримыг нь амьтны арьсан дотор хийгээд өлсгөлөн нохдод хаяж, хэдэн хэсэг тастуулдаг байв.

13:2 Тэгсэн ч гэсэн, төр засагт дуулгаваргүй байх, тэрслэх нь Бурханы тогтоолд дуулгаваргүй байж, тэрслэхтэй адил зүйл юм. Хууль ёсны дагуух **эрх мэдлийг эсэргүүцэгч** нь шийтгэл хүлээвэл зохино.

Гэхдээ, төр засгийг дагахгүй байх шалтгаан бий. Хэрэв тухайн төр засаг Есүс Христэд үнэнч байхаас татгалзахыг шаардах юм уу нүгэл үйлдэхийг тушаавал, Христэд итгэгч хүн түүнд захирагдахгүй байж болно (Үйлс 5:29). Хүний мөсгүй зүйл хийхийг тушаах эрх ямар ч төр засагт байхгүй. Тиймээс итгэгч хүн Бурханыг дагаснаараа хүний уур хилэнг амсах үе тохиолддог. Ийм тохиолдолд тэрээр ямар ч гомдолгүйгээр шийтгэлийг үүрэхэд бэлэн байх ёстой. Итгэгч хүн ямар ч тохиолдолд төр засгийн эсрэг тэрсэлж болохгүй. Мөн төр засгийг түлхэн унагахыг санаархагч нартай нэгдэж болохгүй.

13:3 Ер нь зөвийг хийдэг хүмүүс эрх мэдлээс айх шаардлагагүй. Зөвхөн хууль зөрчигч нар л шийтгэлээс айдаг. Хэрэв торгууль, шүүх, шорон гэх мэт зүйлээс ангид амьдрахыг хүсэж байвал хуулиа мөрддөг иргэн байхад л болно. Тэгвэл, эрх мэдэлтнүүдийн буруутгалыг хүртэх бус, харин дэмжлэгийг олно.

13:4 Тухайн удирдагч нь ерөнхийлөгч, захирагч, засаг дарга, шүүгчийн аль нь ч бай, Бурханы **үйлчлэгч**, Эзэний төлөөлөгч юм. Тэр хүн Бурханыг мэддэггүй байж болно. Гэсэн ч Эзэний томилсон хүн мөн. Хорон санаат хаан Саулыг Давид байнга Эзэний тосолсон хүн гэж хэлж байсан (1Самуел 24:6, 10; 26:9,11,16,23). Саул Давидын амьдралд хор хөнөөл учруулахыг удаа дараа оролдож байсан ч, Давид Саулд муу зүйл хийхийг хүмүүстээ зөвшөөрөөгүй. Яагаад? Яагаад гэвэл, Саул Эзэнээр тослогдсон хаан байсан.

Бурханы зарц учраас удирдагчид хүмүүсийн **сайн сайхны** төлөө буюу тэдний аюулгүй байдал, амар амгалан, ерөнхий ахуй байдлыг хангах үүрэгтэй. Хэрэв хэн нэгэн хууль зөрчвөл, тэрээр түүнийхээ хариуг амсана. Яагаад гэвэл, буруутныг шүүж, шийтгэх эрх мэдэл төр засагт бий. **Тэр илд дэмий зүүгээгүй** гэдэг үг төр засагт Бурханаас ямар их эрх мэдэл олгогдсоныг хэлж байна. **Илд** гэдэг нь зүгээр нэг эрх мэдлийн бэлэг тэмдэг биш, очирт таяг гээд хэлэхэд болох байсан. Гэтэл **илд** гэж хэлсэн нь төр засагт цаазлах эрх мэдэл буйг өгүүлж байгаа бололтой. Тэгэхээр, цаазын ял нь дан ганц Хуучин гэрээний үед л зөвшөөрөгдөж байсан гэвэл буруу болж байна. Төрд цаазлах эрх байж болно гэдгийг Шинэ гэрээний энэ ишлэл илтгэдэг. Хүмүүс үүнийг үгүйсгэхийн тулд Гэтлэл 20:13-аас “Чи хүн бүү ал” гэснийг иш татдаг. Гэхдээ энэ нь хүн амины гэмт

хэргийг хориглосон тушаал юм. KJV дээр “kill” (алах) гэж орчуулсан еврей үг нь “murder” (хүний амь бүрэлгэх) гэсэн утгатай бөгөөд NKJV-д тийн орчуулжээ.⁵⁴ Хүнд ноцтой зарим буруутныг шийтгэхдээ цаазлах ёстойг Хуучин гэрээний хуульд заажээ.

Удирдагч нар бол **Бурханы үйлчлэгч** гэж элч Паул хоёр дахиа сануулж байна. Гэхдээ энэ удаа, **бузар мууг үйлдэгч нэгэн дээр уур хилэнг буулгах өшөө авагч** гэдэг үгийг нэмж хэлсэн. Өөрөөр хэлбэл, удирдагч хүн бол **сайн сайхны төлөөх Бурханы үйлчлэгч** гэдгээс гадна, хууль зөрчигчийг шийтгэхэд Бурханд үйлчилдэг хүн ажээ.

13:5 Тэгэхээр төр засагт захирагдах ёстой хоёр шалтгаан бидэнд байгаа гэсэн үг. Нэгт шийтгэлээс айх айдас. Хоёрт сайн **мөс чанарын** улмаас.

13:6 Бид төр засагтаа захирагдаад зогсохгүй **татвараа төлж** санхүүгээр дэмжих ёстой. Хууль дүрэм, эмх журамтай нийгэмд, цагдаа, гал сөнөөгчөөр хамгаалуулан амьдарч байгаа нь бидний давуу тал мөн. Тэгэхээр бид тэдний зардлаас төлөлцөх хүсэлтэй байх хэрэгтэй. Төрийн албан хаагчид тогтвортой нийгмийн төлөөх Бурханы хүслийг хэрэгжүүлэхийн тулд өөрсдийн цаг зав, ур чадвараа зориулдаг. Тийм болохоор тэднийг дэмжих нь зөв.

13:7 Итгэгч нар тэнгэрийн иргэншилтэй (Филиппой 3:20) гээд хүний нийгмийн төр засгийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй гэсэн

үг биш. Олсон орлого, үл хөдлөх хөрөнгө, хувийн өмчид нь ногдох алив татваруудыг итгэгч нар **төлөх** хэрэгтэй. Хэрэв улс хооронд бараа бүтээгдэхүүн тээвэрлэвэл **гаалийн татвараа** өгөх ёстой. Хууль сахиулах алба үүргэнд байгаа хүмүүсийн дургүйцлийг төрүүлэх вий хэмээн эмээх хэрэгтэй. Төрийн албаны ажилчдын *нэр төр, албан тушаалд* хүндэтгэлтэй хандах хэрэгтэй (хувийн амьдрал нь хүндлүүштэй биш байсан ч гэсэн).

Тэгэхээр, христитгэгчид ерөнхийлөгч болоод ерөнхий сайдын нэр төрийг гутаан доромжлогч нарыг дэмжиж, тэдэнтэй эвсэн нэгдэж болохгүй. Төр засгийг элдвээр муулагч нартай нийлэхээс татгалзах хэрэгтэй. “Өөрийн ард түмний удирдагчийг бүү муул” (Үйлс 23:5).

Д. Ирээдүйд хандах байдал (13:8-14)

13:8 Энэ ишлэлийн эхний хэсэгт “төлөх ёстойгоо цагт нь төлж бай” гэдгийг хэлэхийг зорьжээ. Энэ нь өрийн бүх хэлбэрийг хориглосон хэрэг биш. Өнөөгийн бидний нийгэмд зарим төрлийн өрнөөс зайлсхийх аргагүй ажээ. Тухайлбал, сар бүр бид утас, газ, гэрэл, ус, дулааны мөнгө төлөх шаардлагатай тулгардаг. Мөн, өргүйгээр бизнесээ явуулах боломжгүй байдаг. Тэгэхээр энд төлөх ёстойгоо бүү хойшлуул, өгөх ёстойгоо хугацаанд нь өг гэж энд анхааруулж байгаа юм.

Гэхдээ өрийн тал дээр бидэнд чиглэл өгөх зарчим бий. Тухайлбал, бид онцын шаардлагагүй юмны төлөө өр тавих хэрэггүй. Эргэн төлөх ямар нэгэн бололцоогүй тохиолдолд өр тавих хэрэггүй. Бид зээлээр юм худалдан авч, дараа нь өндөр хүү төлөх хэрэггүй. Бид үнэ цэнэ нь буурч байгаа бүтээгдэхүүн худалдаж авахаар мөнгө зээлэх хэрэггүй. Ерөнхийдөө бол, хэт тансаглал ба хэрэггүй зардлаас зайлсхийн, санхүүгийн хувьд хариуцлагатай амьдарч, “өртөн зээлдүүлэгчийнхээ зарц болдог” (Сургаалт үгс 22:7) гэсэн үгийг байнга санаж байх хэрэгтэй.

Бидэнд байдаг хэзээ ч барагддаггүй өр бол **хайр** юм. Ром ном ганц тохиолдлоос (12:10) бусад газарт хайр гэж хэлэхдээ *агапэ* гэдэг үгийг ашигласан. *Агапэ* нь хувиа хичээдэггүй, хүнээс гарамгүй, агуу их хайр юм. Энэ ертөнцөөс олдохгүй агапэ **хайр** нь хайрлагдах хүнийхээ сайн сайханд үндэслэдэггүй. Харин ч хайрлагдах зохисгүй хүний төлөө байдаг. Энэ нь хайрлуулах зохистой хүнийг төдийгүй, дайснаа ч гэсэн хайрладгаараа бусад хайраас ялгаатай.

Энэ хайрын гол шинж нь өгөх. Тэр дундаа золиос гарган өгөх. Бурхан ертөнцийг ийм хайраар хайрлаж, цорын ганц Хүүгээ өгчээ. Христ чуулганыг ийм хайраар хайрлаж, түүний төлөө Өөрийгөө өгчээ.

Энэ нь сэтгэл хөдлөлөөс гэхээсээ илүү *хүслээс* үүдэлтэй. Бидэнд **хайрлахыг**

тушаасныг бодоход, энэ нь бидний хийхээр сонгож болдог зүйл ажээ. Хэрэв энэ нь хянаж болдоггүй сэтгэл хөдлөл байсан бол, бид хайрлаагүйнхээ төлөө хариуцлагагүй болно. Гэхдээ сэтгэл хөдлөл ерөөсөө байдаггүй гэсэн үг ч биш юм.

Энэ тэнгэрлэг хайр дахин төрөөгүй хүнээс гарах боломж байхгүй. Итгэгч хүн ч гэсэн өөрийнхөө хүч чадлаар ийм хайрыг харуулж чадахгүй. Харин бидний дотор оршигч Ариун Сүнсний хүч чадлаар л бид ингэж хайрлаж чадна.

Хайр гэж юу байдгийг Эзэн Есүс Христ газар дэлхий дээр байхдаа төгс төгөлдөр харуулсан билээ.

Бид Бурханы тушаалуудад дуулгавартай дагах нь Түүнд хайртайн илрэл юм.

Хөршөө **хайрладаг хүн хуулийг биелүүлсэн хэрэг мөн.** Үгүй ядахдаа л, нөхрөө хайрлахыг сургасан хэсгийг нь биелүүлсэн хэрэг юм.

13:9 Элч Паул, хөршдөө хайргүйн улмаас хийдэг үйлдлүүдийг хориглосон тэдгээр **тушаалуудыг** нэр цохон дурдсан. Тэдгээр нь **завхайрал, аллага, хулгай, хуурамч гэрч, шунахайрлыг хориглосон тушаалууд** юм. Хайр бусдын биеийг ашигладаггүй. Садар самуун бусдын биеийг ашигладаг. Хайр хүний амийг авдаггүй. Алуурчин хүний амийг авдаг. Хайр бусдын эд хөрөнгийг хулгайлдаггүй. Хулгайч бусдын юм хулгайлдаг. Хайр шударга ёсыг

гажуудуулдаггүй. Хуурамч гэрч гажуудуулдаг.⁵⁵ Хайр бусдын эд хөрөнгөнд шунахайрдаггүй. Сувдаг сэтгэл шунахайрдаг.

Өөр ямар ч тушаал байна... Паулын нэмж хэлэх байсан нь “Эцэг, эхээ хүндэл” гэсэн тушаал болов уу. Энэ бүгд “**Хөршөө өөрийн адил хайрла**” гэсэн үгэнд багтдаг. Та өөртөө зориулдаг анхаарал халамж, сэтгэл зориулалтаа л бусдад зориулчих.

13:10 Хайр хэзээ ч бусдыг хохироохыг боддоггүй. Харин ч бусдад сайн сайхныг хүсэж, бусдыг хүндэлдэг. Тийм болохоор хайраар үйлдэж байгаа хүн **хуулийн** хоёр дахь хавтангийн шаардлагуудыг үнэхээр биелүүлсэн хэрэг юм.

13:11 Энэ бүлгийн үлдсэн хэсэгт сүнсний хувьд сонор сэргэг, ёс суртахууны хувьд ариун амьдрахыг уриалсан. **Цаг** бага үлджээ. Нигүүлслийн үе шувтарч байна. Цаг орой болж байгаа учраас нойрмог идэвхгүй байдлыг хойш тавих шаардлагатай байна. **Бидний аврал одоо** хэзээ хэзээнээс **илүү ойрхон байна**. Аврагч Эзэн маань биднийг Эцэгийн гэр уруу авч явахаар ирэх нь ойртжээ.

13:12 Одоо үе бол үүр хаяарах дөхсөн, нүглийн харанхуй **шөнөгтэй** адил. Мөнхийн цог жавхлант **өдөр** итгэгч нарын төлөө тун удахгүй ирэх гэж байна. Тийм болохоор бид дэлхийн нөлөөг авсан, зөвт бус байдал, бузар муутай хутгалдсан хиртэй хувцсаа бүгдийг тайлаад, **гэрлийн зэвсгүүдийг агсах** хэрэгтэй. Тэдгээр

нь зэвсэг нь ариун амьдралыг хамгаалах хувцас юм. Энэ тухай Ефес 6:14-18 дээр дэлгэрэнгүй бий. Тэнд итгэгч хүний жинхэнэ чанаруудыг нэг нэгээр нь дүрсэлсэн.

13:13 Энд христитгэлт амьдралын маань хэв маяг ямар байх ёстойг бичсэн юм. Бид **өдрийн** хүүхдүүд болохоор гэрлийн хөвгүүд шиг амьдрах ёстой. Шоу цэнгээн, согтуучуудын зодоон нүдээн, бэлгийн дур таашаал, хэт их зугаа цэнгэл, хэрүүл маргаан, атаа жөтөөгөөр итгэгч нар юугаа хийх юм бэ? Энэ бүхэн тэдэнд ямар ч хэрэггүй.

13:14 Бидний дагаж болох хамгийн сайн зарчим бол, нэгдүгээрт, **Эзэн Есүс Христийг өмсөх**. Нэг ёсондоо, Түүний амьдралын хэв маягийг даган дуурайж, Түүний амьдарсан шиг амьдарч, Түүнийг өөрсдийнхөө Үлгэр Дуурайл, Хөтөч Замч болгоно гэсэн үг.

Хоёрт, **хүсэл тачаалынх нь талаар махбодыг юугаар хангахгүй байх** хэрэгтэй. **Махбод** гэж нь бидний хуучин, ялзарсан мөн чанарыг хэлж байна. Махбод нь тав тух, тансаглал, дур таашаал, хий хоосон зугаа цэнгэл, дэлхийн тааламж, үрэлгэн байдал, материализм гэх мэт зүйлсээр өдөөгдөж байхыг байж ядан хүсдэг. Бид уруу татагдах зүйлсийг худалдан авч, нүгэлд унах боломжийг өөрсдөдөө бий болгож, биет зүйлсийг сүнсний зүйлсээс дээгүүр тавьж байвал **махбодыг хангаж** байгаа хэрэг юм. Бид махбодоо өчүүхэн төдий ч

өөгшүүлж болохгүй. “Махбодод баярлах завшаан бүү олго” (ЖВР).

Мэдлэг чадвартай ч махбодын дур хүсэлдээ баригдсан Августиныг Бурхан Христэд итгүүлж, ариун амьдралд хөтлөхдөө энэ ишлэлийг ашиглажээ. Тэрээр 14 дүгээр ишлэлийг уншаад Эзэнд бууж өгсөн байна. Тэр цагаас хойш түүний нэр түүхэнд “Тэгээн” Августин гэж бичигдэх болсон юм.

Е. Бусад итгэгчдэд хандах байдал (14:1-15:13)

14:1 Ром 14:1-15:13 нь ач холбогдол багатай зүйлсэд хэрхэн хандах талаар Бурханы хүмүүст чухал заавар өгдөг. Эдгээр нь итгэгч нарын дунд олонтаа зөрчил маргаан үүсгэдэг боловч үнэндээ тийн зөрчилдөх шаардлагагүй гэдгийг эндээс харах болно.

Итгэлээр сул нэгэн гэдэг нь ач холбогдол багатай зүйлсэд өндөр ач холбогдол өгдөг итгэгчийг хэлж байна. Хам сэдвийг нь харвал, иудейчүүдэд хориглосон хоол хүнсийг идэх, Бямба гарагт ажиллах зэргийг буруу гэж үздэг итгэгч иудей хүний тухай голлон ярьж байна.

Үүнд хандах *эхний зарчим*: **итгэлээр сул нэгнээ** нутгийн чуулганы нөхөрлөлд хүлээн авах хэрэгтэй. Ингэхдээ түүний үзэл баримтлалынх нь талаар **зарга хийх** хэрэггүй. Христитгэгчид тиймэрхүү ач холбогдол багатай

зүйл дээр нэг санаатай биш байсан ч гэсэн баяр хөөртэй нөхөрлөх боломжтой.

14:2 Бүх хоол цэвэр бөгөөд Бурханы үг ба залбирлаар ариусгагддаг (1Тимот 4:4,5) гэсэн Шинэ гэрээний сургаалд үндэслэсэн итгэлтэй итгэгч хүн энэ тал дээр Христийн эрх чөлөөг бүрэн эдэлж байдаг. Гэтэл мөс чанар нь дорой итгэгч гахай болон ер нь амьтны мах идэхээс болгоомжилж болно. Эсвэл бүр цагаан хоолтон ч байж болох юм.

14:3 *Хоёр дахь зарчим:* харилцан хүлээцтэй хандах. Төлөвшсөн итгэгч нь итгэлээр сул ах дүүгээ **басамжилж** болохгүй. Итгэлээр сул нэгэн нь ч бас гахай, сам хорхой, хавч зэргийг иддэг ах дүүгээ нүгэлтэн мэт **шүүх** хэрэггүй. **Бурхан түүнийг** гэр бүлийнхээ гишүүн болгож **хүлээн авсан** билээ.

14:4 *Гурав дахь зарчим:* итгэгч нар бүгдээрээ Эзэний **зарц**. Тиймээс эзэн мэт аашилж, шүүгчийн байр сууринд суух эрх бидэнд байхгүй. Хүн бүр **эзнийхээ өмнө** хүлээн зөвшөөрөгдөж, эсвэл эс хүлээн зөвшөөрөгдөнө. Жижиг сажиг асуудлыг авч үзэж байгаа үзэл хандлагыг нь хараад, итгэл муутай хэмээн дүгнэж, бусдыг дорд үзэх нь буруу. Иймэрхүү асуудалд Бурхан аль аль талыг нь хамгаалах болно. Түүнд үүнийг хийх бүрэн хүч чадал бий.

14:5 Зарим иудей итгэгч нар Бямба гарагийг үүргийн өдөр гэж үзсэн хэвээрээ л байлаа. Тэд Бямба гарагт ямар нэг ажил хийдэггүй байв.

Үүгээрээ тэд нэг өдрийг нөгөөгөөс онцгойлон үзэж байжээ.

Гэтэл бусад итгэгч нар нь иудейн энэ хууль дүрмийг тоосонгүй. Тэд **өдөр бүрийг адилхан гэж үзэж** байжээ. Учир нь, тэд зургаан өдрийг ердийн, нэг өдрийг ариун гэж бодохгүй байв. Тэдний хувьд бүх л өдөр ариун.

Тэгвэл долоо хоногийн эхний өдөр болох Эзэний өдөр яах болж байна? Христитгэгчид энэ өдрийг онцгойлж үздэггүй гэж үү? Шинэ гэрээг үзвэл, энэ өдөр бидний Эзэн үхлээс амилжээ (Лук 24:1-9). Түүнээс хойш хоёр удаа Эзэний өдөр Христ шавь нартайгаа уулзсан байдаг (Иохан 20:19,26). Ариун Сүнс Пентекостын өдөр өгөгдсөн. Тэр нь долоо хоногийн эхний өдөр байв. Христийн амиллыг бэлгэддэг анхны үр жимсийн баяраас хойш (1Коринт 15:20,23), долоо дахь ням гарагт Пентекост тохиодог (Леви 23:15,16; Үйлс 2:1). Шавь нар долоо хоногийн эхний өдөр цуглаж, талх хуваадаг байв (Үйлс 20:7). Паул Коринтын чуулганд хандиваа долоо хоногийн эхний өдөр цуглуулахыг зааварласан. Тэгэхээр Шинэ гэрээнд Эзэний өдрийг онцгойлсон байна. Гэхдээ шаббат шиг *үүргийн өдөр* болгож биш, харин *онцгой эрхийн* өдөр болгожээ. Бид Эзэнд мөргөж, үйлчлэхийн төлөө энэ өдрийг ангид тавьж, өдөр тутмынхаа ажлаас түр хөндийрдөг.

Христитгэгчид шаббатыг сахих ёстой гэж бичсэн хэсэг Шинэ гэрээнд байхгүй ч долоон

өдрөөс нэгийг тусгаарлах, зургаан өдөр ажиллаад нэг өдөр амрах зарчмыг харж болно.

Итгэгч хүн үүн дээр ямар үзэлтэй байлаа ч, **хүн бүр өөрийн бодолдоо бат итгэлтэй байг** гэсэн зарчмыг баримтлах хэрэгтэй. Гэхдээ ёс суртахууны хувьд *сөрөг биш* зүйлсийн хувьд л ийм зарчим байдгийг бүү мартаарай. Христитгэлийн *суурь* сургаалд хүний үзэл бодол гэдэг зүйл байж болохгүй. Зөв ч биш, буруу ч биш зүйл дээр бол хүмүүс янз бүрийн үзэл бодолтой байж болно. Үүгээр нь нөхөрлөлд хүлээн авах эсэхээ шүүх нь буруу юм.

14:6 Энэ ишлэлд дурдагдсан **өдрийг бодолцогч** гэж Бямба гарагт ямар нэг ажил хийх талаар мөс чанартаа тавгүйрхдэг иудей итгэгч юм. Гэхдээ тэрээр авралыг авах юм уу авралаа хадгалж үлдэхийн тулд шаббатыг сахисан гэсэн үг биш, харин **Эзэнийг** баярлуулахын төлөө юм. Нөгөө талд, өдрийг сахидаггүй хүн итгэлийн ердийн сүүдрийг биш (Колоссай 2:16,17), харин түүний бодит бие болох Христийг хүндэлж байсан.

Иудейчүүдийн бузар гэдэг хоол хүнсийг чөлөөтэй иддэг хүн толгой гудайн **Бурханд талархал өргөдөг**. Мөс чанартаа сул дорой итгэгч ч гэсэн, тэдгээр бузар гэгддэг хоолноос татгалзаж, бусад хоолыг идэж байхдаа Бурханд талархдаг. Тэдний хэн хэн нь Бурханаас ерөөл гуйдаг.

Тэд хоёулаа Бурханыг хүндэлж, **Бурханд** талархаж байгаа юм бол яагаад заавал муудалцаж, зөрчилдөх ёстой гэж?

14:7 Христ бол итгэгч хүний амьдралын бүхий л талбарт Эзэн мөн. Бид өөрсдийнхөө төлөө бус, Эзэний төлөө амьдардаг. Бид өөрсдийнхөө төлөө бус, Эзэний төлөө үхдэг. Бидний үйлдэл, үг яриа бусдад нөлөөлдөг нь үнэн. Гэхдээ Паул энд үүнийг хэлэхийг зориогүй. Харин Бурханы хүмүүсийн амьдралын зорилго, зорилт нь Эзэн байх ёстой гэж хэлж байгаа юм.

14:8 Амьдралд хийж байгаа юм бүхнээ бид Христээр нягтлуулж байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, тухайн зүйл нь Христийн оршихуйд яаж харагдаж байна вэ гэдгийг бодох ёстой. Үхэх гэдэг нь түүнтэй хамт байхаар явж байгаа гэсэн үг учраас үхэх маань ч хүртэл Эзэнийг алдаршуулна. Амьдралдаа ч, үхэлдээ ч бид Түүнийх билээ.

14:9 Христ үхээд амилсан шалтгаан нь бидний Эзэн болж, бид Түүнд сайн дураараа захирагдаж, талархсан халуун сэтгэлээ зориулаасай гэсэн хүсэл байсан. Бид үхэж, бидний бие булшинд орон сүнс сэтгэл маань Түүний оршихуйд байхад ч гэсэн Тэр бидний Эзэн билээ.

14:10 Тийм учраас, иудейн заншилдаа баригдсан итгэгч хүн нь иудейчүүдийн хуанлийг эс сахигч, хориглосон хоолыг төвдөхгүй иддэг **ах дүүгээ** буруутгах хэрэг

байхгүй ажээ. Тэгэх нь мунхаглал юм. Мөн нөгөө талд, итгэлээр хүчтэй итгэгч нь сул дорой ах дүүгээ **басамжлах** нь буруу юм. Бодох ёстой хамгийн чухал юм бол **бид бүгдээрээ Христийн**⁵⁶ **шүүх суудлын өмнө зогсоно**. Тэр газар л жинхэнэ дүн тавигдах болно.

Энэ шүүлт нь итгэгчдийн нүглийг бус, үйлчлэлийг шүүх юм (1Коринт 3:11-15). Тэр үед Христ зарц нарынхаа ажил үйлсийг шалгаж, тохирох шагналыг өгөх болно. Энэ шүүлтийг харь үндэстнүүдийн шүүлт (Матай 25:31-46) ба цагаан өнгөтэй агуу их сэнтийн шүүлттэй хольж хуггаж болохгүй (Илчлэл 20:11-15). Цагаан өнгөтэй агуу их сэнтий бол нүглээ уучлуулаагүй нас барсан үхэгсдийн эцсийн шүүлт болох цэг юм.

14:11 Бид Христийн шүүх суудлын (грекээр *бема*) өмнө зогсох нь гарцаагүй зүйл гэдгийг батлахын тул Исаиа 45:23-ыг иш татжээ. Өөрийнх нь **өмнө өвдөг бүхэн сөгдөж**, бүрэн дээд эрх мэдлийг нь хүлээн зөвшөөрнө гэдгийг Ёхова Өөрийнхөө амаар тунхагласан ажээ.

14:12 Тэгэхээр, бид бүхэн хэн нэг ах дүүгийнхээ талаар бус, харин *өөрийнхөө* тухай **тайланг Бурханд өгнө** гэдэг нь тодорхой. Гэтэл бид зүй ёсны эрх мэдэл, хангалттай мэдлэггүй байж бие биенээ хэтэрхий их шүүдэг.

14:13 Зарим нэг зөрүүтэй үзэл бодлоосоо болоод, Христэд итгэгч ах дүүгээ шүүхийн оронд, түүний сүнслэг өсөлтөд саад учруулах зүйл хийхгүй байхаар **шийдэх** хэрэгтэй.

Үнэндээ энэ зүйлсийн ач холбогдол маш ялихгүй бөгөөд ах дүүгээ **бүдрүүлэх**, унагах шалтгаан болох учиргүй.

14:14 Хуулийн дор амьдрагч иудейчүүдийн хувьд зан үйлийн талаас цэвэр ба бузар хүнс гэж бий. Харин Христэд итгэгч бидний хувьд одоо бузар гэгдэх ямар ч хоол хүнс байхгүй гэдгийг Паул мэддэг байсан, бид ч мэддэг. Бидний иддэг хоол хүнс нь Бурханы үгээр ба залбирлаар ариусгагддаг (1Тимот 4:5). Үгээр ариусгагдана гэдэг нь Библи хоолыг сайн сайхан гэж онцгойлон тодорхойлсон гэсэн үг. Мөн бид хоолыг Бурханы алдрын төлөө идэж, Түүнд үйлчлэх биеэ эрүүл чийрэг байлгахын төлөө хүртэхийн тулд Бурханы ерөөлийг гуйдаг. Ингэж хоол залбирлаар ариусгагдана. Гэтэл итгэлээр сул нэгэн нь гахайн мах идэхийг буруу гэж үзэж байвал, гахайн мах идэх нь буруу. Буруу гэж бодсоноо идвэл Бурханы өгсөн мөс чанарыг сэвтээх болно.

Юу ч өөрөө өөртөө бузар биш гэдэг нь энд өгүүлсэн ёс суртахууны хувьд *сөрөг биш* зүйлсийн тухайд хэлэгдсэн үг гэдгийг бид зөв ойлгох ёстой. Амьдралд бузар юм бишгүй олон бий. Жишээ нь гэхэд, порно зохиол, завхай онигоо, насанд хүрэгчдийн кино, садар самууны бүх хэлбэр. Паулын хэлсэн үгийг хам сэдэвтэй нь уялдуулж ойлгох хэрэгтэй. Мосегийн хуулинд бузар гэсэн хоол хүнсийг идлээ гээд христитгэгчид бузар болохгүй.

14:15 Би итгэлээр сул **ах дүүтэйгээ** хамт суугаад хоол идэх болоход, түүний идэж болохгүй гэж боддог хоолыг идэх гээд өөрийнхөөрөө зүтгээд байх хэрэг байна уу? Хэрэв би тэгж байгаа бол **хайрын дагуу** үйлдэхгүй байгаа хэрэг юм. Яагаад гэвэл хайр нь өөрийгөө биш, бусдыг боддог. Хайр нь ах дүүгийнхээ сайны төлөө, өөрийн эрхээс татгалздаг. **Христ** амиа зориулсан хүний сүнслэг сайн сайхан байдлын хажууд таваг хоол ач холбогдлоороо хэтэрхий шалихгүй зүйл. Гэтэл би иймэрхүү юман дээр хувиа хичээсэн зангаар өөрийнхөө эрхийг өмөөрөөд байвал, итгэлээр сул ах дүүгийнхээ амьдралд нөхөж баршгүй хохирол учруулж болзошгүй. Тэр хүний сүнсийг золихын тулд маш үнэ төлж, Хурганы үнэт цус урсаныг санаарай! Тэгвэл таны эрх гээд байгаа зүйл хэчнээн хямдхан болохыг та ухаарах болно.

14:16 Үнэндээ бол бүрэн зөвшөөрөгдсөн, онцын ач холбогдолгүй ийм зүйлсээс болоод бусдад “ах захгүй”, “бусдыг боддоггүй” гэж буруутгуулах хэрэг байхгүй. Тэгвэл, аяга шөлнөөс нэр төрөө худалдсантай адилхан юм.

14:17 **Бурханы хаанчлалд** хоол унд биш, харин сүнслэг үнэнүүд чухалд тооцогддог. Бурханы хаанчлал бол Бурханыг хамгийн дээд захирагч хэмээн хүлээн зөвшөөрдөг хүрээ. Гадна талаас нь харвал Бурханы талд гэх хүн бүгдээрээ үүнд багтана. Гэхдээ жинхэнэ бодит байдал дээр бол дахин төрсөн хүмүүс л Бурханы

хаанчлалд байдаг. Бурханы хаанчлал гэдэг үг энд ийм утгаар хэрэглэгджээ.

Бурханы хаанчлалын албат харьяатууд хоол хүнсний мэргэжилтэн байхаар дуудагдаагүй. Тэдний анхаарах ёстой гол зүйл бол Ариун Сүнсээр **зөв шударга** амьдрах, бусадтай нийцтэй байж, **амар амгаланг** эрхэмлэх, **баяр баясгаланг** баримтлах нь юм.

14:18 Хүний юу идэх, юу идэхгүй нь чухал асуудал биш. Бурханы хүндлэлийг хүлээж, хүмүүсийн сэтгэлд нийцдэг зүйл бол ариун амьдрал юм. Зөвт байдал, амар тайван, баяр баясгаланг эрхэмлэж буй хүн **Христийн** сургаалыг дагагч бөгөөд үүгээрээ Түүнд үйлчилж буй хэрэг юм.

14:19 Эндээс *бас нэгэн зарчим* урган гарч байна. Бид шалихгүй юмнаас болж маргалдаж муудалцахын оронд, бусад итгэгч нартайгаа эв найртай, нийцтэй байхыг бүх чадлаараа хичээх хэрэгтэй. Бусдыг бүдрүүлэхийн оронд, тэдний хамгийн ариун итгэл дотор барьж босгохын төлөө зүтгэх хэрэгтэй.

14:20 **Бурхан** хүүхэд нэг бүрийнхээ амьдралд ажиллаж байна. Идэж уух юм, өдөр хоногуудын талаарх өчүүхэн жижиг зүйлсээс болоод итгэлээр сул ах дүүгийнхээ амьдралд явагдаж буй **Бурханы ажилд** саад болох нь маш муу зүйл мөн. Одоо Бурханы хүүхдэд бүх хоол цэвэр. Гэхдээ ямар нэг хоол ах дүүг нь тавгүйтүүлж, христитгэлийн амьдралд нь

бүдрүүлэг болсоор байхад аливаа хоолыг иднэ гэж зүтгэвэл буруу болно.

14:21 Ах дүүгээ бүдрүүлж, сүнслэг өсөлтийг нь саатуулж байснаас **мах идэхгүй, дарс уухгүй, ах дүүгийн** маань бүдэрдэг **ямар нэг зүйлийг үйлдэхгүй байх нь** хэдэн мянга дахин **сайн** билээ. Итгэлээр сул нэгнийхээ төлөө багахан хэмжээний золиос гаргаад, эрхээсээ татгалзах нь дээр.

14:22 Талархалтайгаар хүлээн аваг гэж Бурхан надад өгснийг мэддэг болохоор би бүх хоолыг чөлөөтэй иддэг байж болно. Гэхдээ итгэлээр сул нэгнийхээ өмнө энэ эрх чөлөөгөө сайрхан харуулахын хэрэг байхгүй. Хэн ч бүдрэхгүй нөхцөлд, ганцаараа байхдаа энэ эрх чөлөөгөө эдэлбэл дээр.

Янз бүрийн юманд хүлэгдэхгүйгээр, Христийн эрх чөлөөг эдэлж амьдрах үнэхээр сайхан. Гэхдээ бүдрүүлж өөрийгөө буруутан болгож байснаас, эрхээ түр хойш тавих нь илүү дээр. Бусдыг бүдрүүлэхээс зайлсхийгч хүн **ерөөлтэй еэ!**

14:23 Харин итгэлээр сул хүний хувьд яривал, тэрээр идэж болохгүй гэж боддог зүйлээ идэх нь буруу юм. Түүний тийн идэж байгаа нь **итгэлийн** дагуу биш бөгөөд мөс чанараа сэвтээсэн хэрэг ажээ. Хүний мөс чанарыг сэвтээнэ гэдэг **нүгэл** мөн.

Мэдээж хэрэг хүний мөс чанар ямар ч алдаагүй хөтөч огтхон ч биш. Мөс чанарыг Бурханы үгээр боловсруулах хэрэгтэй. Гэхдээ

Меррилл Унгер энэ талаар: “Мөс чанар нь сул дорой байсан ч түүнийгээ дагах нь зөв гэсэн зарчмыг Паул энд тавьж байна. Эс бөгөөс хувь хүмүүсийн үзэл бодол гэдэг юм үгүй болно”⁵⁷ гэж бичжээ.

15:1 Арван тавдугаар бүлгийн эхний арван гурван ишлэлд өмнөх бүлгийн сэдэв үргэлжилнэ. Иудеизмаас гаралтай итгэгч нар ба шүтээн шүтлэгээс гаралтай харь үндэстэн итгэгч нарын дунд үл ойлголцол, зөрчилдөөн гарч байсан тул, иудей ба иудей бус итгэгч нарыг хоорондоо эвтэй байхыг Паул энд гуйж байна.

Хүчтэй хүмүүс нь (зөв ч биш буруу ч биш зүйл дээр харьцангуй чөлөөтэй хандагчид) өөрсдийн эрхийг өмөөрч, хувиа хичээсэн зангаар өөрсдийнхөө **сэтгэлд нийцүүлж болохгүй**. Түүний оронд, итгэлээр сул ах дүүстээ хайр халамжаар хандаж, цээрлэж цэрвэж буй юмст нь төвөг удахгүй байх хэрэгтэй.

15:2 Энд өгүүлж буй зарчим: өөрийнхөө **сэтгэлд нийцүүлэхийн** төлөө амьдарч болохгүй. Харин **хөршийнхөө сэтгэлд нийцүүлж**, түүнд сайныг үйлдэж, түүнийг **босгон байгуулахын** төлөө амьдар. Христэд итгэгч хүний хандлага ийм байвал зохино.

15:3 **Христ** бол бидний үлгэр жишээ. Тэрээр өөрийнхөө биш, Эцэгийнхээ сэтгэлд нийцүүлэхийн төлөө амьдарсан. Тэрээр,

“Таныг буруутгасан хүмүүсийн буруутгал над дээр буув” (Дуулал 69:9) гэж хэлжээ. Тэрээр Бурханы хүндлэлийг туйлаас эрхэмлэдэг байсан тул, хүмүүс Бурханыг доромжлоход тэр бүхнийг Өөр дээрээ тусган хүлээн авсан гэсэн үг.

15:4 Дууллаас ийнхүү иш татсан нь Хуучин гэрээний бичвэрүүд **биднийг сургахын тулд бичигдсэн** гэдгийг сануулж байна. Тэдгээр бичвэрүүд шууд бидэнд хандан бичигдээгүй боловч бидэнд хэрэгтэй үнэлж баршгүй сургамжуудаар дүүрэн. Биднийг асуудал бэрхшээл, зөрчил маргаан, зовлон шаналал, хүнд хэцүүд унах үед, Бурханы бичвэрүүд бат тууштай байхыг бидэнд сургаж, биднийг тайтгаруулдаг. Тэгснээр бид давлагаан доор живэлгүй, Эзэнээс бидэнд бэлдсэн **найдвараар** тэнхээждэг.

15:5 Паул дээрх бүхнийг өгүүлээд, **тэвчээр ба урамшууллыг өгөгч Бурхан**, хүчтэй ба сул дорой, иудей ба харь үндэстэн итгэгч нарыг **Христ Есүсийн** сургаал ба үлгэр жишээний дагуу эв найртай амьдруулах болтугай гэсэн хүслээ илэрхийлсэн.

15:6 Ингэснээр, **Эзэн Есүс Христийн Эцэг Бурханд** ариун хүмүүс хамтдаа мөргөх юм. Аврагдсан иудейчүүд, аврагдсан харь үндэстнүүд Эзэнийг **нэг дуу амаар** магтана. Юутай сайхан зураг вэ!

Ром номд **ам** гэж дөрвөн удаа гардаг. Ингэхдээ аврагдсан хүний туулдаг үе шатыг

санагдуулдаг. Эхлээд түүний ам хараал ба гашуун үгээр дүүрэн байсан (Ром 3:14). Тэгтэл түүний ам таглагдаж, Шүүгчийн өмнө буруутай нь тогтоогдсон (Ром 3:19). Дараа нь тэр амаараа Есүсийг Эзэн гэж хүлээн зөвшөөрсөн (Ром 10:9). Харин эцэст нь түүний ам Эзэнийг магтан алдаршуулж байна (Ром 15:6).

15:7 Энэ бүхнээс бас нэгэн зарчим гарч ирдэг. Ач холбогдол багатай юмсын талаар бид өөр өөр үзэл бодолтой байж болох ч, **Христ** биднийг **хүлээн авсны адил**, бид **бие биеэ хүлээж авах** хэрэгтэй. Нутгийн чуулганд итгэгчийг хүлээн авахын жинхэнэ үндэслэл энэ. Бид урсгал чиглэл, сүнсний төлөвшил, нийгмийн гарлыг нь харж хүлээн авдаггүй. Бид **Христийн хүлээн авсан хүмүүсийг Бурханы алдрын төлөө** хүлээн авах хэрэгтэй.

15:8 Есүс **Христийн** үйлчлэл нь иудей болон харь үндэстнүүдэд хандсан тул бидний сэтгэл тэднийг аль алийг нь шингээхүйц уужим байх хэрэгтэй гэдгийг элч Паул дараагийн зургаан ишлэлээр дамжуулан уншигч нартаа сануулсан. Мэдээж хэрэг Христ **хозлолтой** хүмүүст, иудейчүүдэд үйлчлэхээр ирсэн нь тодорхой. Бурхан Израиль уруу Мессиаг илгээнэ гэж удаа дараа амлаж байсан бөгөөд Христийн ирэлт тэдгээр **амлалтуудын** үнэнийг нотолсон.

15:9 Түүгээр ч зогсохгүй, Христ **харь үндэстнүүдэд** бас ерөөл авчирсан. Үндэстнүүд сайнмэдээг сонсоод, тэдний дотроос итгэсэн

хүмүүс **Бурханыг** агуу **өршөөлийнх нь төлөө алдаршуулахад** Бурханы зорилго оршиж байв. Үүнийг иудей итгэгч нар гайхан хүлээж авах хэрэггүй. Яагаад гэвэл энэ тухай тэдний бичвэрүүд урьдаас айлдсан. Жишээ нь гэхэд Дуулал 18:49-д, Мессиа харь үндэстний итгэгч нартай хамт Бурханд магтаалыг **дуулна** гэж Давид зөгнөжээ.

15:10 Дэд хууль 32:43-т, харь үндэстнүүдийг Бурханы **ард түмэн** Израилтай хамт авралын ерөөлд баярлан байгаагаар дүрсэлсэн байна.

15:11 Дуулал 117:1-д, израильчууд Мессиагийн мянган жилийн хаанчлалд, **харь үндэстнүүдийг Эзэнийг магтахад** уриалж байгаа нь сонсогддог.

15:12 Мессиагийн захиргаанд **харь үндэстнүүд** багтана гэдгийг **Исаиа** ч бас гэрчилсэн (Исаиа 11:1,10). **Харь үндэстнүүд** Мессиа болон түүний сайнмэдээний сайн сайхнаас хуваалцана гэсэн санааг энд хэлэхийг зорьжээ.

Эзэн Есүс бол **Иессийн үндэс**. Тэгэхээр Иессигээс гарсан (энэ ч *бас* үнэн) гэхээс илүү Иессиг гаргасан Бүтээгч гэсэн утгатай байна. Илчлэл 22:16-д Есүс Өөрийгөө Давидын удам ба үндэс гэж хэлсэн. Бурхан болохынхоо хувьд Тэрээр Давидын Бүтээгч мөн. Харин Хүн болохынхоо хувьд тэрээр Давидын удам мөн.

15:13 Ингээд Паул энэ хэсгийг ерөөлийн сайхан үгээр өндөрлөж, нигүүлслээр дамжуулан сайн **найдварыг** өгөгч **Бурхан** өөрт нь итгэдэг

ариун хүмүүсийг **бүх баяр баясгалан болон амар тайвнаар дүүргэх болтугай** хэмээн залбирч байна. Энэ үед Паул харь үндэстнүүдийг голлон бодож байсан болов уу. Гэхдээ түүний залбирал нь бүх хүнд тохирч байна. **Ариун Сүнсний хүчээр найдвараар бялхсан** хүмүүст шалихгүй зүйлээс болж хэрүүл маргаан хийх цаг зав байдаггүй. Бид нэг л зүйлд найддаг учраас, тэр нь христитгэлийн амьдралд маань эв нэгдлийн хүч болдог.

Ё. Паулын төлөвлөгөө (15:14-33)

15:14 Паул арван тавдугаар бүлгийн үлдсэн хэсэгт ромчууд уруу захидал бичих болсон шалтгаанаа тайлбарлаж, тэдэн дээр очихын хүслэн болж байгаагаа илэрхийлсэн.

Паул Ромын итгэгч нартай уулзаж байгаагүй боловч анхааруулга сануулгыг нь баяртай хүлээн авна гэдэгт **итгэлтэй** байв. Учир нь ромчуудын сайн сайхны талаар тэр сонссон ажээ. Мөн тэд христитгэлийн сургаалын талаар **мэдлэгтэй** учир бусдад **зааварлах чадвартай** гэдгийг түүнд дуулгажээ.

15:15 Паул тэдний сүнслэг өсөлтөд итгэлтэй байсан ч, бас тэдний хувьд танихгүй хүн байсан ч, зарим нэг үүрэг хариуцлага, хүртсэн давуу эрхүүдийг нь сануулахаас зүрхшээсэнгүй. Тэр **Бурханаас өгөгдсөн нигүүлслээр** ийм шулуухан бичсэн байна. Тэрхүү **нигүүлсэл** түүнийг элч болгосон билээ.

15:16 Бурхан түүнийг харь үндэстнүүдэд Христ Есүсийн үйлчлэгч-тахилч байдлаар томилжээ. Итгэгч нар шинээр төрж, **Ариун Сүнсээр** Бурханы төлөө тусгаарлагддаг. Тиймээс Паул, аврагдсан харь үндэстнүүдийн итгэгч нарыг тааламжит өргөл мэт Бурханд авчирдаг **Бурханы сайнмэдээг тунхаглах** ажлаа тахилчийн үүрэг гэж харж байв. Г. Кампбелл Морган энэ тухайд:

Сайнмэдээ тунхаглагч ба пасторын ажлын дээр ямар тод гэрэл тусгана вэ! Сайнмэдээг тунхаглахад авралд ирсэн сүнснүүд зөвхөн аюулгүй байдал, ивээл ерөөлийн газарт хүргэгдсэн биш ажээ. Тэд бол Бурханд өргөсөн өргөл юм. Тэд Бурханы сэтгэлийг дүүргэдэг бэлэг, Бурханы хүсэмжилдэг өргөл юм. Христийн сургаалыг няхуур нямбай, тэвчээртэй ажилчнаар заалгаж, Христийн дүр төрхтэй адил төстэй болсон сүнс бол Эцэгийн таалдаг сүнс мөн. Тэгэхээр, бид хүмүүсийг аврахын төлөө төдийгүй Бурханы сэтгэлийг хангалуун болгохын төлөө ажиллаж байна. Энэ бол хамгийн хүчтэй сэдэл мөн.⁵⁸

15:17 Паул өөрийгөө магтан сайшааж сайрхаагүй, харин Христ Есүсийн дотор сайрхсан. Мөн түүний бий болгосон үр дүн нь түүний мундагийнх бус, харин Бурхан түүгээр дамжуулж хийсэн зүйл байсан. Христийн даруу

зарц өөрөөрөө сайрхдаггүй. Харин Бурхан өөрийг нь ашиглаж зорилгоо биелүүлж байгааг мэдэж байдаг. Хэрэв хүн өөрөөрөө сайрхан бардамнаж байвал, тэрээр юу ч үгүй нэгэн гэдгээ, бас түүнд байгаа бүхэн угаас түүнийх биш, харин өгөгдсөн зүйлс гэдгийг, Ариун Сүнсний хүч чадалгүй бол Христийн төлөө юу ч хийж чадахгүй гэдгээ ойлгоогүйн шинж болой.

15:18 Бусдын үйлчлэлээр дамжуулан **Христ** юу хийсэн тухай Паул **ярьж зүрхлээгүй**. Харин өөрийг нь ашиглаж, хэлсэн үг (тунхагласан мэдээ), хийсэн үйлдлээр (үйлдсэн гайхамшиг) нь дамжуулан Эзэн харь үндэстнүүдийг дуулгавартай байдалд авчирсан ажлын хүрээнд л ярьсан.

15:19 Эзэн элч Паулын мэдээг гайхамшиг ба тэмдэг, Сүнсний хүчний янз бүрийн илрэлээр баталж өгсөн. Үр дүнд нь тэрээр Иерусалимаас аваад Иллурикум (Адриатын тэнгист, Македоны хойд зүгт байрлана) хүртэлх нутгуудад **сайнмэдээг бүрэн дэлгэрүүлжээ. Иерусалимаас Иллурикум хүртэл** гэдэг нь Паулын үйлчлэлийн газарзүйн цар хүрээг илэрхийлсэн болохоос, цаг хугацааны дарааллыг хэлээгүй.

15:20 Энэ маршрутаар явсныхаа дараа тэр сайнмэдээ огт хүрээгүй газруудад сайнмэдээ тунхаглахыг зорьж байв. Түүний сонсогч нар нь гол төлөв Христийг өмнө нь огт сонсож байгаагүй харь үндэстнүүд байв. Ийнхүү тэр өөр хүний тавьсан суурин дээр бариагүй байна.

Паул Христийн тухай сонсож байгаагүй нутагт бусдаас түрүүлж сайнмэдээ хүргэж байсан явдлыг Эзэний бусад зарц нар заавал даган дуурайх албагүй. Жишээлбэл, шинэ чуулган таригдсаны дараа тэр газар очиж, сургаж номлохоор дуудагдсан хүмүүс гэж байдаг.

15:21 Харь үндэстнүүдийн дунд суурь тавьсан энэ ажил Исаиагийн эш үзүүллэгийн (Исаиа 52:15) биелэл байв. Өмнө нь сайнмэдээний алхаа хүрээгүй нутгийн харь үндэстнүүд **харж**, сайнмэдээ **сонсож байгаагүй** хүмүүс **ойлгож**, жинхэнэ итгэлээр хүлээн авах болно гэж Исаиа зөгнөжээ.

15:22,23 Сайнмэдээний үр таригдаагүй газар очих хүслээсээ болоод Паул Ромд очихыг өмнө нь маш ихээр эрмэлздэг байжээ. **Харин одоо** 15:19-д дурдсан бүс нутагт суурь тавигджээ. Бусад хүн тэр суурин дээр барих боломжтой болсон. Тийм болохоор Паул Ромд очих гэсэн удаан хугацааны хүслээ биелүүлэх шаардлагагүй болжээ.

15:24 Гэхдээ **Испани уруу явах замдаа** Ромоор дайрч гарахаар төлөвлөжээ. Тэрээр хүсэж байсан шигээ удаан хугацаанд байж чадахгүй учраас, тэдэнтэй бүгдтэй нь нөхөрлөж чадахгүй ч тэдэнтэй нөхөрлөх хүсэл нь бага ч атугай биелэх байв. Харин дараа нь тэд Испани уруу хийж буй аяллынх нь хэрэгцээг хангаж өгнө гэдгийг тэр мэдэж байлаа.

15:25 **Харин** үүнээс өмнө Паул, Иудейн ядуу **ариун хүмүүст** зориулж харь үндэстний

чуулгануудаас цуглуулсан мөнгийг хүргэж өгөхөөр **Иерусалим уруу явах гэж байв.** Энэ мөнгөний тухай 1Коринт 16:1 ба 2Коринт 8,9 дээр дурдагдсан.

15:26,27 **Македони болон Ахайн** итгэгч нар **ядуу** итгэгч нарын зовлонг нимгэлэхийн тулд үүнд баяртайгаар мөнгө хандивлажээ. Энэ мөнгийг хүмүүс сайн дурын үндсэн дээр өгсөн ба ингэх нь тэдэнд зүйтэй санагджээ. Тэд иудей итгэгч нараар дамжиж ирсэн сайнмэдээнээс сүнслэг ивээлийг хүртсэн болохоор иудей ахан дүүстэйгээ материаллаг **эд зүйлсээ** хуваалцахыг зөв гэж үзжээ.

15:28,29 Паул амласан ёсоороо мөнгийг хүргэн өгч, энэ ажлыг **дуусгаад, Испани уруу** явах замдаа Ромоор дайрах байв. Бурханы үгийг Ариун Сүнсний хүчээр тунхаглахад, Христ үргэлж асгадаг **сайнмэдээний ерөөлийн дүүрэн байдал** түүнийг дагаж Ромд очно гэдэгт Паул бүрэн итгэлтэй байлаа.

15:30 Элч Паул өөрийнх нь төлөө залбирч байхыг ромчуудаас гуйж энэ хэсгийг дуусгаж байна. Тэрээр Ром дахь итгэгч нартай **Эзэн Есүс Христийн** дотор нэгдмэл гэдэгт үндэслэн, Ариун **Сүнснээс** ирдэг **хайранд** нь найдан үүнийг гуйсан. Өөрийнх нь хэргийг машид анхааран залбираарай хэмээн Паул тэднээс хүсэмжилсэн. Ленски хэлэхдээ, “Дэвжээн дээр тэмцэлдэх өрсөлдөгч нар шиг, хамаг сэтгэл, бүхий л бодлоо дайчлан залбирахыг Паул тэднээс хүсжээ”⁵⁹ гэсэн байдаг.

15:31 Паул залбирлын дөрвөн сэдэв өгсөн. *Нэгт:* нэгэн цагт Паулын эсэргүүцэж байсан шиг сайнмэдээг эсэргүүцэгч хүмүүс **Иудейд** олон байсан бөгөөд тэднээс хамгаалагдахын төлөө.

Хоёрт: Иудейн **ариун хүмүүс** хандивын мөнгийг сайнаар хүлээн авахын төлөө. Харь үндэстний итгэгч нар болоод харь үндэстнүүдэд сайнмэдээ тунхаглаж байгаа хүмүүст дургүй шашинлаг хүмүүс байсан. Түүнээс гадна, “хандив тусламжийг” хүлээн авахад дургүйцдэг хүмүүс ч байсан. Өгсөн нь авснаасаа илүү нигүүлсэл хүртэнэ гэж үздэг байснаас тэд ийн ханддаг байжээ.

15:32 *Гуравт:* Ромд баяртайгаар очихыг Эзэн зөвшөөрөхийн төлөө. **Бурханы хүслээр** гэдэг үгнээс харахад Паул бүх зүйл дээр Эзэнээр удирдуулахыг эрмэлзэгч байсан аж. *Эцэст нь:* Ромд очих нь хүнд бэрх үйлчлэлийнх нь амралт сэргэлт болохын төлөө.

15:33 **Амар тайвны** эх сурвалж болсон Бурханыг тэдний хувь ногдол байх болтугай гэж ерөөн залбираад Паул энэ бүлгийг өндөрлөж байна. Арван тавдугаар бүлэгт Эзэнийг *тэвчээр ба урамшууллын Бурхан* (5-р ишлэл), *найдварын Бурхан* (13-р ишлэл), амар **тайвны Бурхан** гэж нэрлэсэн. Ядуу дорой нүгэлтэнд хэрэгтэй бүхэн, шаардлагатай бүхэн нь, одоо хийгээд өнө мөнхийн хэрэгцээ нь бүхлээрээ Бурханы дотор бий. **Амен.**

Ж. Зарим хүнийг талархан танилцуулсан нь (16-р бүлэг)

Ром номын төгсгөлийн бүлгийг өнгөцхөн уншвал өнөөгийн бидэнд нэг их ач холбогдолгүй олон нэрсийн жагсаалт мэт харагддаг. Гэхдээ илүү нягтлан судалбал, хүмүүсийн тийн их ойшоодоггүй энэ бүлэг итгэгч бидэнд олон чухал сургамжийг өгнө.

16:1 Фойбег энд **Кенхрей дахь чуулганы үйлчлэгч**⁶⁰ гэж танилцуулж байна. Түүнийг тодорхой санваарт хамрагдаж байсан гэж бодох хэрэггүй. Нутгийн чуулганд үйлчилж байгаа эмэгтэйчүүд бүгдээрээ “үйлчлэгч” мөн.

16:2 Анхны итгэгч нар нэг чуулганаас нөгөө уруу очихдоо тодорхойлох захидал авч очдог байв. Энэ нь хүлээн авч байгаа чуулганд хүндлэл үзүүлдэг, очиж байгаа зочиндоо тус болдог байсан.

Тиймээс элч Паул Фойбег танилцуулж, жинхэнэ итгэгчид **зохих ёсоор**, халуун дулаан хүлээн авахыг ятгаж байна. Мөн боломжит бүх талаар тусалж дэмжихийг гуйсан. Фойбе нь Паул болон олон хүнд тусалж үйлчилсэн гэдгийг энд тодорхойлж өгчээ. Тэрээр Кенхрей дэх номлогч нарт болоод бусад итгэгчдэд зочломтгой ханддаг мятаршгүй сэтгэлтэй эмэгтэй байсан бололтой.

16:3 Дараа нь **Приска, Акул нарт** Паул мэнд дамжуулсан. Тэд **Христ Есүсийн** үйлчлэлд Паултай хамт зоригтойгоор хамтран

зүтгэжээ. Христийн зорилгын төлөө амь хайргүй зүтгэсэн энэ гэр бүлийн төлөө Бурханд талархаад баршгүй.

16:4 Приска, Акул хоёр Паулын төлөө өөрсдийн амийг үхлийн аюулд оруулсан байна. Гэхдээ энэ баатарлаг үйлсийг нарийн дурдаагүй. Паул төдийгүй Паулын үйлчилсэн **харь үндэстнүүдийн чуулганууд** тэдэнд талархаж байжээ.

16:5 Тэдний гэрийн чуулганд мэнд хүргээрэй. Энэ нь тэдний гэрт цуглаж байсан итгэгч нарын жинхэнэ цуглааныг хэлж байна. Хоёрдугаар зууны сүүл хүртэл чуулганд сүмийн барилга гэж байгаагүй. Өмнө нь Приска, Акул хоёр Коринт хотод байхдаа ч гэрт нь цугладаг чуулгантай байсан.

Епайнет гэдэг нь “магтууштай” гэсэн утгатай. Ахай мужийн анхны итгэгч тэрээр нэр шигээ хүн байв. Паул түүнийг **миний хайрт** гэжээ.

16:6 Энэ бүлэгт эмэгтэйчүүдийн нэрийг чухалчилсан байгаа нь (жишээ нь 1, 3, 6, 12-р ишлэлд) эмэгтэй хүмүүс Бурханы үйлчлэлд ихээхэн тус болж чадахыг харуулж байна. **Мариа** ариун хүмүүсийн төлөө **ихэд зүдэн зүтгэжээ**.

16:7 Андроник, Иуни нар хэзээ Паултай **хамт хоригдож байсныг** бид мэдэхгүй. **Садан** гэж хамаатан гэсэн утгатай юу, эсвэл Паулын нэг адил иудей гэсэн утгатай юу гэдгийг тодорхой хэлэхэд хэцүү. Мөн, **тэд элч нарын**

дунд нэр цуутай гэж элч нарын хүндлэлийг хүлээсэн гэсэн утгатай юу, эсвэл өөрсдөө хүндэтгэл хүлээсэн элч нар гэсэн утгатай юу гэдгийн аль нь болохыг хэлэхэд хэцүү. Тэд Паулаас **өмнө** Христэд итгэсэн гэдгийг л бид тодорхой мэднэ.

16:8 Дараа нь элч Паулын **хайртай Амплиат** бидэнтэй учирч байна. Энэ бүлэгт гарч байгаа хүмүүс Голгот толгойтой холбоотой гэдгээс өөр мэдэх юм бидэнд байхгүй ч бидний хэний ч хувьд энэ л хамгийн агуу зүйл билээ.

16:9 **Урбаныг хамтран зүтгэгч** хэмээн хүндэлж, Стахыг **миний хайрт** гэж дуудаж байна. Ром 16 дугаар бүлгийг Христийн шүүх суудлын жижиг хувилбар гэмээр санагддаг. Учир нь, Христэд итгэмжит байсан бүх үйл тэнд магтаал сайшаал хүртэх болно.

16:10 **Апел** хэцүү сорилтыг маш амжилттай даван туулж, **Христ дотор сайшаагдсан** хэмээн тамгалагджээ.

Паул **Аристовулын гэрийнхэнд** мэндчилж байна. Агуу Херод хаанд Аристовул нэртэй ач байсан. Түүний боолуудаас Христэд итгэсэн хүмүүсийг **Аристовулын гэрийнхэн** гэж нэрлэсэн байх магадлалтай.

16:11 **Херодиан** бас боол байсан байх. Паулын **садан** гэснийг бодоход, Аристовулын гэрийнхний доторх цорын ганц иудей боол нь байсан бололтой.

Наркиссын зарим боол ч бас итгэгч байжээ. Паул тэдэнд ч гэсэн мэндчилж байна. Нийгмийн

хамгийн доод давхаргын хүн ч гэсэн христитгэлийн шилмэл ерөөлийн гадна үлддэггүй. Энэ нэрсийн дунд боолуудыг оруулсан нь Христийн дотор нийгмийн ялгаа гэж байхгүйг сануулж байна. Учир нь, бид бүгдээрээ Түүний дотор нэг билээ.

16:12 Труфайна нь “туяхан”, **Труфоса** нь “тансаг” гэсэн утгатай. Гэхдээ тэд Эзэний төлөөх үйлчлэлд хүдэр морьд мэт байв. **Хайрт Персис** бас тэдгээр шаргуу эмэгтэйчүүдийн нэг байлаа. Үгүй болсон хойноо л талархал хүртдэг тэдэн шиг эмэгтэйчүүд нутгийн чуулганд үнэхээр хэрэгтэй билээ.

16:13 Руф гэж Есүсийн загалмайг үүрсэн Симоны хүү байх магадлалтай (Матай 27:32). Тэрээр Эзэний аврал авахын сацуу Христчин зан чанарын жишээ болохоор **Эзэн дотор сонгогджээ**. Тэрээр Эзэний шилдгүүдийн нэг байв. Руфын ээж Паулд эхийн сэтгэлээр ханддаг байсан тул Паул “миний ээж” хэмээн хүндэлдэг байв.

16:14,15 Асункрит, Флегон, Хермес, Патроб, Хермас нар нь Прискилла, Акул нарынх шиг (16:3,5) гэрийн чуулганд идэвхтэй үйлчилдэг байсан бололтой. **Филолог болон Иулиа, Нере болон эмэгтэй дүү мөн Олумп нар** өөр нэгэн гэр чуулганы гол хүмүүс байсан бололтой.

16:16 Ариун үнсэлт бол ариун хүмүүсийн дунд байсан, халуун мэндчилгээний хэлбэр юм. Өнөөгийн зарим оронд одоо ч ингэж

мэндчилдэг. Зохистой бус үйлдлээс зайлсхийхийн тулд **ариун** гэж онцолжээ. Өнөөгийн бидний соёлд гар барьж мэндлэх нь тэр үеийн **үнсэлттэй** адил зүйл юм.

Паулын захиагаа бичиж байсан газар, Ахайн **чуулганууд** түүнтэй хамт мэнд хүргэж байна.

16:17 Элч Паул чуулганд шургалан орсон буруу багш нарыг сэрэмжлүүлэхгүйгээр захидлаа төгсгөж чадсангүй. Өөрсдийнхөө хүрээллийг бүрдүүлж, сэрэмжгүй нэгний итгэлийг хөнөөхөөр урхи тавигч хүмүүсээс христитгэгчид өөрсдийгөө хамгаалах хэрэгтэй. Христийнхний **сурсан** эрүүл **сургаалын эсрэг** зааж номлож байгаа хүмүүсийг анхааралтай харж, **тэднээс** бүрмөсөн **холдох** хэрэгтэй.

16:18 Тийм хуурамч багш нар **бидний Эзэн Есүс Христэд** дуулгавартай хүмүүс биш. Тэд **өөрсдийн** дур хүсэлдээ захирагддаг. Тэд **ялдам үг зусар яриагаараа** ажиг сэжиггүй хүмүүсийг амжилттай урхиддаг.

16:19 Гэхдээ Паулын захидлын уншигч нар Эзэнд **дуулгавартай** бөгөөд энэ нь бүгдэд дуулдсанд Паул **баяртай** байлаа. Гэсэн ч тэднийг аливаа юмыг ялгаж салгадаг, **сайн** сургаалыг дагадаг, бузар **муугаас** холддог байгаасай гэж хүсэж байсан.

16:20 Ингэвээс, **амар амгалангийн** эх сурвалж болох **Бурхан** тэдэнд **Сатаныг** дийлэх ялалтыг өгнө.

Цог жавхлан өөд явж буй ариун хүмүүст хэрэгтэй бүхнийг элч Паул байнга хүсдэг шигээ энэ удаад ч ерөөн залбирч байна.

16:21 Бид Паулын итгэлийн хүү, итгэмжит хамтран зүтгэгч **Тимотыг** мэднэ. Харин **Лукигийн** талаар, Паул шиг иудей гаралтай гэдгээс өөр юм мэдэхгүй. Бид **Иасон, Сосипатр** гэх иудейчүүдтэй өмнө нь уулзсан байх магадлалтай (Үйлс 17:5; Үйлс 20:4).

16:22 Паул энэ **захиагаа Терт** гэдэг хүнд хэлж бичүүлжээ. Терт өөрийн зүгээс уншигч нарт мэндчилгээ дэвшүүлж байна.

16:23 Шинэ гэрээнд **Гаи** нэртэй хүн дор хаяж дөрөв бий. Энд дурдагдсан **Гаи** ба 1Коринт 1:14 дээр дурдагдсан Гаи нэг хүн байх боломжтой. Тэрээр Паулд төдийгүй, хэрэгцээ гарсан итгэгч бүхэнд зочломтгой ханддагаараа танигджээ. **Ераст** нь **Коринт хотын сан хөмрөгийн нярав** байсан байна. Үйлс 19:22, 2Тимот 4:40 дээрх Ераст нар энэ **Ерасттай** нэг хүн мөн эсэхийг бид баттай хэлж мэдэхгүй. **Куартыг** энгийнээр **дүү** гэж дурдсан байна. Гэхдээ л юутай их хүндлэл, ямар их нэр төр вэ!

16:24 “**Бидний Эзэн Есүс Христийн нигүүлсэл та бүгдтэй хамт байх болтугай**” гэдэг нь Паулын захидлаа төгсгөдөг ерөөл. **Бүгд** гэж нэмэгдсэнээс бусдаар 20 дугаар ишлэлтэй адил байна. Ихэнх гар бичмэлд Ром ном энэ ишлэлээр дуусаж, 25-27 дугаар ишлэлийн ерөөлийн үг *14 дүгээр бүлгийн ард* байдаг. Александрын текстэд 20 дугаар ишлэл

байдаггүй. Номыг ерөөлөөр дуусгах нь, тэр тусмаа **амен** гэж төгсгөх нь их тохиромжтой.

16:25 Ромчуудад бичсэн захидал ерөөлийн үгээр төгсөж байна. Энд Паулын тунхагладаг сайнмэдээнд өөрийн хүмүүсийг бат зогсоох чадалтай Бурханд хандаж байна. Паул тунхагладаг сайнмэдээг тунхагласнаар **минь** гэж хэлсэн. Авралын зам ганц гэдэг нь мэдээж. Гэхдээ энэ сайнмэдээг “харь үндэстнүүдийн элч” түүнд даалгасан ажээ. Үүн шиг, иудейчүүдэд тунхагла гэж Петрт бас энэ сайнмэдээг даалгасан байна. Энэ сайнмэдээ **Есүс Христийг** нийтийн сонорт хүргэж, ертөнцийн эхлэлээс өмнө **өнө эртний турш** нууц байсан гайхамшигт үнэнийг **илчилжээ**. Шинэ гэрээнд нууц гэдэг нь өмнө мэдэгдэж байгаагүй, хүний ухаанаар мэдэх боломжгүй, одоо ил болсон үнэнийг хэлдэг.

16:26 Итгэсэн иудейчүүд ба итгэсэн харь үндэстнүүд хамтран өв залгамжлагч, Христийн биеийн эрхтнүүд, сайнмэдээгээр дамжуулан Христийн доторх амлалтын хамтран хуваалцагч болсон нь (Ефес 3:6) тэрхүү нууц юм.

Эдүгээ энэ нь **эш үзүүлэгчдийн Бичвэрүүдээр** мэдэгдсэн. Гэхдээ Хуучин гэрээний биш, Шинэ гэрээний эш үзүүлэгчид юм. Яагаад гэвэл Хуучин гэрээний бичвэрүүдэд энэ тухай бичигдээгүй, харин Шинэ гэрээний эш үзүүлэгчдийн бичвэрүүдэд илчлэгдсэн (Ефес 2:20; 3:5-ыг үз).

Бурхан сайнмэдээг бүх үндэстэнд мэдэгдэхийг тушаасан нь тэднийг итгэлд дуулгавартай болгож, аврахын тулд болой.

16:27 Бурхан ганцаараа **мэргэн ухааны** эх сурвалж мөн. Бидний зууч, **Есүс Христээр алдар нь үүрд мөнхөд Түүнд байх болтуай!**

Ингээд Паулын гайхамшигтай захидал дуусаж байна. Үүний төлөө бид Эзэнд өртэй. Энэ захидал үгүйсэн бол бид хэчнээн ядуу байх байсан бэ! **Амен.**

ТЕСАЛОНИКИЙН ЧУУЛГАНД БИЧСЭН НЭГДҮГЭЭР ЗАХИДАЛ

ОРШИЛ

“Паулын бусад захиаг бодвол энгийн хялбар, аядуу зөөлөн, халамж анхааралтай өнгө аяс энэ захидлаас мэдрэгддэг...энэ захианд ямар нэг маргаан зөрчилдөөний тухай байдаггүй”

–У. Грэхэм Скрожси

І. БИЧЭЭСТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Алдартай зохиогчийн бичсэн эхний номд юуг анхнаасаа онцлон анхаарч байгааг, бусдад хүрэх хэр ур чадвартайг харуулдгаараа өндөр үнэлэгдэх нь бий. Нэгдүгээр Тесалоник нь Паулын бичсэн анхны ариун бичээс захидал байх боломжтой. Уг захидалд гарч байгаа сургаалууд Тесалоникийн итгэгч нарт аль хэдийнээ танил болсон мэт бичигдсэнийг харахад элч Паул Тесалоникт байсан ахархан хугацаандаа Христитгэлийн маш олон сургаалыг зааж амжсан бололтой.

Өнөөдөр итгэгч нарын шүүрэлт ба Эзэний маань хоёр дахь ирэлтэд евангелийн урсгалын итгэгч нар итгэдэг. Бас тэдгээр үйл явдлыг

хүлээдэг. Гэхдээ үргэлж ийм байсангүй. Итгэгч нар энэ онол сургаалыг нухацтай авч үзэх болсон нь Их Британид байсан анхны ахан дүүсийн цуглааны (1825-1850) бичиг туурвилаас гол төлөв улбаатай бөгөөд энэхүү явдал IТесалоникоос үндэс язгуураа авчээ. Энэ захидал үгүй байсан бол Христийн дахин ирэлт ямар байхыг бид зарим талаар сайн мэдэж чадахгүй өнгөрөх байжээ.

II. ЗОХИОГЧ

IТесалоникийг Паул бичсэн гэдгийг Библийн эрдэмтдийн дотроос үгүйсгэдэг хүн үгүй. Ж. Э. Фрэйм хэлсэнчлэн, “Паул гэж хүн огт байгаагүй, түүний бичсэн нэг ч захидал өнөөдөр үлдээгүй гэдгийг батлах гээгүй л юм бол”¹ энэ захидлыг Паул бичсэн гэж үзэх нотолгоо хангалттай бий.

Паул энэ захидлыг бичсэн хэмээн Поликарп, Игнатус, Иустин нарын бичиг зохиол, Марсионы бичээс болоод Мураторын бичээс (Христитгэлийн судруудын эртний жагсаалтууд-эхнийх нь буруу номд тооцогддог, хоёр дахь уламжлалт итгэлийнх) дурдсан байдаг нь *гадаад баримт* юм.

Дотоод баримт гэвэл, Паулын үг хэллэг, найрлага, мөн уян зөөлөн сэтгэлтэй, сүнслэг эцгийн өнгө аяс юм. Дурдсан үйл явдлууд Үйлс номынхтой таарч байна. Түүнээс гадна, 1:1 ба 2:18-д зохиогч өөрийгөө Паул хэмээн нэрлэсэн.

III. БИЧИГДСЭН ОГНОО

Паул арван найман сар Коринтод байх хугацаандаа, Тимотыг өөр рүү нь ирээд нэг их удаагүй байхад (1Тесалоник 3:16; 2:17) 1Тесалоникийг бичсэн. Түүхчид Галлионыг (Үйлс 18-р бүлэг) МЭ 51 оны зуны эхэн сард захирагч болсон гэж үздэг учраас Паул тэнд 50 оны эхээр очиж, түүнээс хойно нэг удалгүй 1Тесалоникийг бичсэн байх учиртай байна. Бараг бүх эрдэмтэд энэ номын бичигдсэн хугацааг 50-аад оны эхэн гэж үздэг. Илүү нарийн хэлбэл МЭ 50 юм уу 51 онд бичигдсэн гэж үзэх нь зүйтэй. Нэг ёсондоо Эзэн маань тэнгэр өөд одсоноос хорьхон жилийн дараа болно.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ, ХӨНДСӨН СЭДЭВ

Паулын илгээлтийн хоёр дахь аян буюу сайнмэдээний гэрэл Тесалоникийн харанхуйд анх гийсэн үе байлаа (Үйлс 17:1-10).

Паул, Силас нар Филиппой дахь шоронгоос суллагаад Амфиполь, Аполлоноор дайрч, Тесалоник хотод хүрэлцэн иржээ. Тухайн үед Тесалоник нь худалдаа арилжаа ба улс төрийн хувьд стратегийн ач холбогдолтой хот байв. Паул заншсанаараа Иудейн синагогт очиж, Хуучин гэрээг тайлбарлахдаа Мессиа зовлон эдэлж, үхлээс амилах ёстой байсан гэж ухуулав. Тэгээд Назарын Есүс бол амлагдсан Мессиа

байсан гэдгийг тунхаглав. Гурван Бямба гарагийн ярьжээ. Иудейчүүдийн зарим нь Паулын мэдээг хүлээн авч, Христэд итгэн Паул, Силас нартай хамт байх болов. Бас үй олон грек хүн, хотын хэсэг язгууртан эмэгтэйчүүд итгэв. Гэтэл эсэргүүцэл өрнөх нь тэр. Итгээгүй иудейчүүд гудамжны танхайчуудаас хүмүүс цуглуулаад үймээн өдөөж, Паул, Силас хоёрын сууж байсан Иасоны гэрт ирэв. Тэд Иасоны гэрээс номлогч нарыг олоогүй болохоор Иасоныг зарим итгэгч нарын хамт хотын эрх баригчдын (политархууд) өмнө чирч авчран дэлхийг үймүүлсэн хэргээр буруутгав. Энэ нь бол үнэндээ магтаал гэмээр санагддаг. Тэгээд тэд Христигэлтнүүдийг буруутгахдаа “тэд Есүс нэртэй өөр хааныг өргөмжилж, Цезарийг унагахаар хуйвалдсан” хэмээн гүтгэжээ. Энэ бол политархуудын хувьд том асуудал байлаа. Политархууд Иасон ба түүний нөхдөөс баталгаа гаргуулан аваад суллажээ. Ингэхдээ гэрийнхээ зочдыг хотоос явуул гэсэн хатуу тушаал өгсөн бололтой.

Тесалоник дахь Христигэлт ах дүүс номлогч нарыг хотоос явах нь дээр хэмээн үзэж, тэднийг Берой уруу үдэж гаргав.

Паул, Силас хоёр тэндээс явсан боловч тэдний ард итгэлийн сургаалыг сайн ойлгосон, туулсан хавчлагаасаа болж шантраагүй итгэгч нарын чуулган үлдсэн гэдэг нь үнэхээр гайхалтай. Үйлс 17:2-ыг уншаад Паул ба түүний хамтрагч нар Тесалоникт гурван долоо л хоносон гэж хялбархан дүгнэж болох юм.

Гэхдээ тэр нь синагогт сургасан үйлчлэлийнх нь хугацааг л хэлсэн болов уу. Паул тэргүүтэй хүмүүс Тесалоник хотод дор хаяж гурван сар болсон байх учиртай. Паулаас Тесалоникчуудад бичсэн захидлыг уншвал, тэндэхийн итгэгч нар Христийн сургаалын өргөн ойлголттой байсан нь харагддаг. Энэ олон зүйлийг ярихын тулд гурав, дөрвөн долоо хоног хангалтгүй.

Паул Берой ороод дараа нь Афин уруу явав (Үйлс 17:15). Тэнд байхдаа тэр Тесалоникийн итгэгч нарт хавчлага нүүрлэснийг дуулжээ. Паул тэдэн дээр очихыг хүссэн боловч Сатан саатуулсан байна (1Тесалоник 2:17,18). Тэгэхээр нь Паул Тимотыг тийш илгээжээ (3:1, 2). Тимот буцаж ирэхдээ тесалоникчуудын талаар маш сайн мэдээ авчирсан нь элч Паулд энэ захидлыг бичих шалтгаан болов. Паул гүтгэж гутаасан дайралтаас үйлчлэлээ өмгөөлж, тухайн нийгэмд ноёлсон ёс бус явдлаас ангид байхыг уриалж, Христ дотор нас барагсдын талаарх буруу ойлголтыг залруулж, Христ ирнэ гээд ажил хийхгүй байгаа хүмүүсийг зэмлэж, сүнслэг удирдагч нараа хүндэлж байхыг ариун хүмүүст ятгасан.

1Тесалоникийн өгүүлж байгаа нэг чухал асуудал бол Эзэн Есүсийн дахин ирэлт болно. Эзэн Есүсийн дахин ирэлтийг 1Тесалоникийн бүлэг бүрд дор хаяж нэг удаа дурдсан байна. Ж. Р. Хардин Вүүд тэр бүгдийг нэгтгэн дараах дүгнэлтийг хэлсэн:

Эзэн Есүсийн эргэн ирэхийг хүлээгч итгэгч хүн (1) зүрхэндээ шүтээн (1:9, 10), (2) үйлчлэлдээ цалгардал (2:9, 19), (3) нөхөрлөлдөө хуваагдал (3:12, 13), (4) бодолдоо гутрал (4:13-18), (5) амьдралдаа нүгэл (5:23) байлгаж эс чадна.²

ТОЙМ

I. МЭНДЧИЛГЭЭ (1:1)

II. ПАУЛ БА ТЕСАЛОНИКЧУУДЫН ХАРИЛЦАА (1:2-3:13)

А. Паул Тесалоникчуудыг магтан сайшаасан нь (1:2-10)

Б. Тесалоникт байхдаа Паулын хийсэн үйлчлэл, дамжуулсан мэдээ, гаргасан зан хандлага (2:1-12)

В. Тесалоникчууд сайнмэдээнд ямар хандлага үзүүлснийг сөхөж ярьсан нь (2:13-16)

Г. Паул Тесалоник уруу буцаж очиж чадаагүйгээ тайлбарласан нь (2:17-20)

Д. Тимот Тесалоникт очсон нь (3:1-10)

Е. Паулын залбирал (3:11-13)

III. ПРАКТИК ЗӨВЛӨГӨӨ (4:1-5:22)

А. Бурханы хүслийг биелүүлдэг ариусгал (4:1-8)

Б. Бусдыг боддог хайр (4:9, 10)

В. Гаднах хүнд ярьдаг амьдрал (4:11, 12)

Г. Итгэгчдийг тайтгаруулдаг найдвар (4:13-18)

Д. Эзэний өдөр (5:1-11)

Е. Ариун хүмүүст хандсан янз бүрийн зөвлөмж (5:12-22)

IV. ТЕСАЛОНИКЧУУДАД ХАНДСАН ТӨГСГӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ (5:23-28)

ТАЙЛБАР

I. МЭНДЧИЛГЭЭ (1:1)

Дэлхийг үймүүлсэн хэмээн буруутгагдсан гурван эрийн нэрээр энэ захидал эхэлж байна. Энэ гурвыг буруутгасан хүмүүс тэдний нэр төрийг гутаан доромжлохыг зорьсон боловч үнэндээ нэр алдрыг нь өндөрт магтчихсан.

Паул бол энэ захидлыг бичсэн хүн. **Силуан**, **Тимот** хоёр тухайн мөчид Паултай хамт явж байсан хүмүүс. Тиймээс тэдний нэр энд орсон. **Силуан** болбоос Филиппой хотын шоронд Паултай хамт дуулж байсан Силас байх магадлалтай (Үйлс 16:25). **Тимот** бол Лустр хотоос гаралтай дүү бөгөөд Тесалоник уруу хийх Паулын аялалд нийлсэн байна (Үйлс 16:1).

Энэ захиаг **Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христ доторх тесалоникчуудын чуулганд** бичжээ. *Чуулган* (экллэсиа) хэмээн орчуулж байгаа үг нь ямар ч төрлийн чуулганыг илэрхийлж болох байсан тул Паул үүнийг тодорхой болгож, хуурамч шүтээнтэй хүмүүсийн чуулган бус, **Эцэг** болох **Бурхан**, **Эзэн** болох **Есүс Христийн** чуулган шүү гэж тодотгон өгчээ.

Мэндчилгээний үгэнд гарч байгаа **нигүүлсэл** ба **амар амгалан** бол тэнгэрийн талаас хүртэж болох хамгийн сайхан ерөөл билээ. **Нигүүлсэл** гэдэг нь өгөгдөх ёсгүй хайр ивээл амьдралын маань талбар бүрд өгөгдөхийг

хэлнэ. **Амар амгалан** гэдэг нь амьдрал бусниулсан нөхцөлд ч үл тэвдэх нам гүм байдал юм. **Нигүүлсэл** бол шалтгаан, **амар амгалан** бол нөлөө. Паул эдгээр ерөөлийн эх сурвалж болсон хоёр ариун нэрийг байнга цуг дурдах нь энэ хоёр бол эн тэнцүү гэдгийг харуулдаг.

II. ПАУЛ БА ТЕСАЛОНИКЧУУДЫН ХАРИЛЦАА (1:2-3:13)

A. Паул тесалоникчуудыг магтан сайшаасан нь (1:2-10)

1:2,3 Паул залбирах бүрдээ тесалоникчуудыг дурсдаг байв. (Бид Христ итгэлт ах, эгч, дүүсээ байнга санаж байна уу?) Паул тэдний төлөө залбирахдаа **үргэлж талархаж, итгэлийн үйл, хайрын хөдөлмөр, найдварын тууштай байдлыг нь санадаг байв. Итгэлийн үйл (ажил)** гэж Бурхан уруу эргэсэн явдлыг нь хэлсэн бололтой. **Итгэлийг ажил үйл** мэт дүрсэлсэн нь “Бид Бурханы ажлыг гүйцэтгэхийн тулд юу хийх вэ?” гэсэн асуултад Есүс “Та нар түүний илгээсэн нэгэнд итгэх нь Бурханы ажил мөн” гэж хэлснийг санагдуулдаг (Иохан 6:28, 29). Энэ талаас нь бодвол итгэл гэдэг үйлдэл ажээ. Гэвч өөрөөрөө сайрхах, гавьяа байгуулах ямар нэг хөдөлмөр биш юм. Үнэндээ, Христээс Аврагч гэх алдрыг нь булаалгүйгээр арчаагүй нүгэлтэн гэх байр сууриа хүлээн зөвшөөрөхдөө хүний хийж чадах

цорын ганц үйл бол энэ билээ. Итгэл болбоос бүтээл нь Бүтээгчээ хүлээн зөвшөөрөх, нүгэлтэн Аврагчаа хүлээн зөвшөөрөх гавьяат бус ажил болно. **Итгэлийн үйл (ажил)** гэдэгт бас Бурхан уруу эргэсний дараах итгэлийн *амьдралыг* ойлгох хэрэгтэй.

Паул тесалоникчуудын **итгэлийн үйлээс** гадна **хайрын хөдөлмөрийг** нь дурсан санадаг байв. Тесалоник дахь итгэгч нарын Бурханд үйлчлэх үйлчлэл нь Эзэн Есүсийг гэх хайраас нь улбаатай байсныг эндээс харж болно. Христитгэл бол хийх ёстой үүргийн улмаас хүлцэн тэвчдэг амьдрал биш ээ. Харин хайрын улмаас үйлчилдэг тэр Нэгэн билээ. Түүний зарц байх нь төгс эрх чөлөө бөгөөд “Түүнийг хайрлах хайр хүчир хүндийг гүйцэтгэх тэнгэрлэг хүчтэй болгодог.” Хайрыг ашиг харсан сэтгэлтэй харьцуулбал, ашиг нь хямдхан үнэ цэнэгүй урамшуулал гэлтэй. Мөнгөөр хэзээ ч хийж чадахгүй үйлчлэлийг Христийг гэх хайраар хийж чаддаг. Тесалоникчууд энэ үнэнийг амьдралаараа гэрчилсэн байна.

Эцэст нь Паул тесалоникчуудын **найдварын тууштай байдалд** талархсан. Өөрөөр хэлбэл, тесалоникийн итгэгч нар Есүсийг тууштай хүлээдэг болох нь эндээс харагдана. Христийн төлөө зоригтой зогссоны улмаас тэд хавчигдах болжээ. Гэхдээ итгэлд нь ямар ч ан цав үүссэнгүй. Филипс үүнийг “мятаршгүй тууштай тэвчээр” хэмээсэн байдаг.

Паулын дурсан санах газар нь **бидний Бурхан бөгөөд Эцэгийн өмнө** байв. Паул Бурханы өмнө залбирахаар очихдоо ариун хүмүүсийн сүнслэг төрөлт ба өсөлтийн талаар дурдаж, тэдний итгэл, хайр, найдварын төлөөх талархлаар амьсгалдаг байжээ.

1:4 Энэ ариун хүмүүсийг **Бурхан** ертөнцийн сууриас өмнө сонгосныг элч Паул батлан хэлж байна. Паул үүнийг яаж мэдсэн юм бол? Түүнд ер бусын хараа байсан гэж үү? Үгүй ээ. Сайнмэдээг хүлээн авсан учир тэд сонгогдсон хүмүүс байсныг Паул мэдэж байсан.

Сонгогдох тухай сургаал⁴ нь Христийн доторх хүмүүсийг Бурхан ертөнцийн сууриас өмнө сонгосон байдаг (Ефес 1:4) хэмээн заадаг. Гэвч шийтгэгдэх хүмүүсийг сонгосон тухай *заадаггүй*. Хүн аврагдаагүй бол энэ нь тухайн хүний өөрийнх нь нүгэл ба итгэлгүй байдлын үр дүн болно.

Сонголтыг заадаг Библи хүний хариуцлага ба сонголт хийх эрх чөлөөг ч бас заадаг. Бурхан газар бүрийн хүн бүхэнд жинхэнэ авралыг санал болгосон билээ. Христ рүү хэнийг ч тэр халуун дотноор хүлээн авна.

Бурханы сонголт ба сонголт хийх хүний эрх чөлөөний тухай энэ хоёр сургаал хүмүүний оюун бодолд авцалдаж ойлгогддоггүй. Гэвч Библи хоёуланг нь заадаг. Тиймээс бид хоёуланг нь уялдуулан ойлгож чадахгүй ч гэлээ хоёуланд нь итгэх ёстой.

Сонгогдогсод нь хэн гэдгийг бид мэдэхгүй. Тиймээс сайнмэдээг бүх дэлхийд хүргэх ёстой. Нүгэлтнүүд сонголтын тухай сургаалыг бариад өөрсдийн итгээгүй явдлыг өмөөрөх эрхгүй. Гэмшиж, Эзэн Есүс Христэд итгэвэл Бурхан тэднийг дамжиггүй аварна.

1:5 Паул **бидний сайнмэдээ** гэж хэлэхдээ бусад элч нарынхаас ондоо мэдээ байгаа гэсэн утгаар хэлээгүй болно. Тэдний сайнмэдээний агуулга нэг боловч, дамжуулсан хүмүүс нь ондоо байсныг Паул ярьж байна. Тесалоникчууд энэ мэдээнд зүгээр л нэг шашны лекц номлол мэт хандсангүй. Тэд үүнийг үгээр хүлээн авсан хэдий ч **зөвхөн үгээр байсангүй**.

Сайнмэдээ нь бас **хүч ба Ариун Сүнс дор бүрэн баталгаагаар** тэдэнд очжээ. (1) **Хүч дор**. Сайнмэдээ нь тэдний амьдралд ер бусын хүчээр ажиллаж, нүглийг ухаарах, гэмших, Бурхан уруу эргэх сэтгэлийг өгсөн. (2) **Ариун Сүнс дор**. Тэр хүчийг Ариун Сүнс бий болгосон. (3) **Бүрэн баталгаагаар**. Паул сайнмэдээг бүрэн баталгаатай гэдгийг мэддэг тул итгэл төгс тунхагласан. Тесалоникчууд үүнийг **бүрэн баталгаагаар** Бурханы үг хэмээн хүлээн авсан. Үр дүнд нь тэдний амьдрал итгэлийн бүрэн баталгаа болов.

Одоо Паул тэдэнтэй хамт байхдаа ямар байснаа сануулж байна. Тэр сайнмэдээг тунхаглаад зогсохгүй түүндээ нийцсэн амьдралаар амьдарч байв. Хамгийн сайн номлол бол ариун амьдрал билээ.

1:6 Тийм учраас Паул, “**Та нар биднийг болон Эзэнийг дуурайгчид болсон**” гэж хэлж чадсан. Зарим хүн Паулыг, “Эзэнийг болон биднийг” гэж Эзэнийг нэгт дурдах ёстой байсан гэж хэлэх байх. Гэвч Паул энд амьдрал дээр болсон үйл явцын дарааллаар ярьж байна. Тесалоникчууд Эзэн Есүсийг таньж мэдэхдээ эхлээд элч Паулын амьдралыг харсан юм.

Хүмүүс бидний дотроос Христийг харах боломжтой гэдгийг эндээс ойлгож болно. “Би Христийг дуурайдаг шиг намайг дуурайгчид бай” (1Коринт 11:1) гэж Паулын хэлсэн үгийг бид ч бас зоригтой хэлж чадах ёстой.

Тесалоникчууд үгийг **зовлон дор баяр хөөртэйгөөр** хүлээн авсан гэснийг анхаарна уу! Үүгээрээ тэд Эзэнийг болоод элч нарыг дуурайсан юм. Гадна нь **зовлон**, дотор нь **баяр хөөр** байжээ. Энэ бол этгээд хачин явдал юм. Энэ ертөнцийн хүнд зовлон ба баяр хөөр нэг зэрэг байх боломжгүй. Тийм хүний хувьд зовлон бол баяр хөөрийн эсрэг зүйл. Христитгэгч хүнд амьдралын нөхцөл байдлаас үл шалтгаалах **Ариун Сүнсний баяр хөөр** байдаг. Түүний хувьд баяр хөөрийн эсрэг нь нүгэл юм.

Тэдний тэвчсэн **зовлон** бол Бурхан уруу эргэснийх нь дараа ирсэн хавчлага дарамт байв.

1:7 Тесалоникчууд итгэлийн үлгэр дуурайл болжээ. Хавчлага дунд ч баяр хөөртэй байсан тэдний жишээ нь юуны түүрүүнд **Македони**

болон Ахайн итгэгч нар буюу Грект байсан бүх итгэгч нарт үлгэр дуурайл болов.

1:8 Гэхдээ тэдний гэрчлэл түүгээр зогссонгүй. Итгэл нь хэд дахин их үр жимс ургуулав. Усны дээрх долгион жижгээс томрох мэт **Эзэний үг** эхлээд **Македони болон Ахайд**, дараа нь **хаа сайгүй** тархав. **Бурхан дахь итгэлийнх** нь тухай мэдээ маш ихээр тархсан учраас Паул ч энэ тухай ярих шаардлагагүй болжээ. Тесалоникчуудын тухай хүмүүс аль хэдийнээ мэддэг болсон байв.

Бидэнд өгөгдсөн ерөөлийг зөвхөн өөрсдөдөө хадгалах нь буруу. Харин бид түүнийг бусад уруу урсгах суваг болох ёстой. Бурхан бидний зүрхэнд гэрэлтсэн нь бусдад тэр гэрлийг өгөхийн төлөө байсан (2Коринт 4:6 JND орчуулга). Хэрэв бид авралын усыг үнэхээр уусан юм бол амийн усны гол биднээс тал тал тийшээ урсан гарах болно (Иохан 7:37, 38).

1:9 Элч Паул ба түүний нөхдийг Тесалоникт очиход хэрхэн халуун дотно угтсан гэдгийг ард олон хэлэлцэж байна. Мөн олон хүний амьдралд гайхалтай өөрчлөлт гарсныг тэд бас ярилцжээ. Тэр хүмүүс **шүтээнүүдээсээ Бурхан өөд эргэж**, зарц мэт Бурханд үйлчлэх хүсэлтэй болцгоожээ.

Тэд шүтээнийхээ оронд Бурханыг сольж тавьсан биш, харин **шүтээнүүдээсээ Бурхан уруу эргэсэн** гэдгийг анхаараарай. Тэд шүтээнүүдээсээ залхсанаа энэ Бурханыг нэг шалгаад үзье гэсэн хандлагатай байгаагүй.

Харин тэд **Бурхан уруу эргэсэн** бөгөөд үнэхээр сэтгэл ханасан учраас шүтээнүүдээ хаясан.

Петрийг хайлуулсан тэр харц,
Стефаны харсан тэр царай,
Мариатай уйлсан тэр зүрх л
Шүтээнээс биднийг салгаж чадна.

-Ора Рован

Үүний цаана өгүүлж байгаа догдолсон сэтгэл, шүтэн бишрэлийг хэзээ ч алдахгүй байцгаая. Хоёр эр харь үндэстний хот уруу Эзэний үгийг авч очив. Тэд Сүнсний хүч дор сайн мэдээг тунхаглажээ. Гайхамшиг болж, хүмүүс дахин төрж байлаа. Эрчүүд, эмэгтэйчүүд Аврагчид итгэлээ өгч, шүтээнүүдээ хаяцгаав. Тэгээд дараа нь итгэгч нарын чуулган тухайн орон нутагт бий болж, Бурханыг магтан, ариун амьдарч, хавчлагыг зоригтой тэсвэрлэж, бусдыг Христ рүү авчирч байв. Эзэний үйлчлэл бол бүх дуудлагын жонон мөн.

1:10 Тесалоникчууд амьд, үнэн Бурханд (шүтээнүүд бол амьгүй бөгөөд худал) үйлчлэхээс гадна Эзэн Есүсийг хүлээж байлаа. Тэдний хүлээлт ямар байсныг задлан харцгаая:

1. Хэнийг хүлээж байгаа - **Хүү**
2. Хаанаас ирэхийг -
тэнгэрээс
3. Батлан даалт -
Түүнийг үхэгсдээс амилуулсан
4. Эрхэм нэр - **Есүс**
5. Зорилго - **ирэх**

уур хилэнгээс биднийг гэтэлгэх

Тесалоникчуудын хүлээлтийн гурван шинж чанарыг бид 9, 10 дугаар ишлэлээс харж чадна.

Эргэх (итгэлийн үйл, 3-р ишлэл)

Үйлчлэх (хайрын хөдөлмөр, 3-р ишлэл)

Хүлээх (найдварын тууштай байдал, 3-р ишлэл)

Ж.Р. Хардин Вүүд⁵ харин дараах байдлаар дүгнэсэн:

Дагах-Бурхан уруу харах

Үйлчлэх-Дэлхий рүү харах

Хүлээх-Есүс рүү харах

Тесалоникчууд Бурханы **Хүүгийн тэнгэрээс ирэхийг** хүлээж байсан. Есүс тэднийг амьд ахуйд ирнэ гэж итгэдэг байсныг нь үүнээс харж болно. Үнэндээ амьд ахуйд нь *хэдийд ч* ирж магад хэмээн хүлээж байжээ. Эзэн Есүс гарцаагүй эргэн ирнэ. Энэ бол Христитгэлийн найдвар. Энэ найдвар Шинэ гэрээний олон хэсэгт дурдагдсан. Үүнд:

Лук 12:36 – “Та нар хуримын найраас эргэж ирэх эзнээ хүлээж буй хүмүүс шиг байгтун.”

Ром 8:23 – “...биднийг үрчилж авахыг буюу бидний биеийг золин авахыг тэсэж ядан хүлээдэг.”

1Коринт 11:26 – “Учир нь энэ талхыг идэж, энэ аяганаас уух бүрдээ та нар Түүнийг ирэх хүртэл Эзэний үхлийг тунхагладаг юм.”

2Коринт 5:2 – “Тэнгэрийн орон гэрээ өмсөхийг хүсэмжлэн, энд бид гасалцгаадаг.”

Галат 5:5 – “Учир нь бид Сүнсээр дамжуулан итгэлээр зөвт байдлын найдварыг хүлээж байна.”

Филиппой 3:20 – “...бид Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна.”

Филиппой 4:5 – “Эзэн ойрхон байна.”

Тит 2:13 – “Ингэхдээ бид аугаа Бурхан ба Аврагч Есүс Христийнхээ ерөөлт найдвар хийгээд цог жавхлант илэрхийллийг хүлээдэг.”

Еврей 9:28 – “...хоёр дахиа үзэгдэхдээ нүглийг үүрэхийн тулд бус, харин өөрийг нь тэсэн ядан хүлээгсдийг аврахын тулд ирнэ.”

Иаков 5:7-9 – “Тиймээс ах дүү нар аа, Эзэнийг ирэх хүртэл тэвчээртэй байгтун. ...Эзэний ирэх ойртсон...шүүгч үүдэн дээр зогсож байна.”

1Петр 4:7 – “Бүх юмсын төгсгөл ойр ирчхээд байна.”

1Иохан 3:3 – “Түүнд ийнхүү найдаж байгаа бүхэн түүний цэврийн адилаар өөрийгөө цэвэршүүлдэг.”

Иуда 21 – “...мөнх аминд аваачих Эзэн Есүс Христийн маань өршөөлийг хүлээн...”

Илчлэл 3:11 – “Би удахгүй очно” 22:7 – “Харагтун, би удахгүй ирнэ.” 22:12 – “Харагтун би удахгүй ирнэ...” 22:20 – “ ‘Би удахгүй ирнэ.’ Амен. Ирээрэй, Эзэн Есүсээ!”

Христитгэгч Эзэний ирэлтийг үзэлгүй нас барж магадгүй. Гэвч бас Эзэн амьд ахуй цагт маань ч ирж магадгүй. Хэрэв тэгвэл итгэгч хүн үхлийг үзэлгүй шууд тэнгэр рүү явна.

Христ хүмүүсийнхээ төлөө ирэхийн өмнө Бичвэрийн аль нэг эш үзүүллэг биелсэн байх албагүй. Энэ бол Бурханы төлөвлөгөөний дараагийн том үйл явдал юм.

Хэрэв бид Эзэнийг ирэхээс өмнө ямар нэг үйл явдал эхлээд болох ёстой гэж бодох юм бол Эзэн хэзээ ч ирж магадгүй хэмээн хүлээхээ болино. Дээш өргөгдөх явдал их зовлонгийн өмнө болно гэх үзэл бол Христ өнөөдөр ч ирж магад гэдгийг итгэгч хүнд харуулдаг ганц үзэл юм. Бусад үзэл Христийн гарцаагүй ирэлтийн тухай ойлголтыг сулруулдаг.

Бидний хүлээж байгаа Нэгэн бол **ирэх уур хилэнгээс биднийг гэтэлгэх** Есүс юм. Ирж буй Аврагчийн тухай энэ дүрслэл хоёр талаар ойлгогдож болно:

1. Тэр биднийг гэм нүглийн маань мөнхийн шийтгэлээс авардаг. Христ загалмай дээр нүглийн маань эсрэг шатсан Бурханы **уур хилэнг** үүрсэн. Түүнд итгэхдээ бид Түүний гүйцэтгэсэн ажлын үр шимийг хүртэх эрхтэй гэж тооцогдсон. Иймд бид Христ Есүс дотор байгаа тул бидэнд ямар ч ял үгүй (Ром 8:1).

2. Тэр бас биднийг ирж буй шүүлтийн үеэс авардаг. Хүүг нь голсон ертөнц дээр Бурхан **уур хилэнгээ** асгах цаг үе. Үүнийг Их зовлонгийн үе, Иаковын зовлон шаналлын үе гэж нэрлэдэг (Даниел 9:27; Матай 24:4-28; 1Тесалоник 5:1-11; 2Тесалоник 2:1-12; Илчлэл 6:1-19:10).

Б. Тесалоникт байхдаа Паулын хийсэн үйлчлэл, дамжуулсан мэдээ, гаргасан зан хандлага (2:1-12)

2:1 Паул Тесалоникт байхдаа хэрхэн биеэ авч явж байсан тухайгаа 1:5 дээр цухасхан дурдаад өнгөрсөн. Харин одоо тэр энд өөрийн үйлчлэл, дамжуулсан мэдээ, биеэ авч явсан байдлаа илүү тодорхой өгүүлж байна.

Христигэлтний гол үйлчлэл бол зан чанарын үйлчлэл гэдгийг голлон ярьсан байдаг. Бидний хэн бэ гэдэг нь юу хэлсэн бэ гэдгээс хавьгүй чухал байдаг. Бидний бодлогогүй үйлдэл маань бодолтой ярианаас маань илүү чанга ярьдаг. Жэймс Дэнни ингэж хэлжээ:

“Христигэгчийн зан чанар бол ажилдаа ашиглах бүх хөрөнгө нь юм. Бусад хүн ямар ч зан чанартай байсан банкны үлдэгдэл нь баруун талдаа илүү гарч л байвал ажлаа хийгээд байж чадна. Харин христигэгч хүн зан чанарыг огоорвол бүхнээ алдсан хэрэг юм.”⁶

Илгээлтэнд амиа алдсан Жим Еллиотын тэмдэглэлдээ бичсэн үг:

“Сүнслэг ажилчны ажлын чанарыг зан чанар нь тодорхойлдог. Өөр хаана ч ийм шалгуур байхгүй. Шелли, Байрон нар ааш муутай ч гэсэн сайхан шүлэг зохиож чадна. Вагнер хэчнээн шалиг завхай байвч уянгалаг

хөгжмийн зохиол бичиж чадна. Харин Бурханы ажилд ийм зүйл огтхон ч болохгүй. Паул Тесалоникчууд ярьж байснаа өөрийн зан чанар, амьдралын хэв маягаараа харуулж байжээ. Эхний захидалдаа тэр есөн удаа “та нар мэднэ” гэж бичсэнээс харахад Тесалоникчууд Паулын амьдралыг нэвт шувт ажиглаж байсныг харуулдаг. Паул Тесалоникт очоод тунхагласан үгээ амьдралаараа харуулжээ. Энэ нь ямар ч мундаг нотолгооноос хүчтэй байв. Хаанчлалын олон ажил чанаргүй байгааг гайхах зүйлгүй. Энэ нь тухайн ажилчны ёс суртахуун, зан чанартай холбоотой.⁷

Элч Паулын эдгээр ишлэлд хэлсэн үг нь өөрийнх нь эсрэг гарсан худал буруутгалаас өөрийгөө өмгөөлсөн үг болов уу. Юуны түрүүнд тэр өөрийнх нь үйлчлэл амжилттай байсныг тесалоникчуудад сануулсан. Паулын ажил үр жимстэй байсны амьд нотолгоо нь тесалоникчууд өөрсдөө байв. Паул тесалоникчууд дээр **дэмий очоогүйг** тэд мэдэж байсан. Тэд Христэд итгэцгээж, чуулган байгуулагджээ.

2:2 Түүгээр ч барахгүй Паул зоригтой үйлчилж байсан. **Филиппойд** хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч, ширүүн харьцаатай нүүрэлдэн, Силастай хамт шоронд орсон ч зориг мохож, урам хугарсангүй. Тэгээд Паул Тесалоникт иржээ. Тэнд тэрээр Бурханы л өгч

чадах зориг зүрхээр **маш их эсэргүүцэл дунд сайнмэдээг** тунхаглажээ. Арай хулчгар хүн бол Бурхан өөрийг нь арай уриалагхан хүмүүс рүү илгээх теологийн түмэн шалтгаан гаргаж ирэх байсан биз ээ. Гэтэл Паул тэгсэнгүй. Тэрээр асар их эсэргүүцэлтэй тулгарсан ч айж эмээхийг үл мэдэн Бурханы мэдээг тунхаглаж байв. Энэ их зориг Бурханы Сүнсээр дүүрсний шууд үр дүн билээ.

2:3 Сайнмэдээнд итгүүлэх гэсэн элч Паулын **ятгалгын** эх сурвалж нь үнэн, шалтгаан нь цэвэр ариун, арга барил нь хуурмаггүй байсан. Эх сурвалж нь гэвэл, хуурамч сургаал бус Бурханы үнэн байв. Шалтгаан нь гэвэл, элч Паул тесалоникчуудын сайн сайхныг бодож байсан бөгөөд хувиа хичээсэн бузар далд шуналын сэдэл түүнд байгаагүй. Арга барил нь гэвэл, тесалоникчуудыг хуурч мэхлэх гэсэн зальт арга хэрэглээгүй. Гэсэн ч Паулд атаархсан хүмүүс түүнийг буруутгаж, буруу номтон, шуналтай хүн, зальт этгээд хэмээн цоллож байв.

2:4 Паул үйлчлэлээ нярвын ариун үүрэг хэмээн үзсэн. Паул өөрөө **Бурханаар батлагдсан** нярав, харин **сайнмэдээ** бол Бурханаас хариуцуулж **даалгасан** үнэт сан хөмрөг нь байв. Хүн яаж ч хандсан тэрхүү мэдээг итгэмжтэй тунхаглаж Бурханы таалалд нийцүүлэх нь Паулын үүрэг. Бурхан ба хүн хоёрыг зэрэг баярлуулах боломжгүй гэдгийг Паул мэддэг байсан учраас **зүрхийг маань**

шалгаж, түүнийхээ дагуу шагнагч **Бурханд** таалагдах замыг сонгожээ.

Нярав хүн эзнийхээ таалалд нийцүүлэх үүрэгтэй. Заримдаа номлогч нар дэмжлэг үзүүлж байгаа хүмүүсийгээ юу гэх бол, юу хийх бол гэдгээс эмээсэндээ үнэнийг бүрэн хэлэхгүй байх сорилттой учирдаг. Гэвч Бурхан бол Эзэн юм. Түүний мэдээг сулруулах юм уу нуун дарагдуулахыг Тэр мэднэ.

2:5 Паул 5-12 дугаар ишлэлд Тесалоникт байхдаа хэрхэн биеэ авч явж байсан тухайгаа өгүүлсэн. Үүгээрээ тэр Христийн зарц нарт гялалзсан үлгэр жишээг үлдээсэн юм.

Нэгдүгээрт, тэр худал заль мэх ба зусардал бялдуучлалаар үр дүнд хүрэхийг зориогүй. Паулын үг яриа үнэнч шударга, ил тод байсан ба Паул огтхон ч хоёр нүүр гаргаагүй.

Хоёрдугаарт, Паул Эзэний ажлыг ашиглаж баян болохыг санаархаж, хувиа хичээсэн далд сэдэл агуулаагүй. Түүний үйлчлэл **шунахайрлаа** гүйцэлдүүлэх арга хэрэгсэл байгаагүй.

Зусарч байгаагүйгээ нотлохын тулд тэр ариун хүмүүсийг гэрчээ болгосон. Харин **шунахай** сэдэлгүй хийснээ нотлохын тулд Бурханыг гэрчээ болгосон. Учир нь **Бурхан** л ганцаараа Паулын сэтгэлийг мэднэ.

2:6 Бурханы агуу хүн Паулын сэтгэл хөндөм бас нэгэн зан чанар эндээс харагдаж байна. Паул болон түүний хамтран зүтгэгч нар **Христийн элч нарынхаа хувьд**

тесалоникчуудаас санхүүгийн дэмжлэг (энд **алдар** гэж нэрлэсэн) авах эрхтэй байсан боловч тэдэнд ямар нэг ачаа дарамт болохыг хүсэлгүй өдөр, шөнөгүй ажиллаж, өөрсдийнхөө хэрэгцээг хангаж байжээ. Коринтод бол өөр байсан. Харин Тесалоникт Паул өөрийнхөө гараар хөдөлмөрлөсөн нь мөнгөний төлөө номлодог гэсэн буруутгал гаргахгүйн тулд байжээ. Түүнээс гадна, Тесалоникийн ариун хүмүүс ядуу зүдүү бөгөөд хавчигдаж байсан тул Паул тэдэнд нэмж дараа болохыг хүсээгүй.

2:7 Бурханы өв болсон хүмүүсийн дунд байхдаа Паул тэднийг захиргаадахын оронд **эх хүн хүүхдээ асрах мэт зөөлөн** байсан. Шинээр итгэсэн хүмүүсийг **асрах** хэрэгцээ байгааг Паул ойлгоод энэ үйлчлэлдээ **эх хүн** мэт анхаарал халамж үзүүлэн ажиллажээ.

2:8 Тесалоникчуудын төлөө гэсэн Паулын сэтгэл маш гүн байв. Тиймээс тэр тэднээс авах биш өгөхийг хүссэн. Паул **Бурханы сайнмэдээг** түгээхдээ хүйтэн, хөндий байдал үзүүлээгүй. Харин амиа ч хүртэл зориулах халуун сэтгэл гаргасан. Паул тэднийг хайрласан. Хайр ямар зориулалт гаргаснаа тооцдоггүй билээ. Паул өөрийн Эзэний адил үйлчлүүлэхийн тулд бус, үйлчилж, амиа өгөхийн тулд Тесалоникт очжээ (Марк 10:45).

2:9 Паулын хувиа хичээгээгүй зангийн бас нэг нотолгоо энд харагддаг: Паул өөрсдөд нь **дарамт болохгүйгээр** ариун хүмүүст үйлчлэхийн тулд майхан оёж, хэрэгцээгээ

хангадаг байв. Сайнмэдээг тунхаглагч нь бусад итгэгч нараар санхүүгийн хэрэгцээгээ хангуулах эрхтэй боловч Паул шаардлагатай цагт нь энэ эрхээсээ татгалзсан. Христийн жинхэнэ үйлчлэгч сайнмэдээг тунхагласныхаа төлөө мөнгө авсан ч аваагүй ч сайнмэдээг тунхаглахаа зогсоодоггүй. Энд гарч байгаа **зүдэл зүтгэл, дараа дарамт, өдөр шөнөгүй** гэдэг үгсийг анхаарч үзээрэй. Сайнмэдээ нь тесалоникчуудаас ширхэг зоос ч гаргаагүй боловч Паулаар асар их үнэ төлүүлсэн.

2:10 Өөрсдийнх нь дунд байхдаа Паул хэрхэн үлгэр жишээ байсныг итгэгч нар гэрчилж чадна. Харин **ариун, зөв, гэм зэмгүй** байсныг нь Бурхан гэрчилнэ. Ариун гэдэг нь нүглээс Бурхан уруу тусгаарлагдсаныг илэрхийлнэ. Зөв гэдэг нь зан чанар, биеэ авч яваа байдлыг илэрхийлнэ. Гэм зэмгүй гэдэг нь Бурхан ба хүнд хандсан хандлагыг илэрхийлнэ. Хэрэв хамгийн сайн номлол нь ариун амьдрал юм бол Паул агуу номлогч байсан нь эндээс харагдана. Гэтэл зарим номлогчийн илтгэх чадвар нь амьдралынх нь хэв маягаас илүү болсон байдаг. Түүнийг индэр дээр байхад нь хүмүүс индрээсээ битгий буугаасай гэж хүсдэг. Харин индрээс буусан үед нь дахиж индэр рүү битгий гараасай гэж хүсдэг.

2:11 Паул 7-р ишлэлд өөрийгөө эх хүнтэй зүйрлэсэн бол энэ ишлэлд эцэг хүнтэй зүйрлэж байна. Эх хүнээр зөөлөн дөлгөөн зан, хайр халамжийг илэрхийлсэн бол эцэг хүнээр мэргэн

ухаан, зөвлөгөөг илтгэсэн. **Эцэг нь хүүхдүүддээ ямар байдаг шиг тэр тэднийг ариун амьдралтай байхыг ятгаж, хавчлага зовлон дунд ч Эзэний төлөө явахыг урамшуулж, Бурханы хүсэл ба Бурханы үгэнд дуулгавартай байхын ивээл ерөөлийг гэрчилсэн.**

2:12 Паулын үйлчлэлийн зорилго нь **өөрийн хаанчлал болон алдарт дууддаг Бурханд ариун хүмүүс зохистойгоор явахад оршиж байв.**

Бид өөрсдөө Бурханд болоод тэнгэрт зохистой хүмүүс биш юм. Тэдгээрт зохистой байх байр суурийг бид Эзэн Есүс Христийн дотроос л олж авдаг. Гэхдээ Бурханы хөвгүүд болохынхоо хувьд энэхүү өндөр дээд дуудлагад **зохистой явах ёстой.** Ингэхийн тулд Ариун Сүнсний удирдлагад өөрсдийгөө захируулж, амьдралдаа байгаа нүглээ үргэлж улайн, түүнээсээ байнга татгалзаж байх нь зүйтэй.

Аврагдсан хүн бүр Бурханы **хаанчлалын** албат нар билээ. Энэ цаг мөчид тэр **хаанчлал** үл үзэгдэх бөгөөд Хаан нь эзгүй байна. Гэхдээ тэр хаанчлалын ёс суртахуун, зүй ёсны сургаалууд нь өнөөгийн бидэнд хамаардаг. Эзэн Есүс хаанчлахаар эргэн ирэх үед тэрхүү **хаанчлал** үзэгдэх хэлбэрээр байгуулагдах ба бид Хааны **алдрыг** хуваалцана.

В. Тесалоникчууд сайнмэдээнд ямар хандлага үзүүлснийг сөхөж ярьсан нь (2:13-16)

2:13 Харин одоо элч Паул 1:5 дээр цухас өгүүлсэн сэдвээ сөхөн ярьж байна. Тесалоникчууд сайнмэдээний тунхаглалд хэрхэн хандсан бэ гэдэг тухай. Тесалоникчууд сайнмэдээг хүлээн авахдаа (өөрөөр хэлбэл сонсохдоо) хүний үг бус Бурханы үг гэж хүлээн авчээ (өөрөөр хэлбэл хүлээн зөвшөөрсөн). 13 дугаар ишлэлд энэ тухай тодорхой өгүүлсэн байна:

Та нар биднээс Бурханы үгийг хүлээн авахдаа үүнийг хүний үг бус, харин итгэдэг та нарын ч дотор ажилладаг Бурханы үнэн үг гэж байгаагаар нь хүлээн авсан. Үүнд бид бас Бурханд үргэлж талархдаг юм.

Тесалоникчууд сайнмэдээг итгэн хүлээн авсанд Паул маш ихээр талархдаг байжээ. Паулын хувиа хичээгээгүй зангийн бас нэг жишээ бол энэ мөн. Бид харин хүмүүсийг өөрсдийнхөө үгэнд итгүүлэхийг хүсдэг. Гэтэл хүний үг итгэлийн бат суурийг тавьж чадахгүй. Хүн зөвхөн Бурханд бүрэн итгэх ёстой. Тэгэхийн тулд хүн Бурханы үгэнд итгэх ёстой. Ингэснээр хүмүүсийн зүрх сэтгэл болон амьдралд үр дүн гарна. Тесалоникчуудад яг ийм зүйл тохиолдсон. Тесалоникчууд Бурханы үгэнд итгэсэн учраас тэр үг тэдний амьдралд ажилласан. Уолтер Скотт энэ тухай ингэж хэлжээ:

Бурханы үг болох Библийн бүх ном, бүх хэсэг Бурханы амьсгалаар бичигдсэн. Бүх юмс, бүх нөхцөл байдал, бүх цаг хугацаанд Библи бол бидний цорын ганц эрх мэдэл мөн. Бурханы үгэнд чичирдэг үеийнхэн хэрэгтэй байна. Бурханы үг бол амьдралын луужин, бидний хөтөч, бидний гэрэл, бидний ёс зүйн баталгаа. Ариун номын төлөө Бурханд талархаж байна.⁸

2:14 Тесалоникийн итгэгч нарын амьдралд Библи ямар үр дүнг бий болгосон бэ? Тэд зөвхөн аврагдаад зогсохгүй хүчтэй хавчлагын өөдөөс зоригтой сөрөн зогссон. Энэ нь тэд үнэхээр итгэсэн гэдгийг баттай харуулсан. Тэд гуйвшгүй тэвчээртэй байснаараа **Иудей** дэх Христийн **чуулгануудыг дуурайгчид болов**. Тесалоникчууд **нутаг нэгт** харь үндэстнүүдээс хавчлага **зовлон амссан** бол Иудей дэх итгэгч нар **иудейчүүдээс** хавчлага зовлон амссанаараа л ялгаатай байлаа.

2:15 Паул энд иудейчүүдийг сайн мэдээний хамгийн том эсэргүүцэгч нар хэмээн буруутгаж байна. Энэ тухай Паулаас илүү мэдэх хэн байх вэ? Нэгэн цагт Паул өөрөө Христитгэлийг буулгаж авах гэсэн тэдгээр иудейчүүдийн нэг толгойлогч байсан. Харин Христэд итгэснийхээ дараа тэдний хавчлагын илдний хурц ирийг өөрөө амссан билээ.

Иудейчүүдийн хамгийн хүнд нүгэл нь **Эзэн Есүсийг** цовдолсон нь юм. Цовдлох ялыг

ромчууд гардан гүйцэтгэсэн ч гэлээ тэднийг турхирсан нь иудейчүүд байсан. Израиль үндэстэн рүү илгээгдсэн Бурханы эш үзүүлэгчдийг олон зууны турш хавчсан үйлдэл (Матай 21:33-39) дээд цэгтээ хүрэхдээ тэд Христийн амийг хөнөөсөн.

Христитгэлийн эрин үед тэд Паул болон бусад элч нарыг **хавчиж, Бурханы** тааллыг гүйцэтгэж байна хэмээн эндүүрцгээж байсан. Үнэн хэрэгтээ тэдний үйлдэл Бурханд таалагдаагүйн дээр тэд **бүх хүнд өсөрхсөн**.

2:16 Иудейчүүд өөрсдөө сайнмэдээг эсэргүүцээд зогсохгүй **харийнханд** сайнмэдээ тунхаглах гэсэн Паул тэргүүтэй хүмүүсийн оролдлогыг хааж боогдуулсан байна. Харийнхан иудейчүүдийн адил аврагдаж байгааг сонсоод тэд маш ихээр дургүйцжээ.

Ийнхүү тэд Бурханы хүслийг эсэргүүцэхдээ эцэг өвгөдийнхөө үйлсийг үргэлжлүүлэв. Энэ байдлаар **тэдний нүглүүд хуралдсаар байв**. Иудейчүүд гэм буруугийнхээ аягыг үргэлж дүүрэн байлгах гэсэн мэт хандсаар иржээ.

Гэвч тэдний сүйрэл тунхаглагдсан. Учир нь **уур хилэн тэдэн дээр буулаа** гэж бичигдсэн байна. **Уур хилэн** гэж юуг хэлсэнээ Паул тодорхой бичээгүй. Гэм бурууг шийтгэх шийтгэл удахгүй ирэхийг хэлсэн мэдэгдэл байж болох юм. Бидний мэдэж байгаагаар Паулын захидлаас хойш хорин жилийн дотор (МЭ 70 он) Иерусалим устгагдаж, амьд гарсан иудейчүүд дэлхий даяар тарсан.

Иймэрхүү хэсгийг уншсан зарим хүн Паул бол антисемит (еврейчүүдийн эсрэг) үзэлтэн, Шинэ гэрээ бол антисемит ном гэж хэлдэг. Үнэн хэрэгтээ Паул нутаг нэгтнүүддээ буюу иудейчүүддээ маш их хайртай хүн байсан. Израильчуудыг аврахын тулд өөрөө Христээс салгагдахыг ч хүртэл хүсэж байсан хүн (Ром 9:1-3). Паулын үйлчлэлийн гол дуудлага харь үндэстнүүд байсан боловч иудей хүнд сайнмэдээ ярих сэтгэлээ тэр хэзээ ч гээгээгүй. Зарим тохиолдолд энэ сэтгэл нь гол дуудлагаас нь ч чухалд тавигдсан мэт харагддаг.

Иудейн удирдагч нарын талаар энд бичсэн элч Паулын үгс бол түүхэн бодит үнэн болохоос хувь хүний үзэл бодол биш. Нөгөө талаар элч Паул Бурханы хөдөлгөснөөр бичсэн гэдгийг санах нь зүйтэй. Антисемитизм нь Христитгэлийнх биш бөгөөд ямар ч нөхцөлд энэ үзлийг зөвтгөж болохгүй. Тэглээ гээд Бурхан Хүүгийнхээ үхэлд иудей хүмүүсийг буруутгадаг гэж хэлэх нь антисемит үзэл биш юм (Үйлс 2:23). Харь үндэстнүүд ч бас хариуцлагад татагдах болно (1Коринт 2:8).

Г. Паул Тесалоник уруу буцаж очиж чадаагүйгээ тайлбарласан нь (2:17-20)

2:17 Энэ бүлгийн үлдсэн дөрвөн ишлэлд элч Паул Тесалоник уруу буцаж очоогүй шалтгаанаа тайлбарласан. Паулыг эсэргүүцэж байсан хүмүүс нь Тесалоникт амссан

хавчлагатай дахин учрахаас айгаад Паул ирээгүй хэмээн тайлбарласан байж болох юм.

Холдож салсан явдал нь зөвхөн биеэрээ гэдгийг Паул юуны түрүүнд тодруулсан. Тесалоникчууд сүнсний хувьд эцэг нь болсон Паулаас салж, өнчирч хоцорчээ. Гэсэн ч тэднийг гэх Паулын сэтгэл нь огтхон ч бөхөөгүй байна. Паул энэ хайраа илэрхийлэхийн тулд **бүх хүслээрээ чармайсан** гэдэг үгийг ашигласан.

2:18 Паул Тесалоникт очихыг нэг бус удаа оролдсон боловч тэр тоолонд нь **Сатан саатуулсан** байна. Сатан ямар замаар саатуулсныг энд тодорхой дурдаагүй.

Өөрийг нь **саатуулаад** байгаа нэгэн бол Эзэн биш Сатан гэдгийг Паул яаж мэдсэнийг ч бид мэдэхгүй. Паул ба түүний хамтрагч нарыг Азид сайнмэдээ тунхаглахыг Ариун Сүнс хориглосон тухай Үйлс 16:6-аас бид уншдаг. Дараа нь Битун уруу явах гэсэн боловч Сүнс тийш явахыг нь бас л хорьсон. Саатуулж байгаа нь Ариун Сүнс үү, диавол уу гэдгийг бид хэрхэн мэдэх вэ? Үүнийг мэдэх нэг арга нь ийм байж болох юм: Бид Бурханы хүслийн дагуу үйлдэж байгаагаа мэдэж байхад ямар нэг саад тотгор учирвал үүнийг Ариун Сүнснээс бус, Сатанаас хэмээн дүгнэж болно. Сатан ер нь Бурханы ерөөж байгаа бүхэнд саад хийхийг хүсдэг. Гэвч Бурхан Сатаны эсэргүүцлээс дээгүүр нэгэн бөгөөд бүхнийг хянаж захирч байдаг билээ. Энэ тохиолдолд Паул хэдий

Тесалоник уруу очиж чадаагүй ч энэ нь 1Тесалоник захидлыг бичих шалтгаан болсон. Уг захидал нь Бурханд алдрыг авчирч, бидэнд ерөөл болсон.

2:19 Элч Паул яагаад Тесалоникийн итгэгч нар уруу очихыг хүсэж байсан бэ? Яагаад гэвэл тэд Эзэн доторх түүний хүүхдүүд байсан. Паул тэднийг Христ рүү хөтөлсөн учраас тэдний сүнсний өсөлтөд өөрийгөө хариуцлага хүлээсэн хүн гэж үзэж байсан. Хожмын өдөр Бурхан тэдний талаар өөртэй нь тооцоо хийнэ гэдгийг Паул мэддэг байсан. Христийн шүүх суудлын өмнө тэд бол Паулын шагналын **найдвар** аж. Паул тэдний дотор баярлан хөөрөхийг хүссэн. **Эзэн Есүсийг ирэхэд** тэд бол Паулын **баяр баясгалангийн титэм** аж.

Тэнгэрт очих үедээ Паул тесалоникчуудыг танина гэж үздэг байсан нь энэ ишлэлээс харагдаж байна. Тэгэхээр бид ч бас хайртай хүмүүсээ тэнгэрт очоод таних болно.

Энэхүү ишлэлд Паул итгэл доторх хүүхдүүдээ өөрийн **титэм** гэсэн байна. Шинэ гэрээнд өөр титмүүдийн тухай бас гардаг: зөв байдлын титэм (2Тимот 4:8), амийн титэм (Иаков 1:12, Илчлэл 2:10), алдрын титэм (1Петр 5:4). Эд бүгд үл муудах титэм билээ (1Коринт 9:25).

2:20 Тесалоникийн ариун хүмүүс Паулын **алдар бөгөөд баяр баясгалан** ажээ. Паул хүний зан чанарт хөрөнгө оруулсан, шагналд нь

мөнхийн мөнхөд Бурханы Хурганд мөргөх сүнсний хөвгүүд охидыг олж авсан.

ЭЗЭНИЙ ИРЭЛТ

19 дүгээр ишлэлд **ирэх** гэдэг үгийг анх удаа Эзэний эргэн ирэлттэй холбон IТесалоник номд ашигласан байна. Энэ нь уг захидлын маш чухал сэдэв учраас энд түр зогсоод Библийн дагуух Эзэний ирэлт гэж юу вэ гэдгийг тайлбарлая.

Шинэ гэрээнд Христийн эргэн ирэлтийн талаар гурван гол грек үгийг ашигласан байдаг:

parousia (па-ру-сий-аа): ирэх ба ирээд байх

apokalupsis (апо-каал-юүп-сис): ил болгох,

илчлэл

epiphaneia (эпи-фаан-и-аа): илрэл, үзэгдэлт

Хамгийн түгээмэл ашиглагдсан үг нь *parousia*. Утга нь гэвэл ирээд байх, хүрч ирэх. Вайнын хэлснээр энэ үг нь ирэх ба ирсний дараа байх гэсэн хоёр утгыг илэрхийлдэг. Эзэний ирэлтийг бид хоромхон зуурын явдал гэж ойлгож болохгүй. Харин энэ бол тодорхой хугацааны үйл явдал юм.

Англи хэлэнд ч гэсэн *coming* (ирэх, ирэлт) гэдэг үг ийм маягаар ашиглагддаг. Жишээлбэл, “Christ’s coming to Galilee brought healing to multitude.” (Галилд Христ *ирсэн нь* олон хүнд эдгэрэл авчрав.) Энэ өгүүлбэрээс бид “Христ Галилд ирсэн, гэхдээ тэндээ хэсэг хугацаанд байсан” гэх санааг ойлгож чадна. Тиймээс Христийн ирэлт гэдэг нь тодорхой хугацааны

үйл явдал гэдгийг мэдэх нь чухал. Христийн ирэлт бол агшин зуурын үйл явдал биш.

Тэгвэл Шинэ гэрээнд гарч байгаа бүх *parousia*-г авч үзвэл Христийн ирэлтийн тэрхүү тодорхой хугацаа нь (1) эхлэл, (2) өрнөл, (3) үзэгдэлт, (4) оргил гэсэн хэсэгтэй байна.

1. *Parousia*-гийн эхлэл бол шүүрэлт юм. Үүнийг дараах ишлэлүүдэд дурдсан (*parousia*-г орчуулсан үгийг налуугаар бичсэн).

Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно. Харин тусбүр өөрийн дараалалтай байна. Христ бол анхны үр жимс, дараа нь Түүнийг *ирэхэд* Христийнхэн амилуулагдана. (1Коринт 15:22-23)

Ах дүү нар аа, нойрсогчдын талаар та нар эс мэдэхийг бид хүсэхгүй байна. Эс бөгөөс та нар найдваргүйчүүдийн адил гашуудах вий. Учир нь бид Есүс үхсэн бөгөөд амилсанд итгэдэг агаад Есүсээр нойрсогсдыг Бурхан түүний хамт тийнхүү авчирна. Бид үүнийг Эзэний үгээр та нарт хэлье. Эзэнийг *иртэл* амьд үлдсэн бид нойрсогчдын өмнө орохгүй. Учир нь, Эзэн өөрөө тушаалын уухай, тэргүүн тэнгэрэлчийн дуу ба Бурханы бүрээнээр тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христ дотор үхэгсэд эхлээд амилна. Дараа нь амьд үлдсэн бид тэдэнтэй хамт агаарт Эзэнтэй уулзахаар үүлэн дунд өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно. Тиймээс эдгээр үгсээр бие биенээ тайвшруул. (1Тесалоник 4:13-18)

Ах дүү нар аа, бидний Эзэн Есүс Христийн *ирэх* хийгээд бид түүн өөд цуглах тухайд... (2Тесалоник 2:1).

Тиймээс ах дүү нар аа, Эзэнийг *ирэх* хүртэл тэвчээртэй байгтун. Харагтун, тариачин хөрсний үнэт үр жимсийг хүлээдэг. Ингэхдээ тэр эрт ба оройтсон бороог ортол тэсвэртэй хүлээдэг юм. Та нар ч бас тэвчээртэй бай. Эзэний *ирэлт* ойртсон тул зүрхээ чангал. (Иаков 5:7-8)

Бяцхан хүүхдүүд ээ, одоо та нар түүний дотор бай. Тэгвэл түүнийг илчлэгдэхэд бид түүний өмнө зоригтой байж, түүнийг *ирэхэд* өмнө нь ичгүүр үгүй байх болно. (1Иохан 2:28)

2. *Parousia-гийн өрнөлийн* нэг хэсэг нь Христийн шүүх суудал юм. Тэнд итгэгч нарын итгэмжит үйлчлэлийг шагнах болно:

Учир нь Эзэн Есүсийг *ирэхэд* түүний өмнө хэн бидний найдвар эсвэл баяр баясгалан эсвэл өргөмжлөлийн титэм бэ? Энэ нь та нар бус уу? (1Тесалоник 2:19)

Амар амгалангийн Бурхан өөрөө та нарыг бүрэн ариусгатугай. Сүнс, сэтгэл, бие тань бүхлээрээ бидний Эзэн Есүс Христийг *ирэхэд* гэм зэмгүй хэвээр байх болтугай. (1Тесалоник 5:23)

Parousia-гийн өрнөлийн бас нэг хэсэгт Хурганы хуримын найр байх болов уу гэж үздэг. Илчлэл номд өгүүлсэн дарааллаас үзвэл

Хурганы хурим нь Христийн яруу алдарт хаанчлалаас өмнө болох ёстой. Тиймээс *ирэх* гэдэг үг Хурганы хуримтай холбоотойгоор ашиглагдаагүй ч бид үүнийг энд багтах ёстой гэж үзсэн.

Хурсан олны дуу шиг, их усны шуугиан мэт, хүчит аяндын нүргээн адил ‘Халлелуяа! Төгс хүчит Эзэн Бурхан маань хаанчилж байна’ гэхийг би сонсов. Баярлан хөөрч, түүнд алдрыг нь өргөн өргөмжилцгөө. Учир нь Хурганы хурим болж, сүйт бүсгүй нь өөрийгөө бэлдэв. Тэрээр гялалзсан, цэвэр нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь нарийн маалинга нь ариун хүмүүсийн зөвт үйлс юм. Тэр надад ‘Хурганы хуримын зоогонд уригдагсад ерөөлтэй ээ! гэ бичигтүн. Эдгээр нь Бурханы үнэн үгс мөн’ гэлээ. (Илчлэл 19:6-9)

3. Христийн ирэлтийн үзэгдэлт гэдэг нь Христ хаадын Хаан, эздийн Эзэн болж хаанчлахаар газар дэлхийд хүч ба агуу алдар дотор биеэрээ ирэхийг хэлдэг. Шүүрэлт энэ дэлхийн хүмүүст харагдахгүй, хормын төдийд болоод өнгөрнө. Харин Христийг хаанчлахаар ирэх үед нүд бүхэн Түүнийг харна. Тиймээс үүнийг *parousia-гийн үзэгдэлт* гэж нэрлэдэг. Энэ бол Христийн ирэлтийн гурав дахь шат юм.

Түүнийг Чидун ууланд сууж байхад шавь нар хэдүүлхнээ түүн дээр ирж, ‘Энэ нь хэзээ болох вэ? Таны *залрал* болон үеийн

төгсгөлийн тэмдэг юу байх вэ? Бидэнд хэлээч' гэв. (Матай 24:3)

Аянга зүүн зүгээс цахилж, баруун зүг хүртэл гялбуулдаг шиг, Хүний Хүүгийн *залрал* тийм байх болно. (Матай 24:27)

Учир нь Хүний Хүүгийн *залрал* Ноагийн өдрүүдтэй адил байх юм. (Матай 24:37)

Үер бууж, бүгдийг хамаан одох хүртэл тэд мэдээгүй юм. Хүний Хүүгийн *залрал* тийм байх болно. (Матай 24:39)

Ингэснээр Эзэн Есүс маань бүх ариун хүнтэйгээ хамт *ирэхэд* бидний Бурхан бөгөөд Эцэгийн өмнө тэр та нарын зүрхийг ариун чанар дор гэм зэмгүй гэж батална. (1Тесалоник 3:13)

Дараа нь хуульгүй нэгэн илчлэгдэх бөгөөд Эзэн амныхаа амьсгалаар түүнийг алж, *ирэлтийн* төрхөөрөө арилгана. (2Тесалоник 2:8)

Бид Эзэн Есүс Христийнхээ хүч чадал ба түүний *ирэх* тухай та нарт мэдүүлэхдээ ухаалгаар зохиогдсон домгуудыг дагаагүй, харин бид түүний сүр жавхланг нүдээр гэрчлэгчид байсан. (2Петр 1:16) [Петр энд Христийн *parousia*-ийн үзэгдэлтийг ярихдаа Христ уулан дээр дүрээ хувирган урьдчилан харуулсан үйл явдалтай холбож байна.]

Хамгийн сүүлд *parousia* оргилдоо хүрнэ. Энэ тухай дараах ишлэлд дурдсан:

Мөн тэд 'Түүний *ирэх* амлалт нь хаана байна вэ? Эцэг өвгөдийг унтсанаас хойш бүх

юмс бүтээлийн эхнээс байсан шигээ хэвээрээ байна шүү дээ' хэмээнэ. (2Петр 3:4)

Энд дурдсанаар эцсийн өдрүүдэд Христийн ирэлтийг үгүйсгэгч, элэглэн дооглогч нар гарч ирэх тухай бичсэн байна. Тэр хүмүүсийн хэлсэн *parousia* гэдэг үгийн утга нь юу вэ?

Тэд шүүрэлтийг хэлсэн үү? Үгүй. Тэр хүмүүс магад шүүрэлтийн тухай юу ч мэдэхгүй байх. Тэд Христийг хаанчлахаар ирэх тухай ярьсан гэж үү? Үгүй. Тэгж хэлээгүй нь тодорхой харагдаж байна. Хам сэдвийг бүхэлд нь харвал тэд гэм нүгэлт хүмүүсийн дээр буулгах Эзэний эцсийн шийтгэлийг доромжилж байна. Бурхан дэлхий дээр буулгах эцсийн шүүлт буюу “ертөнцийн төгсгөлийг” тэд ийн хэлжээ. Тэд санаа зовох шалтгаангүй гэж үзэж байна. Бурхан тийм яриаг дундуур тасалж байсан түүх байхгүй. Ирээдүйд ч Тэр хүмүүсийн ярихыг болиулахгүй. Тиймээс тэр хүмүүс бузар муу үгс, үйлдлээ чөлөөтэй үргэлжлүүлэх нь.

Петр *Христийн мянган жилийн хаанчлалын* дараах цаг үе буюу бидний мэддэг тэнгэр, газар бүрэн устах эрин рүү хандуулж тэдэнд хариулсан. Христийн ирэлтийн энэхүү оргил нь мянган жилийн хаанчлалын дараа, мөнх эриний эхэнд болно.

Parousia-гаас гадна Эзэний ирэлтийг дүрсэлсэн хоёр грек үг Шинэ гэрээнд бий. Тэр хоёр үг бол *apokalupsis, eiphaneia*.

Apokalupsis гэдэг нь ил болгох, илчлэл гэсэн утгатай. Энэ үг Христийн ирэлтийн гурав дахь шат буюу хүч ба алдар дотор дэлхий дээр буун ирэхийг хэлж байна уу, аль эсвэл чуулганд өөрийгөө илчлэх үеийн шүүрэлтийн тухай хэлж байна уу гэдэг дээр Библи судлаач нарын үзэл бодол хуваагддаг.

Энэ үг дараах ишлэлүүдэд гарна. Ингэхдээ шүүрэлт гэдэг утгаар ойлгогдох боломжтой. Нөгөө талд газар дэлхийд хаанчлахаар ирэх гэсэн утгаар ч ойлгогддог.

Бидний Эзэн Есүс Христийн *илчлэлийг* хүлээхдээ та нар ямар ч бэлгээр эс дутна. (1Коринт 1:7)

Ингэснээр итгэлийн чинь шалгуур галаар шалгагдах, мөхөс алтнаас ч илүү үнэтэй байж, Есүс Христийн *илчлэл дээр* магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм. (1Петр 1:7)

Тиймээс та нар оюун санаагаа үйлчлэлд бэлтгэж, эрүүл ухаантай байж, Есүс Христийн *илчлэл дээр* та нарт өгөгдөх нигүүлсэлд найдвараа бүрэн тавь. (1Петр 1:13)

Харин Христийн зовлонг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн түүний алдар *илчлэгдэхэд* та нар хөөрөн баярлах юм. (1Петр 4:13)

Энэ үг Христийн хаанчлахаар ирэх үеийг тодорхой өгүүлсэн хэсэг бас бий:

Харин зовсон та нарт болон бидэнд Эзэн Есүс хүчирхэг тэнгэрэлч нарынхаа хамт

тэнгэрээс *илчлэгдэх үед* амралт өгнө.
(1Тесалоник 1:7)

Eriphaneia гэдэг нь илрэл, үзэгдэлт гэсэн утгатай. Зарим хүн ариун хүмүүсийнхээ төлөө болон ариун хүмүүстэйгээ хамт үзэгдэх Христийн үзэгдэлтийг аль алийг нь илэрхийлж байна гэж үздэг бол, зарим хүн ариун хүмүүстэйгээ хамт үзэгдэх Христийн үзэгдэлтийг зөвхөн илэрхийлж байна гэж үздэг. Энэ үг дараах ишлэлүүдэд дурдагдсан:

Дараа нь хуульгүй нэгэн илчлэгдэх бөгөөд Эзэн амныхаа амьсгалаар түүнийг алж, ирэлтийн *төрхөөрөө* (үзэгдэлтээрээ) арилгана. (2Тесалоник 2:8)

Бидний Эзэн Есүс Христийг үзэгдэх хүртэл чи тушаалыг алдаагүй, өө сэвгүй сахь.
(1Тимот 6:14)

Би, Бурханы болон амьд ба үхэгсдийг үзэгдэлт ба хаанчлалдаа шүүх Христ Есүсийн өмнө чамд чухалчлан захъя.
(2Тимот 4:1)

Урд минь зөв байдлын титэм надад зэхэгдсэн байна. Зөвт Шүүгч Эзэн намайг тэр өдөр, зөвхөн намайг ч биш, түүний үзэгдэхийг хүсэгч бүгдийг бас түүгээр шагнах болно. (1Тимот 4:8)

Ингэхдээ бид аугаа Бурхан ба Аврагч Есүс Христийнхээ ерөөлт найдвар хийгээд цог жавхлант *илэрхийллийг* хүлээдэг. (Тит 2:13)

Нэг ба гурав дахь ишлэлд Христийн энэ ертөнцөд үзэгдэх үзэгдэлтийг тодорхой

өгүүлсэн байна. Бусад ишлэлүүд нь шүүрэлтийг ч хэлсэн байх магадлалтай. Гэхдээ нэг зүйл тодорхой. Шүүрэлт хийгээд хаанчлах зорилготой Христийн ирэлт нь итгэгч хүний урд хүлээж байгаа, түүний тэсэн ядан хүлээх ёстой үйл явдал мөн. Шүүрэлтийн үеэр итгэгч хүн Аврагчийг харж, алдаршуулагдсан биеийг авна. Харин Христ энэ дэлхийд буцан ирэх үед итгэгч хүн түүнтэй хамт яруу алдар дотор илчлэгдэх болно (Колоссай 3:4). Энэ үед итгэгч хүний шагнал бас илчлэгдэнэ. Тэдгээр шагналыг Христийн шүүх суудлын өмнө авчихсан байх боловч Христ энэ дэлхийг хаанчлахаар ирэх үед тэдгээр шагнал бүгдийн өмнө харагдана. Ямар шагнал байх вэ? Лук 19:17-19 дүгээр ишлэлийг харвал мянган жилийн хаанчлалд тодорхой хэсэг газрыг захирах эрх мэдэл байж болох юм. Нэг хүн арван хотыг, нөгөө нэг нь таван хотыг захирна гэж бичигдсэн байдаг.

Эзэний ирэлтийн талаар дурдсан хэсгүүдийг судалж үзэхэд энэ нь ганц удаагийн үйл явдал биш, харин тодорхой хугацаанд үргэлжлэх үйл явдал гэдгийг бид харлаа. Тэрхүү тодорхой хугацаа нь хэд хэдэн үе шаттай байх ажээ. Үе шатуудыг нь эхлэл, өрнөл, үзэгдэлт, оргил гэж нэрлэж болно. Эзэний ирэлт шүүрэлтээр эхэлнэ. Тэгээд бид Христийн шүүх суудлын өмнө зогсоцгоож, дараа нь Христийг энэ дэлхийд эргэн ирэхэд Түүнтэй хамт бүгдийн нүдэнд харагдахаар үзэгдэнэ. Тэгээд эцэст нь бидний мэдэх тэнгэр, газар галаар устаж төгсгөл ирнэ.

Д. Тимот Тесалоникт очсон нь (3:1-10)

Та нарын итгэл гэдэг үг гуравдугаар бүлэгт таван удаа (2, 5, 6, 7, 10) гарах бөгөөд энэ хэсгийг ойлгох түлхүүр болдог. Тухайн үед тесалоникчууд маш хүнд хавчлага дундуур явж байв. Тиймээс энэ сорилтод тэдний итгэл хэрхэн тэсвэрлэж байгааг Паул мэдэхийг хүсэж байсан. Тиймээс энэ бүлэг дагалдуулах ажлын ач холбогдлыг бидэнд заадаг. Нүгэлтнийг Аврагч дээр авчирснаар л ажил дуусахгүй. Харин Эзэний нигүүлсэл ба мэдлэг дотор өсөж төлөвшихөд нь тэдэнд туслах ёстой.

3:1 Тесалоникт буй ариун хүмүүсийн төлөөх Паулын мятаршгүй сэтгэлийг илэрхийлэх зүрхний цохилт бүрийг бид гуравдугаар бүлгийн турш сонсох болно. Паул **Афинд** байхдаа Тесалоникийн итгэгч нарын байр байдлыг мэдэх гэж тэсгэлгүй их хүсэж байв. Өөрөө очъё гэсэн боловч Сатан түүнд саад хийжээ. Тэгээд энэ талаар юу ч хийлгүй зүгээр суухыг тэсэлгүй Тимотыг Тесалоник уруу илгээгээд өөрөө **Афинд ганцаар үлдэв**. (*Өөрсдөө* гэж олон тоогоор бичсэн нь орчуулгын асуудал юм.) Паул **ганцаар** үлдсэнийг бодоход нэг л гуниг төрдөг. Их хотын нүд булаам өнгө үзэмж Паулын сэтгэлийг татсангүй. Түүний хувьд чуулгануудыг анхаарах нь чухал байлаа.

3:2 Тимотын нэрний өмнө байгаа “цол гуншин”: **Христийн сайнмэдээ доторх**

Бурханы хамтран зүтгэгч, бидний дүү. Энд ямар нэгэн санваартан, тусгай төрлийн ариун хүн гэж оноож нэрлэх утгатай үг олдохгүй байна.

Хайрт ах Паулын халамж дор дагалдан үйлчилж байсан нь Тимотод ямар их завшаан бэ! Харин одоо тэр өөрийгөө баталсан учраас Тесалоник уруу илгээлтэд ганцаараа явж байна.

Энэ аяллын зорилго нь ариун хүмүүсийг **батжуулж, итгэлийг нь урамшуулахад** оршиж байв. Тесалоникийн итгэгч нар Христийнх гэдгээсээ болж хавчигдсан. Шинэхэн итгэгч нарын хувьд энэ нь маш хүнд цаг байв. Христэд итгэснээс хойш бүх юм буруудлаа гэдэг зальт уруу татлагыг Сатан тэдэнд өгч байсан нь дамжиггүй.

Тимот тэдэн дээр очоод “Эсэргүүцэл тулгарвал бүү гайх. Хавчлага зовлонд тэвчээртэй бай. Үүнд баярла” гэж заахыг сонсоод тэд маш их урам зориг авсан болов уу. Дарамт шахалтад бууж өгөхгүй байхын тулд Тесалоникийн итгэгчдийг ийнхүү зоригжуулах шаардлагатай байсан.

3:3 Тесалоникийн итгэгч нар хавчлагатай нүүр тулахдаа яагаад ийм хэцүү зовлон амсаж байгааг гайхан, Бурханд таалагдахгүй байгаа юм болов уу хэмээн бодох боломжтой. Тиймээс зовлон дотор **ганхалгүй** зүрх зоригтой байлгахын тулд Тимот тэдэн дээр очоод христитгэгч хүнд зовлон учрах нь гайхах зүйл биш гэдгийг сануулсан.

3:4 Тесалоникт байхдаа христитгэгч хүн зовлон амсах болно хэмээн ярьж байснаа Паул энд сануулж байна. Түүний хэлж байсан үг тэдний амьдралд биелжээ. Тэд ч үүнийг сайн мэдэж байжээ.

Зовлон бидний амьдралд шаардлагатай сахилгажуулалтыг өгдөг:

1. Зовлон бидний итгэл жинхэнэ эсэхийг шалгадаг. Зөвхөн амаараа хүлээн зөвшөөрөгч нар зовлон ирэхэд зайлж оддог. (1Петр 1:7)

2. Зовлон биднийг зовсон хүмүүсийг тайвшруулж, зоригжуулах хүмүүс болгодог. (2Коринт 1:4)

3. Зовлон бидний зан чанарыг төлөвшүүлж, тэвчээр гэх мэт сайн чанаруудыг бидэнд суулгадаг. (Ром 5:3)

4. Зовлон биднийг улам бүр сайнмэдээ тараах хүсэлтэй болгодог. (Үйлс 4:29; 5:27-29; 8:3,4)

5. Зовлон бидний амьдралын хог шаарыг зайлуулдаг. (Иов 23:10)

3:5 Элч Паул энд 1, 2 дугаар ишлэлд өгүүлснийгээ дахин давтаж байна. Тэрээр удаан тэвчиж чадалгүй, Тесалоникийн итгэгч нар шуургыг хэрхэн давж байгааг мэдэхээр Тимотыг илгээжээ. Дявол тэднийг хуурч мэхлэн, тэд Христитгэлийн хүчирхэг гэрчлэлээ хавчлагаас ангижрахын төлөө арилжсан байх вий гэдэгт Паул ихэд санаа зовниж байжээ. Христэд үнэнч сэтгэлийг биеийн тав тухаар

арилжих, титмийн төлөө загалмайг алгасах уруу татлага өнөөдөр ч бидэнд тулгардаг. “Сахилгажуулалтын зовуурь ба золиосыг тойрч гарах гэсэн хүслийг минь уучлаач Эзээн. Юу ч тохиолдсон Тантай хамт алхахад намайг өнөөдөр хүчирхэгжүүлж өгөөч” хэмээн залбирах шаардлагагүй ямар хүн бидний дунд байгаа вэ?

Хэрэв Сатан Тесалоникийн ариун хүмүүсийг итгэлээс нь ухрааж чадсан бол Паул дэмий хөдөлмөрлөсөн гэж үзэх байв.

3:6 Тимот Тесалоникоос Коринтод ирэхдээ **сайн мэдээ** авчрав. Юуны түүрүүнд Паул тэдний **итгэл ба хайрын** талаар сэтгэл амарчээ. Тэд Христийн сургаалд үнэн баттай зогсохоос гадна хайрыг харуулж байв. Энэ бол жинхэнэ шалгуур юм. Христитгэлийн тунхгийг үнэн зөвөөр хүлээн авах нь дан ганц хэрэгтэй зүйл биш ээ. Харин “хайраар дамжин ажиллаж буй итгэл” (Галат 5:6) хамт байх ёстой. “Эзэн Есүст итгэхээс” гадна “ариун хүмүүсийн төлөө гэсэн хайр” (Ефес 1:15) бас байх ёстой.

Тимот тэдний итгэл ба хайрын тухай дурссан атлаа найдварынх нь талаар юм яриагүй нь хачирхалтай байна уу? Христ эргэн ирнэ гэсэн найдварыг нь диавол ганхуулах гэж оролдсон болов уу? Оролдсон нь дамжиггүй. Уиллиам Линкольн “Диавол энэ сургаалыг үзэн яддаг. Яагаад гэвэл найдвар бидний амьдралд ямар их хүчтэйг тэр мэднэ” гэж хэлсэн. Хэрэв тесалоникчуудын найдварт ямар нэг буруу зүйл

агуулагдаж байсан бол Паул энэ захиагаараа засах гэж оролдох байсан нь гарцаагүй.

Тесалоникчууд элч Паул болон түүний нөхдийг сайнаар дурсаж, Паул, Силас, Тимот нарын нэг адил эргэн уулзахыг ихэд хүсдэгийг Тимот уламжилсан.

3:7 Энэ мэдээ Паулын ангасан сэтгэлд хүйтэн ус мэт байлаа (Сургаалт үгс 25:25). Хэдий Паул дарамт шахалт, зовлон бэрхшээл дунд байсан ч тэдний **итгэлээр** зоригжив.

3:8 Паул **“Хэрэв та нар Эзэний дотор бат зогсвоос эдүгээ бид амьд байна”** хэмээн мэдэгдэв. Тесалоникчуудын байдлыг мэдэхгүй байх нь түүний хувьд үхэлтэй адил аж. Харин тэдний сайн байгааг сонсоод амь орсон мэт болжээ. Бурханы энэ агуу хүн бусдыг гэсэн ямар их халуун сэтгэлтэй байсан нь эндээс харагдаж байна.

3:9 Паул **Бурханд талархах** сэтгэлээр дүүрэв. Энэ сэтгэлийг нь үгээр илэрхийлэх арга байсангүй. **Бурханыхаа өмнө** тэднийг дурсан санах тоолонд **баяр хөөрийнх** нь аяга хальж бялхаж байв.

3:10 Паул тогтмол залбирдаг байв. **Өдөр шөнөгүй** залбирдаг байсан. Паулын залбирал гал халуун байсан: **үлэмж ихээр залбирч...** Паулын залбирал тодорхой зүйлийн төлөө байсан: **та нарын царайг харах гэж...** Паулын залбирал бусдын төлөө байсан: **итгэлд чинь дутагдаж буйг дүүргэхсэн гэж...**

Е. Паулын залбирал (3:11-13)

3:11 Тесалоникийн гуравдугаар бүлэг Паулын залбирлаар төгсдөг. Паул Тесалоникт дахиж очихын төлөө болон тэдний нэг нэгнээ гэсэн хайр нь улам ихээр өсөхийн төлөө залбирсан. Залбирал нь бидний Бурхан ба Эцэг Өөрөө болон бидний Эзэн Есүс Христэд хандсан байв. Уг өгүүлбэр олон өгүүлэгдэхүүнтэй атал үйл үг нь ганц тооны хэлбэртэй байна. Өгүүлбэрийн ийм хэрэглээ нь Христ Бурхан болохыг, мөн Бурхан нэг болохыг харуулж байна.

3:12 Тесалоникчууд жинхэнэ христэч хайрыг харуулж байсан нь сайшаалтай. Гэхдээ сайжруулах зүйл заавал байдаг. Тийм болохоор Паул илүү гүнзгий хайрын төлөө залбирч, **Эзэн та нарыг бие биенээ болон бүгдийг гэсэн хайранд өсгөн бялхуулах болтугай** гэсэн. Тэр хайр нь бусад итгэгчдийг төдийгүй бусад бүх хүнийг гэсэн хайр байх ёстой. Дайснаа ч гэсэн хайрлах тийм хайр. Үүний үлгэр жишээг элч нар өөрсдөө үзүүлсэн. Тиймээс Паул **бид та нарын төлөө адил** гэж хэлсэн байна.

3:13 Энэ амьдралдаа бусдыг хайрласны үр дүн нь хожмын амьдрал дахь гэм зэмгүй байдал юм. Хэрэв бид бие биенээ болон бүгдийг хайрлавал **Эзэн Есүс бүх ариун хүнтэйгээ хамт ирэх цагт бидний Бурханы өмнө ариун чанар дор зэмгүй** гэдгээ харуулах болно. Учир нь

хайр бол хуулийн биелэл мөн (Ром 13:8; Иаков 2:8).

Паулын энэ залбирлыг нэг хүн арай өөрөөр ийн хэлжээ: “Эзэн та нарын амьдралыг улам бүр бусдын төлөө гэсэн сэтгэлтэй болгох болтугай. Тэгвэл та нарын дотор Христийн зан чанар улам бүр батжих болно. Ингэснээр та нарын эсрэг гарч болох бүх буруутгал хүчингүй болно...”

Хоёрдугаар бүлэгт бид Христийн ирэлт нь эхлэл, өрнөл, үзэгдэлт, оргил гэсэн хэд хэдэн үе шатуудаас бүрдэхийг бид үзсэн. Арван гуравдугаар ишлэлд өгүүлсэн “**Эзэн Есүс маань бүх ариун хүнтэйгээ хамт ирэхэд**” гэдэг үг гурав дахь үе шат буюу үзэгдэлт юм. Христийн шүүх суудал тэнгэрт болоод өнгөрчихсөн байна. Итгэгч нар шагналаа авчихсан байна. Харин энэ шагналууд Аврагчийг хаадын Хаан ба эздийн Эзэн болж энэ дэлхий дээр ирэх цагт бүгдэд ил болно.

Ариун хүмүүс: Энэ нь шүүрэлтийн үеэр тэнгэр рүү авагдсан итгэгч нар болов уу (1Тесалоник 4:14). Зарим хүн эднийг тэнгэрэлч гэж үздэг. Гэтэл Винсент, “*Ариун хүмүүс нь ариун хийгээд алдаршуулагдсан, Бурханы хүмүүс*” гэж хэлсэн байдаг. Учир нь тэнгэрэлч нар энэ захидлын сэдэвтэй ямар ч холбоогүй, харин зовж байсан тесалоникчуудын хувьд ариун хүмүүс илүү ойр сонсогдож байна хэмээн Винсент үзсэн. Тэрээр бас, “Эзэнийг ирэхэд тэнгэрэлч нар ч бас хамт байна. Гэхдээ Паул тэнгэрэлч нартай ирэх тухай ярихдаа,

2Тесалоник 1:7 дээр тэнгэрэлч нар гэж тусгайлан цохож, *хүчирхэг тэнгэрэлч нарынхаа хамт*”¹⁰ хэмээн нэмж дурдсан.

III. ПРАКТИК ЗӨВЛӨГӨӨ (4:1-5:22)

А. Бурханы хүслийг биелүүлдэг ариусгал (4:1-8)

4:1 Эцэст нь гэдэг үгийг бичсэн нь Паул захиагаа дуусгах гэснийх биш юм. Энэ үг өөр сэдэв рүү шилжиж байгааг илтгэдэг. Тухайлбал, практик зөвлөгөө өгөх гэж байгааг харуулдаг.

Гуравдугаар бүлэг *ариун байдал, хайр, ирэлт* гэсэн гурван чухал үгээр төгссөн. Энэ гурван үг дөрөвдүгээр бүлгийн үндсэн сэдэв болж байна: (1) Ариун байдал (1-8 дугаар ишлэл), (2) Хайр (9, 10 дугаар ишлэл), (3) Ирэлт (13-18 дугаар ишлэл). Эдэн дээр нэмээд ажилч хичээнгүй байх тухай сэдвийг бас хөндсөн (11, 12 дугаар ишлэл).

Дөрөвдүгээр бүлэг нь ариун байдал дотор алхаж, Бурханд таалагдах тухай сэдвээр эхлээд ариун хүмүүсийн дээш авагдах тухай сэдвээр төгссөн. Паул үүнийг бичиж байхдаа Енохыг бодож байсан болов уу гэмээр харагддаг. Ижил төстэй зүйлс: (1) Енох Бурхантай хамт алхсан (Эхлэл 5:24а); (2) Енох Бурханд таалагдсан (Еврей 11:5б); (3) Енох дээш авагдсан (Эхлэл 5:24б; Еврей 11:5а). Элч Паул итгэгчдийг ариун байхыг тушаахдаа улам ариун болохыг ятгасан.

Ариун байдал бол оргилд нь гардаг зүйл биш, харин үйл явц юм.

4:2 Паул тесалоникчуудтай хамт байхдаа ариун амьдралаар Бурханд таалагдахыг **Эзэн Есүсийн** эрх мэдлээр тэдэнд байнга тушаадаг байсан.

4:3 Хүмүүсийнхээ төлөөх **Бурханы хүсэл** нь тэдний **ариусгал** байдаг. Ариусгах гэдэг нь тэнгэрлэг зорилгын төлөө тусгаарлахыг хэлнэ. Бүх итгэгч нар Эзэний үйлчлэлийн төлөө энэ дэлхийгээс тусгаарлагдсан хүмүүс юм. Энэ бол байр суурийн хувьд буй итгэгч нарын ариусгал юм. Энэ байр суурь төгс бөгөөд бүрэн дүүрэн (1Коринт 1:2; Еврей 10:10) Харин нөгөө талаараа итгэгч нар өөрсдийгөө ариусгах ёстой. Нэг ёсондоо итгэгч нар өөрсдийгөө бүх төрлийн нүглээс тусгаарлах ёстой. Энэ ариусгалд үйл явц шаардагддаг. Гуравдугаар ишлэлд гарч байгаа ариусгал гэдэг үг энэ утгаар хэрэглэгдсэн болно. (5:23 дугаар ишлэлийн доор ариусгалын талаар өгүүлснийг үзнэ үү.)

Паул нэг нүглийг онцолж анхааруулсан. Тэр бол хууль бус бэлгийн харилцаа буюу завхайрал. Энэ бол бурхангүй ертөнцийн хамгийн түгээмэл нүглүүдийн нэг юм. **Садар самууныг цээрлэ** гэх анхааруулга нэгдүгээр зууны чуулганд хэрэгтэй байсан шигээ өнөөгийн бидэнд ч хэрэгтэй.

4:4 Христитгэгч бүр **ариусал хийгээд хүндэтгэл дотор өөрийн савыг хэрхэн эзэмшихийг** мэдэх ёстой. Энэ ишлэлд гарч

байгаа **сав** гэдэг үг нь эр хүний өөрийн биеийг эсвэл эхнэрийг нь хэлсэн байж болно. Энэ үгийг 1Петр 3:7 дээр эхнэр гэдэг утгаар, 2Коринт 4:7 дээр бие гэдэг утгаар хэрэглэсэн байдаг.

RSV орчуулга үүнийг эхнэр гэдэг утгаар авч, “хүн бүр ариусал хийгээд хүндэтгэл дор эхнэртэйгээ хэрхэн амьдрахаа мэдэж...” хэмээн орчуулсан.

Харин NEB орчуулга үүнийг бие гэдэг утгаар авч, “хүн бүр ариусал хийгээд хүндэтгэл дор өөрийн биеэ хэрхэн хянахаа мэдэж...” хэмээн орчуулжээ.

Хэрэв хам сэдвийг нь харж шийдвэл **сав** гэдэг үг нь хүний эхнэрийг хэлсэн гэж ойлгогдоно. Эр хүн эхнэртэйгээ хүндэтгэлтэй, таарамжтай харьцаж, гэрлэлтэндээ үнэнч бус байдал огтхон ч гаргаж болохгүй гэдгийг энд сургаж байна. Эр хүн нэг эхнэртэй, эмэгтэй хүн нэг нөхөртэй байх нь хүн төрөлхтөнд зориулсан Бурханы хүсэл мөн (1Коринт 7:2-ыг бас үзнэ үү).

4:5 Гэрлэлтийн талаарх Христитгэлийн үзэл бурханлаг бус ертөнцийн үзлээс эрс ялгаатай. Нэгэн тайлбарлагчийн хэлснээр, “Есүс Лук 13:13 дээр гарч байгаа эмэгтэйд гараа хүргэхэд тэр эмэгтэй цэх шулуун болсон. Харин шүтээн шүтэгч эр эмэгтэй хүнд гар хүрэхэд эмэгтэй хазайж мурийдаг.”

Харь үндэстнүүд бэлгийн харилцааг **тачаангуй хүслийг** нэмэгдүүлэх арга хэрэгсэл гэж үздэг байсан. Тэд цэвэр ариун байхыг сул

доройгийн шинж хэмээж, гэр бүл болохыг хуульчлагдсан нүгэл гэж үздэг байсан. Шалиг яриа, олон нийтийн газрын ханан дээрх увайгүй завхай бичгүүдээрээ тэд ичгүүрт явдлаа алдаршуулдаг байсан.

4:6 Садар самуун бол Бурханы Ариун Сүнсний эсрэг нүгэл (1Коринт 6:19). Мөн биеийнхээ эсрэг үйлддэг нүгэл (1Коринт 6:18). Түүнчлэн бусад хүний эсрэг нүгэл юм. Тийм болохоор Паул, **хэн ч үүнийг зөрчиж, энэ хэрэгт ах дүүгээ мэхэлж болохгүй** гэж хэлсэн. Өөрөөр хэлбэл, христитгэгч хүн гэрлэлтийн хил хязгаараас давж, ах дүүгийнхээ эхнэрийн янаг хайрыг хулгайлж **ах дүүгээ мэхэлж болохгүй**. Өнөө цагт ийм явдлыг төрийн шүүхээр яллаж шийтгэдэггүй ч **энэ бүхний төлөө өшөө авагч нь Эзэн юм**. Садар самууны нүгэл нь хүний амьдралд биеийн болоод сэтгэлзүйн аймшигтай хор хөнөөлийг авчирч чадна. Гэхдээ тэр хүн гэмшээгүй, уучлал аваагүй бол мөнхөд үүрэх үр дагаврыг нь юутай ч харьцуулшгүй. Паул энэ талаар тесалоникчуудад **урьд нь хэлж, чухалчлан анхааруулж байжээ**.

Садар самууны хэрэгт орооцолдоод эцэст нь ичгүүр гутамшигт унаж, шоронд ороод дууссан арван есдүгээр зууны Британийн нэгэн авьяаслаг зохиолч ийн бичжээ:

Бурхад бараг л бүх зүйлийг надад өгсөн.
Харин би удаан хугацаанд ухаан мэдрэлээ
гээж, хүсэл тачаалдаа эзэмдүүлэн юу ч

бодохгүй таашаалаар амьдарсан...Өндөрлөгт байхаас залхахдаа би шинэ мэдрэмж хайн зориуд ёроол уруу явсан...*Бусдын амьдралыг бодож байсан удаа надад үгүй.* Би таашаал аваад л цааш явж байсан. Өдөр тутмын жижиг жижиг үйлдлүүд хүний зан чанарыг бий болгодог эсвэл эвддэг гэдгийг ч умартсан. Тийм болохоор өрөөндөө нууцлан хийсэн зүйлс чинь нэг л өдөр дээвэр дээр гараад чанга гэгч нь хашхирч олны өмнө ил болдог. Би өөрийгөө захирах чадваргүй болж, өөрийгөө хэрхэн жолоодохыг ч мэдэхээ больсон. Би биеийн тааламжаар өөрийгөө захируулсан. Эцэст нь ингээд гутамшигтайгаар дууслаа.¹¹

Тэрээр бусдын амьдралыг бодож байгаагүй хэмээн өөрийгөө тодорхойлжээ. Паулын хэлсэнчлэн тэрээр энэ хэрэгт ах дүүдээ бурууг үйлдсэн гэсэн үг.

4:7 Бурхан биднийг ёс зүйн цэвэр бусын төлөө дуудаагүй. Харин ариусал ба цэвэр амьдралтай холбоотой байлगाхаар дуудсан. Бурхан бидний ялзарсан муу усны нүхнээс дуудаад Өөртэйгөө улам бүр адил болгох насан туршийн үйл явцыг бидний дотор эхлүүлсэн.

4:8 Энэ зааврыг эсэргүүцэгч хүн Паул гэгч хүний сургаалыг үгүйсгэж байгаа хэрэг биш юм. Үнэндээ тэр хүн *Ариун Сүнсээ бидэнд өгсөн*¹² **Бурханыг үгүйсгэж, үл тоомсорлож, басамжилж, эсэргүүцэж байгаа хэрэг юм.** Энд

Ариун гэдэг үгийг зориуд онцоллоо: **Ариун Сүнсийг** тээсэн хүн садар самууныг хэрхэн хүлээн зөвшөөрч чадах юм бэ?

Энэ хэсэгт Гурвалын бүх гишүүд дурдагдсан байна. Эцэг (3-р ишлэл), Хүү (2-р ишлэл), Ариун Сүнс (8-р ишлэл). Итгэгч хүний ариусгалд Бурханы гурвал бүгдээрээ оролцдог нь ямар гайхалтай хэрэг вэ!

Эндээс Паул тачаалтай (1-8 дугаар ишлэл) холбоотой сэдвээ өөрчилж хайрын (9-12 дугаар ишлэл) тухай өгүүлж эхэлнэ. Цээрлэ гэдэг үг нь бялх гэдэг үгээр солигдоно.

Б. Бусдыг боддог хайр (4:9, 10)

4:9 Итгэгч хүн биеэ хянан захирахаас гадна Эзэний доторх ах дүүсийнхээ төлөө гэсэн хайрын сэтгэлтэй байх нь зүйтэй. Бурхангүй явдлыг илэрхийлэх гол үг нь нүгэл байдгийн адил Христитгэлийг илэрхийлэх гол үг бол **хайр** юм.

Тесалоникчуудад бусдыг хайрлах тухай **бичих хэрэггүй** байв. Яагаад гэвэл тэд тэнгэрлэг тослогоо (1Иохан 2:20, 27) болон итгэгч багш нарын заавраас **ах дүүсийн хайрын талаар Бурханаар заалгажээ**. Тесалоникийн итгэгч нар Македони даяарх Христийнхнийг бүгдийг хайрладгаараа бусдаас ялгарсан. Итгэгч нар бие биенээ хайрлахыг тушаахдаа Паул үргэлж Тесалоникчуудыг дурсан санасан.

4:10 Дээр дурдсанчлан ах дүүсийн хайрын оргилд гарна гэж байхгүй. Энэ хайр бол тасралтгүй хийж байдаг зүйл юм. Тиймээс Паул ах дүүсийн хайрандаа **улам их бялхахыг** итгэгч нараас ятган гуйсан.

Ах дүүсийн хайр яагаад ийм чухал юм бэ? Яагаад гэвэл хайр байгаа газар эв нэгдэл байдаг. Эв нэгдэл байвал Эзэний ерөөл оршдог (Дуулал 133:1, 3).

В. Гаднах хүнд ярьдаг амьдрал (4:11, 12)

4:11 Гурван зүйлийг хийх гэж **хичээхийг** Паул итгэгч нарт уриалсан. Энэ ишлэл дурдсан тэдгээр гурван тушаалыг өнөөгийн нийгэмд дараах байдлаар ойлгож болно. Үүнд:

1. Бусдын анхаарлын төвд байх гэж бүү эрмэлз. “Хэнд ч үл анзаарагдан, хайр ба шагналыг зөвхөн Христээс л” горилон амьдар.

2. Бусдын хэрэгт хошуу дүрэлгүй зөвхөн **өөрийн ажилдаа анхаар**.

3. Өөрийгөө тэжээ. Бусдыг сорж амьдардаг шимэгч хорхой шиг, эсвэл гуйранчин шиг бүү бай.

4:12 Бид Христэд итгээд Христийн ирэхийг хүлээж байгаа гэдэг нь амьдралдаа хариуцлагатай байхаас маань огтхон ч чөлөөлөөгүй. Энэ ертөнц биднийг харж байгаа гэдгийг мартаж болохгүй. Хүмүүс Аврагчийг маань биднээр дүгнэнэ. Бид үл итгэгч нарт

зохистой хандаж, санхүүгийн хувьд тэднээс хараат бус байх хэрэгтэй.

Г. Итгэгчдийг тайтгаруулдаг найдвар (4:13-18)

4:13 Хуучин гэрээний итгэгч нар нас барсан хүнд юу тохиолддог талаар дутуу дулимаг ойлголттой байв. Итгэсэн ч бай, итгээгүй ч бай, нас барсан бүх хүний биеэ орхих байдлыг *шеол* гэдэг үгээр илэрхийлдэг байсан.

Бүх хүн эцэстээ нас барж, ертөнцийн төгсгөлд бүгд нэг зэрэг амилж, эцсийн шүүлтэнд орно хэмээн тэд итгэдэг байжээ. Тухайлбал Марта ингэж ойлгодог байсан нь түүний хэлсэн үгнээс харагддаг: “Эцсийн өдрийн амилалд тэр (Лазар) амилна гэдгийг би мэднэ” (Иохан 11:24).

Эзэн Есүс “амь ба мөхөшгүй байдлыг сайнмэдээгээр гэрэлд авчирсан” (2Тимот 1:10). Итгэгч хүн нас барсан даруйдаа Христийн дэргэд очдогийг бид өнөөдөр мэддэг болсон (2Коринт 5:8; Филиппой 1:21, 23). Үл итгэгч нас барвал Үхэгсдийн оронд очдог (Лук 16:22, 23). Бүх итгэгч үхэхгүй харин бүгдээрээ өөрчлөгдөнө гэдгийг бид мэднэ (1Коринт 15:51). Нэгээс олон амилал байгаа гэдгийг бид мэднэ. Шүүрэлтээр зөвхөн итгэгч нар л амилна (1Коринт 15:23; 1Тесалоник 4:16). Нүглийн уучлал авалгүй нас барсан хүмүүс Христийн

мянган жилийн хаанчлалын эцэст амилна (Илчлэл 20:5).

Паул анх Тесалоникт очоод христитгэгчдэд Христийн хаанчлахаар ирэх тухай болон түүний араас юу юу болох тухай заасан байна. Гэтэл хэсэг хугацааны дараа нас барсан ариун хүмүүстэй холбоотой асуудлууд гарч ирэв. Тэдний бие нь эцсийн өдөр хүртэл булшиндаа байна гэж үү? Тэд Христийн ирэлтэд оролцож, Түүний жавхлант хаанчлалыг үзэх үү? Тэдний энэ асуултуудад хариулж, айдсыг нь үлдэн хөөхийн тулд Паул Христ хүмүүсийнхээ төлөө ирэх ирэлтийн үед болох үйл явдлын дэс дарааг өгүүлж байна.

Нойрсогчдын талаар та нар эс мэдэхийг би хүсэхгүй байна хэмээн эхэлсэн нь уншигч нартаа чухал юм хэлэх гэж байгаагаа анхааруулж буй хэрэг юм. Паул энд **нойрсогчдын талаар** өгүүлэх гэж байна. Өөрөөр хэлбэл *нас барсан* итгэгч нарын талаар. Нойрссон гэдэг нь нас барсан итгэгч нарын бие цогцсын талаарх дүрслэл болохоос сүнс, сэтгэлтэй нь холбоогүй. Нойрсох гэдэг нь нас барах гэдгийг илэрхийлж байгаа өөр нэг үг юм. Яагаад гэвэл нас барсан хүн нойрсож байгаа мэт харагддаг. Түүнчлэн cemetery (оршуулгын газар) гэдэг үг грек хэлний koimeterion буюу нойрсох газар гэдгээс гаралтай. Нойрсох бол бидэнд маш танил адилтгал юм. Шөнө бүр унтах маань үхлийн бэлгэдэл болж, өглөө бүр сэрэх маань амилалын бэлгэдэл болдог.

Нас барсан хүний сүнс унтдаг гэж Библи заадаггүй. Баян хүн ба Лазар хоёр нас барсан ч юм мэдэрч, ухаан санаа нь сэрүүн байсан (Лук 16:19-31). Итгэгч хүн үхээд “Эзэнтэй хамт байдаг” (2Коринт 5:8). Итгэгч хүний үхэл бол “Христтэй хамт байх” бөгөөд Паул үүнийг “ололт” ба “хол дээр явдал” гэж үздэгээ хэлсэн (Филиппой 1:21, 23). Хэрэв сүнс унтдаг байсан бол ийм байх боломжгүй.

Үхсэний дараа хүн юу ч үгүй болдог гэж Библи заадаггүй. Үхлийн дараа амьдрал бий. Итгэгч хүн мөнх амийг эдлэх бол (Марк 10:30) үл итгэгч хүн мөнх шийтгэлийг хүртэнэ (Марк 9:48; Илчлэл 14:11).

Нас барсан ариун хүмүүсийн тухайд, найдваргүйчүүдын адил гашуудах хэрэг байхгүй гэдгийг элч Паул хэлж байна. Итгэгч хүний төлөө гашуудах хэрэг байхгүй. Есүс Лазарыг хэдхэн хормын дараа амилуулах гэж байхдаа Лазарын булшин дээр уйлсан (Иохан 11:35-44). Гэхдээ Есүс тэнгэрт дахин уулзалдах найдваргүй, зөвхөн шүүлтэй тулгарах хүмүүсийн найдвар тасарсан гашуудлыг харуулсан юм.

Найдваргүйчүүд гэх үг аврагдаагүй хүний оршуулах ёслолд оролцсон үеийг минь сануулдаг. Тэгэхэд авсыг тойрсон хамаатнууд нь тайтгарч чадахгүй цурхиран уйлцааж, “Мари, даан ч яав даа! Тэнгэр минь гэж, Мари!” хэмээн орилолдож байсан. Энэ нь тайтгаршгүй

найдваргүй байдлын мартахын аргагүй дүр зураг мөн.

4:14 Итгэгч хүний найдах үндэс нь Христийн амилал юм. **Бид Есүс үхсэн бөгөөд амилсанд итгэдэг** шиг Есүсийн дотор нойрссон хүмүүс ч дахин амилж, Түүний ирэлтэд оролцоно гэдэгт итгэдэг. “Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно” (1Коринт 15:22). Христийн амилал бол бидний батлан даалт ба баталгаа мөн.

Есүсээр нойрсогсод буюу “Есүсийн дотор нойрсогсод” гэх үгэнд анхаарлаа хандуулна уу. Бидний сүнсийг Хайрлагч Нэгэн буюу хайрт хүмүүсийнхээ биед нойрсохыг зөвшөөрсөн Нэгэн үхлийн аймшгийг үгүй хийсэн билээ.

Христийн дотор нас барсан хүмүүсийг **Бурхан Түүнтэй (Христтэй) хамт авчирна** гэдэгт бид баттай итгэж болно. Түүнтэй хамт авчирна гэдгийг хоёр утгаар ойлгож болно:

1. Шүүрэлтийн үед Бурхан итгэгч нарын биеийг амилуулаад тэднийг Эзэн Есүстэй хамт тэнгэр рүү буцаан авчирна гэсэн утгаар байж болно.

2. Христ дэлхийг хаанчлахаар эргэж ирэх үед Бурхан итгэл дотор нас барсан хүмүүсийг Христтэй хамт авчирна гэсэн утгатай байж бас болох юм. Өөрөөр хэлбэл, “Бүү санаа зов. Нас барсан итгэгч нар ирэх хаанчлалын алдраас хоцрохгүй. Хүч ба агуу алдар дотор Есүсийг хожим буцаж ирэх үед Бурхан тэднийг Есүстэй хамт авчирна” гэсэн

санааг хэлж байна. (Энэ хэсгийг гол төлөв ийм утгаар ойлгодог.)

Энэ явдал яаж болох юм бэ? Итгэгч нарын бие булшиндаа хэвтэж байгаа шүү дээ. Тийм байтал тэд хэрхэн Есүстэй буцаж ирэх юм бэ? Энэ асуултын хариуг 15-17 дугаар ишлэлд өгсөн. Христ хаанчлалаа байгуулахаар ирэхээсээ өмнө өөрийн хүмүүсийг өөртэйгөө хамт байлгах гэж тэнгэр дэх гэр рүү нь авахаар ирнэ. Тэгээд хожим тэдэнтэй хамт буцаж ирнэ.

4:15 Паул үүнийг яаж мэдсэн юм бол? Тэр үүнийг **Эзэний үгээр** мэдсэн гэдгээ энд хэлж байна. Паул энэ тухай мэдлэгийг *Эзэний шууд илчлэлээр* хүлээн авчээ. Илчлэлийг ямар замаар авснаа Паул бидэнд хэлээгүй. Үзэгдэл байсан уу, эсвэл бодит дуу хоолой байсан уу, эсвэл Ариун Сүнс дотроос нь мэдрүүлсэн үү гэдэг нь тодорхой бус. Гэхдээ Паулын үеийг хүртэл хэн ч энэ тухай мэддэггүй байсан нь бол тодорхой.

Христийг эргэн ирэхэд амьд байх ариун хүмүүс нойрссон итгэгч нарын **өмнө орохгүй**. Өөрөөр хэлбэл нойрссон итгэгчдийг давж гарахгүй.

Энэ ишлэлд Паул өөрийгөө Христийг **ирэхэд амьд** байх хүмүүсийн тоонд оруулан ярьсан байна (Мөн 1Коринт 15:51, 52-ыг үз.) Гэтэл 2Коринт 4:14 ба 5:1 дээр Паул дахин амилах итгэгч нарын тоонд өөрийгөө оруулан ярьсан. Тэгэхээр Эзэний ирэлт хэзээ ч байж болох бөгөөд биднийг нас барахаас өмнө, эсвэл

нас барсны дараа аль ч үед боломжтой гэдгийг эндээс бид дүгнэх ёстой.

4:16 Христ ариун хүмүүсийнхээ төлөө ирэх үед үйл явдал ямар дараалалтай байхыг энд өгүүлсэн. **Эзэн Өөрөө тэнгэрээс бууж ирнэ.** Эзэн тэнгэрэлчээ илгээхгүй, харин **Өөрөө** бууж ирнэ.

Эзэнийг бууж ирэхэд **уухай, тэргүүн тэнгэрэлчийн дуу ба Бурханы бүрээ** хамт байна. Эдгээрийн талаар хэд хэдэн тайлбар бий. Гэхдээ баттай тайлбар нэг ч байхгүй. Яг юуг хэлж байгаа вэ гэдгийг хэн ч бүрэн тайлбарлах боломжгүй. Ямар ямар тайлбарууд байдаг вэ гэвэл:

1. Зарим хүний бодлоор **уухай** гэдэг нь үхсэнийг амилуулж (Иохан 5:25; 11:43, 44), амьдыг өөрчлөх Эзэн Есүсийн өөрийнх нь дуу хоолой гэж үздэг. Харин Хогг, Вайн тэргүүтэй хүмүүс үүнийг тэргүүн тэнгэрэлчийн дуу хоолой гэж хэлдэг.

2. **Тэргүүн тэнгэрэлчийн** (Михаел) дуу нь Хуучин гэрээний ариун хүмүүсийг цуглуулах тушаал гэсэн түгээмэл тайлбар байдаг. Яагаад гэвэл **тэргүүн тэнгэрэлч** Михаел Библид Израильтай холбоотой дурдагддаг (Даниел 12:1; Иуда 9; Илчлэл 12:4-7). Энэ бол Израилийг үндэстнийх нь хувьд сэргээх зорилготой **дуу** гэж үздэг хүмүүс ч бий. Зарим хүн, Эзэн ба Түүний ариун хүмүүсийг дайсны нутгаар дамжин тэнгэр рүү буцахад бараа болгохоор дайчин

тэнгэрэлч нарт тушаал өгөх тэргүүн тэнгэрэлчийн дуу гэж үздэг (Лук 16:22).

3. **Бурханы бүрээ** бол 1Коринт 15:52 дээр гарч байгаа эцсийн бүрээ мөн. Шүүрэлтийн цагт итгэгч нарын амилалттай холбоотойгоор дуугарах эцсийн бүрээ. Энэ бүрээ ариун хүмүүсийг мөнх ерөөл рүү дуудна. Энд гарч байгаа бүрээг Илчлэл 11:15-18 дээр гарч байгаа бүрээтэй хольж хутгаж болохгүй. Илчлэлд дурдагдсан эцсийн бүрээ бол Их зовлонгийн үеэр энэ дэлхий дээр буух эцсийн шийтгэлийг зарлах бүрээ юм. Харин *энд* гарч байгаа эцсийн **бүрээ** бол чуулганы төлөө дуугарах бүрээ юм. Илчлэлд гарч байгаа долоо дахь бүрээ нь үл итгэгч ертөнцөд зориулсан сүүлчийн бүрээ (“сүүлчийн бүрээ” гэж тусгайлан нэрлээгүй ч гэсэн) болно.

Христ дотор үхэгсдийн бие эхлээд амилна. Энэ амилалтад Хуучин гэрээний ариун хүмүүс багтах эсэх дээр хүмүүс янз бүрийн байр суурьтай байдаг. Энэ амилалтад Хуучин гэрээний ариун хүмүүс багтана гэж үздэг хүмүүс тэргүүн тэнгэр элчийн дуу гэдэг үгийг онцлоод тэргүүн тэнгэрэлч нь Израилийн хувь тавилантай нягт холбоотой гэдгийг хэлдэг (Даниел 12:1). Энд Хуучин гэрээний итгэгч нар орохгүй гэж үздэг хүмүүс **Христ дотор (Христ дотор үхэгсэд)** гэдэг үгийг сануулаад энэ амилалт чуулганы үеэс өмнө амьдарч байсан итгэгч нарт хамаагүй, чуулганы үеэс өмнө

амьдарч байсан итгэгч нар их зовлонгийн эцэст амилна гэж хэлдэг (Даниел 12:2). Энэ хоёр үзлийн аль нь ч зөв бай, энд өгүүлсэн амилалт бүх хүнийг хамрахгүй гэдэг нь тодорхой байдаг. Энэ үед бүх үхэгсэд амилахгүй, харин **Христ дотор үхэгсэд** л амилах болно.

4:17 Тэгээд тухайн үед амьд байх хүмүүс тэдэнтэй хамт агаарт Эзэнтэй уулзахаар үүлэн дунд өргөгдөнө. Rapture (шүүрэлт) гэдэг нь Латин Библи дэх энэ ишлэлийн орчуулгад дурдагдсан *өргөгдөх*¹³ гэсэн утгатай үйл үгнээс гаралтай. Rapture (шүүрэлт) гэдэг нь дээш авагдах, өргөгдөх, шүүрэгдэхийг хэлнэ. Энэ үг Үйлс 8:39 дээр Филиппийн тухай, 2Коринт 12:2, 4 дээр Паулын тухай, Илчлэл 12:5 дээр эрэгтэй хүүхдийн тухай ярихад хэрэглэгдсэн.

Агаар бол Сатаны ноёрхлын бүс (Ефес 2:2). Тэгэхээр диаволыг өөрийнх нь нутаг дэвсгэр дээр илт доош нь хийх ялгуусан цугларалт тэнд болно гэсэн үг.

Эдгээр ишлэлд дурдсан бүхнийг та нэг бодоод үз дээ! Газар дэлхий хийгээд далай тэнгис нь Христ дотор үхсэн бүх хүний тоос шороо болсон биеийг гаргаж өгнө. Тэгтэл тэр тоос шороонууд өөрчлөн хувиргах гайхамшгаар алдаршуулагдсан бие болж хувирна. Тэр бие үүрд мөнх өвчин, зовиур, үхлээс ангид байна. Тэгээд тэнгэр өөд одоцгооно. Харин энэ бүхэн нүд ирмэхийн зуур болж өнгөрнө (1Коринт 15:52).

Ертөнцийн хүмүүс Эхлэл 1, 2 дугаар бүлэгт тэмдэглэгдсэн хүний бүтээлийн тухай түүхэнд итгэж чаддаггүй. Хүн хэрхэн бүтээгдсэн түүхэнд итгэж чадаагүй тэдэнд шүүрэлтийн тухай ярихад яах бол? Дэлхийн өнцөг булан бүрд булшлагдаж, тарж бутарч, үйрч сарнисан тоос шорооноос Бурхан сая сая хүмүүсийг дахин бүтээнэ гэдэгт тэд хэрхэн итгэж чадах вэ?

Ертөнцийн хүмүүс сансрын нислэгийг асар их бахдан биширдэг. Гэтэл сансрын нислэг шиг агаар мандлыг ч дайрахгүйгээр хормын дотор тэнгэр рүү хийх аяллын гайхамшигийг сансрын ямар ч сүрт нислэгтэй харьцуулахын аргагүй агуу билээ.

Христийг ирэхэд бид дуу чимээ сонсож, хараа булаах зүйлсийг харж, гайхамшиг мэдэрч, баяр хөөртэй уулзалдаж, тайтгарлыг авах болно.

Эдгээр ишлэлд **Эзэн** гэдэг үг орсон хэсгүүдийг байгааг анхаарна уу: **Эзэний үг** (15-р ишлэл); **Эзэний ирэлт** (15-р ишлэл); **Эзэн өөрөө** (16-р ишлэл); **Эзэнтэй уулзахаар** (17-р ишлэл); **Эзэнтэй үргэлж хамт байх болно** (17-р ишлэл).

Эзэнтэй хамт үүрд байна. Эдгээр үгийн илэрхийлж байгаа баяр хөөр ба ивээл ерөөлийг бүрэн өгүүлж чадах хэн байгаа вэ?

4:18 Тиймээс эдгээр үгсээр бие биенээ тайвшруул. Эзэний ирэлт итгэгч хүнд айдас төрүүлдэггүй. Харин ч хөөр баяр, урам зориг, тайвшралыг өгдөг.

ЭЦСИЙН ҮЕИЙН ШИНЖ ТЭМДЭГ

Шүүрэлт ойрхон байгааг харуулах олон шинж тэмдэг бий. Доор дурдсан зүйлс бидэнд тэр цаг ойр буйг харуулах дохио юм.

1. Израиль улс 1948 онд байгуулагдсан явдал (Лук 21:29). Инжрийн мод (Израиль) нахиалж, навчис нь дэлгэрч байна (Лук 21:29-31). Олон зуун жилийн дараа еврейчүүд өөрсдийн төрөлх нутагтаа тусгаар улс болсон. Энэ нь Бурханы хаанчлал ойрхон буйг харуулдаг.

2. Өөр олон улс гүрэн байгуулагдсан (Лук 21:29). Есүс инжрийн мод л зөвхөн нахиална гэж хэлээгүй. Бусад модод ч нахиална гэсэн. Колончлогч төр засаг унаж, шинэ шинэ улс орнууд гарч ирэхийг бид нүдээрээ үзсэн. Энэ бол шинэ национализмын эрин үе мөн.

3. Израиль нутагтаа ирэхдээ Бурханд итгэлгүй зүрхтэй байгаа явдал (Езекиел 36:24, 25). Израильчууд нутагтаа буцаж байж л нүглүүдээсээ цэвэрлэгдэнэ гэдгийг Езекиел зөгнөсөн. Өнөөгийн Израилийн хүн амын ихэнх нь Бурханд үл итгэгч (агностик) хүмүүс байдаг. Хүн амын цөөнх нь (гэхдээ идэвхтэй дуу хоолойгоо өргөдөг) уламжлалт шашнаа чанд баримтлагч иудейчүүд юм.

4. Дэлхийн хэмжээний хөдөлгөөн (Илчлэл 17, 18). Агуу Вавилон бол Христитгэл гэх хуурамч шашнуудаас бүрдсэн шашин, улс төр, эдийн засгийн маш том тогтолцоо болно гэдгийг бид ойлгодог. Олон хүн

Христитгэлээс нүүр буруулж (1Тимот 4:1; 2Тесалоник 2:3) дэлхийн хэмжээний нүсэр чуулганд нэгдэнэ.

5. Дэлхий даяар сүнслэг зүйлс эрчимжинэ (1Тимот 4:1-3). Дэлхийн хүн амын дийлэнх хэсэгт нөлөө үзүүлнэ.

6. Ёс суртахууны хэм хэмжүүрийн эрс доройтол (2Тимот 3:1-5). Өдөр тутмын мэдээллийн хэрэгсэл үүнийг хангалттай нотолж байна.

7. Хүчирхийлэл, ард иргэдийн бослого тэмцэл (2Тесалоник 2:7, 8). Хуульгүй байдлын сүнс айл өрх, улс орон, чуулганы дотор үлэмж ихэснэ.

8. Сүсэгт дүртэй ч хүчийг нь үгүйсгэгч хүмүүс (2Тимот 3:5).

9. Анти-христийн сүнс газар авна (1Иохан 2:18). Өөрсдийгөө Христитгэлт гэж нэрлэвч итгэлийн үндсэн сургаал бүрийг үгүйсгэгч гаж урсгалынхан олширч байгаагаас үүнийг харж болно. Өнгөлөн далдлалтаар тэд хүмүүсийг мэхэлдэг (2Тимот 3:8).

10. Европын улс орнуудын эвсэлдэн нийлэх чиг хандлага. Ромын гэх гэрээгээр байгуулагдсан Европын Эдийн Засгийн Холбоо нь цаашлаад Ромын Эзэнт гүрнийг (төмөр ба шаврын холимог арван хуруу) дахин сэргээх үүдэл болох магадлалтай (Даниел 2:32-35).

11. Бурхан дэлхийн үйл явдалд хөндлөнгөөс оролцож, шүүлт буулгадаг гэдгийг үгүйсгэх (2Петр 3:3, 4).

Түүнээс гадна олон оронд газар хөдлөл болж, дэлхий даяар өлсгөлөн нүүрлэж, улс үндэстнүүд хоорондоо дайсагналцах явдлыг үүн дээр нэмж болно (Матай 24:6, 7). Улс орны төр засгууд хууль тогтоомжоо хэрэгжүүлж чадалгүй, терроризмыг хумьж хүч хүрэхгүй байгаа нь дэлхийд дарангуйлал үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна. Цөмийн зэр зэвсгийн нөөц хуримтлуулах нь “Хэн (араатан) түүнтэй дайтаж чадах вэ?” (Илчлэл 13:4) гэсэн асуултыг улам жинтэй болгож байна. Дэлхий даяар тархсан телевизийн тоног төхөөрөмж нь бичээст зөгнөсний дагуу бүх дэлхийн хүмүүс нийтээр харах үйл явдлуудыг (тухайлбал, Илчлэл 1:7) биелүүлэх хэрэгсэл байж болох юм. Энэ бүхэн Христийг хаанчлахаар ирэхийн өмнө тохионо. Эдгээр үйл явдал шүүрэлтийн өмнө болно гэж Библи хэлдэггүй. Харин Христийг алдар дотроо ирэхийн өмнө болно гэдэг. Гэтэл хөрс нь нэгэнт бүрэлдсэн байгааг өнөөдөр бид харж байна. Тийм учраас шүүрэлт ч бас ойр байгааг ойлгож болно.

Д. Эзэний өдөр (5:1-11)

5:1 Библийн багш нар заримдаа дөрөвдүгээр бүлгийн өгүүлж байгаа сэдэв дуусаагүй тавдугаар бүлэгт үргэлжилж байгаа учраас

бүлэг хуваалт сайн болоогүй гэж хэлдэг. Гэвч үнэндээ яг зөв газраар бүлгийг тасалсан байдаг. Паул эндээс цоо шинэ сэдэв эхлүүлсэн. Паул шүүрэлтийн тухай сэдвийг орхиод Эзэний өдрийн тухай сэдэв рүү орсон. **Гэвч...-ийн талаар** (грек: *peri de* англи: *but concerning*) гэсэн үгс шинэ сэдэв эхэлж байгаа харуулдаг. 1Коринтод бас ийм зүйл гардаг.

Жинхэнэ итгэгч нарын хувьд шүүрэлт бол тайвшрал өгөх найдвар мөн. Харин Христийн биш хүмүүст ямар утгатай байх бол? Энэ нь тэдний хувьд өөр нэг үе эхэлснийг харуулна. Энд түүнийг **цаг хугацаа болон үе** гэж хэлжээ. Энэ үеийн гол дүр нь иудейчүүд байна. Энэ үед Бурхан Израиль улстай тусгайлан ажиллах ба эцсийн өдрүүдийн талаар Хуучин гэрээний эш үзүүлэгч нарын зөгнөсөн үгс биелнэ. Элч нар Есүсээс хаанчлалаа хэзээ байгуулах вэ гэж асуухад Есүс тэдэнд “тэр цаг хугацаа болон үеийг мэдэх нь та нарын хэрэг биш” гэж хариулсан (Үйлс 1:7). Тэгэхээр **цаг хугацаа болон үе** гэдэг үг хаанчлал байгуулагдахын өмнөх үе ба хаанчлалын үеийг хэлсэн бололтой.

Паул **цаг хугацаа болон үеийн** талаар тесалоникчуудад бичих шаардлагагүй гэж үзсэн. Яагаад гэвэл тесалоникчуудын ариун хүмүүс тэр үеийг эхлэхээс өмнө дээш татагдах учраас тэр цагийг үзэхгүй.

Түүнээс гадна, **цаг хугацаа болон үе**, Эзэний өдөр бол Хуучин гэрээний сэдэв юм.

Шүүрэлт нь элч нарын үеийг хүртэл илчлэгдээгүй нууц байжээ (1Коринт 15:51).

5:2 Тесалоникийн ариун хүмүүс **Эзэний өдрийн** талаар мэддэг байсан. Энэ өдөр хэзээ болох нь тодорхойгүй бөгөөд хүлээгээгүй цагт ирнэ гэдгийг тэд бас мэддэг байсан. Паул **Эзэний өдөр** гэж юуг хэлсэн бэ? Энэ нь мэдээж хорин дөрвөн цаг үргэлжилдэг өдрийг биш тодорхой шинж чанартай нэг үеийг хэлсэн.

Хуучин гэрээнд энэ хэллэг шүүлт, шийтгэл, харанхуйтай холбоотой хэрэглэгдсэн (Исаиа 2:12; 13:9-16; Иоел 2:1-2). Энэ үед Бурхан Израилийн дайснуудын эсрэг давшиж, эргэлт буцалтгүй шийтгэх болно (Зефаниа 3:8-12; Иоел 3:14-16; Обадиа 15-17; Зехариа 12:8-9). Түүнээс гадна Бурхан өөрийн ард түмнийг шүтээн шүтэж, урваж шарвасных нь төлөө шийтгэх болно (Иоел 1:15-20; Амос 5:18; Зефаниа 1:7-18). Ер нь Эзэний өдөр гэдэг нь нүглийг шийтгэх, Эзэний үйл хэрэгт ялалтыг авчрах, Бурханы итгэмжит хүмүүст ерөөл хүртээх цаг юм. Ирээдүйд Эзэний өдөр нь цаг хугацаа болон үетэй бараг нэг байна. Эзэний өдөр шүүрэлтийн дараа эхэлж, доор дурдсан үйл явдлаар үргэлжилнэ. Үүнд:

1. Их зовлонгийн үе буюу Иаковын зовлон шаналангийн үе (Даниел 9:27; Иеремиа 30:7; Матай 24:4-28; 2Тесалоник 2:2; Илчлэл 6:1-19:16).
2. Христ ариун хүмүүстэйгээ хамт ирнэ (Малахи 4:1-3; 2Тесалоник 1:7-9).

3. Христ мянган жил газар дэлхий дээр хаанчилна (Иоел 3:18 [14-р ишлэлтэй харьцуул]; Зехариа 14:8, 9 [1-р ишлэлтэй харьцуул]).
4. Тэнгэр ба газар бүр мөсөн галаар устгагдана (2Петр 3:7, 10).

Эзэний өдөр Ёхова хүн төрөлхтний хэрэгт ил тод хөндлөнгөөс оролцоно. **Эзэний өдөр** Израилийн дайснууд ба итгэлгүй израильчууд дээр шийтгэл буулгаж, Бурханы хүмүүст аврал чөлөөлөлт авчирч, амар амгалан, хөгжил дэвшил бүхий Христийн хаанчлалыг байгуулна. Тэр хаанчлалд Христ Өөрөө алдрыг авах болно.

Эзэний өдөр нь шөнийн хулгайч мэт ирэхийг элч Паул сануулж байна. Ирнэ гэж бодоогүй цагт энэ өдөр ирнэ. Энэ дэлхий ямар ч бэлтгэлгүй байх болно.

5:3 Тэр өдөр хүн төрөлхтөнд төөрөгдөл, сүйрэл авчрах ба гэнэтхэн ирнэ. Тэр өдөр зайлшгүй ирэх тул зугтаж чадах хүн гарахгүй.

Тэр үед энэ дэлхийд амар амгалан, аюулгүй байдал байх болно. Тэгэхэд гэнэтхэн Бурхан шүүлт асар их сүйрэл дагуулан буух болно. **Сүйрэл** гэж үгүй болгох, оргүй арчих тухай яриагүй. Харин сайн сайхан байдлыг эвдэж, үгүй хийх гэж байгаа мэт эвдрэл сүйдлийг хэлж байна. Энэ нь **жирэмсэн эмэгтэйн төрөх өвдөлт ирэх адил** гарцаагүй тохиолдох бөгөөд хэн ч болиулж чадахгүй. Үл итгэгч нар энэ шүүлтээс зугтаж чадахгүй.

5:4 Өмнөх ишлэлүүдэд гарсан “тэд” гэх төлөөний үг энэ ишлэл дээр “**та нар**” болж өөрчлөгдөж байгаа анхаарах нь зүйтэй.

Эзэний өдөр нь аврагдаагүй хүмүүсийн хувьд уур хилэнгийн үе байх болно. Харин бидэнд ямар утга учиртай байх вэ? Хариулт нь гэвэл, бид тэрхүү өдөр ямар ч аюултай тулгарахгүй. Яагаад гэвэл бид **харанхуйд байдаггүй.**

Тэр өдөр нь шөнийн хулгайч мэт ирнэ (2-р ишлэл). **Барьж авч** байгаа ганц шалтгаан нь **хулгайч мэт** ирснээс болж байгаа, **баригдах** хүмүүс нь зөвхөн шөнөөр байгсад буюу үл итгэгсэд юм. Итгэгч нар **харанхуйд байдаггүй** учраас тэр өдөр нь итгэгчдийг барьж авахгүй.

Энэ ишлэлийг эхлээд уншихад тэр өдөр нь зарим итгэгчийг *барьж авна*, гэхдээ *хулгайч мэт биш* гэсэн ойлголт төрөх магадлалтай. Гэхдээ тийм биш. Тэр өдөр нь *нэг ч итгэгчийг барьж авахгүй.* Яагаад гэвэл хулгайч энэ ертөнцийн шөнөөр ирнэ. Харин тэр үед ариун хүмүүс мөнх гэрлийн дотор орчихсон байх болно.

5:5 Итгэгч нар **бүгд гэрлийн хөвгүүд, өдрийн хөвгүүд** мөн. Харин **шөнийнх ч, харанхуйнх ч биш.** Бурханы Хүүг үгүйсгэсэн энэ ертөнцийн дээр асгарах Бурханы шүүлтэд итгэгч нар орохгүй гэдэг нь үүгээр нотлогддог. Эзэний өдрийн шүүлт нь ёс суртахууны харанхуйд сууж, сүнсний шөнөөр амьдарч,

Бурханаас салан одсон хүмүүсийг л онилж байгаа болгосон.

Христитгэгчид **өдрийн хөвгүүд** гэдэг нь Эзэний өдрийнх гэж буруу ташаа ойлгож болохгүй. Өдрийн хөвгүүд гэдэг нь шулуун шударга байдалтай холбоотой хүмүүс гэсэн утгатай. Харин Эзэний өдөр бол ёс суртахууны харанхуйн хүмүүст шүүлт буулгах цаг болно.

5:6 Дараагийн гурван ишлэлд итгэгчдийг өргөмжлөлт байр сууриндаа нийцсэн, сонор **сэргэг, эрүүл ухаантай** амьдрахыг уриалж байна. Бид уруу татлага, залхуурал, идэвхгүй байдал, хайнга байдалд автахгүйн тулд **сэргэг байх** хэрэгтэй. Мөн Аврагчийнхаа ирэхийг хүлээн **сэргэг байх** хэрэгтэй.

Эрүүл ухаантай байх гэдэг нь үг яриа, биеэ авч явах байдал дээр хамаатайгаас гадна идэж уухдаа ч бодолтой байхыг биднээс шаардана.

5:7 Хүний ердийн хэмнэлээр хүн **шөнөөр унтдаг**. Үүн шиг, сүнслэг хэрэгцээгээ анзаарч тоодоггүй (унтсантай ялгаагүй) үл итгэгч хүмүүс бол харанхуйн хүмүүс юм.

Хүмүүс архидан согтуурахдаа **шөнийн** цагийг ихэвчлэн сонгодог. Хүмүүсийн үйлс муу муухай тул тэд харанхуйг гэрлээс илүү хайрладаг (Иохан 3:19). “Шөнийн клуб” гэх нэр архидан согтуурдаг явдал шөнөөр ихэвчлэн болдгийг илтгэх мэт.

5:8 Өдрийн хүмүүс Эзэн Есүсийн нэг адил гэрэл дотор алхах ёстой (1Иохан 1:7). Өөрөөр хэлбэл нүглээс, бузар муугийн алив хэлбэрээс

татгалзана гэсэн үг. Түүнчлэн, Христитгэлийн хуяг дуулгыг байнга өмсөнө гэсэн үг. Энэ нь **итгэл ба хайрын хуяг, авралын найдварын дуулга** юм. Нэг ёсондоо хуяг дуулга нь **итгэл, хайр, найдвар** буюу Христитгэлийн үндсэн гурван зүйл мөн. Хуяг, дуулгыг цааш нь нарийвчлан ярих шаардлага байхгүй. Үүгээр элч Паул ердөө гэрлийн хөвгүүд нь бурханлаг амьдралаар амьдрахын тулд хамгаалалт өмсөх хэрэгтэй гэдгийг хэлсэн. Тэгвэл хүсэл шуналаар дамжуулан энэ дэлхийг ялзруулсан ялзралаас юу биднийг хамгаалж чадах вэ? Биднийг Бурханд түшдэг **итгэл**, Эзэн болон бие биенээ гэсэн **хайр**, Христийн ирэлтийг хүлээсэн **найджар** л энэ бүгдээс хамгаалж чадна.

Тавдугаар бүлэгт гардаг чухал харьцуулалт

Үл итгэгч нар
 (“тэд”)

унтаа
 согтуу
 харанхуйд байдаг
 шөнийн хөвгүүд, харанхуйн
 хөвгүүд
 Эзэний өдөр нь шөнийн
 хулгайч мэт гэнэт ирэхэд
 баригдана
 Жирэмсэн эмэгтэйн төрөх
 өвдөлт адил зугтах аргагүй
 гэнэтийн сүйрэлд өртөнө

Итгэгч нар
 (“та нар”)

сэрүүн
 эрүүл
 харанхуйд байдаггүй
 гэрлийн хөвгүүд, өдрийн
 хөвгүүд
 Эзэний өдөр нь шөнийн
 хулгайч мэт гэнэт ирэхэд
 баригдахгүй
 Уур хилэнд бус аврал авахад
 зориулагдсан

5:9 Шүүрэлт нь нэг талд **авралыг**, нөгөө талд **уур хилэнг** харуулах хоёр шинж чанартай. Итгэгч нарын хувьд шүүрэлт **авралыг** нь бүрэн болгоно. Үл итгэгч нарын хувьд шүүрэлт дэлхий дээр **уур хилэн** буух цаг байна.

Бид өдрийнх учраас Их зовлонгийн үед асгах **уур хилэнд Бурхан биднийг зориулаагүй**. Харин бүрэн дүүрэн **аврал** авахад, нүглээс үүрд эрх чөлөөтэй байхад биднийг зориулсан.

Зарим хүн энд өгүүлсэн **уур хилэн** гэдгийг үл итгэгчдэд оногдох тамын шийтгэл гэж ойлгодог. Мэдээж хэрэг Бурхан биднийг тамын шийтгэлд зориулаагүй нь үнэн. Гэхдээ яг энэ ишлэлийн хувьд тамын тухай өгүүлсэн гэх ямар нэг үндэслэл байдаггүй. Паул энд тамын тухай биш, харин хожмын өдөр дэлхий дээр болох үйл явдлын талаар ярьж байна. Хам сэдэв нь хүн төрөлхтний түүхэнд тохиох хамгийн том **уур хилэнгийн** үе буюу Эзэний өдрийн тухай байна (Матай 24:21). Тэр цагт бид шийтгэл амсах талд зогсохгүй. Харин Аврагчтай хамт байх болно.

Зарим хүн Их зовлон бол Бурханы бус Сатаны уур хилэнгийн цаг гэж ярьдаг (Илчлэл 12:12). Чуулган Христийн хоёр дахь ирэлтийн үеэр Бурханы уур хилэнгээс чөлөөлөгдөх ч гэсэн Сатаны уур хилэнг амсана гэж тэд үздэг. Гэтэл Их зовлонгийн үеийг өгүүлсэн Илчлэл 6:16, 17; 14:19, 10, 19; 15:1, 7; 16:1, 19 дүгээр ишлэлүүд Бурхан болон Хурганы уур

хилэнгийн тухай, түүнтэй холбоотой үйл явдлын талаар өгүүлсэн байдаг.

5:10 Биднийг уур хилэнгээс чөлөөлж, авралыг маань баталгаажуулахын тулд Эзэн Есүс Христ ямар агуу их үнэ төлсөн тухай энэ ишлэлд сануулж байна. **Бид сэрүүн ч бай, унтсан ч бай Өөртэй нь хамт амьд байхын тулд Эзэн Есүс бидний өмнөөс үхсэн.**

Сэрүүн ч бай, унтсан ч бай гэдэг үг хоёр утгаар ойлгогддог. Шүүрэлтийн үед итгэгч нар амьд байсан ч, нас барсан байсан ч гэсэн утгаар зарим эрдэмтэд тайлбарладаг. Шүүрэлтийн үед хоёр төрлийн итгэгч байна. 1. Христийн дотор нас барсан итгэгч нар; 2. Шүүрэлтийн үед амьд байх итгэгч нар. Энэ өнцгөөс харвал Христийг ирэх үед бид үхсэн ч бай, амьд ч бай **Түүнтэй хамт байх болно.** Тэгэхээр нас барсан итгэгч нар юунаас ч хоцрохгүй. Эзэн Есүс Мартад үүнийг тайлбарлахдаа: “Амилал ба амь бол Би байгаа юм. Надад итгэдэг нь үхэвч [шүүрэлтээс өмнө нас барсан итгэгч] амилна [үхэгсдийн дундаас амилна]. Надад амьдрагч хийгээд итгэгч [шүүрэлтийн үеэр амьд байх итгэгч] бүхэн хэзээ ч үхэхгүй...” гэж хэлжээ (Иохан 11:25, 26).

Харин зарим эрдэмтэд **унтсан ч бай, сэрүүн ч бай** гэдэг үгийг “итгэлээр сэргэг ч бай, дэлхийлэг амьдралтай ч бай” гэсэн утгаар тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, бид сүнсний хувьд сонор сэрэмжтэй ч бай, сүнслэг зүйлсэд хайхрамжгүй ч бай, Эзэнтэй уулзахаар дээш

өргөгдөх болно гэдгийг Паул хэлж байна гэсэн үг. Учир нь сүнсний аврал маань хэр идэвхтэй сайн итгэгч байснаас хамаарахгүй. Хэрэв хүн үнэхээр итгэсэн бол Эзэнийг бүх сэтгэлээрээ хүлээсэн ч бай, үүрэглэн суусан ч бай Христийг ирэх үед **бид Түүнтэй хамт амьд байх болно**. Бидний сүнслэг байдал хэр шагнал авахыг маань тодорхойлно. Харин зөвхөн Христэд итгэснээр л хүн аврагддаг.

Энэхүү хоёр дахь үзлийг баримталдаг хүмүүс, **сэрүүн** гэдэг үг 6 дугаар ишлэлд гарч байгаа сэргэг гэдэгтэй ижил үг байгааг хэлдэг. Мөн унтах гэдэг үг нь 6, 7 дугаар ишлэлд гарч байгаа үгтэй адил бөгөөд “Бурханы юмсыг боддоггүй, дэлхийн зүйлсэд автсан” байдлыг илэрхийлж байна гэдэг (Вайн). Гэтэл энэ үг нь 4:13, 14, 15 дугаар ишлэлд гарч байгаа, үхлийг илэрхийлсэн нойрсох гэдэг үгтэй ижил үг биш байна¹⁴.

5:11 Ийм их авралыг үзсэн бид туйлын агуу Аврагчийг хайрлан, Түүний эргэн ирэлтийн гэрэл дотор байж, сургаал, урамшуулал, үлгэрлэлээр нэг нэгнээ сэнхрүүлж, Бурханы үг ба хайр халамжаар нэг нэгнээ барьж байгуулцгаая. Бид хожим бүгдээрээ Түүнтэй хамт үүрд мөнх амьдрах тул энэ дэлхий дээр ч бас хамтдаа эв найртай амьдрах ёстой.

Е. Ариун хүмүүст хандсан янз бүрийн зөвлөмж (5:12-22)

Тесалоникийн чуулганы зарим итгэгч ажил хийхээ больж, бусдыг “шимэгчлэн” амьдрах болсныг ахлагч нар нь зэмлэсэн боловч зэмлүүлсэн хүмүүс нь үгийг нь хүлээн аваагүй бололтой. Тийм учраас чуулганы удирдагч нар ба тэднийг дагаж байсан хүмүүст Паул энэ зөвлөмжүүдийг өгсөн болов уу.

Дунд чинь зүдэн зүтгэдэг хүмүүсийг хүндлээрэй хэмээн Паул ариун хүмүүсээс хүсэмжилж байна. Энэ нь тэднээс өгөгдөж байгаа сүнслэг зааврыг дагаарай гэсэн утгатай. **“Эзэн дор та нарыг удирдаж, зааварладаг хүмүүс”** гэсэн үгнээс энэ утга тодорхой харагддаг. Ахлагч нар бол Бурханы хонин сүргийг хариулдаг хоньчид. Тэд заах, удирдах, анхааруулах үүрэгтэй.

Чуулганыг нэг хүн удирдаж байгаагүй гэдгийг харуулах Шинэ гэрээний олон жишээний нэг бол энэ ишлэл. Чуулгануудад нэгээс олон ахлагч байжээ. Тэд нутгийн чуулганы сүргийг хамтдаа хоньчилж байсан. Дэнни үүнд дараах тайлбарыг өгсөн:

Бидний харж байгаачлан Тесалоникийн чуулганд нэг удирдагч хамаг эрх мэдлийг атгаж суугаагүй байна. Удирдлага нь хэд хэдэн эрчүүдийн гарт байжээ.¹⁵

Гэхдээ *нэг хүн* удирдахгүй гэдэг нь *бүх хүн* удирдана гэсэн үг биш. Чуулганы удирдлага демократик (удирдлагыг бүх нийт атгана) бус аристократик (чадвартай нь удирдана) шинжтэй байх ёстой.

5:13 Ахлагч нар Эзэний төлөөлөгч мэт үйлчилдэг. Тэдний ажил бол Бурханы ажил мөн. Тийм учраас **хайраар тэднийг өндрөөр үнэлэх ёстой**¹⁶. Энэ хэсэгт **“өөр хоорондоо эв найртай бай”** гэсэн үг санаандгүй ороогүй нь лавтай. Христитгэгчдийн дундах хамгийн том асуудлуудын нэг нь эв түнжингүй байх явдал юм. Итгэгч бүрийн дотор махбодын зан чанар байдаг учраас хэн ч байсан нутгийн чуулганыг хувааж, бутрааж чадна. Эв найртай байхын үндэс болсон хайр, даруу хандлага, тэсвэр тэвчээр, өр нимгэн сэтгэл, уужуу санаа, уучлагч зүрхийг зөвхөн Сүнсээр батжих замаар л бий болгож чадна. Удирдагч нарыг тойрон хүрээлсэн бүлэг үүсэх үед **эв нэгдэлд** аюул учирдаг. **Эв нэгдлээ** ийм юмаар бүү сүйдлээрэй хэмээн Паул анхааруулсан биз ээ.

5:14 Энэ ишлэлд өгүүлсэн зүйлс чуулганы сүнслэг удирдагч нарт зориулагдсан гэж харагддаг. Ах дүү нарт хэрхэн хандах ёстойг энд зааварласан.

1. **Зүгээр суугсдад (эмх журамгүй хүмүүст) зааварла:** Чуулганы эв нэгдлийн төлөө хуруугаа ч хөдөлгөхгүй мөртлөө хариуцлагагүй хандлагаараа эвдэн нурааж байгаа хүмүүс. Мөн ажил хийх сонирхолгүй

хүмүүс. 2Тесалоник 3:6-12 дээр дурдсан залхууран амьдрагч, ажил хийдэггүй, бусдын хэрэгт хошуу дүрэгч хүмүүс юм.

2. **Хулчгаруудыг зоригжуул:** Асуудлаа даван гарч, Эзэний төлөө тууштай явахад байнгын зоригжуулалт хэрэгтэй байдаг хүмүүс.

KJV орчуулгыг харвал *comfort the feeble-minded* (ухаан доголдолтой/унхиа муутайг тайтгаруул) гэж хөрвүүлсэн байдаг. Окенга энэ тухайд, “Хэрэв энэ үг *feeble-minded* (ухаан доголдолтой/унхиа муутай) гэсэн утгатай байсан ч бид тэднийг тайтгаруулж, зоригжуулах л ёстой. Сайнмэдээг тунхаглахад тийм хүмүүс цуглардаг шүү дээ” гэжээ. Энэ нь сайнмэдээ ба чуулганы хувьд нэр төрийн хэрэг биш гэж үү? Тийм хүмүүсийг хүнлэг чанар, хайрын сэтгэл, анхаарал халамжаар угтан авах нэг ч болтугай газар байна шүү дээ.

3. **Доройд нь тусал:** Сүнслэг байдал, оюун санаа, материаллаг байдлын хувьд сул хүмүүст туслах. Энд хэлсэн гол санаа нь итгэл дотор байгаа сул **дорой** хүмүүст сүнслэг болон оюун санааны тусламж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй гэсэн утгаар болов уу. Гэхдээ бид санхүүгийн туслалцаа үзүүлэхээ ч бас хойш нь тавьж болохгүй.

4. **Бүгдэд тэвчээртэй ханд:** Хүмүүс бухимдуулж, цухалдуулсан ч тэсвэр тэвчээрийн нигүүлслийг үзүүл.

5:15 Харин одоо Паул нийт итгэгч нарт хандан ярьж байна. Ингэхдээ тэр бусдад өс санаж хариуг нь барина гэсэн бодлуудыг бүү зөвшөөр гэдгийг хэлж байна. Хүний төрөлх зан чанар цохисон хүнийг эргүүлж цохих, шанг нь өгөх гэсэн хандлагатай байдаг. Харин Христитгэлт хүн Эзэн Есүстэй нөхөрлөж, иймэрхүү асуудалд эрс өөр хандлага үзүүлэх хэрэгтэй. Итгэгч хүн Эзэн Есүстэй нөхөрлөж байвал бусад итгэгч нартаа болон аврагдаагүй хүмүүст өр зөөлөн хандлага ба хайрыг үзүүлж чаддаг.

5:16 Нөхцөл байдал хэчнээн хүндэрсэн ч Христитгэлт хүн баяр хөөртэй байж чадна. Яагаад гэвэл Христ бол итгэгч хүний баяр хөөрийн эх ундарга ба баярлан хөөрөх шалтгаан билээ. Түүнээс гадна, бүх нөхцөл байдлыг Христ хянаж удирддаг. **“Үргэлж баяртай бай”** гэсэн үгтэй энэ ишлэл грек хэл дээрээ Шинэ гэрээний хамгийн богино ишлэл юм. Харин монгол хэлнээ Шинэ гэрээний хамгийн богино ишлэл бол “Есүс уйлав” гэдэг үгтэй ишлэл.

5:17 Залбирал нь Христитгэлт хүний үргэлжийн хандлага байх ёстой. Гэхдээ хамаг ажил албаа хаяад юу ч хийхгүй залбираад байна гэсэн үг биш. Тодорхой тогтсон цагуудад залбирч болно. Шаардлага гарсан үед хаана ч, хэдийд ч залбирч болно. Мөн залбирлаар дамжуулан Эзэнтэй байнгын нөхөрлөлтэй байж болно.

5:18 Бурханд **талархах** нь христитгэгч хүний төрөлхийн зан болсон байдаг. Хэрэв Ром 8:28-д бичсэн зүйл үнэн бол бид хэзээ ч, хаана ч, ямар ч нөхцөлд, бүх зүйлд Эзэнийг магтах боломжтой. Ингэсэн цагт бид өөрсдөдөө нүглийг зөвшөөрдөггүй.

Энэ гурав бол чуулганд хэзээд байх ёстой сайн дадал юм. Эдгээр нь бидний **төлөөх Христ Есүс дэх Бурханы хүслийг** илэрхийлдэг. Эзэн Есүс энэ дэлхий дээр үйлчилж байхдаа эдгээр зааж, өөрийн биеэр үлгэрлэн харуулсныг **Христ Есүс дэх** гэдэг үг бидэнд сануулж байна. Эзэн Есүс сургаал ба үлгэрлэлээр баяр хөөр, залбирал, талархлын тухай Бурханы хүслийг бидэнд илчилсэн.

5:19 Дараагийн дөрвөн ишлэл чуулгантай холбоотой асуудлыг хөндсөн.

Сүнсийг бөхөөх гэдэг нь бидний дотор хийж буй Түүний ажлыг унтраах, Түүнийг хязгаарлах, Түүнд саад болох гэсэн үг. Нүгэл Сүнсийг бөхөөдөг. Хүний уламжлал Сүнсийг бөхөөдөг. Нийтийн мөргөлд хүний зохиосон дүрэм журам Сүнсийг бөхөөдөг. Хагаралдаан Сүнсийг бөхөөдөг. Нэг хүн “Хүйтэн харц, хөндий үгс, чимээгүй байдал, санаатай үл тоомсорлол Сүнсийг бөхөөх шалтгаан болдог. Нинжин сэтгэлгүй шүүмжлэл ч ялгаагүй” гэжээ. Хүний дотор болон чуулганы доторх Сүнсний үйлчлэлд саад болох нь Сүнсийг бөхөөж буй хэрэг хэмээн Райри хэлсэн байдаг.

5:20 Хэрэв бид энэ ишлэлийг өмнөхтэй нь холбох юм бол эш үзүүллэгийг **басамжлахад** Сүнсийг бөхөөдөг гэж тодорхой ойлгогдоно. Жишээлбэл, залуу дүү маань нийтийн мөргөлийн үеэр эвлүүлж ядан хэдэн үг хэлсэн гэж бодъё. Хэрэв бид түүнийг Христийн төлөө гэрчлэхээс ичээх байдлаар шүүмжилбэл Сүнсийг бөхөөж буй хэрэг юм.

Эш үзүүлэх гэдэг үг Шинэ гэрээнд юуны түрүүнд Бурханы үгийг ярих гэсэн утгаар хэрэглэгдсэн. Бурханы илчлэлээр эш үзүүлж байсан хүмүүсийн үг Библид хадгалагдан бидний гар дээр иржээ. Харин хоёрт Бурханы оюун санааг Библид илчилсний дагуу тунхаглах гэсэн утгатай.

5:21 Бид сонсож байгаа зүйлсээ шүүн тунгааж, **сайн**, цэвэр, үнэн зүйлсээс **зуурах** хэрэгтэй. Номлол, сургаал бүхнийг **шалгах** жишиг хэм хэмжээ бол Бурханы үг юм. Хүмүүс Сүнсээр өгөгдсөнийг эрх чөлөөтэй ярих үед буруу зөрүү зүйлс гарах тохиолдол бий. Гэхдээ Сүнсийг бөхөөх нь тийм буруу зөрүүг засах арга зам биш.

Доктор Дэнни:

Сүнснээс авсан үгээ хэн ч хэлж болдог, эш үзүүлэх эрх чөлөөг олгосон нээлттэй уулзалт цугларалтууд орчин цагийн чуулганд нэн хэрэгцээтэй байна.¹⁷

5:22 Ёр муугийн алив хэлбэрээс цээрлэ гэсэн үг хуурамчаар хэлээр ярих, худал эш үзүүллэг, хуурамч сургаалыг хэлсэн байх магадлалтай. Эсвэл бузар муу гэдэг ерөнхий утгаар хэлсэн байж болно.

А. Т. Пиерсон 16-22 дугаар ишлэлээс Христитгэлт хүнд хандсан долоон зарчмыг заасан. Үүнд:

1. Магтаалын зарчим (16): Бурханы хийж байгаа бүхэн хязгааргүй агуу гэдгийг олж харах.

2. Залбирлын зарчим (17): Тохиромжгүй, цагаа олоогүй залбирал гэж огт байхгүй.

3. Талархлын зарчим (18): Махбодод маань таагүй нөхцөл байдалд ч талархах.

4. Сүнслэг байдлын зарчим (19): Сүнс бидний дотор болон биднээр дамжин бүрэн чөлөөтэй ажиллах ёстой.

5. Заах, сурах зарчим: Бурхан ямар ч зам ашиглаж болно.

6. Шүүн тунгаах зарчим (21): 1Иохан 4:1-тэй харьцуулах. Бурханы үгээр бүгдийг шалгах.

7. Ариун байдлын зарчим (22): Ёрын муу юмс бодол санаанд маань орж ирвэл тэднийг үлдэн хөөх.¹⁸

IV. ТЕСАЛОНИКЧУУДАД ХАНДСАН ТӨГСГӨЛИЙН МЭНДЧИЛГЭЭ (5:23-28)

5:23 Паул христитгэгчдийн ариусгалын төлөө залбирч байна. Энэ ариусгалын эх

сурвалж нь **амар амгалангийн Бурхан** юм. Хамрах хүрээ нь “**бүрэн**” гэдэг үгэнд илэрхийлэгджээ: “таны бүх юм” хамаарна гэсэн үг.

Энэ ишлэлийг ашиглаад зарим хүн “ариун байдлын” сургаалыг (“Holiness” doctrine) нотлох гэж оролддог. Тэр сургаал итгэгчдийг энэ амьдралдаа ч *ямар ч нүгэлгүй төгс* болж чадна хэмээн сургадаг. Гэтэл Паул, “**амар амгалангийн Бурхан өөрөө та нарыг бүрэн ариусгатугай**” гэж залбирахдаа ийм санаа хэлэхийг зориогүй. Нүглийн зан чанар бүрэн үгүй болохын төлөө Паул залбираагүй. Харин ариусгал нь итгэгч нарын бүх хэсэгт буюу **сүнс, сэтгэл, биед** бүхэлд нь өсөн нэмэгдэх болтугай гэж залбирсан.

АРИУСГАЛ

Шинэ гэрээнд дөрвөн янзын ариусгалыг ярьсан. Тэдгээр нь итгэхийн өмнөх, байр суурийн, үйл явцын, төгс ариусгал болно.

1. Хүн аврагдахаасаа ч өмнө ариусгалын үр шимийг амсах тохиолдол бий. Ийм жишээг бид 1Коринт 7:14 дээрээс уншдаг. Энд үл итгэгч нөхөр нь итгэгч эхнэрээрээ ариусгагддаг гэж бичсэн байдаг. Энэ бол *итгэхийн өмнөх ариусгал* юм.

2. Хүн дахин төрөх үедээ Христтэй нэгдсэний үр шимийг хүртэн *байр суурийн хувьд ариусгагддаг*. Энэ нь итгэгч хүн энэ дэлхийнх биш болж, Бурхан уруу

тусгаарлагдсан гэсэн утгатай. Энэ тухай Үйлс 26:18; 1Коринт 1:2; 6:11; 2Тесалоник 2:13; Еврей 10:10, 14 дээр дурдсан.

3. Харин түүний дараа *ариусгалын үйл явц* гэж бий. Итгэгч хүн энэ ертөнц хийгээд нүгэл, бас өөрийн махбодын зан чанарыг огоорч, Бурханд тусгаарлагдахыг ариусгалын явц гэнэ. Үүний үр дүнд итгэгч хүн улам бүр Христтэй адил болдог. Паул энд Тесалоникчуудын төлөөх залбиралдаа энэ ариусгалыг дурдсан болно. Энэ тухай 1Тесалоник 4:3-4; 2Тимот 2:21 дээр бас гардаг. Бид Бурханы үгэнд дуулгавартай байх үед Ариун Сүнс бидний дотор ажиллаж ийм ариусгалыг бий болгодог (Иохан 17:17; 2Коринт 3:18). Итгэгч хүн дэлхий дээр байгаа цагт энэ ариусгал явагдсаар л байна. Энэ дэлхий дээр байх үед нүгэлгүй төгс байдалд хүрнэ гэж хэзээ ч байхгүй. Гэхдээ итгэгч хүн тэр зорилго уруу байнга урагшилж байх ёстой.

4. *Төгс ариусгалыг* итгэгч хүн тэнгэрт очоод авна. Итгэгч хүн Эзэнтэй хамт байхаар явах үедээ Түүний нэг адил нүглээс ангид төгс төгөлдөр, бүрэн ариун болно (1Иохан 3:1-3).

Элч Паул мөн тесалоникчуудыг хамгаалагдсан буюу **гэм зэмгүй хэвээр байхын** төлөө залбирсан. Хүний бүх хэсэгт буюу **сүнс, сэтгэл, биед** бүхэлдээ хамгаалагдсан байх ёстой. Та энэ гурван үгийн дарааллыг анзаарна уу. Хүн

үргэлж бие, сэтгэл, сүнс гэж дарааллуулдаг бол Бурхан **сүнс, сэтгэл, бие** гэдэг. Бүтээлийн эхэнд сүнс хамгийн чухал нь, бие хамгийн бага ач холбогдолтой нь байсан. Нүгэл энэ дарааллыг алдагдуулсан. Хүн биеийнхээ төлөө амьдарч, сүнсийг огоордог. Бид нэгнийхээ төлөө залбирахдаа Библийн энэ дарааллыг дагаж, сүнслэг тусламжийг материаллаг хэрэгцээнээс нь өмнө тавих хэрэгтэй.

Энэ ишлэлийг бусад өөр хэсэгтэй хамт авч үзвэл хүн бид гурван үндсэн хэсгээс бүрддэг нь тодорхой байна. **Сүнс** маань биднийг Бурхантай харилцах чадвартай болгодог. **Сэтгэл** маань сэтгэл хөдлөл, хүсэл сонирхол, мэдрэмж, эрмэлзэл зэрэгтэй холбоотой (Иохан 12:27). Харин **бие** маань биднийг агуулж байгаа савтай адил (2Коринт 5:1).

Биднийг бүрдүүлж байгаа энэ хэсгүүд бүгд хамгаалагдах хэрэгтэй. Библийн нэг тайлбарлагчийн хэлснээр бид дараах зүйлсээс хамгаалагдах ёстой:

1. Сүнс маань: (а) сүнсийг бохирлогч бүгдээс (2Коринт 7:1); (б) Бурхантай явуулж байгаа харилцааг гэрчилдэг Ариун Сүнсний гэрчлэлд саад бологч бүхнээс (Ром 8:16); (в) Бурханы хүсдэг мөргөлөөс холдуулагч бүхнээс (Иохан 4:23; Филиппой 3:3) хамгаалагдах ёстой.

2. Сэтгэл маань: (а) бузар муу бодлуудаас (Матай 15:18, 19; Ефес 2:3); (б) сэтгэлийн эсрэг дайтдаг махбодын хүсэл тачаалуудаас

(1Петр 2:11); (в) өрсөлдөөн ба маргаанаас (Еврей 12:15) хамгаалагдах ёстой.

3. Бие маань: (а) бохир муу зүйлсээс (1Тесалоник 4:3-8); (б) бузар мууд ашиглагдахаас (Ром 6:19) хамгаалагдах ёстой.

Зарим хүн аврагдаагүй хүмүүст сүнс байгааг үгүйсгэдэг. Үүнийгээ батлахын тулд сүнсний хувьд үхмэл (Ефес 2:1) гэсэн тайлбарыг өгдөг. Гэвч сүнсний хувьд үхмэл гэдэг сүнсгүй гэдгээс өөр асуудал. Сүнсний хувьд үхмэл байдал нь Бурхантай харилцах харилцааны хувьд яригддаг зүйл юм. Дэлхий дээр элдэв янзын далдын хүч, сүнслэг юмстай харилцахдаа хүний сүнс маш идэвхтэй амьд байгаа харагддаг. Харин Бурханы зүгт үхмэл болсон байдаг.

Лэнски анхааруулж байна:

Дутуу хагас Христитгэлд сэтгэл ханасан олон хүн бий. Тийм хүмүүсийн амьдрал зарим талаараа дэлхийлэг байдаг. Харин элч нарын үгс төрөлх чанарын маань бүх талбар уруу хатгадаг нь биднийг цэвэр ариунаас хаашаа ч зугтах боломжгүй болгохын тулд билээ.¹⁹

Паулын залбиралд Бурханы ариусгал ба хамгаалалт итгэгч нарын бодгалийн бүх хэсэгт өсөж, **Эзэн Есүс Христийг ирэхэд тэднийг гэм зэмгүй хэвээр байлгаасай** гэсэн хүсэл байсан. Энд шүүрэлтийн дараа болох Христийн шүүх

суудлыг ярьж байна. Тэр үед итгэгч хүний амьдрал, гэрчлэл, үйлчлэлийг дүгнэж, түүнийхээ дагуу шагнагдана, эсвэл шагналгүй хоцорно.

5:24 Бид 4:3-ыг үзэхдээ ариусгал маань Бурханы хүсэл болохыг мэдэж авсан. Тэрээр бидний өөрийнхөө өмнө гэм зэмгүй зогсоохын тулд биднийг дууджээ. Эхлүүлсэн энэ ажлаа тэр заавал дуусгана (Филиппой 1:6). Биднийг дуудагч нь амлалтдаа итгэмжит билээ.

5:25 Паул захидлаа төгсгөхдөө ариун хүмүүсийг өөрсдийнх нь төлөө залбирахыг гуйсан. Паулд залбирал хэзээ ч илүүдэж байгаагүй шиг бидэнд ч бас илүүдэхгүй. Бусад итгэгч нарынхаа төлөө залбирахгүй байх нь нүгэл мөн.

5:26 Түүний дараа Паул **бүх ах дүү нарыг ариун үнсэлтээр мэндчилэхийг** гуйсан. Энэ нь тухайн үеийн мэндчилгээний нэг хэлбэр юм. Одоо ч гэсэн зарим оронд эрэгтэй нь эрэгтэйгээ, эмэгтэй нь эмэгтэйгээ үнсэж мэндчилэх заншил байдаг. Бас эсрэг хүйснийхээ хүнийг үнсэж мэндчилдэг газар ч бий. Харин үүнийг эвгүйцэн үздэг газар бол ийн мэндчилэхгүй байх нь зөв.

Мэндчилэхдээ заавал үнсээрэй гэж Эзэн тушаагаагүй, элч нар ч бас үүрэгдээгүй. Үнсэж мэндлэхийг буруугаар ойлгодог газар тухайн соёлынхоо дагуу мэндчилэхийг Библи зөвшөөрдөг. Бурханы Сүнс гаж буруу зүйлээс хамгаалахын тулд **үнсэлт нь ариун байг** гэж бичүүлжээ.

5:27 Элч Паул энэ захидлыг бүх ариун²⁰ ах дүү нарт уншиж өгөхийг хичээнгүйлэн гуйсан. Хоёр шалтгааныг энд дурдъя:

1. Уг захидалд Бурханы үгийн эрх мэдэл байгааг Паул үүгээр харуулсан. Хуучин гэрээг синагогуудад олны өмнө уншдаг шиг энэ захидал чуулгануудад чангаар уншигдана.

2. Библи бол хэсэг бүлэг хүмүүст биш бүх итгэгч нарт зориулагдсан гэдгийг Паулын энэ үг баталж байна. Библийн үг бүхэн ариун хүн бүрийн төлөө юм.

Дэнни энэ тухайд:

Хэн нэг хүнийг сайнмэдээнээс холдууллаа гээд мэргэн цэцэн болох юм уу сайн сайханд хүрэх хэн ч байхгүй. Ариун бичээсийг чөлөөтэй хэрэглэхийг саатуулж, бичигдсэн болгоныг нь бүх ах дүү нарт эс уншуулж, чуулганы гишүүдийг үргэлжийн балчир байлгахыг санаархахаас илүү итгэлгүй байдал, тэрслэл гэж чуулганд үгүй.²¹

Христитгэлээр амжилттай явах гурван түлхүүрийг 25-27 дугаар ишлэлд өгсөн байна: (1) Залбирал (25-р ишлэл); (2) Бусад итгэгч нараа хайрлах, тэдэнтэй нөхөрлөх (26-р ишлэл); (3) Бурханы үгийг уншиж, судлах (27-р ишлэл).

5:28 Ингээд Паул захидлаа бичиж дууслаа. Захидал бүрийн төгсгөлд тавьдаг үгээ тавихаа ч

мартсангүй. Паул Тесалоникчуудад бичсэн эхний захидлаа нигүүлслээр эхэлж, нигүүлслээр төгсгөж байна. Түүний хувьд Христитгэл бол эхнээсээ дуустал **нигүүлсэл** ажээ. **Амен.**

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

¹(Оршил) Жэймс Эверет Фрэйм, *Тесалоникчууд бичсэн захидал хүртэлх Паулын захидлуудын критик ба эксегетик тайлбар*, (Олон улсын критик тайлбар цуврал), хуудас 37.

²(Оршил) Жорж Роберт Хардин Вүүд, *Элч Паулын анхны захидал*, хуудас 13, 14.

³(1:1) Сонгомол текст “Бидний Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христээс” гэх үгийг гээсэн байдаг. Гэтэл ихэнх гар бичмэлд энэ үг бий. Өмнөхөн талд нь ашигласан хэллэг төстэй байсан учраас хуулж бичсэн хүн үүнийг анзааралгүй гээж бичсэн байх магадлал өндөр.

⁴(1:4) Ефес 1 дүгээр бүлгийн “*Тэнгэрлэг сонголтын тухай нэмэлт тайлбар*” гэдгийг үз.

⁵(1:10) Жорж Роберт Хардин Вүүд, *Элч Паулын анхны захидал*, хуудас 17.

⁶(2:1) Жэймс Дэнни, *Коринт хотынхонд бичсэн хоёр дахь захидал*, хуудас 100.

⁷(2:1) Елизабет Еллиотын хянаж хэвлэлтэнд бэлтгэсэн *Жим Еллиотын тэмдэглэлүүд*, хуудас 218.

⁸(2:13) Уолтер Скот, дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй.

⁹(3:2) *Minister* гэдэг нь латинаар зарц гэсэн үг юм.

¹⁰(3:13) Марвин Винсент, *Шинэ гэрээн дэх үгсийн судлал*, IV:34.

¹¹(4:6) Оскар Уайлд: Тэрээр ижил хүйстэн болохын тулд эхнэрээсээ салжээ.

¹²(4:8) Сонгомол текстэд (NU) “өгдөг” гэж бичсэн.

¹³(4:17) Латин хэлний *rapere* (өргөгдөх) гэдэг үйл үгийн өргөгдсөн байх гэсэн утгатай хувилал нь *raptus*. Үйл үгийн энэ хувилалаас *rapture* гэсэн үг гаралтай. Харин Жероме энэ хэсгийг Вулгатад (Библийн латин орчуулга) “*rapiemur cum illis*” (бид тэдэнтэй хамт өргөгдөх болно) орчуулсан байдаг.

¹⁴(5:10) Эх хэл дээрх текст дээр дараах үгс гарна: 5:10 дээрх *сэрүү*, 5:6 дээрх сэргэг гэдэг үг грекээр *gregoreo* (“сонор” гэсэн утгатай, эрэгтэй хүний “Грегори” гэдэг нэр эндээс гаралтай). 5:6, 7 дээр *katheudo* гэдэг үгийг унтах гэж орчуулсан. Шууд утгаараа унтахыг хэлэх боловч бас “сүнслэг залхуурал, хайнга байдлыг” хэлнэ (Арнет ба Гингрич). 4:13-15 дугаар ишлэлд гарч байгаа нойрсох бол грек хэлний *κοίταο* гэдэг үгний орчуулга.

¹⁵(5:12) Жэймс Дэнни, *Тесалоник хотынхонд бичсэн захидал*, хуудас 205.

¹⁶(5:13) Ахлагч нарын талаар нарийн өгүүлсэн зүйлийг үзэх бол 1Тимот 3:1-7 ба Тит 1:5-9 дүгээр ишлэлүүдэд өгсөн тайлбарыг үзнэ үү.

¹⁷(5:21) Жэймс Дэнни, *Тесалоник хотынхонд бичсэн захидал*, хуудас 244.

¹⁸(5:22) Артур Т. Пиерсон, дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй.

¹⁹(5:23) Р. Ч. Х. Лэнски, *Элч Паулаас Колоссай, Тесалоник, Тимот, Тит, Филемон уруу бичсэн захидлууд*, хуудас 364.

²⁰(5:27) Сонгомол текстэд “ариун” гэх үгийг гэсэн байдаг.

²¹(5:27) Жэймс Дэнни, *Тесалоник хотынхонд бичсэн захидал*, хуудас 263, 264.

НОМЗҮЙ

(1, 2 Тесалоник)

Бакленд, А. Р.

Элч Паулаас Тесалоник хотынхонд бичсэн нэгдүгээр захидал, Филадельфия: Юнион хэвлэлийн газар, 1908 он.

Бакленд, А. Р.

Элч Паулаас Тесалоник хотынхонд бичсэн хоёрдугаар захидал, Филадельфия: Юнион хэвлэлийн газар, 1909 он.

Дэнни, Жэймс.

Тесалоник хотынхонд бичсэн захидал, Нью Йорк: Жорж Х. Дораны Компани, огноо байхгүй.

Еади, Жон.

Тесалоник хотынхонд бичсэн Паулын захидлуудын грек текстийн тайлбар, Лондон: Макмилан, 1877 он.

Фрэйм, Жэймс Э.

Тесалоникчууд бичсэн захидал хүртэлх Паулын захидлуудын критик ба эксегетик тайлбар, Олон улсын критик тайлбар цуврал, Нью Йорк: Чарльз Скрибнерийн Хөвгүүд хэвлэлийн компани, 1912 он.

Хогг, Ч. Ф. болон У. Э. Вайн.

Элч Паулын Тесалоникчуудад бичсэн захидлууд, Лондон: К. А. Хаммонд, 1953 он.

Келли, Уиллиам.

Элч Паулын Тесалоникчуудад бичсэн захидлууд, Лондон: К. А. Хаммонд, 1953 он.

Келли, Уиллиам.

Эш үзүүлэгийг ойлгох нь, Лондон: Г. Морриш, 1976 он.

Моррис, Леон.

Паулаас Тесалоникчуудад бичсэн захидлууд, Ти Би Си, Гранд Райпидс хот: У. Б. Ирдманс хэвлэлийн компани, 1957 он.

Моррис, Леон.

Паулаас Тесалоникчуудад бичсэн нэг, хоёрдугаар захидал, Эн Ай Си, Гранд Райпидс хот: У. Б. Ирдманс хэвлэлийн компани, 1959 он.

Вүүд, Жорж Роберт Хардин.

Элч Паулын анхны захидал, Лондон: Хэнри Э. Уолтер ХХК, 1952 он.

ТЕСАЛОНИКИЙН ЧУУЛГАНД БИЧСЭН ХОЁРДУГААР ЗАХИДАЛ

ОРШИЛ

“Тесалонкчуудад бичсэн нэгдүгээр захидлын адил, энд ч бас элч Паул алдаа дутагдлын талаар өгүүлсэнгүй. Харин үнэнээс зуурч, алдаа дутагдлаас зугтаж явахад нь ариун хүмүүсийн зүрх сэтгэлийг бага багаар, бүх талаас нь бэлтгэн өгч байна. Энэ бол Бурханы нигүүлсэл ба мэргэн ухааны арга зам билээ. Зүрх сэтгэл зөв болсон байхад алдаа дутагдал, бузар муу үйлийг хэрхэх тухай ярих нь илүүц юм.”

–Виллиям Келли

І. БИЧЭЭСТ ЭЗЛЭХ ОНЦГОЙ БАЙР СУУРЬ

Энэ богино захидал онол сургаал болоод практик амьдралын хувьд маш чухал зүйлсийг өгүүлдэг. Паул энд Христийн хоёр дахь ирэлт ба ёс бусын хүний илчлэгдэх тухай тайлбарлаж, энэ талаарх тесалоникчуудын ойлголтыг зассан. Түүнчлэн, Христийн хоёр дахь ирэлтийг хүлээх нэрээр ямар ч ажил хийхгүй байгаа хүмүүст эрүүл сургаал айлдаж, ажил хийхгүй хүнд хоол бүү идүүл гэж сургажээ.

II. ЗОХИОГЧ

2Тесалоникийн талаарх *гадаад баримт* 1Тесалоникийнхоос ч их. Эртний Поликарп, Игнатиус, Иустин нар баталснаас гадна Иренаус нэрийг нь дурдан уг захидлаас хоёр удаа иш татсан байдаг. Мөн Марсионы бичээсийн өмнөтгөлд болон Мураторын бичээст дурдагдсан.

Уг захидал маань тун богино учраас *дотоод баримт* нь 1Тесалоникийг бодвол бага. Гэхдээ утга санаа нь 1Тесалониктой олон талаар уялдаж, зарим сэдвийг нь нөхөж байгаагаас үзэхэд Паул бичсэн хэмээн дүгнэх үндэслэл болдог. Үүнийг цөөн хэдэн эрдэмтэд л үгүйсгэдэг.

III. БИЧИГДСЭН ОГНОО

1Тесалоникийг бичсэний дараа түүнээс үүдсэн зарим нэг асуудал, захидлын зарим хэсгийг буруу ойлгосон явдлыг залруулах үүднээс 2Тесалоник бичигджээ. Тэгэхээр энэ хоёр захидлын хооронд хэдэн сар юм уу хэдэн долоо хоног л өнгөрсөн болов уу. Паул, Силуан, Тимот нар ч салаагүй байсан (1:1). Тэд хамтдаа Коринт хотод байв (Үйлс 18:1, 5). Тэгэхээр захидал бичигдсэн хугацааг 50-иад оны эхэн буюу бүр тодруулбал МЭ50 юм уу 51 он байсан гэж үзэх нь зүйтэй.

IV. ТҮҮХЭН НӨХЦӨЛ, ХӨНДСӨН СЭДЭВ

Тесалоникчуудад эхний захиагаа бичсэний дараа дахин нэг захидал бичих болсон нь гурван үндсэн шалтгаантай. Нэгд: ариун хүмүүс хавчигдаж байсан учраас тэднийг урамшуулж, зоригжуулах (1 дүгээр бүлэг). Хоёрт: тэд Эзэний өдрийн талаар будлиж байсан тул энэ талаарх ойлголтыг нь залруулах (2 дугаар бүлэг). Гуравт: Эзэн эргэж ирнэ гэдэг сургаар цагаа хий дэмий өнгөрөөж байсан зарим хүнийг засах (3 дугаар бүлэг).

Эзэний өдрийн хувьд гэвэл, тухайн үеийн итгэгчид Эзэний өдөр хэдийнээ болчхож хэмээн айсан. Паул өөрөө тэр өдрийг ирчихсэн хэмээн заасан гэх цуу яриа тэдний айдсыг хурцатгажээ. Тиймээс элч Паул энэ ойлголтыг нэг мөр болгож өгсөн.

Эзэний өдөр нь Эзэний ирэлт буюу шүүрэлтээс ялгаатай болох нь эндээс харагдана. Эзэн ирсэн гэвэл ариун хүмүүс айхгүй. Харин тэд Эзэний өдрийн эхний шат болох их зовлонгийн үе ирсэн байх вий хэмээн айж байжээ.

Шүүрэлт болохын өмнө ямар нэг үйл явдал болно гэж Паул ерөөсөө зааж байгаагүй. Тэгвэл одоо Эзэний өдөр ирэхийн өмнө итгэлээс салах явдал гарч, хязгаарлан баригч зайлуулагдаж, ёс бусын хүн илчлэгдэнэ хэмээн зааж байна.

Энэ захидлыг зөв ойлгохын тулд шүүрэлт, Эзэний өдөр, Христ хаанчлахаар ирэх энэ

гурван үйл явдлыг ялгаж салгаж, зөв ойлгох хэрэгтэй. Эзэний өдрийн талаар 1Тесалоник 5:2 дугаар ишлэлийн тайлбар дээр тодорхой өгүүлсэн. Харин шүүрэлт ба илчлэлийн хоорондох ялгааг 2Тесалоник 1:7 дээр тусгайлан тайлбарласан.

ТОЙМ

I. МЭНДЧИЛГЭЭ (1:1, 2)

II. ПАУЛ БА ТЕСАЛОНИКЧУУД (1:3-12)

А. Паул талархах өртөн (1:3-5)

Б. Бурханы зөвт шүүлт (1:6-10)

В. Ариун хүмүүсийн төлөөх Паулын залбирал (1:11, 12)

III. ЭЗЭНИЙ ӨДРИЙН ТУХАЙ (2:1-12)

А. Гуйвахгүй тогтвортой байхыг ятгасан нь (2:1, 2)

Б. Ёс бусын хүн (2:3-12)

IV. ТАЛАРХАЛ БА ЗАЛБИРАЛ (2:13-17)

А. Ариун хүмүүс шүүлт амсахгүй гэдэгт Паул талархсан нь (2:13, 14)

Б. Ариун хүмүүс тайтгарч, батжихын төлөө Паул залбирсан нь (2:15-17)

V. ПРАКТИК ЗӨВЛӨГӨӨ (3:1-15)

А. Бие биенийхээ төлөөх залбирал (3:1-5)

Б. Дуулгаваргүй ах дүүст ямар арга хэмжээ авах талаар (3:6-15)

VI. ЕРӨӨЛ БА МЭНДЧИЛГЭЭ (3:16-18)

ТАЙЛБАР

I. МЭНДЧИЛГЭЭ (1:1, 2)

1:1 Паул энэ захиаг Коринт хотоос бичиж байхад **Силуан, Тимот** хоёр хамт байв. Захидлыг **тесалоникчуудын чуулганд** хаягласан. Энэ захидлыг хүний талаас хэн, хэн рүү бичсэнийг энэ үг тодорхой харуулж байна. **Бидний Эцэг Бурхан доторх** гэдэг үг нь тесалоникчуудын чуулганыг харь үндэстнүүдийн ердийн нэг цугларалтаас ялгаж өгчээ. Харин **Эзэн Есүс Христ** гэсэн нь уг чуулганыг Христийнх гэдгийг нь тодотгосон.

1:2 Элч Паул тэдгээр ариун хүмүүст алдар нэр, аз хийморь, баяр жаргал бус **нигүүлсэл ба амар тайвныг** хүсэн ерөөжээ. **Нигүүлсэл** нь Бурханы хүсэл доторх бүхнийг авах боломжийг өгдөг бол **амар тайван** нь ямар ч нөхцөлд амгалан тогтууныг өгдөг. Хүн өөртөө болон бусдад үүнээс илүү өөр юуг хүсэж чадах вэ?

Нигүүлсэл ба амар тайван нь бидний Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христээс ирдэг. Нигүүлсэл нь амар тайвны өмнө байдаг. Хүн Бурханы **амар тайвныг** амсахаасаа өмнө **нигүүлслийг** нь мэдэх хэрэгтэй. Паул энэ хоёр ерөөлийн эх сурвалж нь **бидний Эцэг Бурхан ба Эзэн Есүс Христ** хамтдаа гэдгийг харуулан энэ хоёр нэрийг нэг дор дурдсанаараа **Эцэг, Хүү** хоёр адил тэнцүү гэдгийг илэрхийлсэн.

II. ПАУЛ БА ТЕСАЛОНИКЧУУД (1:3-12)

A. Паул талархах өргөн (1:3-5)

1:3 Захидал маань ариун хүмүүсийн төлөөх талархлаар эхэлж байна. Үүнийг уншихаар хайрт сүнсний хүүхдүүдийнхээ талаар баярлан хөөрч буй Христийн жинхэнэ зарцын зүрхний цохилтыг сонсож байгаа мэт санагддаг. Паулын хувьд талархал бол Бурханы өмнө хийдэг байнгын үүрэг байв. Үүнийг христитгэгчдийн **итгэл** ба **хайрын** талаас үзвэл бидний хувьд ч гэсэн зохих үүрэг мөн. Тэдний **итгэл** гайхалтай хурдан өсөж, бүгдээрээ бусдыг улам ихээр **хайрлаж** байв. Энэ нь элч Паулын залбирлын хариу байлаа (1Тесалоник 3:10-12).

Та дарааллыг нь анзаараарай: Эхлээд **итгэл**, дараа нь **хайр**. Ч. Х. Макинтош “Итгэл нь Бурханы доторх хайрын мөнх булагт биднийг холбодог. Үр дүнд нь сэтгэл маань Бурханы хүмүүсийг хайрладаг” гэсэн.

1:4 Тесалоникчуудын сүнслэг байдал нь Паул ба түүний хамтрагч нарын хувьд **Бурханы** бусад **чуулгануудын дунд** бахархах зүйл болсон. Тесалоникчууд хэдий **хавчлага** амсаж байсан ч зоригтой, итгэлтэй байсан. **Тэвчээр** гэдэг нь зориг хатуужил, тууштай сэтгэл юм.

1:5 Тесалоникчууд хавчлага, зовлон дунд зоригтой зогсохдоо **Бурханы зөвт** үйлдлийг харуулсан. Бурхан тэднийг дэмжиж, тэтгэж, хүчжүүлж, зоригжуулж байв. Бурханы хүч

үгүйсэн бол тэд Христийн төлөө зовоходоо тэвчээр ба итгэлийг харуулж чадахгүй байсан.

Ийм баатарлаг тэвчээрээрээ тэд **Бурханы хаанчлалд зохистой** болохоо баталсан. Гэхдээ гавьяа зүтгэлээр хүн Бурханы хаанчлалд орох эрхийг олдог гэсэн санаа энд үгүй. Бурханы хаанчлалд орох эрх Христийн гавьяагаар л олддогийг мартаж болохгүй. Харин хүн Бурханы хаанчлалын төлөө зовж байвал ирэх өдрүүдэд Түүнтэй хамт хаанчлахын шинж юм (Ром 8:17; 2Тимот 2:12).

Э. В. Рожерс, та нар Бурханы хаанчлалд зохистой гэж тооцогдоно гэдгийг тайлбарлахдаа:

Энэ бол хүний өөрийн хариуцлага. Бурханы бүрэн эрхийн талаас бол гэрэл дотор ариун хүмүүсийн өвийн хамтрагч болох нь нэгэнт тогтоогдсон. Энэ нь зөвхөн Христийн үхэл ба амилалтай нэгдсэний үр дүн мөн. Нэгэнт аврагдсан хүний өнгөрсөн ба ирээдүйн юу ч түүний мөнхийн хувь тавиланд нөлөөлж чадахгүй тийм агуу их нигүүлслийг бид Бурханы хайрт Хүүгийн дотор хүртжээ. Гэвч Бурхан өөрийн хүмүүсийг хавчлага, зовлонгийн дундуур явахыг зөвшөөрч, хаанчлалынхаа зохистой иргэд болгохоор зан чанарыг нь төлөвшүүлдэг байна.

Элч нарын зарим нь Есүсийн нэрийн төлөө зовлон амсах зохистойд тооцогдсондоо баярлаж байсан. Христийн ажилд нэмэх юм юу ч үгүй. Харин дуудлагад нь Бурхан зохистойд тооцох болтугай хэмээн Паул тесалоникчуудын төлөө залбирсан. Итгэгч хүн загалмайгаар дамжин хаанчлалд орох эрхтэй болдог бол итгэгч хүний зовлон дундах тэвчээр, итгэл нь зан чанарын хувьд хаанчлалд

зохистой нэгэн болохыг харуулдаг. Нийгэмд итгэл даахгүй хүмүүс байдаг. Эдгээр ариун хүмүүсийн дунд ийм юм бүү байгаасай хэмээн Паул залбирсан.²

Б. Бурханы зөвт шүүлт (1:6-10)

1:6 Бурханы шударга үйлдэл нь хавчигч нарт шийтгэл, хавчигдагч нарт амралтыг өгөх гэсэн хоёр замаар илэрсэн.

Виллиям энэ тухай:

Бурхан өөрийн хүмүүсийг хавчигдахыг зөвшөөрч, хавчих хүмүүсийн өмнүүр хөндөлддөггүй нь хоёр шалтгаантай. Бурханы хүмүүс засаглалд зохистойг шалгах нь эхний зорилго (5 дугаар ишлэл). Хавчигч хүмүүс нь шүүгдвэл зохихыг харуулах нь хоёр дахь зорилго.³

1:7 Бурхан өөрийн хүмүүсийн дайснууд дээр шийтгэл буулгана. Харин өөрийнх нь төлөө зовсон хүмүүсийг амралтаар шагнана.

Бид 7 дугаар ишлэлийг уншаад, Христ дүрэлзэх гал дотор тэнгэрээс эргэн иртэл ариун хүмүүс амралтыг олохгүй юм байна гэж дүгнэж болохгүй. Нас барсан итгэгч хүн амралтыг олдог. Амьд итгэгчид бүх шаналангаасаа амралтыг олох цаг бол шүүрэлтийн үе. Эзэн дайснуудынхаа дээр шүүлт асгах үед түүний хүмүүс **амралт** эдлэн буйг энэ ертөнц харна гэдэг санааг энэ ишлэл хэлж байгаа юм.

Эзэн Есүс хүчирхэг тэнгэрэлч нарынхаа хамт тэнгэрээс илчлэгдэх үе нь Бурханы зөв

шударга өшөө авалтын цаг байна. Түүнийг ирэхэд бурханлаг бусаас өшөө авч, итгэгч нарт **амралтыг** өгнө. Энд Христийн ирэлтийн аль үеийг хэлж байна вэ? Гурав дахь үе шат буюу Христийн ирэлтийн үзэгдэлтийг хэлж байгаа нь тодорхой байна. Тэр цагт Христ ариун хүмүүсийнхээ хамтаар газар дэлхийд хаанчлахаар эргэн ирэх болно.

ШҮҮРЭЛТ БА ИЛЧЛЭЛ

Шүүрэлт ба илчлэл тусдаа үйл явдал гэдгийг яаж мэдэж байгаа юм бэ хэмээн асуух хүн байж болох юм. Бичээст энэ хоёр үйл явдлыг дараах байдлаар ялгаж өгсөн:

Шүүрэлт	Илчлэл
1. Христ агаарт бууж ирнэ (1Тесалоник 4:17)	1. Христ газарт бууж ирнэ (Зехариа 14:4)
2. Христ ариун хүмүүсийн төлөө ирнэ (1Тесалоник 4:16, 17)	2. Христ ариун хүмүүстэй хамт ирнэ (1Тесалоник 3:13; Иуда 14)
3. Шүүрэлт нууц байсан. Өөрөөр хэлбэл Хуучин гэрээнд илчлэгдээгүй зүйл (1Коринт 15:51)	3. Илчлэл нууц байгаагүй. Өөрөө хэлбэл Хуучин олон зөгнөлийн гол сэдэв (Дуулал 72; Исаиа 11; Зехариа 14)
4. Христ ариун	4. Христ ариун

хүмүүсийнхээ төлөө ирэхэд тэнгэрт ямар нэг шинж тэмдэг илрэхгүй.

5. Шүүрэлтийг Христийн өдөр гэдэг (1Коринт 1:8; 2Коринт 1:14; Филиппой 1:6, 10).

6. Шүүрэлтийг ерөөлийн цаг гэж дүрсэлсэн (1Тесалоник 4:18).

7. Шүүрэлт нь хормын дотор, нүр ирмэх зуур болж өнгөрнө (1Коринт 15:52). Нэг ёсондоо хүн төрөлхтөнд харагдахгүй.

8. Шүүрэлт чуулганд хамаатай (Иохан 14:1-4; 1Коринт 15:51-58; 1Тесалоник 4:13-18).

9. Христ өглөөний гэрэлт од мэт ирнэ (Илчлэл 22:16).

10. Шүүрэлт сайнмэдээний эхний

хүмүүстэйгээ ирэхэд тэнгэрт янз бүрийн шинж тэмдэг илэрнэ (Матай 24:24, 30).

5. Илчлэлийг Эзэний өдөр гэдэг (2Тесалоник 2:1-12)

6. Христийн илчлэл шүүлт, шийтгэлд голлон төвлөрнө (2Тесалоник 2:8-12).

7. Христийн илчлэлийг бүх ертөнц даяар харна (Матай 24:27; Илчлэл 1:7).

8. Илчлэл нь юун түүрүүнд Израильд, тэгээд мөн харь үндэстнүүдэд хамаатай (Матай 24:1-25:46).

9. Христ жигүүртээ эдгэрэл тээх зөв шударгын нар мэт ирнэ (Малахи 4:2).

10. Илчлэл сайнмэдээний эхний

гурван төстэй номд гурван төстэй номд
дурдагдаагүй боловч дурдагдсан боловч
Иоханы сайнмэдээнд Иоханы сайнмэдээнээс
далд утгаар хэд хэдэн олодохгүй.
удаа дурдагдсан.

11. Авагдсан хүмүүс нь ерөөл хүртэнэ (1Тесалоник 4:13-18). Үлдсэн хүмүүс нь шүүлт амсана (Матай 24:37-41).
11. Авагдсан хүмүүс нь ерөөл хүртэнэ (Матай 24:37-41).
11. Авагдсан хүмүүс нь шүүлт амсана (Матай 24:37-41).
(1Тесалоник 5:1-3)

12. Шүүрэлтийн өмнөх үйл явдлуудад ямар нэг цаг хугацааны мэдээлэл өгөгдөөгүй.
12. Илчлэлийн цаг хугацааг тодорхой зааж өгсөн. Тухайлбал, 1260 өдөр, 42 сар, гурван жил хагас г.м. (Даниел 7:25; 12:7, 11, 12; Илчлэл 11:2; 12:14; 13:5).

13. Шүүрэлтийн тухай хэсгүүдэд “Хүний Хүү” гэдэг нэрийг ашиглаагүй.
13. Илчлэлийг Хүний Хүүгийн ирэлт хэмээсэн (Матай 16:28; 24:27, 30; Марк 13:26; Лук 21:27).

Эдгээр нь тусдаа үйл явдал байлаа ч нэгэн зэрэг тохиохгүй гэдгийг бид яаж мэдэх вэ? Дунд нь тодорхой хугацаа байгаа гэдгийг бид яаж мэдэх вэ? Ийм дүгнэлтийг хийх гурван шалтгаан дурдаж болно. Үүнд:

1. Эхнийх нь Даниелын эш үзүүлэгийн далан долоо хоногийг үндэс болгодог (Даниел 9:25-27). Бид өнөөдөр жаран ес ба дал дахь долоо хоногийн хоорондох завсрын хугацаа буюу чуулганы эрин үед амьдарч байна. Дал дахь долоо хоног бол долоон жилийн Их зовлонгийн үе юм. Тэрхүү Их зовлонгийн үе эхлэхээс өмнө чуулган тэнгэр дэх гэр рүүгээ авагдах болно (Ром 5:9; 1Тесалоник 1:10; 1Тесалоник 5:9; Илчлэл 3:10). Хаан суудалд залрахаар Христ эргэн ирэх нь дал дахь долоо хоногийн дараа болно (Даниел 9:24; Матай 24).

2. Чуулганы шүүрэлт ба Христийн үзэгдэлт хоёрын дунд тодорхой хугацаа байгаа гэж дүгнэх удаах шалтгаан нь Илчлэл номын бүтцийг үндэс болгодог. Эхний гурван бүлгийг харвал чуулган дэлхий дээр байгааг харж болно. 4 дүгээр бүлгээс эхлээд 19:10 хүртэл Их зовлонгийн үе буюу Хүүг нь үгүйсгэсэн ертөнц дээр Бурханы уур хилэн асгарч байгааг дүрсэлсэн. Гэтэл энэ үед чуулган дэлхий дээр байгаа тухай нэг ч дурдаагүй. Чуулган 3 дугаар бүлгийн төгсгөлд тэнгэр рүү авагдсан. Их зовлонгийн үеийн дараа Христ дэлхий дээр эргэн ирж, дайснуудаа дарж, хаанчлалаа байгуулж байгаа тухай Илчлэл 19:11 дээр гардаг.

3. Христ ариун хүмүүсийнхээ төлөө ирэх хийгээд ариун хүмүүстэйгээ хамт ирэх энэ хоёр үйл явдлын дунд тодорхой цаг хугацаа шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийхэд гурав дахь шалтгаан бий. Шүүрэлтийн үед бүх

итгэгчид дэлхийгээс авагдаж, алдаршуулагдсан биетэй болцгооно. Гэтэл Христийг хаан болохоор эргэн ирэх үед алдаршуулагдсан биеийг авалгүй мянган жилийн хаанчлалын үеэр гэрлэж, үр хүүхэдтэй болох итгэгчид газар дэлхий дээр байна (Исаиа 11:6, 8). Тэр итгэгчид хаанаас гарч ирэх вэ? Тэгэхээр чуулганы шүүрэлт ба Христийн илчлэлийн хооронд хүмүүс итгэгч болоход хугацаа хэрэгтэй.

Эргээд 7 дугаар ишлэлийг үзвэл **Эзэн Есүс** хүч чадал, агуу алдартайгаар ирэхийг дүрсэлжээ. Түүний хүч чадлыг харуулсан **тэнгэрэлч нар** Түүнийг дагалдах болно.

1:8 Дүрэлзэх гал гэж Бурханы оршихуйн бэлгэдэл, сүр жавхлангийн үүл, Шекинаг хэлж байж болох юм (Гэтлэл 16:10). Аль эсвэл удахгүй асгарах аймшигт шүүлтийн зураглал байж болно (Дуулал 50:3; Исаиа 66:15). Ер нь нь бол хоёр дахь нь болов уу.

Бурхан **өшөө авах** гэдэг нь өс хонзонгоо авах гэсэн үг биш, харин буруутанд шударгаар хариу барихыг хэлж байгаа юм. Бурхан хонзогnoj хорссон сэтгэлээр “тэнцүүлэх” гэсэн санаагүй бөгөөд харин ариун зөвт чанарынхаа шаарддаг шийтгэлийг өгч байгаа болно. Бурхан хилэнцэтний үхэлд баярладаггүй (Езекиел 18:32).

Паулын өгүүлж байгаачлан шийтгэл хүртэх хоёр төрлийн хүн байна. Үүнд:

1. **Бурханыг мэддэггүй хүмүүс:** Сайнмэдээг огт сонсоогүй байж болох ч Бурханы бүтээл,

байгаль дэлхий ба өөрсдийнх нь мөс чанар дотор илчлэгдсэн жинхэнэ Бурханы мэдлэгийг хүлээн авахаас татгалзсан хүмүүс (Ром 1, 2).

2. Бидний Эзэн Есүс Христийн сайн мэдээг дагадаггүй хүмүүс: Сайнмэдээг сонссон авч хүлээн авахаас татгалзсан хүмүүс. Сайнмэдээ бол зүгээр нэг юм сонсоод түүндээ үнэмших тухай биш, харин Тэр Нэгэнийг дагах тухай юм. Шинэ гэрээнд итгэх итгэл нь дотроо дуулгавартай дагахуйг багтаадаг.

1:9 Тэд мөнх сүйрлийн төлөөсийг төлнө (шийтгэл авна). Нүглийг шийтгэдэггүй бурхан үнэндээ бурхан биш билээ. Хайрын Бурхан нүглийг шийтгэхгүй гэдэг үзэл нь Бурхан бол бас ариун бөгөөд зөв шударгыг хийх ёстой нэгэн гэдэг үнэнийг үгүйсгэж буй хэрэг юм.

Шийтгэлийн шинж чанарыг энд **мөнх сүйрэл** хэмээн дүрсэлжээ. “Мөнх” (*aiônios*) гэж орчуулагдсан үгийг Шинэ гэрээнд долоон удаа ашигласан. Ингэхдээ гурван удаагийнх нь “годорхой хугацааны эрин үе” гэсэн утгатай (Ром 16:25; Тимот 1:9; Тит 1:2) бол үлдсэн дөрөвт нь эцэс төгсгөлгүй үүрд мөнх гэсэн утгатай байдаг. Ром 16:26 дээр Бурханы оршин байгаа нь эцэс төгсгөлгүй болохыг дүрслэхийн тулд энэ үгийг ашигласан.

Сүйрэл гэдэг нь оргүй алга болно гэсэн үг огт биш. Харин сайн сайхнаа алдах, оршин байхуйн гол зорилгоосоо бүрэн салахыг хэлнэ. Лук 5:37 дээр Эзэн Есүс “зад татагдах” (язгуур нь адил үгийг энд ашигласан) туламны тухай

ярьсан. Дарсны тулам оргүй алга болоогүй. Харин ямар ч ашиггүй болж сүйдсэн.

Шүүрэлт Их зовлонгийн дараа болно гэж үздэг хүмүүс Библийн энэ хэсгийг ашиглан байр сууриа өмгөөлдөг. Христ хаанчлахаар эргэн иртэл итгэгчид амралтыг эс олж, хавчигсад нь шийтгэгдэхгүй бөгөөд энэ бүхэн Их зовлонгийн төгсгөлд тохионо гэж тэр хүмүүс хэлдэг. Тиймээс итгэгчдийн найдвар бол Их зовлонгийн дараах шүүрэлт хэмээн тэд үздэг.

Энэ захидлыг хүлээн авсан тесалоникчууд одоо бүгд нас барж, тэнгэрт Эзэнтэй хамт амралтыг амсаж байгаа гэдгийг тэд харахгүй байгаа юм. Түүнчлэн, хавчигсад нь ч бүгд нас барж, Үхэгсдийн оронд зовлон эдэлж байгаа.

Тэгвэл Христ дэлхий дээр хүч чадал, агуу алдар дотор ирэх хүртэл ийм байдал бий болохгүй гэсэн Паулын үг ямар утгатай юм бэ? Итгэгчид амралтыг олж, хавчигсад нь шийтгэгдэх байдал дэлхий дахинд ил тод үзэгдэх цаг үеийн тухай Паул ярьсан. Тэр цагт тесалоникчуудын зөв, хавчигсдынх нь буруу байсныг энэ ертөнц харах болно. Их зовлонгийн төгсгөлд болох Эзэний дайснуудын сүйрэл гэдэг нь Бурханы хүмүүсийг зовоож байсан бүх цаг үеийн хүмүүсийн гамшиг сүйрлийг нийтэд ил тод харуулах цаг үе юм.

Христ хаанчлахаар эргэн ирэх нь Түүний үзэгдэлт гэдгийг санавал тун тустай. Үнэн зөв нь юу байсныг тэр цагт бүх дэлхийн өмнө

дэлгэн харуулна. Гэтэл шүүрэлтийн үед ийм юм болохгүй.

Хилэнцэт хүмүүс шийтгүүлэхдээ **Эзэний оршихуй ба Түүний хүчний алдраас** хөөгдөх болно. Эзэнгүйгээр мөхөх гэдэг нь мөнхөд Түүнгүй байхыг хэлдэг.

1:10 Түүний ирэлт нь Эзэний хувьд алдар, ирэхийг нь харагсдын хувьд бишрэлийн цаг байх болно.

Тэрээр **ариун хүмүүсийнхээ дунд алдаршина**. Өөрөөр хэлбэл тэдний дотор болон тэднээр дамжуулан хийсэн зүйлийнхээ улмаас Тэр хүндлэгдэнэ. Тэдний аврал, ариусгал, алдаршуулал нь Түүний хэмжээлшгүй нигүүлсэл ба хүч чадалд алдар магтаал болно.

Тэр **бүх итгэгчдэдээ гайхагдах болно**.⁴ Бурхан арчгүй дорой хүмүүст ийм их сайн сайхныг өгснийг хараад хүмүүс шагшин гайхах болно.

Тэдний дунд тесалоникчууд ч гэсэн бий. Яагаад гэвэл тэд элч нарын **гэрчлэлд** итгэсэн билээ. **Тэрхүү өдрийн**, бүр тодруулбал Есүс Христийн илчлэгдэх өдрийн алдар хийгээд ялалтыг тесалоникчууд хуваалцана.

Тэгэхээр 5-10 дугаар ишлэлийг бид өөрөөр найруулан бичвэл: “Зовлон бэрхшээлийн дунд тэвчээртэй байгаа чинь үнэхээр чухал. Энэ бүхний дотор Бурхан Өөрийн зөвт зорилгоо хэрэгжүүлж байна. Хавчлагад зориг тэвчээртэй байгаа чинь хожим ирэх Христийн хаанчлалын алдраас хуваалцахын шинж тэмдэг мөн. Нэг

талд, та нарыг зовоогч нарт Бурхан шүүлтийн арга хэмжээ авна. Нөгөө талд, зовж байгаа та нарт Бурхан амралтыг өгнө. Паул, Силуан, Тимот бид ч бас та нартай хамт байна. Тэрээр дүрэлзэх галын дотор эрх мэдлийг нь хэрэгжүүлэгч тэнгэрэлч нарын хамтаар тэнгэрээс буун ирэхдээ та нарын дайснуудыг шүүж, Бурханыг санаатайгаар умартагсад болоод сайнмэдээнд дуулгаваргүй хүмүүсийг шийтгэх болно. Тэр хүмүүс мөнх сүйрлийг амсана. Түүгээр ч зогсохгүй тэднийг Эзний өмнөөс зайлуулна. Энэ үйл явдлууд нь бүх итгэгчдийн дотор алдаршихаар Түүнийг эргэн ирэх үед болно. Тэдгээр итгэгчдийн дотор та нар ч бас байх болно. Яагаад гэвэл та нар бидний тунхагласан сайн мэдээнд итгэсэн билээ.”

В. Ариун хүмүүсийн төлөөх Паулын залбирал (1:11, 12)

1:11 Өмнөх ишлэлүүдэд элч Паул ариун хүмүүсийн яруу алдарт дуудлагын тухай өгүүлсэн. Тэд хавчлагыг тэсвэрлэхээр дуудагджээ. Энэ нь тэднийг Бурханы хаанчлалд удирдлагад гарах зохистой хүмүүс болгодог. Харин тэдний амьдрал энэхүү өндөр дээд **дуудлагад зохистойд** тооцогдох болтугай хэмээн элч Паул залбирдаг байжээ. Мөн Бурханы агуу **хүч** нь сайныг үйлдэх уриалга бүхэнд тэднийг дуулгавартай байлгаж, **итгэл**

доторх үүрэг бүхнийг биелүүлэх чадалтай болгох болтугай гэж залбирдаг байсан.

1:12 Үр дүн нь хоёр талтай. Нэгд, **бидний Эзэн Есүс Христийн нэр** тэдний дотор алдаршина. Өөрөөр хэлбэл, тэд энэ ертөнцөд Эзэн Есүсийг тусган харуулж, үүгээрээ Түүнд алдрыг авчирна. Хоёрт, тэд өөрсдөө **Түүний дотор** алдаршина. Христ бол тэдний тэргүүн мөн. Тиймээс Түүнтэй нэгдэж, биеийнх нь эрхтнүүд болсноор тэдэнд ч бас хүндлэл ирнэ.

Энэхүү залбирал зөвхөн **бидний Бурхан ба Эзэн Есүс Христийн нигүүлслийн дагуу** хариу авч чадна гэдгийг сануулаад 1 дүгээр бүлэг төгсөж байна. Элч Паул үүгээрээ итгэгч хүний амьдралд байдаг зовлонгийн утга учир, үр дүнг гайхалтай сайхан дүгнэн тайлбарлажээ. Тесалоникчууд энэ баттай мэдээг уншаад ямар их урамшин зоригжсон бол доо!

III. ЭЗЭНИЙ ӨДРИЙН ТУХАЙ (2:1-12)

A. Гуйвахгүй тогтвортой байхыг ятгасан нь (2:1, 2)

Харин одоо Паул **бидний Эзэн Есүс Христийн ирэх хийгээд** Эзэний өдрийн тухайд ариун хүмүүсийн дунд бий болсон буруу зөрүү бодлуудыг залруулахыг оролдож байна. Тесалоникийн ариун хүмүүс маш хүнд хавчлагыг туулж байсан учраас Эзэний өдөр буюу Их зовлонгийн үе ирчихсэн хэмээн дүгнэхэд амархан байв. Элч Паул өөрөө Эзэний

өдөр ирчихсэн хэмээн үздэг бөгөөд заадаг гэх цуу яриа дэгдсэн нь улам нэрмээс болж байв. Тийм учраас Паул үүнийг нэг тийш болгох хэрэгтэй болсон.

Энэ ишлэлийн дотор Паулын ашигласан **тухайд** (грек: *hyper*) гэх ганц үг томоохон асуулт үүсгэдэг. Энэ үгийн утга **бидний Эзэн Есүс Христийн ирэх** “тухай” юм уу аль эсвэл **бидний Эзэн Есүс Христийн ирэх** “явдлаар ятган” **гуйж байгаа** юм уу гэдэг нь бүрэн тодорхой биш байдаг. Хэрэв эхний утгыг зөв гэж үзвэл шүүрэлт ба Эзэний өдөр нь нэг ижил үйл явдал гэж дүгнэхээс өөр аргагүй. Яагаад гэвэл удаах ишлэлүүд нь Эзэний өдрийн тухай өгүүлсэн нь маргаангүй. Хэрэв хоёр дахь утгыг зөв гэж үзвэл Эзэний өдөр ирчихлээ хэмээн бодох хэрэггүй гэдгийг шүүрэлтэд үндэслэн та нараас гуйж байна гэсэн утгатай болно. Аль нь зөв бэ гэдэг маргаантай. Виллиям Келлигийн нэг адил бид хоёр дахь утгыг зөв гэж үздэг. Тэрээр хэлэхдээ:

Тэр өдөр (Эзэний өдөр) ирчихсэн хэмээх буруу ойлголтоос үүдэлтэй айдас хүйдсийг үгүй болгож, итгэл найдвар өгөхийн тулд Эзэний ирэлтээр тайвшруулсан.⁵

Паулын хэлснийг бид дараах байдлаар ойлгодог: “Эзэний өдөр ирчихлээ хэмээн бүү айгаарай. Шүүрэлтэд үндэслэн үүнийг та нараас гуйж байна. Эзэний өдөр ирэхээс өмнө шүүрэлт

тохиох учиртай. Тэр үед та нарыг тэнгэр дэх орон гэр рүү чинь авч явах тул та нар Эзэний өдрийн аймшгийг үзэхгүй.”

Бидний Эзэн Есүс Христийн ирэх хийгээд бид түүн өөд цуглах гэдэг үг гарцаагүй шүүрэлтийг өгүүлж байна. Шүүрэлтийн үед бид агаарт Түүнтэй уулзахаар цуглах болно.

2:2 Шүүрэлт ба Эзэний өдөр нь ялгаатай гэдэг нь тодорхой. Тесалоникчууд Эзэн ирчихлээ хэмээн санаа зовоогүй. Эзэн ирээгүйг тэд мэдэж байсан. Харин тэд Эзэний өдөр эхэлчихлээ хэмээн санаа зовсон. Хүнд хавчлага зовлон амсаж байсан учраас Эзэний өдрийн эхний үе шат болох Их зовлонгийн үе ирчихсэн хэмээн тэд боджээ.

Паул ч бас Эзэний өдөр ирчихсэн гэж ярьсан гэх цуу дэгдсэн байв. Цуу үг янз бүрийн хувилбартай байдаг. Паулын талаарх цуу үг ч бас адил байв. Зарим хүн Паулыг илчлэл авсан (**сүнсээр**) гэж ярьж байхад, зарим нь Их зовлонгийн үе эхэлсэн гэж Паул хүмүүст заасан (**үг яриагаар**) гэж ярьж байв. **Биднээс ирсэн мэт захидал** гэдэг нь Эзэний өдөр ирсэн гэх агуулгатай, Паулын нэрээр бичсэн хуурамч захидлыг хэлсэн болов уу. Биднээс ирсэн мэт гэдэг үгийг **сүнс, үг яриа, захидалд** гурвууланд нь ашигласан байх магадлалтай. Ямартай ч энэ гурван эх сурвалжийн алинд нь ч итгэж болохгүй.

Гар бичмэлийн дийлэнхийг дагасан KJV ба NKJV орчуулгуудыг харвал тесалоникийн

ариун хүмүүс **Христийн өдөр ирчихлээ** хэмээн айж байжээ. **Христийн өдөр** гэх үг болон үүнтэй адил үгс нь ихэнхдээ шүүрэлт ба Христийн шүүх суудлыг зааж байдаг (1Коринт 1:8; 5:5; 2Коринт 1:14; Филиппой 1:6, 10; 2:15, 16).

Гэхдээ Христийн өдөр ойрхон байна гэдгээс тесалоникчууд айгаагүй. Христийн өдөр гэдэг тэдний хувьд зовлонгоос ангижрах гэдэгтэй адил сонсогдох байсан биз ээ. Шүүрэлт Их зовлонгийн өмнө болно гэх үзэлтэй ихэнх хүн “Эзэний өдөр ирчихлээ”⁶ гэх RV-ийн хувилбарыг зөв гэж үздэг. Паулын захидлыг уншигч нар Бурханы уур хилэнгийн өдөр эхэлсэн байх вий гэдгээс айж байсан.

Б. Ёс бусын хүн (2:3-12)

Харин одоо **тэрхүү өдөр** ирээгүйг яаж мэдэж болохыг элч Паул тайлбарлаж байна. Эхлээд болох ёстой үйл явдлууд байгаа ажээ. Шүүрэлт болсны дараа тэдгээр үйл явдал тохионо.

Энэ бүхний түүрүүнд **урвалт** буюу итгэлээс салах явдал гарна.⁷ Энэ нь юу гэсэн утгатай вэ? Бид зөвхөн таамаглаж чадна. Бидний таамаглаж байгаагаар энэ нь Христитгэлийг нийтээр орхиж, татгалзах явдлыг хэлж байгаа болов уу.

Түүний дараа дэлхийн тавцан дээр нэг хүн гарч ирнэ. Түүнийг **ёс бусын хүн** буюу хуульгүй хүн⁸ гэж нэрлэснээс харахад түүний гол шинж чанар нь нүгэл ба тэрслэл аж. Гэвч

тэрээр мөнхийн шийтгэл хүртэх тавилантай тул **сүйрлийн хөвгүүн** гэж нэрлэгдсэн.

Их зовлонгийн үеэр гарч ирэх энэ хүний талаар бичээст янз бүрээр дүрсэлсэн байх бөгөөд нэг хүнийг олон өөрөөр нэрлэсэн байдаг тул баттай тодорхойлох амаргүй. Зарим хүн түүнийг еврей антихрист байна гэдэг. Харин зарим нь дахин мандсан Ромын эзэнт гүрний тэргүүн, харь үндэстний хүн байна гэдэг. Эцсийн цагт гарч ирэх их удирдагч нарын зарим нэрүүдийг дор жагсаав:

...сүйрлийн хөвгүүн болох ёс бусын хүн
(2Тесалоник 2:3)

...Антихрист (1Иохан 2:18)

...жижиг эвэр (Даниел 7:8; 24б-26)

...нэгэн шазруун хаан (Даниел 8:23-25)

...хожим ирэх жонон (Даниел 9:26)

...хүссэнээ хийх хаан (Даниел 11:36)

...зохисгүй хоньчин (Зехариа 11:17)

...тэнгисээс гарч ирэх араатан (Илчлэл 13:1-10)

...газар доороос гарч ирэх араатан (Илчлэл 13:11-17)

...долоон толгой, арван эвэртэй час улаан араатан (Илчлэл 17:4, 8-14)

...умард зүгийн хаан (Даниел 11:40)

...өмнө зүгийн хаан (Даниел 11:40)

...хуурамч эш үзүүлэгч (Илчлэл 19:20; 20:10)

...Магог газрын Гог (Езекиел 38:2-39:11)

[мянган жилийн хаанчлалын дараа гарч ирэх,

Илчлэл 20:8 дээр дүрсэлсэн Гогтой андуурч болохгүй]

...өөрийнхөө нэрээр ирэх нэгэн (Иохан 5:43)

Ёс бусын хүн яг хэн бэ гэдгийг тодорхойлох гэсэн янз бүрийн оролдлого үргэлж гарч байсан. Тухайлбал түүнийг Ромын католик чуулган, пап, Ромын эзэнт гүрэн, итгэлээсээ урвасан Христитгэлт улс гүрний сүүлийн хэлбэр, амилсан Иудас, амилсан Неро, еврейн улс, Мухаммед, Лутер, Напелеон, Муссолини, Сатаны биежилт гэх мэтээр тодорхойлж байжээ.

2:4 Тэрээр аливаа бурхан шүтээнд мөргөх мөргөлийн бүх хэлбэрийг хүч түрэмгийлэн эсэргүүцэж, Иерусалим дахь **Бурханы сүм дотор** Өөрийгөө өргөмжлөх болно. Антихрист гэж хэн байхыг энэ дүрслэл маш тодорхой хэлж өгч байна. Тэрээр Христийг эсэргүүцэгч төдийгүй өөрийгөө Христийн оронд тавигч ажээ.⁹

Даниел 9:27 ба Матай 24:15-д дүрсэлснээр, Антихрист Их зовлонгийн үеийн дунд үеэс эхлэн Бурханыг доромжилсон үйлдэл гаргаж эхэлнэ. Түүнд мөргөхөөс татгалзсан хүмүүс хавчигдаж, олон хүн амиа алдана.

2:5 Паул тесалоникчуудтай **хамт байхдаа эдгээрийн тухай** хэлж байжээ. Гэтэл амсаж байгаа хавчлагыг нь зөв зүйтэй тайлбарлаж байгаа мэт харагдсан худал сургаалыг сонсмогцоо тэд элч Паулыг хэлсэн үгийг мартсан байна. Бид маш амархан мартдаг тул

итгэлийн агуу үнэнүүдийг бидэнд байнга сануулж байх хэрэгтэй болдог.

2:6 Ёс бусын хүний бүрэн дүүрэн, ил тод үзэгдэлтийг **юу хязгаарлан барьдгийг**, тогтоосон цаг хүртэл юу хязгаарлан барьсаар байгааг тесалоникчууд **мэдэж** байсан.

Энэ бүлгээс тодорхой хариу авч чадахгүй гурав дахь асуулт эндээс урган гарна. Эхний асуулт: “Урвалт (*apostasia*) гэж юу вэ?” Хоёр дахь асуулт: “Ёс бусын хүн гэж хэн бэ?” Гурав дахь асуулт: “Хязгаарлан баригч гэж хэн/юу вэ?”

Зургадугаар ишлэлийн эхний хэсэгт хязгаарлан баригчийг ямар нэг юм мэт дүрсэлсэн. Гэтэл 7 дугаар ишлэлд хэн нэг хүн мэт дүрсэлсэн.¹⁰ Э. В. Рожерс үүнд маш тодорхой тайлбар өгсөн:

Хуульгүй Хүнийг товлосон цагаас өмнө гаргаж ирүүлэхгүйн тулд зорилготойгоор, төлөвлөгөөтэйгөөр, санаатайгаар хязгаарлан баригч бол Хэн нэгэн төдийгүй ямар Нэгэн юм мөн.¹¹

Хязгаарлан баригч гэж хэн бэ, юу вэ гэдгийг тодорхойлсон хамгийн түгээмэл долоон тодорхойлолт: (1) Ромын эзэнт гүрэн, (2) Еврей улс, (3) Сатан, (4) хүн төрөлхтний засаг захиргааны хууль журам, (5) Бурхан, (6) Ариун Сүнс, (7) Сүнсний орших газар болсон жинхэнэ чуулган.

Чуулган хийгээд итгэгч хүний дотор оршигч Ариун Сүнсийг тэрхүү хязгаарлан баригч гэж

үзэх нь бусад тодорхойлолтоос илүү нийцдэг. Энэ бүлэгт хэн нэгэн ба ямар нэгэн юм мэт дүрсэлсэн шиг Иоханы 14:26, 15:26, 16:8, 13, 14 дүгээр ишлэлүүдэд Сүнсийг саармаг (Ариун Сүнс) ба эр хүйсийн (тэр) аль алианаар нь илэрхийлсэн.¹² Эхлэл 6:3 дугаар ишлэлийг үзвэл Ариун Сүнсийг өнө эрт цагт бузар мууг хязгаарлан баригч байсан мэт дүрсэлсэн. Мөн Исаиа 59:19б, Иохан 16:7-11, 1Иохан 4:4 дээр Ариун Сүнс ийм үүрэгтэйгээр дүрслэгдсэн.

Ариун Сүнс өөрсдийнх нь дотор оршдог учраас итгэгчид газрын давс (Матай 5:13), ертөнцийн гэрэл (Матай 5:14) болдог. Давсаар хүнсийг хадгалж хамгаалахаас гадна, хүнсийг ялзарч муудахаас сэргийлдэг. Хүмүүс муу муухай үйлсээ харанхуйд хийх дуртай (Иохан 3:19). Харин харанхуйг гэрэл зайлуулдаг. Ариун Сүнс чуулган (1Коринт 3:16) хийгээд итгэгч хүний (1Коринт 6:19) дотор үргэлж оршигчийн хувьд энэ дэлхийг орхиход хуульгүй хүнийг хязгаарлан баригч одох болно.

2:7 Паулыг бичиж байх тэр үед ч гэсэн **ёс бусын нууц нь хэдийнээ ажиллаж** байсан. Тэгэхээр Бурханд дуулгаваргүй байдлын сүнс гадаргын дор аль хэдийнээс ажиллаж, гарч ирэхэд хэзээд бэлэн байгааг бид эндээс ойлгодог. Тэрээр **нууц** хэлбэрээр ажиллаж байна. Энэ нь далдын юм гэсэн утгаар бус, харин бүрэн дүүрэн гарч ирээгүй байгааг илэрхийлнэ. Одоогоор гурилыг исгэх хөрөнгө мэт хэлбэрт байна.

Энэ сүнс бүрэн дүүрэн үзэгдэхэд юу саад болж байна вэ? Чуулган хийгээд итгэгч бүрийн дотор оршигч Ариун Сүнсний оршихуй түүнийг хязгаарлагч хүч гэж бид үздэг. **Дундаас нь зайлуулагдах хүртэл** Ариун Сүнс үүнийгээ үргэлжлүүлэх болно. Дундаас нь зайлуулагдах үе бол шүүрэлт юм.

Үүнийг сөргүүлэн дараах асуултыг асуух хүн байж болох юм. Ариун Сүнс энэ ертөнцөөс хэрхэн зайлуулагдаж чадах юм бэ? Бурханы гурвалын нэг болох Ариун Сүнс цаг үргэлж хаа сайгүй оршигч биш гэж үү? Тэгэхээр Ариун Сүнс энэ ертөнцийг орхиж чадахгүй юм биш үү?

Ариун Сүнс хаа сайгүй оршигч гэдэг нь үнэн. Ариун Сүнс нэг цагт хаа сайгүй зэрэг оршигч юм. Гэвч Ариун Сүнс Пентекостын өдөр газар дэлхийд бууж ирсэн гэдэг нь огт өөр зүйл юм шүү. Есүс Эцэгийн хамт Ариун Сүнсийг илгээх болно гэж олонтаа амласан (Иохан 14:16, 26; 15:26; 16:7). Тэгвэл Сүнс яаж ирсэн байх вэ? Тэрээр чуулган хийгээд итгэгч бүрийн дотор байнга оршигч байхаар буун ирсэн юм. Пентекостын өдрийг хүртэл Сүнс итгэгчидтэй хамт оршиж байсан бол Пентекостоос хойш итгэгчдийн дотор орших болсон (Иохан 14:17). Пентекостоос өмнө Ариун Сүнс итгэгчдийг орхидог байсан. Тийм болохоор Давид “Ариун Сүнсээ надаас бүү аваач” (Иохан 14:16) хэмээн залбирчээ.

Ариун Сүнс чуулган хийгээд итгэгчдийн дотор байнга оршин суухаар Пентекостын өдөр

ирсэн шигээ энэ ертөнцийг орхино гэдэгт бид итгэдэг. Гэхдээ Ариун Сүнс энэ дэлхийд байж, хүмүүсийг нүглийнх нь улмаас зэмлэж, Христэд итгүүлж, аврал уруу хөтөлсөн хэвээр байх болно. Шүүрэлтийн үед Ариун Сүнс зайлуулагдана гэдэг нь Их зовлонгийн үед хэн ч аврагдахгүй гэсэн үг биш. Мэдээж хэрэг хүмүүс аврагдана. Гэхдээ тэр хүмүүс чуулганы нэг хэсэг болохгүй. Харин Христийн яруу алдарт хаанчлалын харьяатууд болно.

2:8 Чуулган тэнгэр рүү өргөгдсөний дараа **хуульгүй нэгэн** энэ ертөнцөд **илчлэгдэнэ**. Энэ ишлэлд элч Паул Антихристийн ажил үйлсийн талаар ярилгүй, шууд түүний эцсийн сүйрлийг өгүүлж байна. Антихрист илчлэгдсэн даруйдаа устгагдах юм шиг эндээс ойлгогдож болох юм. Гэхдээ мэдээж тийм биш. Христ хаан суухаар эргэн ирж түүнийг устгахаас өмнө тэрээр 9-12 дугаар ишлэлд дурдсан бүхнийг гүйцэлдүүлэх аймшигт ноёрхлыг тогтооно.

Ёс бусын хүн шүүрэлтийн дараа илчлэгдэж, Христийн илчлэл хүртэл байна гэж үзэх маань зөв бол түүний үйл ажиллагаа ойролцоогоор долоон жил буюу Их зовлонгийн үетэй адил хугацаанд үргэлжилнэ.

Эзэн Есүс амныхаа амьсгалаар түүнийг алж (Исаиа 11:4; Илчлэл 19:15-тай харьцуулж хар), **ирэлтийн төрхөөрөө** (үзэгдэлтээрээ) түүнийг сөнөөнө. Агуу заль мэхтэй Антихристийн дэглэмийг дуусгахад Христийн

үг ба үзэгдэлтийнх (*parousia*) нь хурц туяа (*epiphaneia*) хэрэгтэй.

Христ газар дэлхийд эргэн ирээд хаан сэнтийд заларч, мянган жил хаанчлах үе бол Христийн ирэлтийн үзэгдэлт гэдгийг бид өмнө тайлбарласан.

2:9 Хуульгүй нэгэн нь Сатаны ажлын дагуу гарч ирнэ. Тэрээр Сатанаас эрч хүч авах тул Сатантай адил. Тэрээр зүсэн бүрийн ер бусын үйлс, тэмдгүүд, худал хуурмаг гайхамшиг үйлдэнэ.

Тэгэхээр бүх гайхамшиг Бурханаас байдаггүйг ойлгох нь чухал. Диавол болон түүний албатууд ч гайхамшиг үйлдэж чадна. Хуульгүй хүн ч бас гайхамшгууд үйлдэнэ (Илчлэл 13:13-15).

Гайхамшиг гэдэг нь ямар нэг ер бусын хүч чадал юм. Гэхдээ заавал Бурханы хүч чадал байх албагүй. Бидний Эзэний гайхамшгууд Түүнийг амлагдсан Мессиа гэдгийг батлан харуулсан. Гэхдээ тэдгээр гайхамшгууд ер бусын учраас бус, харин эш үзүүллэгүүдийг биелүүлж, зөвт ариун чанартай учраас тийнхүү батлан харуулсан. Тийм чанарыг Сатан хэзээ ч гаргаж чадахгүй. Гаргая гэвэл Сатан өөрийн мөн чанараа үгүйсгэсэн хэрэг болно.

2:10 Нигүүлслийн эрин үед сайнмэдээ сонссон ч **үнэний** төлөөх **хайр** үгүй, мөхөж буй хүмүүсийг хууран мэхлэхийн тулд Антихрист бузар муу, нүгэл хилэнцийн бүх хэлбэрийг ичгүүр сонжуургүйгээр ашиглана. Хэрэв тэд

итгэсэн бол **аврагдах** байсан. Харин эдүгээ тэд Антихристийн гайхамшгуудад хууртах ажээ.

2:11 Бурхан тэдэн рүү төөрөгдөл илгээж, тэд худал хуурмагт итгэх болно. Худал хуурмаг гэдэг нь өөрийгөө Бурхан гэж зарласан Антихристийн үг. Тэр хүмүүс Эзэн Есүсийг махбодоор үзэгдсэн Бурхан хэмээн хүлээн авахаас татгалзсан юм. Эзэн Есүс газар дэлхийд байхдаа “Би Эцэгийнхээ нэрээр ирсэн юм. Гэтэл та нар Намайг хүлээж авдаггүй. Хэрэв өөр нэгэн өөрийнхөө нэрээр ирвэл та нар түүнийг хүлээж авна” (Иохан 5:43) хэмээн анхааруулан хэлжээ. Тэгэхээр өөрийнхөө нэрээр ирж, өөрт нь Бурхан адил мөргөхийг шаардах ёс бусын хүнийг тэд хүлээн авна. “Гэрлийг үгүйсгэсэн хүнийг гэрэл хүлээн авахгүй.” Хүн зүрхэндээ шүтээн тавьбал Бурхан шүтээнийх нь дагуу түүнд хариулна (Езекиел 14:4).

Антихрист еврей хүн байх магадлалтай (Езекиел 28:9, 10; Даниел 11:37, 38). Иуда овгийн Давидын удмын биш хүнийг еврейчүүд Мессиа гэж итгэн хууртахгүй болов уу.

2:12 Энэхүү Нигүүлслийн эрин үед сайнмэдээг сонссон ч Христэд найдаагүй хүмүүст аврагдах боломж шүүрэлтийн дараа дахиж олдохгүй гэж энэ ишлэлээс дүгнэж болохоор байна. Хүн Эзэн Есүст одоо л итгэхгүй бол хожим Антихристэд итгэх болно. Итгэлгүй, бузар мууг хайрласан **бүхэн** шүүгдэх болно гэж энд хэлжээ. Энэ нь бидэнд Лук 14:24-д хэлсэн “Уригдсан байсан нөгөө хүмүүсээс нэг

нь ч миний зоогноос амсахгүй” гэх үгийг сануулдаг.

Их зовлонгийн үед олон хүн аврагдана гэдгийг бид мэднэ. Тухайлбал зуун дөчин дөрвөн мянган еврей хүн аврагдаж, дэлхий даяар хаанчлалын сайнмэдээг тунхаглах Бурханы элч нар болцгооно. Гэхдээ одоогийн энэ үед сайнмэдээг огт сонсоогүй буюу Аврагчийг санаатай үгүйсгээгүй хүмүүс аврагдах юм.

IV. ТАЛАРХАЛ БА ЗАЛБИРАЛ (2:13-17)

А. Ариун хүмүүс шүүлт амсахгүй гэдэгт Паул талархсан нь (2:13, 14)

2:13 Паул эхний арван хоёр ишлэлд Антихрист болон түүний дагалдагчдын мөхлийн тухай ярьсан. Харин эндээс эхлэн тесалоникийн итгэгчдийн дуудлага хийгээд хувь тавиланг өмнөхтэй эсрэгцүүлэн өгүүлж байна. Ингэхдээ тэрээр Эзэнээр хайрлагдсан Тесалоникийн ах дүү нарын төлөө Бурханд талархсанаа илэрхийлж, авралынх нь талаар, өнгөрсөн, одоо, ирээдүйг тоймлон дүгнэсэн.

Бурхан...та нарыг сонгосон. Бурхан хүнийг сонгож авардаг хэмээн Библи тодорхой заадаг. Гэхдээ хүнийг мөхүүлэхээр сонгодог гэж Библи огтхон ч заадаггүй. Хүмүүс өөрсдийн сайн дурын сонголтын улмаас авралаас төөрдөг. Бурхан хөндлөнгөөс оролцохгүй бол хэн ч

аврагдахгүй байсан. Мөхөж байгаа бүхний дотроос заримыг нь аврах эрх Бурханд бий юу? Ерөнхийдөө бол Бурхан бүх хүнийг аврагдаасай гэж хүсдэг (1Тимот 2:4; 2Петр 3:9). Гэхдээ Библид “Универсализм” (эцэстээ бүх хүн аврагдана гэх онол) үгүй.

Эхнээсээ/анхны. Энэ үгийг хоёр утгаар ойлгож болно. Нэгд, Бурхан ертөнцийн сууриас өмнө сонгосон (Ефес 1:4). Хоёрт, “анхны үр жимс” гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, Тесалоникийн итгэгчдийг чуулганы эрин үеийн аврагдах бүх хүмүүсийн анхных байхаар Бурхан сонгосон гэж ойлгож болно.

Авралын төлөө. Үүнийг өмнөх ишлэлүүдэд өгүүлсэнтэй эсрэгцүүлэн тавьжээ. Үл итгэгчид итгэлгүй байдлаасаа болоод мөнх сүйрлийг амсах бол итгэгчид **авралын төлөө** сонгогджээ.

Сүнсний ариусгалаар дамжуулан. Хүнийг итгэгч болгох Ариун Сүнсний ажил. Тэрээр хүнийг энэ ертөнцөөс Бурханд тусгаарлаж, нүглийнх нь талаар зэмлэж, Христ рүү хандуулдаг байна. “Христийн л ачаар *найр* болно. Ариун Сүнсний л ачаар *зочид* ирнэ” хэмээн нэг хүн тун оновчтой хэлжээ.

Үнэн итгэл. Авралын ажилд Бурханы зүгээс хийдэг зүйлийг сая өгүүлсэн. Харин итгэл бол хүний зүгээс хийх ёстой зүйл юм. Зарим хүн зөвхөн Бурханы сонголтыг онцлоод хүн үүнд юу ч хийж чадахгүй гэж хэлдэг. Гэтэл нөгөө хэсэг нь хүний талыг хэт дөвийлгөөд Бурханы хэмжээгүй эрхт сонголтыг орхигдуулдаг. Гэтэл

энэ хоёр хоёулаа чухал. Бурханы сонголт ба хүний хариуцлага нь хоёулаа Библийн сургаал мөн. Яаж энэ хоёр зүйл нэгэн зэрэг үнэн байж болохыг ойлгохгүй байсан ч бид хоёуланд нь итгэх хэрэгтэй.

2:14 Бидний сайнмэдээгээр та нарыг дуудсан. Бурхан биднийг мөнхийн авралд сонгосон. Цаг нь ирэхээр **Тэр биднийг дуудсан.** Дуудлага гэдэг нь хүн үнэнд итгэсэн мөчийг хэлж байна. **Бидний сайнмэдээ** гэдэг нь өөр сайнмэдээ байдаг гэсэн үг биш. Сайнмэдээ бол ганц. Гэхдээ сайнмэдээг тунхаглагч нар хийгээд түүнийг сонсогч нар нь янз бүр. Паул өөрийн тунхагласан Бурханы **сайнмэдээг** ярьж байна.

Бидний Эзэн Есүс Христийн алдрыг хүртээх гэж. Элч Паул ирээдүйд авралын эцсийн үр дүн юу байхыг өгүүлж байна. Бидний авсан аврал эцэстээ биднийг Христтэй мөнх хамт байлгаж, Түүнтэй адил болгоно. Ж.Н. Дарби энэхүү санааг тусгасан магтаалын сайхан дуу зохиосон байдаг:

Тэгээд би үнэхээр таны Хүүтэй адил болох гэж үү?

Түүний намайг гэсэн нигүүлсэл ийм агуу гэж үү?

Алдын Эцэг минь, таны энэ төлөвлөгөө юутай бишрэм бэ!

Ерөөлт дүр төрхийг нь би алдар дотор хуваалцана.

Итгэгч хүмүүсийн талаарх Бурханы зорилгуудыг 13, 14 дүгээр ишлэл бидэнд гайхалтай тоймлон харуулжээ. Нэг ёсондоо энэ хоёр ишлэлд “системчилсэн теологи товч

хэлбэрээрээ” агуулагдаж байна. Тэрээр “тэнгэрлэг сонголтоор эхэлж, тэнгэрлэг хүчээр хэрэгжиж, тэнгэрлэг мэдээгээр идэвхжиж, тэнгэрлэг алдар дотор төгс болох” авралыг бидэнд өгчээ.

Б. Ариун хүмүүс тайтгарч, батжихын төлөө Паул залбирсан нь (2:15-17)

2:15 Өндөр дээд дуудлагатай ариун хүмүүсийг элч нарын **үгээр бас захидлаар заасан уламжлалуудыг баримталж, бат зогсохыг** сануулж сэнхрүүлж байна. Баримтлах ёстой **уламжлалууд** нь зөвхөн элч нараас эх сурвалжтай байх ёстойг үл ойшоож болохгүй. Өөрсдийн уламжлалыг Бурханы тушаалуудаас дээгүүр үзэж байсан хуулийн багш нар ба фарисайчуудыг Есүс зэмлэж байсан (Матай 15:6). Паул мөн хүний уламжлалаар олзуулуузай хэмээн колоссайчуудыг сэрэмжлүүлсэн (Колоссай 2:8). Бидний баримтлах ёстой **уламжлалууд** бол ариун Бичээсүүдэд байгаа агуу үнэнүүд билээ.

Чуулган хийгээд шашны удирдагч нарын уламжлалуудыг зөвтгөхийн тулд заримдаа энэ ишлэлийг ашиглах нь бий. Гэвч Бурханы үгийн эсрэг уламжлал нь ашиггүй төдийгүй аюултай. Хүний уламжлалуудыг Библи тэнцүү хэмжээнд хүлээн авбал аль уламжлал нь зөв, аль уламжлал нь бурууг юугаар шийдэх юм бэ?

Паул сургасныхаа араас ер нь залбирал бичдэг (1Тесалоник 5:23, 24; 2Тесалоник 3:16). Паулын залбирал **бидний Эзэн Есүст Өөрт** нь болон **Эцэг Бурханд маань** хандсан. Паул ер нь энэ хоёр нэрийг хамт дурддагийг бид мэднэ. Гэхдээ тэрээр Хүүг нь эхэнд дурдах тохиолдол их цөөн. Паул тэдний нэгдмэл байдал ба бүрэн тэгшийг үүгээр харуулдаг. Грек дээрээ, өгүүлбэрийн эзэн олон тоо (**Христ** ба **Бурхан**) байхад араас орсон дөрвөн үйл үгийг (хайрлах, өгөх, тайтгаруулах, бататгах) ганц тооны хэлбэрээр бичсэнээрээ Хүү ба Эцэг нэг Бурхан юм гэдгийг харуулжээ.

Бурхан өнгөрсөнд юу хийсэн нь Түүнд найдах ирээдүйн зориг хүч болдог. Тэрээр **биднийг хайрлаж, мөнх тайтгарал ба сайн найдварыг нигүүлслээр** өгчээ. Хүүгээ өгсөн нь Бурханы хайрыг бидэнд хамгийн дээдээр харуулсан бөгөөд Паул түүнийг энд сөхөн ярьж байна. Тэрээр Голгот дээр нүглийн асуудлыг шийдсэн гэдгийг мэддэг учраас бидэнд мөнхийн амар амгалан ба алдарт ирээдүйн **найдвар** бий. Энэ бүхэн Түүний гайхам **нигүүлслээр** хийгдсэн билээ.

2:17 Бурхан аливаа сайн үйлс хийгээд үг дотор тесалоникчуудын **зүрхийг тайтгаруулж**, тэднийг **бататгах болтугай** хэмээн Паул залбирч байна. Зовлон бэрхшээл дундах зоригжуулахаас гадна тулааны дунд урагшлах хүч. Элч Паулын үгийн санд “ухрах” гэдэг үг байгаагүй. Биднийхэд ч бас байх ёсгүй.

Аливаа сайн үйлс хийгээд үг гэдэг үгийг бүү орхигдуулаарай. Уруулаас маань урсдаг үнэн дангаараа хангалтгүй. Амьдралд маань бас ажил хэрэг, үйлс болдог байх ёстой. Заах нь үйлдэхтэй хамт, онол нь практиктай хамт, номлол нь үйлчлэлтэй хамт байх ёстой.

V. ПРАКТИК ЗӨВЛӨГӨӨ (3:1-15)

A. Бие биенийхээ төлөөх залбирал (3:1-5)

3:1 Элч Паул ариун хүмүүсийн залбирал хэрэгтэй гэж үзсэн. Тиймээс тэр гурван талбарт залбирч өгөхийг тесалоникчуудаас хүссэн: (1) сайнмэдээ түгэн дэлгэрэхийн төлөө; (2) сайнмэдээний ялалтын төлөө; (3) сайнмэдээ тунхаглагч нарын хамгаалалтын төлөө.

Эзэний үг түргэн тархахыг Паул хүссэн. Саад тотгорыг үл харгалзан газраас газарт сайнмэдээ түгэхийг Паул хүссэн (Дуулал 147:15-г үз).

Мөн **Эзэний үгээс тесалоникчуудын дунд бий болсон шиг үр дүн хаа сайгүй бий болж, сүнсний болоод ёс суртахууны гайхамшигт хувьсгал гараасай хэмээн хүссэн.**

3:2 **Буруу гажуу, хорон муу хүмүүсээ өөрийгөө болон хамтрагч нарыгаа гэтэлгэх нь Паулын гурав дахь хүсэлт байсан.** Тэрээр тодорхой зарим эсэргүүцлийг хэлж байсан бололтой. Тухайлбал Коринт хот дахь еврейчүүдийн эсэргүүцэл (Үйлс 18:1-18). Паул

буруу гажуу гэдэг үгийг сонгосон нь маш оножээ. Сайнмэдээг болон түүнийг тунхаглагч нарыг эсэргүүцэхээс илүү ухаангүй явдал үгүй. Үүнийг тайлбарлахад арга мухарддаг. Хүмүүс улс төр, шинжлэх ухаан болоод бусад салбарын талаар ихэд ухаалаг ярих атлаа сайнмэдээн дээр ирэхээр саруул ухаанаа гээчихдэг.

3:3 “Итгэл нь бүгдэд байхгүй” гэж 2 дугаар ишлэлд хэлснийг **Эзэн бол итгэмжит** хэмээн 3 дугаар ишлэлд эсрэгцүүлснийг анзааралгүй бүү өнгөрөөрэй. Энэ нь бидний харааг итгэлгүй хүн дээрээс авч хэзээ ч итгэл алддаггүй Бурхан дээр тавьж байна. Тэрээр биднийг эцэс хүртэл батлах **ИТГЭМЖИТ** (1Коринт 1:9). Тэрээр биднийг сорилтоос гэтэлгэх **ИТГЭМЖИТ** (1Коринт 10:13). Тэрээр биднийг бүхий л зүй бусаас минь цэвэрлэж, нүглүүдийг маань уучлах **ИТГЭМЖИТ** бөгөөд зөвт (1Иохан 1:9). Тэрээр биднийг **ёрын муугаас** (Сатанаас) **хамгаалан хүчтэй болгох ИТГЭМЖИТ**.

3:4 Итгэл нь бүгдэд байхгүй...Эзэн бол итгэмжит...**Эзэн дотор бид та нарт итгэдэг** [өөрөөр хэлбэл, бидэнд та нарын талаарх итгэл байдаг]. Дэнни үүнийг тайлбарлахдаа “Өөрсдөөрөө бол сул дорой, тогтворгүй, дур зоргоороо, мунхаг байх хүмүүст бид Эзэний дотор найдаж чадна” хэмээсэн. Паул энд өөрийнхөө тушаасан зүйлсийг хийх ёстойг ариун хүмүүст сануулж байна. Бурханы талаас хийгдэх зүйл ба хүний талаас хийгдэх зүйл гэж байдгийг эндээс ч бас бид үзэж болно: Бурхан

та нарыг хамгаална. Харин та нар тушаалуудыг сахиарай. 1Петр 1:5-ыг үзвэл үүнтэй адил зүйл бий: Та нар итгэлээрээ [хүний зүгээс] Бурханы хүчээр хамгаалагдсан [Бурханы зүгээс] ажээ. Филиппой 2:12,13 бас адил: “...өөрсдийн авралыг...гүйцээ [хүний зүгээс]...та нарын дотор үйлдэгч нь Бурхан өөрөө юм [Бурханы зүгээс].”

3:5 Хавчлага тохиолдох үед бусдад хорсож, удаан үргэлжлэх зовлон бэрхшээлийн хүнд бэрхээс болоод шантрахад амархан. Тиймээс элч Паул **Бурхан** яаж хайрладаг шиг хайрлаасай, **Христ** хэрхэн тэвчсэн шиг тэвчээсэй хэмээн тесалоникчуудын төлөө залбирч байна.

KJV орчуулгад “Христийг хүлээх тэвчээр” хэмээснийг NKJV-д **Христийн тэвчээр** гэж буулгасан байна. 1611 оны орчуулга нь Христийн эргэн ирэлтийг хүлээх зуураа тэвчээртэй байх гэсэн утгатай бол NKJV нь Христ газар дэлхий дээр байхдаа харуулсан, тэнгэрт байхдаа харуулсаар байгаа тэвчээр, хүлцлийг харуулах гэсэн утгатай.¹³

Энэ ишлэлд байгаа **Эзэн** гэдэг үг Ариун Сүнсийг хэлсэн байх магадлалтай. Тэгэхээр 2:13, 14 дээрхтэй адил Гурвалын бүх гишүүн энэ ишлэлд дурдагджээ.

Б. Дуулгаваргүй ах дүүст ямар арга хэмжээ авах талаар (3:6-15)

3:6 Тесалоник дахь ариун хүмүүсийн зарим нь Эзэний эргэн ирэхийг эрчимтэй хүлээхдээ

амьдралынхаа хэрэгцээний төлөө ажил хийхээ больсон байна. Паул ийм явдлыг огтхон ч сайшаагаагүй. Харин ийм ах дүүдээ ямар арга хэмжээ авах талаар тодорхой зааварчилгаа өгсөн.

Ажил огт хийхгүй, бусдын хэрэгт оролцож, **залхууран амьдрагч ах дүү бүрээс хол байхыг** Паул тушаасан өнгө аясаар зааварласан (10, 11 дүгээр ишлэлийг үз). Тийм ах дүүсээс хөндийрч буруутай үйлдлийг нь эсэргүүцэж байгаагаа харуулах хэрэгтэй. Гэхдээ энэ дутагдал нь чуулганаас хөөгдөх шалтгаан болдоггүй аж.

Тесалоникчууд уйгагүй хөдөлмөрлөх, хичээнгүй ажиллах, өөрийгөө тэжээх **уламжлалыг** Паулаас хүлээн авсан.

3:7 Эзэн Есүсийн дахин ирэхийг мэддэг хэрнээ майхан оёх ажлаа Паул орхиогүй. Паул Христийг хэдийд ч ирж магад хэмээн хүлээж байсан ч амьд ахуйд нь ирэхгүй ч байж мэднэ хэмээн бодож, түүнийхээ дагуу үйлчилж, ажиллаж байсан.

3:8 Бусдын гэрт орогнож, бусдын олсныг иддэг гэж хэн ч Паулыг буруутгаж чадаагүй. Яагаад гэвэл Паул сайнмэдээг тунхаглахынхаа хажуугаар өөрийн хэрэгцээгээ хангаж байсан. Өөрөөр хэлбэл Паул өдөржин шөнөжин ажиллаж байжээ. Яагаад гэвэл тэрээр тесалоникчуудад **дарамт болохгүй** байхаар шийджээ.

3:9 Элч Паул бол сайнмэдээ тунхаглагч хүн. Тиймээс үйлчлэлээр нь дамжиж итгэсэн

хүмүүсээр хэрэгцээгээ хангуулах эрхтэй (1Коринт 9:6-14; 1Тимот 5:18). Гэвч Паул энэ эрхээсээ татгалзаж, хэнээс ч хараат бус байдал ба эцэж цуцашгүй хичээл зүтгэлийн **үлгэр дуурайл** үлдээхийг зорьжээ.

3:10 Ажил хийдэггүй залхуу хүмүүсийг бүү дэмж хэмээн Паул тесалоникчуудад тушаадаг байжээ. Ажил хийх чадвартай итгэгч хүн ажил хийхгүй байвал хоол идэх ёсгүй. Энэ нь итгэгч хүн сайхан сэтгэлтэй байх ёстой гэдэг зарчимтай харшилдаж байна уу? Огтхон ч үгүй. Залхуу занг өөгшүүлэх нь сайхан сэтгэл биш ээ. Спержон “Алдаж эндсэн хүнийг хайрлана гэдэг алдаа дутагдлыг нь ч хайрлахын нэр биш ээ. Харин бүх зүйл дээр Эзэн Есүст итгэмжит байвал жинхэнэ хайр тэр мөн” гэж хэлсэн байдаг.

3:11 Ажил төрөл хийдэггүй, зүй зохистой амьдардаггүй ах дүүсийн сүнслэг байдал, бодол сэтгэл буруудаж явааг хэлэхийн тулд элч Паул энд үгээр тоглож байна.¹⁴ Түүний үгийг өөрөөр найруулан хэлбэл:

1. Хуруугаа хөдөлгөдөггүй, хошуугаа хөдөлгөгч.
2. Зүлгэж суудаггүй, зүгээр суугч.
3. Өөрийнхөнд хойрго, өрөөлийнхөнд зүтгэлтэй.
4. Өөрийн ажилд анхаардаггүй, өрөөлийнхөнд хөндлөнгөөс оролцогч.

3:12 **Тийм хүмүүс** бусдын өмнө бүрээ таталгүй, өөрийн амьдралын хэрэгцээг

хангахын тулд **хөдөлмөрлөж** байхыг **бидний Эзэн Есүс Христ дотор тушаан ятгасан**. Ингэвэл итгэгч хүн сайн гэрчлэлтэй байж, Бурханыг алдаршуулна.

3:13 Харин итгэмжтэй хөдөлмөрлөж байгаа хүмүүсийн хувьд, цаашдаа ч тийм байхыг нь урамшуулах хэрэгтэй. Уралдаан эхэлснээрээ биш, дуусгаснаараа үнэлэгддэг билээ. Тиймээс тэд зөв зүйлийг **үйлдэхэд цуцаж болохгүй**.

3:14 Харин элч Паулын зааврыг **дагахгүй** хүнд хэрхэн хандах вэ? Бусад итгэгч ах дүүс нь түүнтэй нөхөрлөж, дотно байхаа болих хэрэгтэй. Энэ бол сахилгажуулалт юм. Тэр хүн зан хандлагаасаа ичиж, байгаа байдлаа засаж залруулах алхам хийхэд түлхэц болох үүднээс ийм сахилгажуулалт хэрэглэдэг.

3:15 Гэхдээ энэ сахилгажуулалт нь чуулганаас хөөх хэмжээний хатуу биш аж. Алдаж буруудсан хүнтэй **ах дүүгийн хувиар** харьцах ёстой гэсэн байна. Харин чуулганаас хөөгдсөн хүнд “харь хүн болоод татвар хураагч мэт” хандах ёстой (Матай 18:17).

Итгэгч хүнд хүртээж байгаа сахилгажуулалт нь Эзэн рүү хийгээд Бурханы хүмүүс рүү эргүүлэх, сэргээх зорилго агуулах ёстой. Сахилгажуулалтыг гомдол, хорслоор бус, Христийн хайр халамж ба бат тууштай сэтгэлээр хүртээх хэрэгтэй. Түүнтэй **дайсан мэт** харьцаж болохгүй. **Харин ах дүүгийн хувиар** хандвал зохино.

Тесалоник дахь итгэгчид өдөр тутмын ажил төрлөө хүртэл хаяад Эзэний ирэхийг хүлээж байсан нь өнөөгийн бидэнд их жигтэй санагдаж болох юм. Өнөөгийн чуулганд ийм асуудал байхгүй. Харин ч үүний эсрэг байдал ажиглагддаг. Бид Христийн ирэлтийн найдвараар сэтгэлээ сэргээх, Түүнд баярлан баясах завгүй болтлоо ажил төрөлдөө улайрч, мөнгө олох гэж яарах болсон.

VI. ЕРӨӨЛ БА МЭНДЧИЛГЭЭ (3:16-18)

3:16 Энэ ишлэлийг “шуургатай захидлын тайван төгсгөл” гэж нэрлэсэн удаатай. Тесалоник хотод зовлон бэрхшээл амсаж байгаа ариун хүмүүс **амар амгалангийн Эзэний амар тайвныг** цаг ямагт, **бүхий л аргаар** амсах болтугай хэмээн залбирч байна.

Христитгэгч хүн амар амгалангийнхаа төлөө энэ ертөнцийн юунд ч түшиглэдэггүй. Харин Эзэн Есүс гэдэг Бодгальд, мөн Түүний хийсэн ажилд зөвхөн түшдэг. Тийм амар тайвныг энэ ертөнц өгч чадахгүй, бас авч чадахгүй. Гэхдээ амьдралын ямар ч нөхцөл байдалд бид энэ амар тайвныг ашиглах ёстой. “Амар тайван гэж хавчлагагүй байхын нэр биш. Харин Бурханд итгэх итгэлийн улмаас ямар ч нөхцөл байдалд зүрх сэтгэлдээ тогтуун амгалан байхыг хэлнэ.”

3:17,18 Захидлын энэ хэсэгт ирээд Паул бичээчийнхээ гараас үзгийг нь авч төгсгөлийн **мэндчилгээг** бичжээ. Бичсэн захидал бүрдээ

тэмдэг болгох үүднээс тэр ийм мэндчилгээ дэвшүүлдэг аж. Зарим хүн үүнийг ойлгохдоо, тухайн захидал Паулынх мөн гэдгийн баталгаа болгох гэж төгсгөлийг нь тэр өөрийн гараар бичдэг байсан гэж үздэг. Харин зарим нь, **бидний Эзэн Есүс Христийн нигүүлсэл нь та бүгдтэй хамт байх болтугай** гэх Паулын ерөөл бол уг тэмдэг юм гэдэг. (Ром 16:24; 1Коринт 16:23; 2Коринт 13:14; Галат 6:18; Ефес 6:24; Филиппой 4:23; Колоссай 4:18; 1Тесалоник 5:28; 1Тимот 6:21; 2Тимот 4:22; Тит 3:15; Филемон 25; Еврей номыг Паул бичсэн бол Еврей 13:25). Эдгээр ишлэлийг харвал Паулын бүх захидал **нигүүлсэл** гэх үгээр төгсжээ.

ЧУУЛГАНЫ ШҮҮРЭЛТ

Эзэн эргэж ирэх тухай 1Тесалоникийн бүлэг болгонд, 2Тесалоникийн эхний хоёр бүлэгт өгүүлсэн. Энэ сэдэв уг хоёр захидлыг холбох холбоос болдог.

Гэхдээ оюуныг хөгжүүлэх, сониуч занг өдөөх гэж өгөгддөггүй гэдгийг санах хэрэгтэй. Эш үзүүллэгийн зорилго нь амьдралд нөлөөлж, амьдралын хэв маягийг өөрчлөхөд оршино.

Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь итгэгчдийн амьдралд бүх талаар нөлөө үзүүлдэг.

1. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь бидний амьдралыг ариусгагч нөлөөтэй (1Тесалоник 5:23; 1Иохан 3:3).

2. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь алдагдсан хүмүүсийн төлөө залбирах, ажиллах сэтгэлийг өгдөг (Эхлэл 19:14; Езекиел 33:6; Иуда 21-23).
3. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь хавчлага зовлонг тэвчихэд биднийг зоригжуулдаг (Ром 8:18; 2Коринт 4:17; 1Тесалоник 4:13-18).
4. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь материаллаг эд хөрөнгөөсөө зуурах сэтгэлийг нимгэлдэг. Түүний ирэлт ойртох тусам тэдний үнэ цэнэ буурдаг (Леви 25:8-10, 14-16-г үз).
5. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь бурууг үйлдсэн хүмүүсээсээ уучлал гуйх, шаардлагатай бол нөхөн төлөх сэтгэлийг бидэнд өгдөг (Матай 5:24; Иаков 5:16).
6. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь хэн ч ажиллаж чадахгүй шөнө ирж буйг ойлгуулж, шаргуу хөдөлмөрлөх ухаарлыг өгдөг (Иохан 9:4; 1Тесалоник 1:9, 10а).
7. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь бидэнд Эзэнээ хүлээх хандлагыг бий болгож (Лук 12:36), Түүнийг ирэхэд нүүр улайхгүй байхын тулд Түүний дотор амьдрахад хүргэдэг (1Иохан 2:28).
8. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь Христийг тунхаглах зоригийг өгдөг (Марк 8:38; Лук 9:26).
9. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь тайтгарлыг өгдөг (Иохан 14:1-3; 28;

1Тесалоник 4:18; 2Тесалоник 1:7; 2Тимот 2:12).

10. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь хүлээцтэй, дөлгөөн, уужуу болгодог (Филиппой 4:5).

11. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь эв нэгдэл, хайрыг төрүүлдэг (1Тесалоник 3:12, 13).

12. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь тэнгэрийн зүйлсийг бодох хандлагыг өгдөг (Колоссай 3:1-4).

13. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь үйлсийг маань шалгах Эзэнтэй, сайн үйлдээ шагналтайг маань сануулдаг (Ром 14:10-12; 1Коринт 3:11-15; 2Коринт 5:10).

14. Христ эргэж ирнэ гэсэн найдвар нь сайнмэдээг тунхаглах хүчирхэг уриалга болдог (Үйлс 3:19-21; Илчлэл 3:3).

Христ эргэж ирэх мэдээ итгэдэггүй хүмүүсийг гэмшүүлдэг. Тэгээд тэд Христийг өөрсдийнхөө Эзэн ба Аврагч болгож, амь амьдралаа Түүнд зориулах болно. Шүүрэлтийн үеэр Христийн дотор байгсад л Түүнтэй хамт явна. Бусад нь үлдэж хоцрон шүүлт амсана.

Шүүрэлт өнөөдөр болбол юу болох бол?

Христийн ирэх нь тесалоникчуудын хувьд төдийгүй христитгэгч хүн бүрийн амьдралд тун чухал учраас зарим нэг тайлбарыг нэмэлтээр оруулж байна:

Шүүрэлт Их зовлонгийн өмнө тохионо гэх үзэл зөв болох нь

1. Шүүрэлт Их зовлонгийн өмнө тохионо гэж үзэх эхний шалтгаан бол Эзэн Есүсийн хэзээ ирэх нь тодорхойгүй байдал юм. Итгэгчид Эзэн Есүсийг хэзээ ч ирж магад гэсэн сэтгэлээр хүлээх ёстойг дурдсан хэсгүүд Библид олон бий. Бид Эзэнийхээ ирэх цагийг мэдэхгүй учраас сонор сэрэмжтэйгээр Түүнийг харуулдан хүлээх учиртай. Хэрэв чуулган Их зовлонг үзнэ гэвэл Христийг хэзээ ч ирж магад гэсэн сэтгэлээр хүлээх боломжгүй. Одоохондоо Их зовлонгийн үе эхлээгүй байгаа учраас Христ наад зах нь долоон жилийн дараа ирнэ хэмээн дүгнэж болно. Христ хэдийд ч ирж болно гэж итгэх боломжтой цорын ганц үзэл бол шүүрэлт Их зовлонгийн өмнө болно гэсэн үзэл юм.

Эзэн Есүсийн ирэх цагийг бид мэдэхгүй учраас Түүний ирэхийг байнга хүлээж байх ёстой гэдгийг харуулсан зарим ишлэлийг доор жагсааж байна.

“Зөвхөн үүнд ч биш, харин бас бид, өөрсдөдөө Сүнсний анхны үр жимсийг авсан бид ч дотроо ёлон биднийг үрчилж авахыг буюу бидний биеийг золин аврахыг *тэсэж ядан хүлээдэг*” (Ром 8:23).

“Учир нь энэ талхыг идэж, энэ аяганаас уух бүрдээ та нар *түүнийг ирэх хүртэл Эзэний үхлийг тунхагладаг юм*” (1Коринт 11:26-Эзэн коринтын итгэгчдийг амьд ахуйд

ч хүрээд ирж магад гэсэн өнгө аясаар бичжээ).

“Тэнгэрийн орон гэрээ өмсөхийг *ихэд хүсэмжлэн*, энэ майханд бид гасалцгаадаг” (2Коринт 5:2-Итгэгчид шүүрэлтийн үеэр алдрын биеийг өмсөнө).

“Учир нь бид Сүнсээр дамжуулан итгэлээр зөвт байдлын найдварыг *хүлээж байна*” (Галат 5:5-зөвт байдлын найдвар бол Эзэн Есүсийн ирэлт хийгээд тэр цагт бидний хүлээн авах алдрын бие юм).

“Харин бидний иргэний харьяалал тэнгэрт байгаа бөгөөд тэндээс бид Аврагч Эзэн Есүс Христийг *хүлээж байна*. Тэр бүх юмсыг өөртөө захируулж чадах хүчээрээ дорд биеийг маань өөрийнхөө цог жавхлант биетэй адил болгон өөрчилнө” (Филиппой 3:20, 21).

“Та нарын тэвчээр бүх хүнд мэдэгдэг. *Эзэн ойрхон байна.*” (Филиппой 4:5).

“Учир нь тэд өөрсдөө хэрхэн та нарын дунд бид очсон болон амьд бөгөөд үнэн Бурханд үйлчлэхийн тулд та нар хэрхэн шүтээнүүдээсээ эргэж Бурхан өөд эргэж, түүний үхэгсдээс амилуулсан Есүс, ирэх уур хилэнгээс биднийг гэтэлгэх Хүү нь тэнгэрээс ирэхийг *хүлээж буй* тухай мэдүүлэв” (1Тесалоник 1:9,10).

“Ингэхдээ бид аугаа Бурхан ба Аврагч Есүс Христийнхээ ерөөлт найдвар хийгээд

цог жавхланта илэрхийллийг хүлээдэг” (Тит 2:13).

“Христ мөн олны нүглийг үүрэхийн тулд ганц удаа өргөгдсөн бөгөөд хоёр дахиа үзэгдэхдээ нүглийг үүрэхийн тулд бус, харин өөрийг нь тэсэн ядан хүлээгсдийг аврахын тулд ирнэ” (Еврей 9:28).

“Учир нь айсуй нэгэн тун удалгүй ирнэ. Эс саатна” (Еврей 10:37).

“Тиймээс, ах дүү нар аа, Эзэнийг ирэх хүртэл тэвчээртэй байгтун. Харагтун, тариачин хөрсний үнэт үр жимсийг хүлээдэг. Ингэхдээ тэр эрт ба оройтсон бороог ортол тэсвэртэйгээр хүлээдэг юм. Та нар ч бас тэвчээртэй бай. Эзэний ирэх ойртсон тул зурхээ чангал. Ах дүү нар аа, та нар өөрсдөө шүүгдчихгүйн тулд бие биеийнхээ эсрэг бүү гомдолло. Харагтун, шүүгч хаалган дээр зогсож байна” (Иаков 5:7-9).

“Бүх юмсын төгсгөл ойр ирчхээд байна. Тиймээс бодлоготой, залбиралдаа эрүүл байгтун” (1Петр 4:7).

“Түүнд ийнхүү найдаж байгаа бүхэн түүний цэврийн адилаар өөрийгөө цэвэршүүлдэг” (1Иохан 3:3).

“Мөнх аминд аваачих Эзэн Есүс Христийн маань өршөөлийг хүлээн, Бурханы хайранд өөрсдийгөө сахь” (Иуда 21-Эзэн Есүс Христийн маань өршөөл гэдэг нь Эзэн Есүс цусаараа худалдаж авсан хүмүүсээ

тэнгэр дэх гэр рүү нь авч явахаар эргэж ирэхийг хэлж байна).

“*Би удахгүй очно.* Хэнд ч титмээ алдахгүйн тулд өөрт буйгаа бат сахь” (Илчлэл 3:11).

“Харагтун, *Би удахгүй ирнэ.* Энэхүү номын эш үзүүллэгийн үгсийг сахигч нь ерөөлтэй ээ!” (Илчлэл 22:7).

“Харагтун, *Би удахгүй ирнэ.* Хүн бүрд үйлдсэнийх нь дагуу буцаан төлөх шагнал минь Надтай хамт байгаа” (Илчлэл 22:12).

“Эдгээр зүйлсийг гэрчлэгч тэр ‘Тийм ээ, *Би удахгүй ирнэ*’ гэж айлдаж байна. Амен. Ирээрэй, Эзэн Есүс ээ!” (Илчлэл 22:20).

Хэдийгээр шүүрэлттэй шууд холбоогүй боловч Христ хэзээ ирэх нь тодорхой биш гэдгийг харуулсан хэсгүүд бас бий. Христийн ирэх хугацааг хэн ч мэдэхгүй, Тэр хэзээ ч ирж мэднэ гэсэн үзлийг Христийн чуулган түүхийнхээ турш үргэлж баримталсаар ирсэн.

“*Тиймээс Эзэн чинь ямар өдөр ирэхийг та нар мэдэхгүй тул сонор сэргээг бай.* Харин үүнийг мэд. Хэрэв гэрийн эзэн шөнийн манааны үед хулгайч ирэхийг мэдсэнсэн бол тэрээр сэрүүн соргог байж, гэрээ ухуулахгүй байх байсан. Тиймээс та нар мөн бэлэн бай. Хүний Хүү та нарын санаагүй цагт ирнэ” (Матай 24:42-44).

“*Харин тэр өдөр, цагийг хэн ч эс мэднэ.* Тэнгэрэлчүүд ч, Хүү ч мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ. *Болгоомжлогтун,*

сэрэмжлэгтүн. Учир нь тэрхүү цаг хэзээг та нар эс мэднэ. Энэ нь холын аянд гарахдаа гэрээ орхиж, зарц нартаа үүрэг өгч, хүн бүрд ажлыг нь оноож мөн хаалгачдаа сэрэмжтэй байхыг тушааж буй хүнтэй адил юм. Тиймээс сэрэмжлэгтүн. Учир нь гэрийн эзэн орой эсвэл шөнө дунд эсвэл тахиа донгодоход аль эсвэл өглөө, хэзээ ирэхийг та нар мэдэхгүй. Тэр гэнэт ирээд, та нарыг унтаж байхыг чинь харах вий. Та нарт ч тэр, бүгдэд ч адил би хэлж байна. Сэрэмжлэгтүн” (Марк 13:32-37)

“Та нар хуримын найраас эргэж ирэх эзнээ хүлээж буй хүмүүс шиг байгтун. Эзэн нь ирээд тогшмогц тэд даруй хаалгаа нээх юм” (Лук 12:36).

“Бидний Эзэн Есүс Христийн илчлэлийг хүлээхдээ та нар ямар ч бэлгээр эс дутна” (1Коринт 1:7).

“...амьд ба үхэгсдийг...шүүх Христ Есүс” (2Тимот 4:1).

“Нялхас аа, энэ бол сүүлчийн цаг. Антихрист ирж байна гэж та нар сонссончлон, одоо ч гэсэн антихристүүд олноороо гарч ирж байна. Энэ нь эцсийн цаг гэдгийг бид үүнээс мэднэ” (1Иохан 2:18).

“Хэрэв чи сэрэхгүй бол Би хулгайч мэт очно. Ямар цагт чам дээр очихыг минь чи мэдэхгүй” (Илчлэл 3:36)

“Харагтун, Би хулгайч шиг очно. Сэрүүн байж, хувцсаа сахидаг хүн ерөөлтэй еэ! Эс

тэгвэл, тэр хүн нүцгэн явж, ичгүүрийг нь хүмүүс харах вий” (Илчлэл 16:15)

1. Шүүрэлт Их зовлонгийн өмнө тохионо гэж үзэх хоёр дахь шалтгаан бол чуулган ирэх уур хилэнг үзэхгүй гэсэн амлалт юм. Ром 5:9 дээр Паул “бид уур хилэнгээс ч аврагдах болно” гэсэн. 1Тесалоник 1:10 Эзэн Есүсийг ирэх уур хилэнгээс гэтэлгэгч хэмээн дүрсэлсэн. Бурхан биднийг уур хилэнд бус, Эзэн Есүс Христээр маань аврал авахад зориулсан гэдгийг бид 1Тесалоник 5:9-өөс бид мэдэж авсан. “Уур хилэн” гэдэг нь Их зовлонгийн үеийн уур хилэн байж болно. Аль эсвэл үл итгэгчдийн дээр буух Бурханы мөнхийн шийтгэл ч байж болно. Харин Тесалоник уруу бичсэн захидлын хам сэдвийг үзвэл Их зовлонгийн үеийн уур хилэн гэж ойлгох нь илүү нийцдэг (1Тесалоник 5:2, 3; 2Тесалоник 1:6-10; 2:10-21-ийг үз).

3. Илчлэл 3:10-т Христ өөрийн хүмүүсээ газар дэлхий дээр нутаглагсдыг сорихоор, бүх дэлхий дээр ирэх гэж буй сорилтын цаг-“*аас*” (грекээр *ек*, “-ийн гадна” гэсэн утгатай) хамгаална гэж амласан.

4. Илчлэл номын бүтэц нь шүүрэлт Их зовлонгийн өмнө тохионо гэсэн сургаалтай тохирдог. Илчлэл номын 2 ба 3 дугаар бүлэгт чуулган газар дэлхий дээр байх боловч 3 дугаар бүлгээс хойш газар дэлхий дээр байгаагаар дахиж огт дурдагдахгүй. Илчлэл номын 4 ба 5 дугаар бүлэгт ариун хүмүүс ялалтын титэм өмсөөд тэнгэрт байгаагаар гардаг. Түүний араас

6-19 дүгээр бүлэгт дэлхий дээрх их зовлонгийн тухай өгүүлдэг. Тэр үед чуулганы ариун хүмүүс тэнгэрт байх болно.

5. Их зовлонгийн үе ёс бусын хүн илчлэгдэхээс нааш эхлэхгүй (2Тесалоник 2:3). Харин хязгаарлан баригч зайлуулагдахаас нааш ёс бусын хүн илчлэгдэхгүй (2Тесалоник 2:7,8). Тэрхүү хязгаарлан баригч бол яах аргагүй Ариун Сүнс мөн. Чуулган энэ дэлхийд байгаа учраас Ариун Сүнс бузар мууг дээд цэгт нь хүргэхээс хязгаарлан барьж байна. Шүүрэлтийн үед Ариун Сүнс чуулган хийгээд итгэгчдийн дотор байнга оршигч байдлаасаа болино.

Нэг талдаа бол Ариун Сүнс энэ ертөнцөд үргэлж байсан, цаашид ч байх болно. Гэхдээ Ариун Сүнс Пентекостын өдөр буун ирсэн гэдэгт өөр онцгой утга бий. Тэрээр Пентекостын өдөр ирэхдээ чуулган хийгээд итгэгч хүний дотор байнга оршигч болсон. Ариун Сүнс зайлуулагдана гэдэг нь үүнтэй адил. Гэхдээ Их зовлонгийн үед Бурханы Сүнс ажиллахгүй гэсэн үг биш. Тэр цагт ч гэсэн Ариун Сүнс нүгэлтнүүдийг гэмшүүлж, итгүүлэх болно. Гэхдээ тэр итгэгчдийн дотор байнга оршихгүй, бас тэднийг чуулганы нэг хэсэг болгохгүй. Тэр үеийн Ариун Сүнсний үйлчлэл нь Хуучин гэрээний үеийнхтэй адил төстэй байх болов уу.

6. Шүүрэлтийг 1Тесалоник 4:18-д тайтгаруулах зүйл мэт бичсэн. Харин Эзэний өдөр нь тайтгаруулагч мэт биш хулгайч мэт

шөнөөр ирнэ (1Тесалоник 5:2). Эзэний өдөр бол хэн ч зугтах аргагүй гэнэтийн сүйрэл (3-р ишлэл), уур хилэнгийн (9-р ишлэл) цаг байх болно. Тэгвэл шүүрэлт нь эсрэгээрээ гэрэл гэгээтэй найдвар юм.

7. Христ ариун хүмүүсийнхээ төлөө ирэх хийгээд ариун хүмүүстэйгээ хамт ирэх нь дундаа тодорхой хугацаатай. Христ ариун хүмүүсийнхээ төлөө ирэх үед бүх итгэгчид энэ дэлхийгээс авагдаж, алдрын биетэй болцгооно. Гэтэл Христийг хаанчлахаар эргэн ирэх үед ердийн биетэй аврагдсан хүмүүс үр хүүхэд төрүүлж өсгөн амьдарч байх болно (Исаиа 65:20-25; Зехариа 8:5). Хэрэв чуулганы шүүрэлт ба Христийн илчлэл нэг зэрэг болох юм бол (шүүрэлт Их зовлонгийн дараа тохионо гэх үзэл) энэ хүмүүс хаанаас гарч ирэх вэ?

Чуулганы шүүрэлт ба Христийн хаанчлал дундаа тодорхой хугацаатай гэж үзэх бас нэг шалтгаан бий. Шүүрэлтийн дараа Христийн шүүх суудлын өмнө ариун хүмүүсийн итгэмжит байдлыг шүүж, үйлсийнх нь дагуу шагнах үйл явдал тэнгэрт болох ёстой (2Коринт 5:10) Энэ үед өгсөн шагнал нь мянган жилийн хаанчлалд ариун хүмүүс ямар ямар эрх мэдэлтэй байхыг тодорхойлно (Лук 19:17,19). Хэрэв шүүрэлт ба хаанчлахаар ирэх явдал нэг зэрэг болно гэвэл ариун хүмүүс хэзээд нь Христийн шүүх суудлын өмнө зогсох вэ?

8. Эзэний өдөр нь хүмүүсийг шөнийн хулгайч мэт барьж авна. Тэр өдөр үүнээс өөр

байдалтай ирэхгүй (1Тесалоник 5:2). Гэтэл Эзэний өдөр нь итгэгчдийг шөнийн хулгайч мэт барьж авахгүй гэдгийг Паул тодорхой хэлсэн (1Тесалоник 5:4). Тэгэхээр Эзэний өдөр нь итгэгч нарт хамаагүй гэсэн үг болно. Үүнд хоёр шалтгаан бий: (1) Итгэгчид бол шөнийнх биш, өдрийн хөвгүүд юм (1Тесалоник 5:4, 5). (2) Бурхан итгэгчдийг уур хилэнд зориулаагүй (1Тесалоник 5:9).

9. Шүүрэлтийн үеэр итгэгчид Эцэгийн гэр рүү явна (Иохан 14:3). Их зовлонгийн дараа шүүрэлт болно гэсэн үзэлтэй хүмүүсийн хэлдэг шиг буцаад шууд газар дэлхий дээр ирэхгүй.

10. Их зовлон нь иудейчүүдэд голлон хамаатай. Үүнийг Иаковын зовлон шаналангийн үе гэж нэрлэдэг (Иеремиа 30:7). Матай 24 дээр ч гэсэн иудейчүүдтэй гол төлөв холбоотой зүйлс дурдагдсан: Иудей нутаг (16-р ишлэл), шаббат буюу амралтын өдөр (20-р ишлэл), ариун газар (15-р ишлэл). Эдгээр нь чуулгантай хамааралгүй зүйлс юм.

11. Хуучин гэрээний зарим хүний бэлгэдэл нь шүүрэлт Их зовлонгийн өмнө тохионо гэх үзлийг баталдаг. Бид бэлгэдлээс ямар нэг онол сургаал гаргахгүй, гэхдээ тэдгээр бэлгэдэл нь шүүрэлт Их зовлонгийн өмнө болно гэсэн үзэлтэй тохирч байна.

Чуулганы дүрслэл болсон Енох Бурханы шүүлт усан галаваар буухын өмнө тэнгэр рүү аваачигдсан. Гэтэл Израилийн итгэгч үлдэгсдийн дүрслэл болсон Ноа гэр бүлийнхээ

хамтаар үерийн дундуур гарсан ч усан галаваас хамгаалагдсан.

Бурханы шүүлт Содом дээр галаар буухын өмнө Лот аврагдсан.

Абрахам хүү Исаакаа Бурханд өргөсөн нь Бурханы Хүү Голгот дээр өргөгдөхийн бэлгэдэл болдог. Тэр явдлаас хойш Исаакийн дурдагдсан хамгийн анхны хэсэгт Исаак эхнэр болох эмэгтэйтэйгээ уулзаж, гэртээ авчирч байгаа түүх гардаг. Үүний нэгэн адилаар, Христ тэнгэрт одсон цагаасаа хойш анхны удаа үзэгдэхдээ Өөрийн сүйт бүсгүйг тэнгэр дэх гэр рүүгээ авч явна.

Бурангуй явдалт Иезебел дээр шүүлт буухын өмнө Елиа тэнгэр рүү аваачигдсан.

12. Даниелийн эш үзүүллэгийн эхний жаран есөн долоо хоног нь МЭӨ 445 онд Артаксеркс хааны тушаал гарахад эхэлж, Христийг цовдлогдох хүртэл үргэлжилсэн. Тэрхүү жаран есөн долоо хоног чуулганд ямар ч хамаагүй. Тэгвэл сүүлийн дал дахь долоо хоног буюу Их зовлонгийн үед чуулган яагаад байх ёстой гэж? (69 ба 70 дахь долоо хоногийн хоорондох дурдагдаагүй хугацаа бол чуулганы эрин үе юм.)

Шүүрэлт Их зовлонгийн өмнө болно гэсэн үзлийн эсрэг, дараа болно гэсэн үзлийг дэмждэг зарим үндэслэл, тэдний няцаалт

1. Илчлэл 3:10-т өгсөн амлалт ариун хүмүүсийг их зовлонгоос гаргаж биш, их зовлон

дунд хамгаална гэсэн утгатай (Иохан 17:15-тай харьцуул).

Хариу: “...чамайг...цагаас хамгаална” гэж орчуулсныг үгчилбэл “...цагийн гадна гаргаж хамгаална” гэх утгатай юм. Грек хэлний *ek* утварын утга нь “-ийн гадна”. Тэгэхээр чуулган Их зовлонгийн дунд юм уу дотор нь байхдаа биш, харин Их зовлонгийн гадна хамгаалагдана гэж ойлгох нь зөв.

Үүнтэй ижил үгийг Иоханы 17:15 дээр Есүс залбиралдаа хэрэглэсэн байдаг: “Тэднийг та ертөнцөөс аваач гэж Би гуйхгүй, харин муу муухайгаас хамгаалахыг гуйж байна.” Пламмер үүнийг дараах байдлаар тайлбарласан: “Христийн дагалдагчид Христийн *дотор* амьдарч, хөдөлдөг шиг Христ дагалдагчдаа муу нэгний *гадна (ek)* хамгаалагдахын төлөө залбирсан.” Энэ залбирал хариугаа авсан. Итгэгчид Сатаны эзэмшлийн *гадна* хамгаалагдаж, Бурханы хайрт Хүүгийн хаанчлал уруу шилжсэн.

2. Ром 5:3 “зовлон тэвчээрийг...төрүүлдэг” гэсэн нь Их зовлонг хэлсэн. Яагаад гэвэл зовлон гэдэг үг нь грек хэлнээ ялгацтай байна.

Хариу: Зовлон зөвхөн Их зовлонгийн үед л тэвчээрийг төрүүлдэг гэдэг нь Паулын хэлэх гэсэн санаа биш. Харин амьдралд тохиолдох алив зовлон нь тэвчээрийг төрүүлдэг гэж хэлсэн нь тодорхой байна. Грек хэл нь франц, испани хэлний нэг адил хийсвэр нэр үгэндээ ялгац

авдаг. Тиймээс “их зовлон” бус “зовлон” гэж орчуулах нь зөв.

3. Христитгэгчид ертөнцөд зовлонтой байна гэж Есүс хэлсэн (Иохан 16:33). Тиймээс Их зовлонг амсахгүй байх ямар нэг шалтгаан байхгүй.

Хариу: “Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орох ёстой” (Үйлс 14:22) гэдгийг бид огт үгүйсгээгүй. Гэхдээ итгэгч бүрийн амьдралд тулгардаг зовлон нь Христээс татгалзсан ертөнцийг хүлээж байгаа Их зовлонгийн үеэс огт ондоо зүйл юм шүү.

4. Хоёрдугаар Тесалоник 1:7-г үзвэл Их зовлонгийн төгсгөлд Эзэн Есүс газар дэлхийд эргэн ирэх хүртэл ариун хүмүүс амралтыг олохгүй гэсэн байдаг.

Хариу: Уг захидлыг зориулж бичсэн тесалоникчууд өнөөдөр тэнгэрт амралтыг олсон байгаа билээ. Харин Эзэн Есүсийг хүч чадал, агуу алдар дотор эргэн ирэх үед тэднийг хавчигсдын мөхөл ба ариун хүмүүсийн зөвтгөлийг энэ ертөнц үзэх болно.

5. Бүхнийг сэргээх үе буюу мянган жилийн хаанчлал хүртэл Эзэн Есүс тэнгэрт байх учиртай гэж Үйлс 3:21 дээр хэлсэн.

Хариу: Үүнийг Израилийн эрчүүдэд хэлсэн (4-р ишлэл). Израиль үндэстний хувьд энэ үг үнэн. Энэ үг Аврагч Эзэн Есүсийн Иерусалим хотод хандаж хэлсэнтэй тохирч байна: “Учир нь би та нарт хэлье. ‘Эзэний нэрээр ирэгч нь ерөөлтэй еэ!’ гэж хэлтлээ Та нар намайг

харахгүй” (Матай 22:39). Энэ үйл явдал Их зовлонгийн үеийн эцэст болно. Харин тэрхүү үйл явдал болохоос долоон жилийн өмнө чуулган дээш авагдсан байх болно.

6. Дайснууд нь бүгд устгагдах хүртэл Христ Бурханы баруун гарт залрах тухай Дуулал 110:1 дээр хэлдэг. Энэ явдал Их зовлонгийн эцэст болно.

Хариу: Их зовлон дуусаад 1000 жил болсны дараа буюу мянган жилийн хаанчлалыг дуусахад Христэд дайсагнагчид гарч ирэх тухай Илчлэл 20:8,9 дээр дурдсан байдаг. Бурханы баруун гар гэдэг нь хүндлэл, эрх мэдлийн байр суурийг, бас газарзүйн байршлыг илэрхийлсэн байж болно.

7. Ерөөлт найдвар ба цог жавхлант илэрхийлэл нь нэг зүйл гэдгийг Тит 2:13-аас харагддаг. Тиймээс чуулганы шүүрэлт ба Христийн илэрхийлэл нэг дор болно. Бид Их зовлонгийн өмнө тохиох шүүрэлтийг биш, Христ хаанчлахаар ирэхийг хүлээх ёстой.

Хариу: Грэнвилл Шарпын грек хэлний өгүүлбэрзүйн дүрмээс улбаалан ийм үндэслэл гаргаж ирдэг. Уг дүрэмд: “*kai* (ба, бөгөөд, болон)-аар холбогдсон, ижил тийн ялгалтай хоёр нэр үгийн эхнийх нь тухайлах ялгацтай, удаах нь ялгацгүй байвал хоёр дахь үг нь эхний үгтэйгээ ижил зүйлийг хэлж байгаа бөгөөд нөгөө зүйлийг цааш нь тодруулж байна гэсэн үг” гэжээ. Тит 2:13 дээр “...бидний аугаа Бурхан ба Аврагч Есүс Христийн...” гэснийг жишээ

болгож авч үзье. “Бурхан”, “Аврагч” гэх хоёр үг “*kai*”-аар холбогдсоноос гадна ижил тийн ялгалтай (харьяалах) байна. Мөн тухайлах ялгац нь (бидний) “Бурхан” гэдэг үгийн өмнө байгаа боловч “Аврагч” гэдэг үгийн өмнө ороогүй. Тэгэхээр Грэнвилл Шарпын дүрмийн дагуу “Аврагч” гэдэг нь “Бурхан” гэдэгтэй адил зүйлийг хэлж байгаагаас гадна Түүнийг цааш нь тодотгосон хэрэг юм. Аврагч Есүс Христ бол Бурхан юм гэдэг нь үүгээр нотлогдож байна.

Цашилбал саяын жишээ татсан ишлэл дэх “ерөөлт найдвар хийгээд (*kai*) цог жавхланта илэрхийллийг хүлээдэг” гэдэг хоёр үгийн хувьд грек дээрээ эхнийх нь тухайлах ялгацтай, удаах нь ялгацгүй байна. Мөн хоёулаа ижил тийн ялгалтай. Тэгэхээр Грэнвилл Шарпын дүрмийн дагуу ерөөлт найдвар гэдэг нь цог жавхланта илэрхийлэлтэй нэг ижил зүйл гэсэн дүгнэлтэд хүрдэг. Тэгээд цог жавхланта илэрхийлэл гэдгийг ерөнхийдөө Христийн хаанчлахаар ирэх ирэлт гэж ойлгодог учраас, их зовлонгийн өмнө тохиох шүүрэлтийг биш, харин газар дэлхий дээр алдраа дуурсган ирэх Христийн ирэлтийг хүлээх нь итгэгч хүний найдвар юм гэж хэлдэг.

Үүнд хоёр янзаар хариулж болно. Эхний хариу: Хэчнээн сайн дүрэм байлаа ч гажилт гэж заавал байдаг. Грэнвилл Шарпын дүрэмд ч бас зарим гажилтууд бий. Тухайлбал Лук 14:23 дээр “зам, хашаа хавиар яв (грекээр: зам ба хашаа уруу яв)” гэсэн байна. Хэрэв уг дүрмийг баримталбал зам, хашаа хоёр нэг ижил зүйл гэж

дүгнэхэд хүрнэ. Бас нэг гажилт Ефес 2:20 дээр бий. Тус ишлэлд “...элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр” гэжээ. Элч ба эш үзүүлэгчийг нэг ижил алба үүрэг гэж хэлэх хүн үгүй биз ээ.

Хоёр дахь хариу: Ерөөлт найдвар гэдэг нь цог жавхлант илэрхийлэлтэй ижил зүйлийг хэлсэн гэж бодъё. Тэгвэл шүүрэлт нь чуулганд үзэгдэх цог жавхлант илэрхийлэл, илчлэл нь ертөнцөд үзэгдэх цог жавхлант илэрхийлэл байж болох биш үү? Илчлэл (*apokalupsis*) ба илэрхийлэл/харагдалт (*epiphaneia*) гэх үгс шүүрэлтийг төдийгүй Христийн хаанчлахаар ирэх явдлыг аль алийг нь илтгэдэг.

8. Христ хаанчлахаар ирэх ирэлт бол итгэгч хүний найдвар мөн гэдгийг харуулсан ишлэлүүд: 1Коринт 1:7; 1Тимот 6:14; 2Тимот 4:8; 1Петр 1:7, 13; 4:13.

Хариу: Эдгээр ишлэлд хэрэглэсэн илчлэл (*apokalupsis*) ба илэрхийлэл/харагдалт (*epiphaneia*) гэх үгс нь Христ ариун хүмүүсийнхээ төлөө ирэх хийгээд Христ ариун хүмүүстэйгээ хамт ирэхийн аль алинд таардаг. Христ эхлээд чуулганд, дараа нь ертөнцөд Өөрийгөө илчилж, харуулна.

Гэхдээ энэ ишлэлүүд бүгдээрээ Христийн хаанчлахаар ирэх тухай өгүүлсэн байлаа ч итгэгч хүний найдвар нь эш үзүүлэлийн ирээдүйн ерөөлийг бүхэлд нь хамарч байгаг мартаж болохгүй. Бид шүүрэлтийг, Христ

хаанчлахаар ирэхийг, мянган жилийн хаанчлалыг, мөнх эрин үеийг хүлээж байна.

9. Их зовлонгийн өмнө болох шүүрэлтийг хүлээх нь чуулганд уламжлан ирсэн найдвар биш. Ж. Н. Дарбигаас хойш, 160 жилийн өмнөөс л ийм үзэл дэлгэрэх болсон.

Хариу: Шинэ гэрээний чуулган тэнгэрээс ирэх Бурханы Хүүг хүлээж байсан. Ариун хүмүүс Түүний хэзээ ирэхийг мэдэхгүй байсан учраас хэзээ ч ирж болзошгүй хэмээн хүлээсэн.

Хэн нэг хүн юу заасан, заагаагүйг ярьсан маргааныг *ad hominem* (хүнд чиглэсэн) гэж нэрлэдэг бөгөөд ийм маргаан хийх нь утгагүй. “Өмнө нь юу зааж байсан, тэрийг л заах нь зөв” гэж үзвэл буруу. Харин “Библи юу зааж байна вэ?” гэж асуувал зөв юм.

10. Нэгдүгээр Коринт 15:52 дахь сүүлчийн бүрээ, 1Тесалоник 4:16 дахь Бурханы бүрээ нь шүүрэлттэй холбоотой бөгөөд Илчлэл 11:15-д гарч байгаа долоо дахь бүрээг хэлж байна. Тэрхүү долоо дахь бүрээ нь “ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийнх болох” үед буюу Их зовлонгийн эцэст дуугарсан учраас Христийн эргэн ирэлт Их зовлонгийн дараа болно.

Хариу: Эдгээр нь бүгд нэг ижил бүрээг хэлээгүй. “Сүүлчийн бүрээ”, “Бурханы бүрээ” хоёр бол нэг ижил. Шүүрэлт болж, итгэгчид амилж, тэд Эцэгийн гэр рүү явахыг энэ бүрээ зарлана. Энэ нь чуулганы хувьд “сүүлчийн бүрээ” юм. Харин Илчлэл 11:15 дээр гарч

байгаа долоо дахь бүрээ бол Их зовлонгийн үед тохиосон цуврал шүүлтүүдийн хувьд эцсийнх байх болно. Энэ нь үл итгэгч Израиль ба үл итгэгч харь үндэстнүүдийн хувьд сүүлчийн бүрээ юм. 1Тесалоник 4:16-д “Бурханы бүрээ”, 1Коринт 15:52-т “сүүлчийн бүрээ” гэж нэрлэсэн бүрээ нь Их зовлонгийн өмнө дуугарна. Харин долоо дахь бүрээ нь Их зовлонгийн төгсгөлд дуугарна.

11. Илчлэл 20:4,5-д дурдагдсан анхны амилал Их зовлонгийн төгсгөлд болсон. Шүүрэлт Их зовлонгийн өмнө болно гэсэн үзэлтэй хүмүүс их зовлонгийн өмнө амилал болно гэж хэлдэг нь үүгээр няцаагдаж байна.

Хариу: Анхны амилал гэж ганц удаагийн үйл явдал бус, хэд хэдэн удаагийн үйл явдал юм. Анхны амилалын түрүүч нь Христийн амилал юм (1Коринт 15:23). Дараагийнх нь шүүрэлтийн үеэрх итгэгчдийн амилал. Гурав дахь нь Христийг газар дэлхий дээр эргэн ирэх үед Их зовлонгийн үеийн ариун хүмүүсийн амилал (Илчлэл 20:4, 5). Өөрөөр хэлбэл, анхны амилал гэдэг нь Христийн болоод итгэгч хүмүүсийн амилал юм. Үүнд тэдний хэзээ амилсан нь хамаагүй. Харин үл итгэгчид мянган жилийн хаанчлалын төгсгөлд Цагаан өнгөтэй агуу сэнтийн өмнө зогсохоор амилах болно (Илчлэл 20:11-15).

12. Матай 13:24-30 дээрх сургаалт зүйрлэлд сайн ба муу үр үеийн төгсгөл хүртэл хамт

ургадаг. Өөрөөр хэлбэл Их зовлонгийн төгсгөл хүртэл.

Хариу: Тийм. Гэхдээ уг сургаалт зүйрлэлд чуулганы тухай бус хаанчлалын тухай өгүүлсэн. Их зовлонгийн эцэс хүртэл жинхэнэ ба хуурамч хүмүүс хаанчлалын дотор байх болно.

13. Тушаалын уухай, тэргүүн тэнгэрэлчийн дуу, Бурханы бүрээ дуугарах учраас шүүрэлт нууц байх боломжгүй (1Тесалоник 4:16).

Хариу: Шүүрэлт нүд ирмэхийн зуур болно (1Коринт 15:52) гэсэн үгэнд үндэслэн шүүрэлт нууц байна гэж заах болсон. Ямартай ч энэ ертөнц юу болоод байгааг харахын завдалгүй, юу болсныг ойлгохоос өмнө бүх зүйл болоод өнгөрчихсөн байна.

14. Жорж Мюллер, Самуел Трегеллес, Освальд Смит гэх мэт нөлөө бүхий хүмүүс шүүрэлт Их зовлонгийн дараа болно гэсэн үзлийг зөв гэж үздэг байсан.

Хариу: Тэглээ гээд юуг ч баталж чадахгүй. Энэ хоёр үзлийн аль аль талд нь мундаг сайн итгэгчид байсан.

15. Шинэ гэрээнд Христийн ирэлтийн тухай өгүүлсэн хэсгүүдийн ихэнх нь хаанчлахаар ирэх ирэлтийнх нь тухай байдаг шүү дээ.

Хариу: Гэхдээ энэ нь шүүрэлтийг үгүйсгэдэг гэсэн үг биш. Шинэ гэрээнд диваажингийн тухай тамаас олон удаа дурдагдсан гээд там байдаггүй гэсэн үг биш юм.

16. Чуулган Их зовлонгийн үед Бурханы уур хилэнг бус, харин Антихристийн буюу Сатаны уур хилэнг амсана.

Хариу: Их зовлонгийн үеийн уур хилэнг Илчлэл номд зургаан удаа Бурханы уур хилэн гэсэн байдаг:

“Өөр нэгэн тэнгэрэлч буюу гурав дахь нь тэднийг даган, чанга дуугаар ‘Хэн араатанд болон хөрөгт нь мөргөж, духан дээрээ, эсвэл гар дээрээ тэмдэг авна, тэр хүн *Бурханы уур хилэнгийн* дарсыг мөн уух болно. Энэ нь түүний уур хилэнгийн аяганд шингэлэлгүй хольсон дарс юм. Тэр хүн ариун тэнгэрэлч нар ба Хурганы өмнө гал, хүхэр дотор зовж тарчилна’ гэв” (Илчлэл 14:9,10)

“Тэнгэрэлч хадуураа дэлхий уруу ширвэж, дэлхийн усан үзмийг хураагаад, тэдгээрийг *Бурханы уур хилэнгийн* агуу их шахуургад хаялаа” (Илчлэл 14:19).

“Би тэнгэрт агуу бөгөөд гайхалтай өөр нэгэн тэмдгийг харав. Эцсийн долоон гамшиг бүхий долоон тэнгэрэлч байв. Яагаад гэвэл тэдгээрээр *Бурханы уур хилэн* төгссөн юм” (Илчлэл 15:1).

“Дөрвөн амьтны нэг нь үеийн үед амьдрагч *Бурханы уур хилэнгээр* дүүрэн долоон алтан аягыг долоон тэнгэр элчид өгөв” (Илчлэл 15:7).

“Сүмээс долоон тэнгэрэлчид ‘Явагтун, *Бурханы уур хилэнгийн* долоон аягатайг

дэлхий дээр асга’ гэж чанга дуугаар хэлэхийг би сонсов” (Илчлэл 16:1).

“Агуу хот гурван хэсэг болон хуваагдаж, үндэстнүүдийн хотууд нурав. Агуу их Вавилон Бурханы өмнө дурсагдаж, *Бурхан догшин уур хилэнгийнхээ* дарсны аягыг түүнд өгөв” (Илчлэл 16:19).

17. Есүс “Би удахгүй очно” (Илчлэл 22:7, 12, 20) гэсэн хэдийд ч гэсэн утгаар биш, харин “гэнэтхэн” гэсэн утгаар орсон.

Хариу: Энэ бол их маргаантай хэсэг. “Гэнэтхэн” гэсэн утгатай байлаа ч “Учир нь айсуй нэгэн тун удалгүй ирнэ. Эс саатна” (Еврей 10:37) гэх мэт ишлэлүүд ч гэсэн байгаа.

18. Хоёрдугаар Тесалоник 2:5-8 дээр гарч байгаа хязгаарлан баригч бол Ариун Сүнс биш, харин Ромын засаг захиргаа юм уу Бурханы хүч чадал юм.

Хариу: Уг багц ишлэлийг тайлбарласан хэсэгт энэ тухай өгүүлсэн.

19. Петр, Паул нар үхнэ гэдгээ мэдэж байсан (Иохан 21:18, 18; 2Петр 1:14, 15; 2Тимот 4:6). Тэгэхээр тэд өөрсдийнх нь амьд ахуйд ирж магад гэж бодоогүй гэсэн үг.

Хариу: Паул заримдаа өөрийгөө Эзэнийг ирэхэд амьд байх юм шиг ярьж байсан (1Тесалоник 4:15) бол заримдаа өөрийгөө нас бараад, дахин амилах итгэгчдийн тоонд оруулан ярьж байсан (Филиппой 3:10,11). Бид ийм хандлагатай байх ёстой. Нэг талаас бол Эзэн маань биднийг амьд ахуйд ч ирж магад хэмээн

хүлээж, нөгөө талаас бол бид шүүрэлтээс өмнө нас барж магад хэмээн бодож амьдрах хэрэгтэй.

Бүх юмсын төгсгөл ойрхон байгаад Петр итгэж байсан (1Петр 4:7). Түүнчлэн “Бүх юмс бүтээлийн эхнээс байсан шигээ хэвээр байна шүү дээ” (2Петр 3:4) гэж хэлэн Эзэнийг ирэлтийг үгүйсгэгч хүмүүсийг Петр буруушаасан.

20. Эзэнийг ирэхээс өмнө сайнмэдээ бүх дэлхий даяар тунхаглагдах ёстой (Матай 24:14) учраас Эзэн ямар ч хамаагүй үед ирэх боломжгүй.

Хариу: Гэхдээ энэ нь *хаанчлалын сайнмэдээг* хэлж байна (14-р ишлэл). Хаанчлалын сайнмэдээ нь Их зовлонгийн үед бүх дэлхий даяар тунхаглагдана. Хаанчлалын сайнмэдээ нь “Эзэн Есүс Христэд итгэвэл аврагдаж, Христ ирэх үед Түүнтэй хамт мянган жилийн хаанчлалд орно” гэх мэдээ юм. Аврагдах зам нь бидний тунхагладагтай ижил. Гэхдээ бидний тунхаглаж байгаа сайнмэдээ шүүрэлт рүү чиглэдэг. Өөрөөр хэлбэл бид “Эзэн Есүс Христэд итгэвэл аврагдаж, Есүс ирэх үед Түүнтэй хамт Эцэгийн гэр рүү явна” гэх мэдээг тунхагладаг.

21. Матай 28:19, 20 болон Үйлс 1:8 дээр “бүх үндэстэн рүү”, “дэлхий хязгаар хүртэл” явж сайнмэдээг ярих тухай гардаг. Тэгэхээр элч нарын амьд ахуй цагт Эзэн эргэж ирэх боломжгүй байжээ.

Хариу: Колоссай 1:6, 23 дээр Паул “бүх дэлхий”, “тэнгэрийн доорх бүх бүтээл” сайнмэдээ сонссон гэж хэлсэн. Ром 10:18 дээр сайнмэдээг ертөнцийн хязгаарт хүрсэн гэсэн байна. Гэхдээ мэдээж энэ хэсгүүд нь тухайн цаг үед мэдэгдэж байсан ертөнц, Газар дундын тэнгис орчмын улс орнуудын тухай хэлж байгааг бид ойлгодог.

22. Үйлс 18:21; 23:11; Ром 15:22-25, 30, 31 дээр дурдсанчлан Паул урт хугацааны илгээлт төлөвлөсөн байхыг харахад тэрээр Эзэнийг ойрын ирээдүйд ирнэ гэж хүлээгээгүй биш үү?

Хариу: Паулын төлөвлөгөө нь Бурханы хүслийн дагуу байсан (Үйлс 18:21; Ром 1:10; 1Коринт 4:19). Паул өөрийнх нь амьд ахуйд Эзэн ирэхгүй юм шиг ажиллаж, хэзээ ч ирж магад хэмээн Эзэнийг хүлээдэг байсан.

23. Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирэх тухай Паул ярьж байсан (1Тимот 4:1-3; 2Тимот 3:1-5). Эзэний ирэхгүй тодорхой хугацаа байгаа гэсэн санаа эндээс цухалздаг.

Хариу: Паул бас “ёс бусын нууц нь хэдийнээ ажиллаж байна” гэж хэлсэн (2Тесалоник 2:7). Иохан ч гэсэн өөрийн амьдарч байсан үеийг “сүүлчийн цаг” гэж хэлсэн (1Иохан 2:18). Энэ хүмүүс Христ хэзээ ч ирж магад гэж итгэхийг боломжгүй зүйл гэж үзээгүй.

24. Матай 25:14-30, Лук 19:11-27 зэрэг сургаалт зүйрлэлүүдэд Эзэн нь эргэж ирэлгүй удна гэж өгүүлдэг. Тийм болохоор анхны

итгэгчид Эзэнийг хэзээ ч ирж магад хэмээн хүлээж байгаагүй.

Хариу: Анхны итгэгчид онол сургаалаа сургаалт зүйрлэлүүд дээр тулгуурлаж байгаагүй. Яагаад гэвэл тэд шүүрэлтийг хүлээж байсан (1Тесалоник 1:10). Тэгэхдээ Матай 25:19 дээрх “удаан хугацаа” гэдэг үг хэзээ ч ирж магадгүй гэдгийг үгүйсгэх шалтгаан болж чадахгүй. Лукийн сургаалт зүйрлэлд *хаанчлалыг* нэн даруй ирэхгүй гэж хэлсэн (Лук 19:11). Гэлээ ч энэ нь чуулганы шүүрэлт хэдийд ч тохиож болно гэдгийг няцаахгүй.

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

¹(1:1) Шинэ гэрээний үеийн христитгэгчдийн чуулган одоо ч гэсэн Тесалоник хотод бий. Өнөөдөр тэднийг Салоники гэж нэрлэдэг.

²(1:5) Э. В. Рожерс, *Ирээдүйн тухай*, хуудас 80.

³(1:6) Жорж Уиллиамс, *Ариун бичвэрийг тайлбарлах судлаачийн тайлбар*, хуудас 948.

⁴(1:10) Хамгийн эртний (NU) хийгээд мажорити (M) гар бичмэлүүдэд аль алинд нь “итгэсэн хүмүүстээ” гэж бичигдсэн байдаг нь зөв болно.

⁵(2:1) Уиллиам Келли, *Эш үзүүлэгийн элементүүд*, хуудас 253.

⁶(2:2) Сонгомол текстэд “Эзэн” (*Kurios*) гэсэн байна. Харин мажорити текстийг баримталсан KJV ба NKJV-д “Христ” (*Christos*) гэсэн байна. Зарим эрдэмтэд “Христийн өдөр” гэдгийг хавчлагын сүүлийн хугацаа гэж үздэг. Гэтэл ёс

бусын хүн илчлэгдээгүй байхад хавчлагын сүүлийн хугацаа байх боломжгүй юм. Зарим тесалоникчууд энэ хугацааг аль хэдийнээ эхэлсэн хэмээн буруу бодож байсан. Энэ хугацааг шүүрэлтийн дараах үйл явдалтай холбосноороо Паул ийм үзлийг бүрэн няцаажээ. ⁷(2:3) Ж. Двайт Пентекост зэрэг зарим теологичид *apostasia* гэх үгийг “салах явдал” хэмээн орчуулж, шүүрэлтийг (газраас салах) хэлж байна гэж үзсэн. Хэрэв тийм бол энэ ишлэл нь шүүрэлт их зовлонгийн өмнө тохионо гэх үзэлд хүчтэй дэмжлэг болно.

⁸(2:3) Мажорити текстэд “ёс бусын (нүглийн) хүн” гэсэн бол сонгомол текстэд “хуульгүй хүн” гэсэн байна.

⁹(2:4) *Anti* гэх грек угтвар нь “эсрэг”, “оронд нь” гэсэн хоёр утгатай. Энэ хоёр утга хоёулаа Антихристэд таарч байна.

¹⁰(2:6) Грек дээрээ 6 дугаар ишлэл саармаг хүйс ашигласан бол 7 дугаар ишлэл эр хүйс ашигласан.

¹¹(2:6) Э. В. Рожерс, *Ирээдүйн тухай*, хуудас 65.

¹²(2:8) Ариун Сүнсийг саармаг хүйсээр ярьдаг нь хэлзүйн асуудал юм. Яагаад гэвэл *пнеума* гэж саармаг хүйсийн үг ажээ. Харин заримдаа Ариун Сүнсний хүн мэт чанарыг тодотгохын тулд эр хүйсийг ашигладаг байна.

¹³(3:5) *Christou* (үгчилбэл: “Христийн”) гэдэг харьяалахын тийн ялгалтай үгийг орчуулсан энэ хоёр орчуулгын хувилбарууд хоёулаа зөв юм. Уг үгийг KJV нь объектив (тусагдахуун-Христ

үйлийг хүлээн авагч) байдлаар, NKJV нь субъектив (Христ тэвчээрийг үзүүлэгч) байдлаар орчуулсан байна.

¹⁴(3:11) Грек дээрээ “огт *ergazomenous* (ажил хийх)гүй, харин *periergazomenous* (бусдын хэрэгт оролцож байна)” гэсэн байдаг. Хоёр үгэнд байгаа “*erg*” (ажил) гэх үндсийг анхаарна уу.

НОМЗҮЙ

1Тесалоникийн төгсгөлд буй номзүйг үзнэ үү.

Зохион байгуулагчид:

Христмас Вайлли Цуглаан

Индогуан цуглаан

Үл Устах Үгс сайн дурын үйлчлэл

Зөвлөх хороо:

Марк Фийнер

Пак Сү Ён

Б. Пүрэвсүрэн

Ю. Гангаа-Эрдэнэ

Орчуулагчид:

Б. Пүрэвсүрэн

Б. Шинэбаяр

Хянан засварласан:

Б. Пүрэвсүрэн

Ю. Гангаа-Эрдэнэ

Эх бэлтгэсэн:

.....

Зохиогчийн эрх © Виллиям МакДоналд 1989, 1990,
1992, 1995

Америкийн Нэгдсэн Улс

Зохиогчийн албан ёсны зөвшөөрлөөр Монгол хэлнээ
орчуулж, БНСУ-д 2018 онд хэвлэв.

Зохиогчийн бүх эрх хадгалагдана. Тус хэвлэлийн
аль ч хэсгийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр
цахилгаан, механик, фото хуулбар, хальсанд хуулах
гэх мэт бусад ямар ч утга болон хэлбэрт шилжүүлэн,
хуулж, хэвлэж үл болно.